



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-52
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	53-186
1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/	55-61
2.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	61-74
3.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	74-88
4.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	88-112
5.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамиуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	112-117
6.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	117-129
7.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	129-141
8.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	141-162
9.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	163-167
10.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	167-170
11.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	170-172
12.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	172-173
13.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	173-182
14.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 8 гишүүн 2024.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	182-186

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 17-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 19 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Бейсен, С.Бямбацогт, С.Ганбаатар, Б.Жавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Ц.Туваан;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Ш.Раднаасэд;

Хоцорсон: Г.Амартүвшин -11 минут, Э.Батшугар -34 минут, Ж.Бат-Эрдэнэ -21 минут, Б.Баярсайхан -23 минут, Ж.Ганбаатар -11 минут, Д.Ганбат -27 минут, Т.Доржханд -06 минут, Л.Мөнхбаатар -10 минут, Г.Мөнхцэцэг -11 минут, С.Одонтуяа -16 минут, Д.Өнөрболор -27 минут, Ц.Сэргэлэн -23 минут, Г.Тэмүүлэн -25 минут, Н.Учрал -1 цаг 23 минут, О.Цогтгэрэл -1 цаг 05 минут, Б.Энх-Амгалан -1 цаг 02 минут, Б.Энхбаяр -51 минут, Ж.Эрдэнэбат -1 цаг 52 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуунаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун үг хэлэв.

Нэг.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Энхсүрэн, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн гаалийн улсын байцаагч М.Пүрэвсүрэн, “Эрүүл мэнд реформ” ТББ-ын гишүүн М.Халиунаа, “Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэг”-ийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 35.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

“60 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

60.1.Энэ хуулийн 8.1.2, 15.3.2-т заасан стандартыг дотоодын уламжлалт эмийн үйлдвэр 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

60.2.Энэ хуулийн 16.14 дэх хэсэгт заасныг үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын үйлдвэрлэгч 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

60.3.Энэ хуулийн 16.10 дахь хэсэгт заасан өнчин эмийн бүртгэлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хийнэ.

60.4.Энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 11

Бүгд: 40

72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгохдоо дараах зарчмыг баримтална:

47.1.1.эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг, эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.2.тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай, тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.3.Төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Г.Занданшатар: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийн “сонгон шалгаруулж,” гэснийг хасаж, “байгууллагыг” гэснийг “байгууллага” гэж, “байгууллага” гэснийг “байгууллагатай” гэж

тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 24
Бүгд: 42
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Гурав. Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.40 дэх заалтын “бусад” гэсний дараа “хэлбэрийн” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1.2 дахь заалтын “хүний нөөц,” гэсний дараа “иргэдийн” гэж, 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсгийн “байгууллагад” гэсний дараа “улирал” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “гурван” гэснийг “хоёр” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтын “бүртгэлд бүртгэх” гэснийг “бүртгэл” гэж, 33.2.2 дахь заалтын “жагсаалтад оруулах” гэснийг “жагсаалт” гэж, 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтын, 46 дугаар зүйлийн 46.14.4 дэх заалтын “хадгалсан, ашигласан,” гэснийг “жилийн хугацаа өнгөрсөн” гэж, 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 46 дугаар зүйлийн 46.10.11 дэх заалтын “өндөргүй, бодит” гэснийг “доогуур” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.4 дэх заалтын, 47.4, 47.5, 47.6 дахь хэсгийн “жигжиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, 51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсгийн “, 34.4-т” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалтын “байгууллагын” гэснийг, 40.1.6 дахь заалтын “байгууллагад” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн “нийгэмлэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 14
Бүгд: 46
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 19.3.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 19.3.2-19.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.2.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох;

19.3.3.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх;

19.3.4.эм болон эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах эм худалдах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 11
Бүгд: 46
76.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний дараа “19.3.5,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 15
Бүгд: 47
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13.9 дэх хэсгийн “Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 9
Бүгд: 46
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “эмнэлгийн жижиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, “эмнэлгийн жижиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 8
Бүгд: 47
83.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нөлөөт эм,” гэсний дараа “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 13 дахь хэсгийн “борлуулсан бол” гэсний дараа “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 4 дэх хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж, 17 дахь хэсгийн “тусламжаар төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 24 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодис,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 4 дэх хэсгийн тайлбарын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй,” “зах зээлд гаргах зөвшөөрөл,” “мансууруулах эм, уламжлалт эм, биобэлдмэл,” гэснийг, 10 дахь хэсгийн “лабораторийн оношилгооны хэрэгслийг Монгол Улсын эм,” гэснийг, 24 дэх хэсгийн “зохих” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 8
Бүгд: 48
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа нарын 5 гишүүнээс 2023.12.27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./10:54/

Хоёр.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн зөвлөх М.Найданхүү, “Бодлого судлал төв”-ийн тэргүүн А.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 10 цаг 58 минутаас 11 цаг 00 минутад хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Мөнхцэцэг, Ц.Туваан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “гэрээт бэлчээрийн газар дахь” гэснийг “гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх” гэж, 3.3 дахь хэсгийн “Гэрээт бэлчээрийн газрыг” гэснийг “Бэлчээрийг гэрээгээр” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	21
Бүгд:	47
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “малчдын” гэснийг “малчин өрхийн” гэж өөрчилж, 4.1.2, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.4 дэх заалтыг хасах:

“4.1.2. “малчин өрх” гэж жилийн дөрвөн улиралд мал аж ахуй эрхэлж, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг;”

“4.1.5.“байгалийн нөөц” гэж гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн ургамал, уст цэг, ан амьтан зэргийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 21
Бүгд: 47
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтын “үйл ажиллагаа гишүүдэд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 22
Бүгд: 48
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “гарах” гэсний дараа “, гаргах үндэслэл, журам” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.9 дэх заалт тус тус нэмж, 6.2 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг хасах:

“6.1.9.Анхдагч холбооны бүх гишүүдийн хурал /цаашид “бүх гишүүдийн хурал” гэх/-тай холбогдсон энэ хуульд зааснаас бусад асуудал,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 23
Бүгд: 48
52.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “20-оос” гэснийг “10-аас” гэж, 7.2.3 дахь заалтын “удирдлагын бүтцийг тогтоож, бүрэлдэхүүнийг” гэснийг “ахлагч, тэргүүлэгчдийг” гэж тус тус өөрчилж, мөн заалтын “, томилох” гэснийг, 7.3 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 22
Бүгд: 48
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсгийг 8.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“8.1.1.малчин өрхийн гишүүнийг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах;”

“8.1.3.малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах;”

“8.5.Анхдагч холбооны малчин өрхийн гишүүн холбогдох хуульд заасны дагуу нөхөрлөл, хоршоо, компанийн үүсгэн байгуулагч, гишүүн, хувьцаа эзэмшигч байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 22

Бүгд: 47

53.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлд 9.1.4 дэх заалт нэмж, мөн зүйлийн гарчгийг “Боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах” гэж өөрчилж, 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.1.4 дэх заалтыг 8.3 дахь хэсэг болгон шилжүүлж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Анхдагч холбоо нь малчин өрхийн гишүүдийг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:”

“9.1.4.нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, холбогдох мэдээллээр хангах.”

“8.3.Анхдагч холбооны гишүүдэд төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 20

Бүгд: 46

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтын “хадлан, тариалангийн” гэснийг “хадлангийн” гэж өөрчилж, 10.1.2, 10.1.3 дахь заалтыг нэгтгэн 10.1.2 дахь заалт болгож, 10.1.4, 10.1.6, 10.1.7 дахь заалт, 10.2 дахь хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд 10.5 дахь хэсэг нэмэх:

“10.1.2.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, өнжөөх, бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх;”

“10.1.6.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг Газрын тухай хуулийн 21.4.5, 21.4.6-д заасны дагуу ашиглуулахад хяналт тавих;

10.1.7.тухайн жилийн бэлчээрийн гарц, байгаль, цаг уурын урьдчилсан төлөв байдлыг харгалзан өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх;

10.1.8.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.5.1-7.5.3-т заасан шаардлагыг хангасан, халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй мал оруулах, дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих;”

“10.2.Газрын тухай хуулийн 52.7 дахь хэсэгт заасан газарт тэжээлийн ургамал тариалж болно.”

“10.5.Анхдагч холбооны гишүүн бус малчин өрх Анхдагч холбооны гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг ашиглах тохиолдолд нийтийн эрх ашгийг хүндэтгэн түүнийг зохистой ашиглаж, хамгаална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 23

Бүгд: 47

51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8.4 дэх хэсэг болгон шилжүүлж, мөн зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн цаг үеийн шинжтэй, нэмэлт ажиллах хүч шаардагдах ажлын үед Анхдагч холбооны гишүүд харилцан тусалж, хамтран ажиллана.”

“11 дүгээр зүйл.Малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах

11.1.Анхдагч холбоо нь малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

11.1.1.малын чанар, ашиг шимийг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

11.1.2.тухайн бүс нутгийн онцлогт дасан зохицсон, баталгаажсан үүлдэр, омгийн малыг үржилд ашиглах, үржлийн мал бойжуулах, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг технологит хугацаанд хэрэгжүүлэх;

11.1.3.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг бүртгэх;

11.1.4.мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх арга хэмжээнд малаа товлосон хугацаанд бүрэн хамруулах, эрүүл мэндийн бүртгэлийн дэвтрийг тогтмол хөтлөх;

11.1.5.малын индексжүүлсэн даатгалд хамруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 24

Бүгд: 47

48.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	22
Бүгд:	47

53.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8.4 дэх хэсэг болгон шилжүүлж, мөн зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн цаг үеийн шинжтэй, нэмэлт ажиллах хүч шаардагдах ажлын үед Анхдагч холбооны гишүүд харилцан тусалж, хамтран ажиллана.”

“11 дүгээр зүйл.Малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах

11.1.Анхдагч холбоо нь малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

11.1.1.малын чанар, ашиг шимийг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

11.1.2.тухайн бүс нутгийн онцлогт дасан зохицсон, баталгаажсан үүлдэр, омгийн малыг үржилд ашиглах, үржлийн мал бойжуулах, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг технологит хугацаанд хэрэгжүүлэх;

11.1.3.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг бүртгэх;

11.1.4.мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх арга хэмжээнд малаа товлосон хугацаанд бүрэн хамруулах, эрүүл мэндийн бүртгэлийн дэвтрийг тогтмол хөтлөх;

11.1.5.малын индексжүүлсэн даатгалд хамруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	17
Бүгд:	48

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “хийж, чанар, гарал үүслийг хянан баталгаажуулах” гэснийг “хийх, боловсруулалтын түвшинг

нэмэгдүүлэх,” гэж өөрчилж, мөн заалтын “мал,” гэснийг хасаж, 12.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2.стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, борлуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 20

Бүгд: 48

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан,Төслийн 13, 14, 19 дүгээр зүйлийг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулж 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл.Анхдагч холбооны удирдлага, зохион байгуулалт

131.Анхдагч холбооны эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал, түүний чөлөөт цагт Тэргүүлэгчид байна.

13.2.Анхдагч холбоо нь таваас дээшгүй Тэргүүлэгчтэй байх бөгөөд тэдгээрийг хоёр жил тутамд бүх гишүүдийн хурлаас сонгоно.

13.3.Анхдагч холбооны бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах Ахлагчтай байна.

13.4.Ахлагч нь сумын малчин өрхийн холбоонд болон бусад этгээдийн өмнө Анхдагч холбоог төлөөлнө.

13.5.Анхдагч холбооны Тэргүүлэгчдийн шийдвэрээр Ахлагчийн эрх, үүргийг аль нэг Тэргүүлэгчид түр шилжүүлж болно.

13.6.Анхдагч холбооны Тэргүүлэгчдийн энэ хуульд зааснаас бусад эрх, үүргийг тухайн холбооны онцлогт тохируулан дүрмээр тодорхойлно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 17

Бүгд: 48

64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын “гишүүн малчин өрх гэрээт бэлчээрийн газрыг ашиглах” гэснийг “бэлчээрийг гэрээгээр ашиглах хүсэлтийг сумын Засаг даргад гаргах, бэлчээрийг” гэж өөрчилж, 15.2, 15.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Гэрээгээр ашиглаж байгаагаас бусад бэлчээрийг ашиглах, отор нүүдэл хийх асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн хүсэлтээ сумын Засаг даргад гаргана.

16.3.Шинээр өрх тусгаарласан болон шилжиж ирсэн малчин өрхийг Анхдагч холбоонд элсүүлэх шийдвэрийг бэлчээрийн даацад тохируулан сумын Засаг даргын

саналыг үндэслэн бүх гишүүдийн хурал шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 16
Бүгд: 48
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “холбооны” гэсний өмнө “малчин өрх Анхдагч” гэж нэмж, 16.2 дахь хэсгийн “этгээдийн” гэснийг “малчин өрхийн” гэж өөрчилж, 16.6 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 16
Бүгд: 48
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 18 дугаар зүйлд шилжүүлж, 17 дугаар зүйлийг хасах:

“18.2.Бүх гишүүдийн Хурлын тов, хэлэлцэх асуудлыг Ахлагчийн саналыг үндэслэн Тэргүүлэгчид тогтоох бөгөөд дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлын зарыг хурал болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргэнэ.

18.3.Анхдагч холбооны нийт гишүүдийн гуравны нэгээс дээш хувийн саналаар бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 20
Бүгд: 49
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.6, 18.7 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.5, 18.8 дахь хэсгийг тус тус хасах:

“18.7.Бүх гишүүдийн хурлын тэмдэглэлийг хөтлөх бөгөөд тэмдэглэлд хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 18
Бүгд: 49
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “хуульд заасан журмын дагуу гаргаж,” гэж нэмж, 20.3.1 дэх заалтын “холбооны өдөр тутмын” гэснийг “Анхдагч холбоо болон Тэргүүлэгчдийн” гэж өөрчилж, 20.3.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 18
Бүгд: 49
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “**БОЛОН УЛСЫН**” гэснийг “**МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБОО,**” гэж өөрчилж, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 18
Бүгд: 49
63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “удирдлагад” гэснийг “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад” гэж, 23.1.3 дахь заалтын “гишүүдийн” гэснийг “стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 20
Бүгд: 49
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 22
Бүгд: 49
55.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 23
Бүгд: 50
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Нэгдсэн” гэснийг “Малчин өрхийн” гэж, мөн хэсгийн “бүх” гэснийг “зохиx” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 23
Бүгд: 50
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “өвс тэжээлийг хөнгөлөлтэй үнээр олгох болон бусад” гэснийг “төрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 23
Бүгд: 50
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.5 дахь хэсгийг хасах:

“32.1.Холбоо нь хууль, дүрэмд заасны дагуу үйл ажиллагаа, санхүүжилт, түүний зарцуулалтыг гишүүддээ тайлагнана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 19
Бүгд: 50
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 17
Бүгд: 50
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “МАЛЧИН ӨРХИЙН” гэсний дараа “НЭГДСЭН” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 17
Бүгд: 50
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 19
Бүгд: 50
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль,” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 28
Бүгд: 50
44.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.3.1.бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

19.3.2.бэлчээрийн даац тогтоох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 19
Бүгд: 50
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.1.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмж, 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 4 дэх заалт болгох:

“3/20 дугаар зүйлийн 20.2.10, 20.2.11 дэх заалт:

20.2.10.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас отрын бэлчээр, бусад аймаг, сумын бэлчээрт түр хугацаагаар мал оруулах, гаргах асуудлыг холбогдох аймаг, сумын Засаг даргатай хамтран шийдвэрлэх;

20.2.11.энэ хуулийн 20.2.10-т заасны дагуу шийдвэрлээгүй бол уг асуудлыг дээд шатны Засаг дарга, Засгийн газар шийдвэрлэх.”

“4/21 дүгээр зүйлийн 21.4.4, 21.4.5, 21.4.6, 21.4.7 дахь заалт:

21.4.4.бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээ байгуулах;

21.4.5.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед тухайн сумын малчдад бэлчээрийн даацад тохируулан түр хугацаагаар ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;

21.4.6.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас бусад аймаг, сумын малыг отрын бэлчээр болон бусад бэлчээрт түр хугацаагаар оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх;

21.4.7.өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зун, намрын улиралд малаас чөлөөлөх хугацааг тогтоож, мөрдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 24

Бүгд: 50

52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 23.4.7 дахь заалтын “бэлчээрийн даацыг” гэсний дараа “хөдөө, аж ахуйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан аргачлалын дагуу” гэж нэмж, мөн заалтын 23.4.9 дэх заалтын “бэлчээр ашиглалтын” гэснийг “уг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 24

Бүгд: 50

52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 24

Бүгд: 50

52.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн зориулалтаар ашиглуулах газрын зааг, байршлын талаар шийдвэр гаргах,” гэснийг “гэрээгээр ашиглах бэлчээрийн зааг, байршлын талаар Малчин өрхийн анхдагч холбооноос гарсан саналыг хэлэлцэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 34
Бүгд: 49
30.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “бэлчээрийн газрыг” гэснийг “бэлчээрийг” гэж, “гэрээний” гэснийг “гэрээ байгуулах,” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 29
Бүгд: 50
42.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх зарчмын зөрүүтэй саналуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Гурав.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “ажлыг зохион байгуулах” гэснийг “малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх эдийн засгийн хөшүүрэг нэвтрүүлэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 28
Бүгд: 50
44.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дөрөв.Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 29
Бүгд: 50
42.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 53 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Чинзориг, Н.Энхболд нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Г.Ганболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 12 цаг 34 минутаас хуралдааныг даргалав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 19

Бүгд: 39

51.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, мөн хэлтсийн шинжээч Л.Пүрэвсүрэн, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин, мөн танхимын гүйцэтгэх захирал Т.Дүүрэн, Бодлого, стратегийн газрын дарга Ж.Оюунчимэг, мөн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын дарга С.Энхцэцэг, мөн арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга М.Шинэбаяр, Улаанбаатар хотын Худалдааны танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ, Өмгөөллийн “Хэруга Партнерс” хуулийн фирмийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч Л.Загдаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Г.Амартүвшин, О.Цогтгэрэл, Н.Учрал, Ц.Мөнхцэцэг, Ж.Батжаргал, Г.Ганболд, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин, Өмгөөллийн “Хэруга Партнерс” хуулийн фирмийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч Л.Загдаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 13 цаг 19 минутаас 13 цаг 24 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Г.Амартүвшин нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг танилцуулав./14:00-14:02/

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар хийх Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, мэдээллийг хойшлуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

55.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамишуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Баярсайхан, Д.Сарангэрэл нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу гишүүний саналыг “дэмжсэн”-ээр авсан болно.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг, Б.Ундрах, А.Насандэлгэр, Шүүхийн сахилгын хорооны гишүүн С.Энхтөр, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, мөн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, мөн танхимын шүүгч Б.Батцэрэн, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, мөн танхимын шүүгч Н.Баярмаа, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Н.Энхболд нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны гишүүн С.Энхтөр нар хариулж, тайлбар хийв.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7, 8, 13, 14 дэх заалт болгох:

7	Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Орхон аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 22
Бүгд: 41
46.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 22, 23 дахь заалтын “тойргийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн Нэг, Хоёр дахь хэсгийн 3 дахь заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Налайх дүүрэг ” гэж, Нэг, Хоёр дахь хэсгийн 4 дэх заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Багануур дүүрэг” гэж, мөн зүйлийн Гурав, Дөрөв дэх хэсгийн “Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хэрэг маргааныг” гэснийг “эрүү, иргэний хэрэг, маргаан, эрүүгийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэрэг, маргааныг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “20... оны дүгээр/дугаар сарын ...-ны өдрийн дотор” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсэгт заасан анхан болон давж заалдах шатны шүүхэд шүүгчийг томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн

зүйлийн Гурав, Зургаа дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан бол” гэснийг “тухайн шүүхэд дөрвөөс доошгүй жил ажилласан шүүгчийг албан ажлын зайлшгүй шаардлагаар” гэж өөрчлөх гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл хуралдаан даргалагчаас өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Г.Амартүвшин нар үг хэлэв.

Г.Занданшатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “Улсын дээд шүүхтэй зөвшилцөж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “89 дүгээр зүйлийн” гэсний дараа “89.1 дэх хэсгийн “, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан” гэснийг,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 28
Бүгд: 40
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь хэсэг нэмсүгэй:

13.Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагаа, Арван долдугаар бүлэгт заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийг нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх хянан шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн ““АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ” гэсний дараа “НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “шүүхийн” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” гэснийг мөн зүйлийн “31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 19

Бүгд: 40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “нэмэлт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 21

Бүгд: 40

47.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх:

“3/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн зориулалтын шаардлага хангасан шүүхийн байраар хангах хүртэлх хугацаанд нийслэл дэх зарим шүүхийг байраар хангаж, шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/Нийслэлд гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны тойргийн шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн давж заалдах шатны шүүхийг тойргоор байгуулах асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

7.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан прокурорын байгууллагын орон тоо, төсөвт өөрчлөлт орох эсэхийг судлан үзэж, шаардлагатай бол саналаа боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэхийг Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайханд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх” гэснийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Д.Ганбат, М.Оюунчимэг, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Рэнцэнбазар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Т.Мөнхцэцэг, Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Үйлдвэржилт, дэд бүтцийн хэлтсийн дарга Ш.Маргад, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Тогтохсүрэн, Б.Баттөмөр, Ж.Батжаргал, Ц.Сандаг-Очир, Г.Тэмүүлэн, Г.Ганболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 16 цаг 33 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39

51.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, мөн газрын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга Б.Түвшинжаргал, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Захиргааны газрын дарга О.Энхбаяр, мөн компанийн Газрын тосны хайгуул, ашиглалтын газрын дарга Д.Буян-Арвижих, Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Төлөвлөлтийн инженерийн албаны дарга А.Баяржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	16
Бүгд:	39

59.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр товлосон бүх асуудлыг хэлэлцэж дуусах хүртэл хуралдааныг сунгав./17:59/

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал О.Сансархүү оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж/цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.23 дахь заалт нэмсүгэй:

38.1.23.оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	15
Бүгд:	39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.19-д” гэсний дараа “38.1.23-т” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	17
Бүгд:	39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.	

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд, мөн хэлтсийн мэргэжилтэн Н.Отгонбаяр, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын хэлтсийн дарга Э.Уламбаатар, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дарга М.Бямбасүрэн, Гаалийн ерөнхий газрын харьяа Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын гаалийн улсын байцаагч П.Болд-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Ц.Идэрбат, Б.Саранчимэг, Ц.Туваан, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “худалдааг дэмжих” гэснийг “худалдааны чөлөөт байдлыг дэмжих” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.2 дахь хэсгийг хасах:

“3.1.Энэ хууль ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас сэргийлэх, түүнтэй тэмцэх, устгахтай холбоотой үйл ажиллагаанд үйлчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“ургамал” гэж байгалийн болон таримал бүх төрлийн ургамал, түүний үр, бусад ургал эрхтнийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтай тэмцэх, ариутгах, халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээний зааврыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлан энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 20
Бүгд: 38

47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 19

Бүгд: 38

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар дээрх зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн” гэснийг “шаардлагатай тохиолдолд лабораторид хүргүүлэх, шинжилгээний дүгнэлтэд үндэслэн” гэж өөрчлөн, 7.4 дэх хэсгийн “нийтэд” гэсний өмнө “энэ хуулийн 22.1-д заасан албан тушаалтан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 18

Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйл болон 11 дүгээр зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

10.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран хөнөөлт организмын төрөл, зүйлээс хамааран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, орох, гарах хяналтын цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлийг тогтоож, анхааруулсан тэмдэг байршуулна.

10.2.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тухайн шатны Засаг дарга дараах арга хэмжээг зохион байгуулна:

10.2.1.хорио цээртэй хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтыг тогтоох, хязгаарлах, устгах;

10.2.2.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, орох, гарах хяналтын цэг, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн байгууламжид хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналтын доор мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалыг хийлгэх;

10.2.3.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах.

10.3.Хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах зардлыг энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан тухайн шатны Засаг дарга, 9.1.3-д зааснаар хорио цээр тогтоох тохиолдолд Засгийн газар тус тус шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэснийг “хийхэд холбогдох стандартыг баримтална” гэж өөрчилж, 14.3 дахь хэсгийг хасаж, тайлбарыг 15.4 дэх хэсэгт шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “газар нутагт” гэсний өмнө “, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийн “төрийн бус байгууллага” гэсний дараа “, хуулийн этгээд” гэж нэмж, 19.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19.6, 19.7 дахь хэсэг болгох:

“19.6.Пестицидийг турших, бүртгэх, ашиглах, импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдахтай холбогдсон харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулна.

19.7.Пестицидийн хаягдал болон сав, баглаа боодлыг эгүүлэн татах, устгахтай холбогдсон харилцааг Хог хаягдлын тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9.7 дахь заалт нэмж, 19.9.4, 19.9.5 дахь заалтын “байгаль орчны” гэсний дараа “нөлөөллийн” гэж тус тус нэмэх:

“19.9.7.ургамал хамгаалал, хорио цээрийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшсэн агрономичтой болохыг нотлох дипломын хуулбар, нийгмийн даатгалын лавлагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9.7 дахь заалт нэмж, 19.9.4, 19.9.5 дахь заалтын “байгаль орчны” гэсний дараа “нөлөөллийн” гэж тус тус нэмэх:

“19.9.7.ургамал хамгаалал, хорио цээрийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшсэн агрономичтой болохыг нотлох дипломын хуулбар, нийгмийн даатгалын лавлагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17

Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 21.1.2 дахь заалт нэмж, төслийн 21.1.2 дахь заалтыг 22.2.11 дэх заалт болгон шилжүүлэх:

“21.1.2.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, ургамал хамгааллын салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмж, 22.3 дахь хэсгийн “бүртгэхтэй холбогдсон” гэсний өмнө “эрх олгох,” гэж нэмэх:

“22.2.7.хөнөөлт организмын эрсдэлийн шинжилгээ хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.2.9 дэх заалтын “бүтээгдэхүүн, зохицуулалттай бусад эд, материалд” гэснийг “бүтээгдэхүүнд” гэж, 22.2.10 дахь заалтын “мэргэжлийн багийн” гэснийг “эрх бүхий албан тушаалтны” гэж, “зохицуулалттай эд, материалыг” гэснийг “ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг” гэж өөрчилж, 22.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.8.хорио цээртэй хөнөөлт организмгүй, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн газар нутгийг энэ хуулийн 16.2-т заасан журмын дагуу тогтоох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн гарчгийн “Иргэн, хуулийн этгээдийн” гэснийг “Хүн, хуулийн этгээдийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйл нэмэх:

“25 дугаар зүйл.Эрдэм шинжилгээний байгууллагын бүрэн эрх

25.1.Эрдэм шинжилгээний байгууллага нь ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалт, олшролт, хөнөөлийн талаар тандан судалгаа, туршилт, зохион бүтээх ажил хийх, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт гаргах;

25.1.2.ургамал хамгааллын бүтээгдэхүүний хор аюулын шинж чанар, түүний ургамал, ус, хөрсөн дэх үлдэгдлийг тодорхойлох;

25.1.3.энэ хуулийн 18.1-д заасан ургамал хамгаалах цогц аргыг хэрэгжүүлэх болон ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг турших, ашиглах, импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдах талаар зөвлөмж боловсруулах;

25.1.4.ургамлын хөнөөлт организмаас хамгаалах стандарт, технологийн заавар боловсруулах, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хүн, хуулийн этгээдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх.

25.1.5.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын сургалтыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 18

Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “тархахаас сэргийлэх” гэсний өмнө “тохиолдолд” гэж, 8.1.1 дэх заалтын “зоорь, агуулахад” гэсний өмнө “үтрэм, ил талбай,” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн” гэсний өмнө “хүнс,” гэж, 18 дугаар зүйлийн 18.3.2 дахь заалтын “бэлчээр,” гэсний дараа “хадлангийн болон ойн сан бүхий газар,” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “тооцоонд” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “ил ялгаварлах” гэснийг “үл ялгаварлах” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “тухайн нутаг дэвсгэрийн” гэснийг “тухайн шатны” гэж, 8.3 дахь хэсгийн “холбогдох” гэснийг “шаардлагатай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “үед” гэснийг “тохиолдолд” гэж, “хорио цээрийн дэглэмийг” гэснийг “хорио цээрийг” гэж, 9.2 дахь хэсгийн “мөрдөнө” гэснийг “баримтална” гэж, 9.4 дэх хэсгийн “Холбогдох шатны” гэснийг “Бүх шатны” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “хөнөөлт организмын голомтыг устгах үйл ажиллагааг” гэснийг “устгалыг хөнөөлт организмын” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хяналтын байгууллага” гэснийг “хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэж, 22 дугаар зүйлийн 22.2.6 дахь заалтын

“мэдээллийн санд” гэснийг “мэдээллийн сангийн дэд сан болох” гэж, “дэд санг бий болгож” гэснийг “цахим санг бүрдүүлж” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бий болгож” гэснийг “бүрдүүлж” гэж, “хангаж ажиллана” гэснийг “хангана” гэж, 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх заалтын “байгуулах” гэснийг “бүрдүүлэх” гэж, 27.5 дахь хэсгийн “эрүүл мэндийг хамгаалах” гэснийг “эрүүл мэнд, ургамал хамгааллын” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “боловсруулсан” гэснийг, 4.1.9 дэх заалтын “бусад” гэснийг, 4.1.10 дахь заалтын “хүн,” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “химийн” гэснийг, 5.1.5 дахь заалтын “түүхий эд,” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “нутаг дэвсгэрийн дотор” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “хөнөөлт организмын тархалт” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “шинжид зориулсан болон тухайн хөнөөлт организмын” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.9.5 дахь заалтын “тайлангийн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмэн 2 дугаар зүйлийн дугаарыг “3” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Ургамал хамгааллын тухай,” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай,” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмэн 2 дугаар зүйлийн дугаарыг “3” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас” гэснийг “хөнөөлт организмээс” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	17
Бүгд:	38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Тариалангийн тухай хуулийн” гэсний дараа “2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Ургамал хамгааллын тухай” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” гэж,” гэж, “хөнөөлт организм” гэсний өмнө “болон 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтын “өвчин, хортон, хог ургамал” гэснийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	20
Татгалзсан:	18
Бүгд:	38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, 1 болон 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1.24 дэх заалт:

“20.1.24.ургамлын зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээ.”

2/27 дугаар зүйлийн 27.5.26 дахь заалт:

“27.5.26.ургамлын хорио цээртэй хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээ;””

“2 дугаар зүйл.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.26 дахь заалтын дугаарыг “27.5.27” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “гарчгийн “Ургамал хамгааллын тухай” гэсний өмнө “Ургамлын эрүүл мэнд,” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “7.8 дахь зүйлийн” гэсний дараа “гарчгийн “Ургамал хамгааллын тухай” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” гэж,” гэж, “мөн зүйлийн 4 дэх хэсгийн” гэсний дараа “болон 13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтын” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 1 болон 3 дугаар зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.65 дахь заалт нэмсүгэй:

“6.65.таримал ургамлын үр, сортын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 10.27, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.””

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.48 дахь заалтын “13.2 дугаар зүйл,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 1 болон 3 дугаар зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.65 дахь заалт нэмсүгэй:

“6.65.таримал ургамлын үр, сортын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 10.27, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.””

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.48 дахь заалтын “13.2 дугаар зүйл,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.15 дугаар зүйлийн 1” гэснийг “6.15 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь заалт” гэж өөрчилж, “6.13 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэснийг, “6.14 дүгээр зүйлийн” гэсний дараах “2,” гэснийг, “6.15 дугаар зүйлийн” гэсний дараах “6” болон “9” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“5.5.Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн түвшинг харгалзан импортын мэдэгдэл олгох амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3, 4, 5 дугаар зүйл нэмж, 2 дугаар зүйлийн дугаарыг “6” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Генетик нөөцийн тухай,” гэсний дараа “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.8.мал, амьтны гоц халдварт өвчин /цаашид “амьтны гоц халдварт өвчин” гэх/, ургамлын хорио цээртэй хөнөөлт организм /цаашид “ургамлын хорио цээртэй зүйл” гэх/ илэрсэн тохиолдолд тухайн хилийн боомт, гүний гаальд хорио цээр тогтоох саналыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран Засгийн газарт оруулах, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг хянах;”

4 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг болон 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “гадаад хорио цээртэй өвчний халдвар, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хорио цээртэй хөнөөлт организм” гэж, мөн заалтын “эрүүл мэндийн” гэснийг “эрүүл мэнд, ургамал хамгааллын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хөнөөлт организм” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны”

гэж, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын “байгууллага” гэсний өмнөх “хорио цээрийн” гэснийг “эрх бүхий” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 8 гишүүн 2024.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн Г.Нарантуяа, Б.Энхболд, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

1.Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:58/

2.Хүүхэд хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан

асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:58/

3.Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:58/

4.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:58/

5.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:58/

6.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:59/

7.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:59/

8.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:59/

9.Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:59/

10.Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:59/

11.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:59/

12.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:00/

13.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:00/

14.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:00/

15.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:00/

16.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:00/

17.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:00/

18.“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:01/

19.Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:01/

20.Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:01/

21.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:01/

22.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:01/

23.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:01/

24.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:02/

25.Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./19:02/

26.“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:02/

27.“Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:02/

28.“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:02/

29.“Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./19:03/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих боломжгүй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 32

Бүгд: 37

13.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 14 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 51 минут үргэлжилж, 72 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 79.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
10 цаг 19 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданишатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 16 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. 2 дугаарт малчин, 2 дугаарт эм, дэг гээд яриад байх юм бол болино шүү, яг эм, эмнэлэг ингээд эхлэх гэж байсан чинь 2 дугаарт Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явна. 3 дугаарт Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. 4 дүгээрт Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 4 дүгээрт Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд 5. 6 дугаарт Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 6 дугаарт. 7 дугаарт Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 8 дугаарт Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 9-д Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн, 9 дүгээрт Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, 10-т Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль нэмэлт, 10-т Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүд, 11-д Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 12-т Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл. Энийг жооохон урагшаа оруулахгүй бол хугацаатай юм. Сая төсөв хэлэлцчихсэн болбол, төсөв хэлэлцээгүй гээд хойшоо тавьчихсан байна. Энийг 7, 8 руу оруулчихъя. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээлэл төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, Авлига хүнд суртлыг бууруулах Шил ажиллагааны хэрэгжилтийн талаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Өнөөдөр хэлэлцэх асуудалтай холбогдуулж Монгол Улсын Их Хурлын гишүүн Болорчулуун нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байгаа тул зөвшөөрөл олгоно уу гэсэн үг бичиг ирүүлсэн байна. Болорчулуун Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа. Бас би нэг компанийн талаар бас нэг бишигүй ярьсан, тэмцсэн, бас сонгуульд ойртож байгаад нэг ярихаа азнаад байсан юм. Энэ болбол Монголд бүртгэлтэй Оюу

толгой гэж нэг даварсан компани байна. Монгол Улсын баялгийг цөлмөж байгаа нэг ёсны дээрэмдэж байгаа, борлуулсан алт, зэсийнх нь үнэ Монгол улсаар Монголынбанкаар дамжих ч үгүй, эцэс сүүлдээ Монголын баялаг болсон тэр ажилчдад нь хүртэл цалин өгөхөөс, олигтойхон өгөхөөс татгалздаг ийм компани байна. Оюу толгойн ил уурхайн ажилчид ажлаа түр зогсоогоод ажил хаяад 2, 3 хонож байна. Далд уурхайнх ч зарим нь хаясан гэж байна. Яагаад гэвэл Монголчуудын цалинг илүү цагийн нэмэгдэл, шөнийн нэмэгдэл тэр болгоныг бүүр хассан гэж байна. Үндсэндээ цалин нь болбол 40-өөс 50 хувь буурч байна гэж байна.

Оюу толгой болбол бүх юм олон улсын стандартын дагуу ажиллаж байгаа нэг онцлог нь. Ганцхан цалин олон улсын стандартын дагуу биш. Гадаад ажиллагсдын цалин Монгол ажиллагсдын цалин бол тэнгэр газар шиг зөрөөтэй байна, 8-аас 10 дахин зөрөөтэй, яг ижилхэн ажил хийгээд, ижилхэн үүрэг гүйцэтгэж байгаа Монгол, гадаад ажилчдын ялгаа ийм эрс ялгаатай. Баялгийг нь цөлмөхөөсөө гадна ажиллагсад Монгол хүний үнэлэмжийг ингэж доогуур үзэж байна. Оюу толгой 21 онд бид нар яах вэ энэ Даваасүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг түр хороо байгуулагдсан, ингээд тэмцсэн ажилласан. Рио Тинтотой болбол Монголын 34 хувьд оногдох 2,3 миллиард долларыг бас цайрууллаа гэдгээ бол мэдэгдсэн. Дубайн гэрээг цуцаллаа гэсэн. Гэтэл өнөөдөр Дубайн гэрээ нь үргэлжлээд явж байна шүү дээ. 21 оны эцэст 12, 3 миллиард долларын өртэй байсан. Өнөөдөр 17 миллиард доллар гарчихсан байна. Оны эцэст 19 миллиард доллар хүрэх нь байна.

Монгол Улсыг хэзээ ч ашиг авахааргүй ийм байдалд хүргэж байна. Тогтохсүрэн дарга та битгий хэл, та нар бас жижигхэн сэдэв бариад ингээд улс төржихөөсөө илүү энэ том эрх ашгийнхаа төлөө ярь л даа. Энэ чинь 6

Эрдэнэттэй тэнцүү том орд шүү дээ. Бид 7 Эрдэнэттэй бол хэнээс юу гуйх юм бэ? Монгол Улс өртэй байх уу, 33 миллиард долларын өртэй байх уу? Монголын ард иргэд өртэй байх уу? Тэгээд энэ ер нь энэ Оюу толгой гэж компани болбол хөрөнгө оруулагч биш, мөнгө хүүлэгч, зээл зуучлагч болчихсон байна. Өнөөдөр лебор дээр нэмэх нь 6,5 гэсэн гэрээтэй. Дээр нь тэр соперын 5,5-ыг нэмээд 12 хувиар 11-ээс 12 хувиар хүүжиж байна шүү дээ. Ийм болохоор ямар ч ашиг гаргахгүй байна. Энэ дээр бол цаашидаа болбол бид нар энийг зогсоох ёстой энэ байдлыг. Би тэр Оюу толгойн ТУЗ-д байгаа тэр гадаадад сургууль төгссөн тэр Баясгалан, Тана гээд л эмэгтэйчүүд байгаа, Цэрэнбат байгаа. Эд нар болбол юу хийж байгаа юм бэ? Би тэр Баясгаланг болбол яриад энэ Оюу толгойн хамгийн сүүлийн үеийн өрийн мэдээллийг өгөөдөх гэхэд одоо хүртэл таг байна.

Ялангуяа энэ Оюу толгойн дээр Өмнөд Африкийн уурхайд ажиллаж байсан Өмнөд Африкийн иргэд иргэн ийм захирлууд дандаа ажилладаг гэж байна. Тэд болбол хүний хөдөлмөрийг шулахдаа бол гаргуун болсон байх л даа. Бетри гээд ОТ-н захирал нь, Милиза гээд хүний нөөцийн менежер гээд бүгд Өмнөд Африкийн хүмүүс гэж байна. Тэгэхээр Монгол хүний үнэлэмжийг байхгүй болгож байна, цалинг нь хасаж байна. Энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ямар юм хэлэх вэ?

Үйлдвэрчний эвлэл нь болбол 10 гаруй жил болсон, 15 жил болсон үйлдвэрчний эвлэл. Нөгөөдүүлийнх нь менежер гэсэн нэрээр цалинг нь нууцлалын зэрэгтэй нэмэгдүүлчихдэг гэж байна. Ингээд нөгөөдөх нь ажилчдынхаа эрх ашгийг хамгаалж чадахгүй, шинэ үйлдвэрчний эвлэл байгуулсан гэж байна. Ер нь цалин хөлсийг өсгөж, бууруулахдаа болбол 3 талт хэлэлцээрээр ажилчин, үйлдвэрчний эвлэл байгууллага, компани ингээд гуравласан байдлаар тохирох

ёстой байтал 1 талын, 2 талын байдлаар цалинг нь эрс багасгаж байгаа явдлыг бол ингээд Монгол ажилчид эсэргүүцэж байгаа шүү.

Г.Занданишатар: Зөвхөн Оюу толгой ч энэ ашигт малтмалтай холбоотой асуудлаар гишүүдээс олон бичиг хүсэлт ирсэн байгаа. Тэгээд энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэлэлцэх анхны хэлэлцүүлэг үргэлжилж байгаа учраас энэ хэлэлцүүлгийн дараа ашигт малтмалтай холбоотой асуудлаар бас жич хууль санаачилсан тухай танилцуулна. Дэгийн тухай хуулийн дагуу санаачилсан хуулийг танилцуулах ёстой. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явагдаж байгаа. Зарчмын зөрүүтэй саналын 35 дахь саналаар санал хураалт явуулна. Ажлын хэсэг, Засгийн газрын гишүүд саналаа нэгтгэж ойлголцсон гэж ойлгож байгаа тийм үү? Ингээд ойлголцохгүй болбол зогсооно шүү шууд. Ойлголцсон гэж үзлээ. Ийм учраас.

35.Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

“60 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт, 60.1. 36-г хураасан юм байна. 35 дээр унаад энийг эргэж санал хураахгүй зогссон байна. Шилжилтийн үеийн 60 дугаар зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт.

60.1.Энэ хуулийн 8.1.2, 15.3.2-т заасан стандартыг дотоодын уламжлалт эмийн үйлдвэр 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ хууль зүйн техникийн хувьд Дагаж мөрдөх журмын тухай хууль дээрээ тусгагдахгүй юу? Хууль дотор ингэж, 60.2.Энэ хуулийн 16.14 дэх хэсэгт заасныг үйлдвэрлэх-экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч дотоодын үйлдвэрлэгч 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлнэ.

60.3.Энэ хуулийн 16.10 дахь хэсэгт заасан өнчин эмийн бүртгэлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хийнэ.

60.4.Энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө.” Найруулгын хувьд эмийн бүртгэлийг хийнэ гэж агуулгаар биш эмийн бүртгэлийн заалтыг тэдний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж найруулна шүү. Энэ бол Дагаж мөрдөх журмын тухай хууль юм байгаа биз дээ. Ингээд санал хураалт явуулна. Дэлгэрсайхан сайд байж бай, би энэчээнээс аваад ирсэн. Санал хураалт. 29 гишүүн дэмжиж, 72,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36 дугаар саналыг бол хураачихсан байна. 50 хувь болоод, Идэрбат гишүүн горимын санал гаргаад 55,3 хувиар дахин санал хураалтаар дэмжигдсэн. Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулна. 1.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн холбогдох баримт бичиг түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг. Энийг хойшлуулсан, энийг хойшлуулаад гүйцээн боловсруулах чиглэл авсан учраас ингээд хойшлуулсан байна.

Дараагийнх нь 2 Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Нэг эх үүсвэрээс худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгохдоо дараах зарчмыг баримтална:

47.1.1.эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг, эсхүл эмийн зардалд өндөр хувь эзэлж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.2.тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай, тасалдал үүсэх өндөр эрсдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл;

47.1.3.Төрөөс төлбөрийг нь хариуцах удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний эм.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн. Энэ ойлголцсон учраас энийг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

3.Төслийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийн “сонгон шалгаруулж,” гэснийг хасаж, “байгууллагыг” гэснийг “байгууллага” гэж, “байгууллага” гэснийг “байгууллагатай” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Бид чухал хууль хэлэлцэж байгаа. Энэ дотор бол 47 дугаар зүйлийн 47.5-ыг та бүхэн анхаараарай, анхаарна уу. Энэ дээр сонгон шалгаруулж гэдэг үг ороод байгаа юм. Тэгээд одоо ерөөсөө л бид нарын энэ сонгон шалгаруулдаг үйл ажиллагааны ард дандаа авлигал, танил тал, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил нуугдаж байдаг. Тийм учраас тээвэрлэх, хадгалах, түгээх эрхийг нь өгчихсөн хувийн хэвилийнхнээр дамжуулан эм түгээхдээ тэр шаардлагыг хангасан бол хэдэн компани ч оролцсон тэр квотыг нь өгөөд

борлуулдаг байх энэ тогтолцоог бид дэмжих ёстой.

Тийм учраас би бол энэ дээр зөвхөн сонгон шалгаруулах гэдэг үгийг нь авчих. Тэгээд л тэр шаардлагыг нь хангасан байгууллагууд нь түгээгээд тараагаад байж болох юм. Ер нь бол энэ хувийн хэвилийг хааж боох Монгол төрийн бодлого гэж байхгүй. Түр хороо бол бид монопол тогтолцоог задлах энэ үйл ажиллагааг эхлүүлсэн. Үгсэн хуйвалдаг үнэ хөөрөгдүүлдэг Монгол системийг устгаж, хувийн хэвилийг хааж боох бодлого бид явуулах гээгүй шүү. Харин хувийн хэвилийнхнийг шударга өрсөлддөг, замбараагүй, хязгааргүй үнэ нэмдэг тогтолцоог байхгүй болгох, төр чанарыг нь хянаж чаддаг ийм тогтолцоог л бид хүсээд байгаа. Түр хорооны ажлын гол зорилго бол энэ. Тийм учраас би бас түрүүн Хасуурын Ганхуяг гишүүн ч бас хэлээд байгаа. Энэ Зөрчлийн хууль дээр баахан зөвшөөрөл гэж яриад байгаа.

Их Хурлын дарга та ч гэсэн бас өчигдрийн хуралдаан дээр хэлсэн. Энэ баахан зөвшөөрөл чинь ард нь юу байгаа юм бэ? Нөгөө хялбаршуулах ажил чинь хаана байгаа юм бэ? Жишээлбэл онлайн системээр цахимаар эмийн зөвшөөрөлтэй компанийг 500 саяас 1 тэрбум төгрөгөөр зарна гээд явж байна шүү дээ. Тэгэхээр дандаа тусгай зөвшөөрөл авдаг. Энэ хясан боогдуулдаг бодлого нь өөрөө бюрократ системээрээ дамжуулан үнэ хүргэдэг. Авлигын тогтолцоог дэмждэг ийм буруу зүйл байгаад байгаа. Тийм учраас би эрхэм гишүүдийг дэмжихгүйгээр санал хураалгаад, зүгээр энэ сонгон шалгаруулалт гэдэг үгийг нь л авах гэж байгаа юм шүү. Сонгон шалгаруулалт хэрэггүй, шаардлага хангасан, энэ чинь түгээх, хадгалах тусгай зөвшөөрлийг нь өгч байгаа компаниудыг шалгаруулна шүү дээ. Түүнээс дурын компанийг май, май та тараа гэхгүй. Тийм, тийм учраас та бүхэн энэ дээр анхаарч дэмжиж өгөөрэй гэж хүсье.

Г.Занданишатар: Санал хураалт явуулъя, шуурхай явуулъя гэсэн шүү дээ. Тэгээд энэ чинь дэмжээгүй Байнгын хороо дэмжээгүй санал юм байна шүү дээ. Үг хэлэх тусам энэ чинь харин босоод ирж магадгүй шүү. Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд бүгдээрээ анхааралтай. Дэмжих, дэмжсэн санал өгцгөөнө шүү гэж байна. Байнгын хорооны санал байна. Ингээд Чинбүрэн гишүүний санал дэмжигдлээ.

Гурав.Нийгмийн бодлогын, энэ эцсийн хэлэлцүүлэг дээрээ та хэд сайн яриарай. Ингээд мэтгэлцээн үргэлжлэх болбол хуулийг хойшлууллаа. Хойшлууллаа. Энэ асуудлынхаа учрыг олж байж. Энэ асуудал босчихсон. Ингээд дараагийн асуудалдаа орно. Би та нарт хууль эхлэхэд нь анхааруулсан. Та нарыг би ойлголцож байж орж ирээрэй гэсэн, тэгээд одоо ингээд ойлголцоогүй юм байна. Та хэд чинь ойлголцчихлоо гээд та 2 чинь гар бариад орж ирсэн шүү дээ. Одоо 8 санал энэ бүр удаан юм байна. Өнөөдөр 16 асуудалтай, өнөөдөр сунаж хуралдана шүү. Өнөөдөр 12 цаг хүртэл хуралдаж байж дуусгахаар болж байна. Ийм байдлаар ингээд сунжраад байх юм бол хэлэлцэхгүй шүү. Энийгээ Байнгын хороон дээрээ ахиж хэлэлц, сайн хэлэлцээрэй.

Цааш, гурав.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя. 1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.40 дэх заалтын, ингээд хурал цаашаа явуулах боломжгүй болбол би сүүлчийн удаа анхаарууллаа шүү. Уншсан юм ч сонсогдохгүй байна. Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.40 дэх заалтын “бусад” гэсний дараа “хэлбэрийн” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1.2 дахь заалтын “хүний нөөц,” гэсний дараа “иргэдийн” гэж, 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсгийн

“байгууллагад” гэсний дараа “улирал” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “гурван” гэснийг “хоёр” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтын “бүртгэлд бүртгэх” гэснийг “бүртгэл” гэж, 33.2.2 дахь заалтын “жагсаалтад оруулах” гэснийг “жагсаалт” гэж, 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтын, 46 дугаар зүйлийн 46.14.4 дэх заалтын “хадгалсан, ашигласан,” гэснийг “жилийн хугацаа өнгөрсөн” гэж, 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалтын “зах зээлд гаргах зөвшөөрөлтэй” гэснийг “бүртгэлтэй” гэж, 46 дугаар зүйлийн 46.10.11 дэх заалтын “өндөргүй, бодит” гэснийг “доогуур” гэж, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.4 дэх заалтын, 47.4, 47.5, 47.6 дахь хэсгийн “жижиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, 51 дүгээр зүйлийн 51.6 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсгийн “, 34.4-т” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.1.4 дэх заалтын “байгууллагын” гэснийг, 40.1.6 дахь заалтын “байгууллагад” гэснийг, 54 дүгээр зүйлийн гарчгийн “нийгэмлэг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Одонтуяа гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн. Энэ найруулгын санал шүү дээ. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ.

С.Одонтуяа: Тэгэхээр сая нөгөө Төсвийн байнгын хороо хуралдаад бас тэнд ирцэд хэд хэдэн хууль дэмжих гээд бас чухал ажилтай байлаа даргаа. Тэгэхээр зүгээр энд нэг зүйлийг л хэлэх гэсэн юм. Ер нь энэ хууль бол хувийн хэвшилтэйгээ дахиад л төр өрсөлдөж байгаа л хууль болж байгаа шүү гэдгийг дахин хэлье. Хувийн хэвшилүүд баяжих гээд байна, хувийн хэвшилүүд ашиг олоод байна тэд нар чинь маш их татвар төлдөг, маш их ажлын байр бий болгодог. Би үнэ буулгах гээд байгааг ойлгож байна. Тэгэхдээ үнэ буулгая гэсэн

та нарын сайхан санааны ард дарга нарын авлигал чинь дээд цэгтээ тулна, дарга нарын оруулж ирсэн эмээр өнөөдөр өрхийн эмнэлэгт үйлчилдэг болно. Дарга нарын авчирсан чанаргүй эмээр Монгол Улс чинь үйлчлүүлэх болчихоод байгаа шүү. Энийг би бас хэлчихье.

Тэгээд дэлхий дээр социализмын 2 л орон байгаа шүү дээ социалист аргаар явж байгаа. Тэгээд ерөөсөө энэ дээр Байнгын хороон дээр хэлсэн, цөөнх болсон. Тэгээд та нар энэ нэг төр нь хувийн хэвшилээ үзэн яддаг өрсөлддөг энэ чинь бүүр хэрээс хэтэрлээ шүү, энийг бол анхааруулъя. Энэ хууль дээр чинь маш их асуудал гарна шүү. Чанаргүй эм орж ирэх, авлигал чинь нөгөө бүүр дахиад дээшээгээ улам өснө шүү гэдгийг анхааруулъя. ЭМД-д хамруулж байгаа эмийг үнийг нь бас тодорхой хэмжээгээр хөнгөлөх маш олон арга байгаа шүү дээ. Дэлхийн бүх улс орнууд хэрэглээд болж байна. Заавал ингээд төр бүгдийг нь худалдан авна гэдгээр дайраад байх юм. Тэгээд энэ хууль чинь энэ зах зээлийн систем чанараасаа ухарч байгаа хууль шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Г.Занданишатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Яг энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн хуулийг яг хэлэлцэж эхэлж байхад хэн нь хэн бэ гэдэг нь яг харагдаж эхэлж байна л даа. Энэ нөгөө нэг ЭМЯ өөрөө компанийн ашиг сонирхлын төвлөрөл болчихсон, аалзны тор мэт энэ зах зээл мафижсан гэдгийг сая шинжээчид, хянан шалгагч нар бодит баримтаар гаргаад ирсэн. Өнөөдөр ингээд зарим нэг компанийн төлөөллүүд энд суучхаад ингээд аймаар ярьж байна шүү дээ. Ингэж болохгүй шүү дээ. Үнэхээр утасдаад л энэ болохгүй энийг унагаагаарай. Өмнөх парламентыг эм, эмнэлгийн хэрэгсэл ингэж унасан, одоо бас яг унагаах бодлого явж байна. Бид нар ганц үнэ буулгах тухай яриагүй, эмийн чанарыг 1 дүгээрт тавьж байна, эмийн лабораторио чанаржуулъя гэж

байна. Энийгээ төр бодлогоороо хяналтдаа аваад, харин хувийн хэвшил маань энийгээ гүйцэтгээд явъя.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эмийнхээ зах зээлийг бодлогоороо бариад чанаржуулъя. Хүнийхээ эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулж зохицуулах хуулийг нь яаралтай гаргая. Одоо бол ямар ч хууль үйлчлэхгүй байгаа. Нөгөө хуулийн хугацаа нь дуусчихсан байгаа өмнө үйлчилж байгаа хуулийн. Одоо тэгээд энийг унагаах гэж байна шүү дээ, ийм юм байж болохгүй. Энд танхим дотор эмийн аалзны тор буюу тэр цаад эздийн төлөөллүүд сууж байгаа нь харагдаад байна шүү дээ. Одоо болиоч, ард иргэдээ бод л доо. Энэ хуулийг бүгдээрээ заримыг нь буцааж хэлэлцээд, энийг заавал батлах ёстой. Ард түмэн харж байна шүү.

Сонсголын үр дүн бол энд харагдана шүү. Эм 80, 70 хувь нь тодорхойгүй, хүний эрүүл мэндэд хортой байна, чанаргүй байна, лаборатори ажиллахгүй байна. Энэ хуулийг батлах ёстой шүү гэдгийг хатуухан хэлье.

Г.Занданишатар: Энийг тасаллаа. Энэ гишүүдэд ахиж сануулъя. Энэ хэлэлцэх эсэх дээр яригддаг асуудал энэ яг тодорхой энэ саналыг дэмжсэн, дэмжээгүй л санал үг хэлнэ. Энэтэй ямар ч холбоогүй саналууд хэллээ. Ахиж санал хэлэхгүй, холбоогүй асуудал байна. Энэ найруулгын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 69,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн санал хураалт бол дууслаа.

Ингээд Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 19.3.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалтын 19.3.2-19.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.2.эм, уламжлалт эм, биобэлдмэл, тэдгээрийн түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэх-экспортлох;

19.3.3.эм, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх;

19.3.4.эм болон эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах эм худалдах;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужсин, Бадарчийн Жаргалмаа, Мөнхөөгийн Оюунчимэг, Даваажанцангийн Сарангэрэл, Жигжидсүрэнгийн Чинбүрэн цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. 76,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн” гэсний дараа “19.3.5,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай. Төслийн 1 дүгээр зүйлийн 13.9 дэх хэсгийн “Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг

хасах, санал. Энийг гүйцээн боловсруулах чиглэл. 2 дугаар зүйлийг мөн адилхан. Зөвшөөрлийн хуулийн 2, 3 дахь санал хураалт, 4 дэх санал хураалтыг, Зөвшөөрлийн тухай хуулийг бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Дөрөв.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай. Төслийн 1 дүгээр зүйлийн “эмнэлгийн жижиг хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, “эмнэлгийн жижиг хэрэгслийн” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 83 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нөлөөт эм,” гэсний дараа “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 13 дахь хэсгийн “борлуулсан бол” гэсний дараа “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж, 4 дэх хэсгийн “Зах зээлд гаргах зөвшөөрөлгүй” гэснийг “Бүртгэлгүй” гэж, 17 дахь хэсгийн “тусламжаар төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 24 дэх хэсгийн “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй эм,” гэснийг “эм, эмийн үйлчлэгч бодис,” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 4 дэх хэсгийн тайлбарын “зах зээлд гаргах зөвшөөрөлгүй,” “зах зээлд гаргах зөвшөөрөл,” “мансууруулах эм, уламжлалт эм, биобэлдмэл,” гэснийг, 10 дахь хэсгийн “лабораторийн оношилгооны хэрэгслийг Монгол Улсын

эм,” гэснийг, 24 дэх хэсгийн “зохих” гэснийг тус тус хасах. Санал гаргасан. Ажлын хэсэг санал хураалт. 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тоо бодох гэж байна. Ингээд дараагийн асуудалд орно. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

10.49 цаг

Эцсийн найруулгуудыг сонсох байгаа. Энийг дараа нь болоод, одоо Малчны хууль арай бэлэн болоогүй байна уу? Малчны хуулийн, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн материалыг тараая. Дараа нь Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг хэлэлцэнэ. Хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, өнгөрсөн 7 хоногт Улсын Их Хурлын гишүүд хөдөө орон нутагт тойрогтоо ажиллах үеэр орон нутаг, хөдөө орон нутгийн удирдлагууд, иргэдээс хөндсөн сэтгэл санаа эмзэглүүлж байгаа хамгийн том асуудал бол энэ ашигт малтмалын лицензийн олголт эмх замбараагүй байгаа, орон нутгийн саналыг авахгүй байгаа, хариуцлагагүй уул уурхайтай холбоотой асуудлууд байна. Энэ талаар бол Улсын Их Хурлын гишүүн Адъяаа, Тогтохсүрэн, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Даваасүрэн нарын гишүүд бид нар бас хууль санаачилж өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуулийг, өргөн мэдүүлсэн хуулийг зарлах ёстой, чуулганы хуралдаанд мэдэгдэх ёстой.

Ингээд энэ хуулийн төслөөр бол Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж энэ хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл авахын тулд нутгийн

иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг хийж зөвшөөрөл авсан байх. Уг зөвшөөрөл нь сонгон шалгаруулалт явуулах гол үндэслэл болох. Мөн тухайн сум, дүүргийн тухайн сум, багийн ИТХ-аас заавал зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл буюу лиценз авах хүсэлт гаргахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байхаас гадна нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг заавал хийлгэсэн байх, зөвшөөрлөө аваад үйл ажиллагаа явуулж байгаа байдал, байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр хийж байгаа ажилд нь хяналт тавих төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгож ажиллуулдаг байх зэрэг заалтыг тусгасан.

Энэ хуулийн төслийг ирэх 7 хоногийн Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан байгааг мэдэгдэж байна. Ер нь зөвхөн энэ ашигт малтмалын тусгай зөвшөөрөл буюу лицензийг нутгийн ард иргэдийн саналыг авахгүйгээр татгалзсан санал өгөөд, тахилгатай шүтлэгтэй уул, ус, булаг шанд, гол усны эх олгож болохгүй гэж орон нутгийн иргэд, ИТХ, сум, аймгийн Засаг дарга нь эсэргүүцэж татгалзсан санал өгөөд байхад түүнийг үл тоож үндсэндээ хуйвалдааны замаар зөвшөөрөл олгож байна гэж ард иргэд шүүмжилж байна. Ийм ч учраас ганцхан аймгийн жишээ дээр авч хэлэхэд манай Тогтохсүрэн гишүүн бид ажиллаж байхад Баянхонгор аймгийн жишээ дээр авахад 2023 онд Баянхонгор аймгийн 1796907,2 га талбайд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон байна. Тухайлбал Баацагаан сумын Ноён Богд ууланд 3432 га, Баянлиг, Баянговь сумын нутаг Шавар булаг гэдэг газарт 3778,2 га, Баянцагаан сумын Урт хашаатын худаг хэмээх газарт 8136,5 га талбайд сонгон шалгаруулалт хийж, хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна.

Энэ бүхнийг та бүхэн анзаарч байгаа байх. Ноён, Богд, Шаварт булаг, Хашаатын булаг худаг гэх мэтээр

нэрээсээ эхлээд уул ус, булаг худаг шандтай газрууд байгаа. Ийм говийн бүс нутагт бол говийн хөрс эмзэг. Худаг ус бол говьд чандмань эрдэнэ. Ийм учраас нутгийн иргэд энэ говийн эмзэг хөрс, байгаль экологийн орчин, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд нөлөөлж байна гэж нутгийн иргэд маш их эсэргүүцээд аймгийн Засаг дарга нь тухай бүр татгалзсан үндэслэл бүхий хариунууд өгөөд байхад сонгон шалгаруулалт зарлагдаж, тусгай зөвшөөрөл өгсөн байна. Ийм учраас энэ тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх шаардлагыг УУХҮЯ-нд өгсөн. Харин сайд нь Ганбаатар болбол бас эергээр хүлээж авч эдгээр тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгож түдгэлзсэнээ мэдэгдсэн.

Ийм учраас дээр дурдсан газруудад хайгуулын лиценз авсан Алтан шар тал, Бадарванда, Паринтес компаниудын лицензүүдийг цуцлуулах асуудлыг бас хуулийн дагуу холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлээ. Ийм байдлыг цаашид харин давтагдаж болохгүй. Ийм учраас энэ байдал бол ганцхан аймгийн жишээн дээр ийм байна. Ийм байдал бусад аймгуудад ч байгаа. Дур зоргын хууль зөрчсөн хүчээр түрүү барьсан иймэрхүү үйлдлүүдийг таслан зогсоохын Улсын Их Хурлаас Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг санаачлан хэлэлцүүлж, цаашид энэ асуудлыг цэгцлэхээр санаачилсан болохыг мэдэгдэж байна. Ингээд 27, 8-нд сонсгол хийхээр бас Эдийн засгийн байнгын хороо шийдвэр гаргасан байгаа юм байна.

Хоёр. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг

Хэлэлцэх асуудалдаа оръё. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Батжаргал нарын 38 гишүүнээс 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

БОХХАА-н байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор дээрх хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн миний бие ахалж, Улсын Их Хурлын гишүүн Анандбазар, Батжаргал, Туваан, Мөнхцэцэг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа. Тус Байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс Монгол орны байгалийн бүс бүслүүрийн онцлогийг харгалзан малчин өрхийн анхдагч холбоо 10-аас доошгүй малчин өрхийн гишүүнчлэлтэй байхаар малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх, бэлчээрийг гишүүдэд хуваарьтай ашиглуулах талаарх заалтуудыг нэгтгэн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг даацад нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх өнжсөөх, бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшинээс бууруулахгүй байхаар өөрчлөн найруулахаар, төслийн нэрийг Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай гэж, гэрээт бэлчээрийн газар гэсэн нэр томъёог гэрээгээр ашиглаж байгааг бэлчээрийн газар гэж өөрчлөхөөр.

Малчин өрхийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаанд төрийн оролцоогүй байх зарчмыг баримтлан сум, аймгийн малчин өрхийн холбоог үүсгэн байгуулах хурлыг Засаг дарга зохион байгуулах зохицуулалтыг төслөөс хасах зэрэг төслийн талаар зарчмын зөрүүтэй 25, найруулгын шинжтэй 1 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар 8 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, харин төслийн хууль, тогтоомжийн эш хэсэгт уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг нэмэх гэсэн санал олонхын дэмжлэг аваагүй болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Болорчулуун хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан. Байнгын хороо ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналыг саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж,

олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс бас хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн даргад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Бодлого судлалын төвийн тэргүүн Аюурзанын Энх-Амгалан, НЗД-ын зөвлөх, судлаач Минжигдоржийн Найданхүү нар оролцож байна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Тогтохсүрэн даргаар тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би 2 зүйл асууна. 1 дэх юм нь Байнгын хорооноос асууя Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Манай Тэмүүлэн нарын гишүүний Малчны тухай хууль, Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль гэсэн 2 хууль байгаа юм. Тэгээд энэ 2 хуулийг ер нь цаашидаа Байнгын хороо нэгтгээд нэг хууль болгох, хууль санаачлагч нартай ярилцаад нэг хууль болгох талаар ер нь ярилцаж байгаа юмнууд байна уу? Би Байнгын хороон дарга байхгүй л байх шиг байх юм. Тэгэхгүй бол нэг баахан Малчны тухай хуультай болчихсон юм шиг л юм харагдах гээд байгаа байхгүй юу. Малчны

тухай хуулийн нэг бүлэг нь малчдын холбооны болгоод явчхаж болох байхгүй юу. Тийм. Тийм учраас би 1 дүгээрт Байнгын хороо энэ асуудал дээр ер нь ярилцсан энэ зүйл байна уу гэж Байнгын хорооноос асуух гэж байгаа юм.

2 дахь асуудал нь Болорчулуун сайдаас нэг юм асуух гээд байгаа юм бас. Энэ бид нийгэмд нэг маш том хүлээлт үүсгэхээд байгаа юм. Энэ жил малчид маань зуд турхан болсон хүндхэн байгаа тэрийг ойлгож байна. Тийм. Сүүлийн үед бол малчид маань үнэхээр хүндрэлтэй 2 том асуудал малчдад тулгараад байгаа асуудал байхгүй юу. Нэг дэх нь болбол энэ байгаль цаг уурын эрсдэлийн асуудал байгаа. Байгаль цаг уур маш эрсдэлтэй болсон. Ган зудын давтамж ойртчихсон, эрсдэлтэй үзэгдлүүд маш их ойрхон болдог болчихсон. 2 дахь нь болбол малын түүхий эдийн орлогын үнэ муу байгаагаар энэ 2 асуудалтай холбогдуулж л малчдын амьдралд сөрөг нөлөөлөл их байна гэдэг асуудал яриад байгаа юм. Тийм учраас бол малчидтай холбоотой ийм хуулиудыг би Их Хурал хэлэлцээд явж байгаа гэж бодож байгаа юм.

Гэтэл ЗГ нөгөө энэ жил зуд турхан болсонтой холбогдуулаад 4 сард Болорчулуун сайдаа шийдвэр гаргаад, малчдын тэтгэврийн зээлийг нэг жилийн хугацаагаар хойшлуулна. Хойшилсон нэг жилийн хугацааных нь тэтгэврийн юу тэтгэвэр биш шүү, зээлийн малчдын зээлийн хойшилсон хугацааных нь 75 хувийг төрөөс төлнө, 25 хувийг нь зээлийн хүүгийнх нь 25 хувийг нь малчдаар өөрсдөөр нь төлүүлнэ гээд ЗГ шийдвэр гаргасан юм байна лээ. Ингээд малчдад зарлачихсан. Одоо хүртэл энэ нь хэрэгждэггүй. Малчдад хүлээлт бий болчихоод байдаг. Нөгөө банк нь зээлээ төл гэж шаардаад байдаг. ЗГ хойшлуулна гэхихсэн гээд шийдвэр гаргачихсан гээд ингээд байгаад байдаг. Орон нутагт энэ асуудал огт хэрэгжихгүй байгаа байхгүй юу. Тийм учраас би энэ асуудлыг Болорчулуун сайдаас хэзээ шийдэх вэ, хэзээ хэрэгжиж

эхлэх юм бэ? Банкнуудтай ярихаар зэрэг банкнууд чинь юу гэж хэлж байна вэ гэхээр ХХААХҮЯ-тай гэрээ байгуулж бид нар юмаа ярилцаагүй ийм асуудлаар бид нар ярилцаж чадахгүй байна гэсэн юм яриад байгаа байхгүй юу. Тийм учраас би энэ дээр их тодорхой хариултыг авмаар байгаа юм. Ийм 2 асуудал байна.

Г.Занданиатар: Хэн хариулах вэ? Эхлээд Байнгын хороо, дараа нь Болорчулуун сайд хариулна. Байнгын хорооноос Тэмүүлэн гишүүн. Ажлын хэсэг Тэмүүлэн гишүүн хариулна. Тэмүүлэн гишүүн хариулаарай.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. Тэгэхээр Батжаргал нарын 38 гишүүд маань болбол Малчин өрхийн холбооны тухай хуулийг өргөн барьсан. Миний бие бас энэ 17 гишүүний хамтаар Малчны тухай хуулийн төслийг болбол өргөн барьсан. Яах вэ ерөнхий суурь харилцаа нь болбол бас хоёулаа нэгд өрх, Малчин өрхийн холбооны тухай хууль маань болбол цэвэр холбооны гишүүдтэй холбоотой, тэдгээрийн эрх ашигтай холбоотой. Мөн юу гэдэг юм тэдгээрийн оролцоо болон үүрэг хариуцлагатай холбоотой энэ харилцааг болбол зохицуулж байгаа хууль байгаад байгаа юм.

Малчны тухай хууль маань болбол цэвэр бас яг энэ малчдын маань суурь харилцаа, бодлого, туслалцаатай холбоотой. Малчин хүний хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой. Мөн тухайн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой харилцааг болбол зохицуулж байгаа ийм хууль байгаад байгаа. Тэгэхээр энэ 2 маань болбол нэг талдаа нэг нь болбол Малчны хууль суурь хууль болохоор, анхдагч хууль болохоор ийм хууль. Нөгөөдөх маань болбол цэвэр энэ ТББ болон холбооны үйл ажиллагаатай холбоотой, гишүүдийнхээ эрх ашигтай холбоотой, тэдгээрийнхээ оролцоог хангахтай холбоотой ийм хуулийн төсөл болбол байгаад байгаа.

Байнгын хороон дээр болбол энэ асуудлыг болбол нэгтгэх талаар болбол ярилцаагүй. Цаг хугацааны хувьд Малчин өрхийн нэгдсэн холбооны хууль маань болбол 4 сарын эхээр өргөн баригдсан. Нөгөө Малчны тухай хууль маань болбол 4 сарын сүүлээр гээд цаг хугацааны хувьд хэлэлцүүлгийн явцад болбол бас дэс дарааллын хувьд хамтарч хэлэлцэж нэгтгэх боломж бололцоо болбол бас хараахан бүрдээгүй байсан л гэдэг энэ хариултыг бас танд хэлэх байна.

Г.Занданишатар: Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Малчдын хагас жилийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийг хэрхэн төлөх вэ гэж байна. Яг одоогоос 10 хоногийн өмнө 7-нд Монголбанк арилжааны банкнуудтай Хүнс, хөдөө аж ахуйн яам, ЗГХЭГ бид нар бол гэрээнд гарын үсэг зурсан. Энэ тогтоолоор болбол эхний хагас жилийг ХХААХҮЯ-ны батлагдсан төсвөөс малчдын тэр зээлийн хүүгийн зөрөөг өөрөөр хэлбэл зээлийнх нь хүүгийн 75 хувийг төлөх ийм шийдвэр гарсан. Гэхдээ хүсэлт гаргасан малчдын хүсэлтийг харгалзан гэж тогтоол дээр дурдсан байгаа. Үүний дагуу арилжааны банкнууд руу манай яамнаас малчдын зээлийнхээ хүүгийн зөрөөг авах ийм хүсэлт гаргасан малчдын мэдээллийг ирүүл гэсэн бичгийг явуулсан байгаа. Өчигдрийн байдлаар 16 мянган малчин 170 тэрбумын зээлийн хөнгөлөлт хүссэн ийм тооцоо бичиг ирсэн байна лээ. Ирэх 7 хоногоос болбол 7 хоногийн эхнээс авхуулаад ингээд шуурхай хүслийнх нь дагуу шилжүүлээд явна гэдгийг бас хэлэх байна гэдгийг.

Г.Занданишатар: Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг дэмжиж байна. Тэгээд малчид маань нийлээд нэгдээд

сайн дураараа бас холбоо байгуулах, бэлчээр усаа хамгаалах, бэлчээрээ нөхөн сэргээх гээд нэлээн чухал заалтуудыг бас оруулж ирсэн байна. Гол асуух зүйл бол Тэмүүлэн гишүүнээс асуулт асууя. Ер нь малчдын НДШ-ийг бид тэтгэврийн насыг 5 жилээр наашилуулсан байж байгаа. 15 жил мал аж ахуйн салбарт ажилласан 50 настай эмэгтэй, 55 настай эрэгтэйг бол тэтгэвэрт гарах бололцоо боломжийг нь олгосон байж байгаа. Одоо малчид маань юу ярьж байна вэ гэхээр бид нар НДШ-ийг нөхөн төлүүлэх ийм хууль гаргадаг байсан. Харамсалтай нь энэ хууль маань юу гэдэг юм 2023 оноос хойш сунгагдаагүй.

Тэгэхээр энэ НДШ-ийг нөхөн төлүүлэх энэ хуулийг сунгах бололцоо боломж байна уу? Энэ хууль гарч байж малчид маань юу гэдэг юм нөгөө төлөөгүй байсан нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлөх, яг энэ юу гэдэг юм Тэтгэврийн тухай хууль дээр заасан 50 настай малчин тэтгэвэрт гарах, 55 настай малчин тэтгэвэрт гарах ийм бололцоо боломжууд бас гарах юм байна. Тийм учраас малчдыг энэ НДШ-ээ төлөх ийм бололцоо боломжоор бас хангаж өгөөд, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх энэ хуулийг бас оруулж өгөөч. Энэ дээр та ер нь ямар санал бодолтой байж байгаа юм бэ гэж асуумаар байна? Баярлалаа.

Г.Занданишатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, дараа нь Малчны тухай хууль чинь дараа нь хэлэлцсэн шүү дээ.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнөөдөр үндсэндээ бас энэ малчдын нийгмийн даатгал, нийгмийн баталгаа болоод ЭМД-ын асуудал болбол үндсэндээ хамгийн чухал асуудлууд бол байгаа. Төр Үндсэн хуулиараа энэ малчдынхаа нийгмийн баталгаа, иргэн хүнийхээ эрүүл аюулгүй болоод орчинд амьдрах тухайн тэр хүний бас баталгааг нь хангах болбол үндсэн үүрэг байгаа

байгаа. Үндсэндээ Монгол Улсад нийтдээ 298 мянган малчин буюу 300 мянга орчим малчид байгаагаас өнөөдөр нийгмийн даатгалд хамрагдаж байгаа малчид маань болбол 20 орчим хувь хүрэхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр үндсэндээ төрийн зүгээс бодлого гаргах зайлиггүй шаардлагатай.

Сая сүүлийн 30 жилийн зах зээлийн ороо бусгаа цагийн хамгийн гол хохирогч нь болсон хүмүүс болбол үндсэндээ малчид байгаад байдаг. Тухайн тэр архив бүртгэлүүд нь байхгүй болчихсон, ажилласан жилүүд нь дутуу байдаг, нөгөөдхийгөө нөхөн тооцуулъя гэхээр бүртгэл материал нь олддоггүй ч гэдэг юм уу, эргээгээд энэ тэтгэврийнхээ насандаа хүрээд тэтгэвэрт гаръя гэхээр боломж бололцоо байхгүй болчихсон, хууль, эрх зүйн орчин талаасаа болбол хаалттай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Монголын төр болбол зайлиггүй энэ газрын дээрх хамгийн үнэ цэнтэй баялаг болсон хүнээ хамгаалах, нийгмийн баталгаагаар хангах болбол энэ өөрөө суурь бодлогын харилцаа асуудал гэж болбол харж байгаа.

Хувь хүн талаасаа болбол би энэ малчдын НДШ-ийг нөхөн төлүүлэх хуулийн төслийг Чинзориг сайдын хамтаар бас 2021 он, 20 онд өргөн бариад 21 оны 1 сарын 1-нээс 22 оны 1 сарын 1-нд хэрэгжүүлсэн. Гэсэн ч өнөөдөр үндсэндээ малчид хэлж байгаа зүйл бол та бүхний өргөн барьсан хууль чинь тэгш бус байдлаар үйлчилсэн. Бид нар нэгд мэдээллээр хангагдаагүй хуулийг сурталчилж чадаагүй. 2 дугаарт тухайн тэр 21 оны 1 сарын 1-нээс бараг 6 сар хүртэл болбол хатуу хөл хориотой байсан учраас ноос ноолуурын цаг байгаагүй, амьжиргаа орлого байгаагүйгээс энэ хуулийн үйлчлэлийг бүрэн хамрагдаж чадаагүй гэдэг. Бодит тоог нь аваад үзэхээр үндсэндээ яг үнэндээ тийм байгаад байгаа юм. Дөнгөж 20-хон мянган малчид, хувиараа бизнес эрхлэгчдээс бас 18, 9 мянган малчид бол иргэд болбол хамрагдсан

байгаад байгаа юм. Тэгэхээр одоо болбол энэ хуулийн төслийг бас өргөн барьсан байгаа. Малчдын нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг өргөн барьсан. Улсын Их Хурал хэлэлцэх эсэх нь болбол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал.

Энэ дараагийн асуудал болох Малчны тухай хууль дээр малчдын НДШ-ийг нөхөн төлүүлэх боломжийг бүрдүүлъя. Энийг болбол 26 оны 1 сарын 1 хүртэл болбол хуулийн үйлчлэл байхаар гэдэг юм уу, доод тал нь болбол нэг жилийн хугацаанд байхаар болбол оруулж өгсөн. Цаашид бид нар энэ нийгмийн даатгалд хамрагдсан малчдыг болбол бий болгож, тодорхой хугацаа зааж өгөөд, тэрнээс цаашаа болбол юу гэдэг юм бүгд гарааны тэгш нөхцөлөөс эхлээд явъя. Төр 20, 30 жилийн хугацааныхаа алдаа оноог болбол залруулаад явъя л гэсэн ийм зохицуулалтыг болбол хийх ёстой гэж болбол байр суурийг баримталж байгаа юм.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэцгээе. Зарчмын зөрүүтэй 35 санал байгаа. Тэгье. Санал хураалт явуулах уу? Санал хураалт явуулъя. БОХХАА-н байнгын хороо дэмжсэн санал. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр заалт.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “гэрээт бэлчээрийн газар дахь” гэснийг “гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх” гэж, 3.3 дахь хэсгийн “Гэрээт бэлчээрийн газрыг” гэснийг “Бэлчээрийг гэрээгээр” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Цогт-Очирын Анандбазар, Жигжидийн Батжаргал, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Цэвэгдоржийн Туваан цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. Санал

хураалт явуулна, гишүүд суудалдаа сууя. Цэрэнпунцаг гишүүн суудалдаа сууя. Чинзориг сайдаа гишүүдийг саналыг нь өгүүлье. Өөрийнхөө хуулийг батлагдчихаар тэгээд л бусдыг ингээд уруу татаад суугаад. Та сууж байгаарай тэгвэл. Санал хураалт. Миний карт уншихаа больчихлоо. 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “малчдын” гэснийг “малчин өрхийн” гэж өөрчилж, 4.1.2, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.4 дэх заалтыг хасах:

“4.1.2. “малчин өрх” гэж жилийн дөрвөн улиралд мал аж ахуй эрхэлж, түүний ашиг шимээр үндсэн орлогоо олдог өрхийг;”

“4.1.5. “байгалийн нөөц” гэж гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн ургамал, уст цэг, ан амьтан зэргийг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтын “үйл ажиллагаа гишүүдэд” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Энэ чинь одоо шинэ хөдөө гэдэг санаачилгатай ч гэсэн нэгдэхээр. Бат-Эрдэнэ гишүүний ч гэсэн санаачилга болж байна. 54,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ Аубакир гишүүн хаана явна вэ? Энэ Аубакирыг эрэн сурвалжлах ажил зохион байгуулъя. Өчигдөр бас байхгүй. Хүмүүнлэгийн боловсролын хууль дараад алга болсон.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “гарах” гэсний дараа “, гаргах үндэслэл, журам” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.9 дэх заалт тус тус нэмж, 6.2 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг хасах:

“6.1.9.Анхдагч холбооны бүх гишүүдийн хурал /цаашид “бүх

гишүүдийн хурал” гэх/-тай холбогдсон энэ хуульд зааснаас бусад асуудал;” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “20-оос” гэснийг “10-аас” гэж, 7.2.3 дахь заалтын “удирдлагын бүтцийг тогтоож, бүрэлдэхүүнийг” гэснийг “ахлагч, тэргүүлэгчдийг” гэж тус тус өөрчилж, мөн заалтын “, томилох” гэснийг, 7.3 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 8.3 дахь хэсгийг 8.5 дахь хэсэг болгон доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулах:

“8.1.1.малчин өрхийн гишүүнийг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах;”

“8.1.3.малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах;”

“8.5.Анхдагч холбооны малчин өрхийн гишүүн холбогдох хуульд заасны дагуу нөхөрлөл, хоршоо, компанийн үүсгэн байгуулагч, гишүүн, хувьцаа эзэмшигч байж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Анужин, Болорчулуун хоёр эсрэг гараад байна шүү.

7.Төслийн 9 дүгээр зүйлд 9.1.4 дэх заалт нэмж, мөн зүйлийн гарчгийг “Боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах” гэж өөрчилж, 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 9.1.4 дэх заалтыг 8.3 дахь хэсэг болгон шилжүүлж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Анхдагч холбоо нь малчин өрхийн гишүүдийг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:”

“9.1.4.нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, холбогдох мэдээллээр хангах.”

“8.3.Анхдагч холбооны гишүүдэд төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Болорчулуун гишүүн суу, суу. Хөдөө аж ахуйн байна, өглөө болохоор уул уурхайн асуудал ярьчаад л, тэгээд. Оюу толгой гээд л ярьсан хүн. 66,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. 56,5 хувийн саналаар.

8.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтын “хадлан, тариалангийн” гэснийг “хадлангийн” гэж өөрчилж, 10.1.2, 10.1.3 дахь заалтыг нэгтгэн 10.1.2 дахь заалт болгож, 10.1.4, 10.1.6, 10.1.7 дахь заалт, 10.2 дахь хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд 10.5 дахь хэсэг нэмэх:

“10.1.2.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, өнжсөөх, бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшинээс бууруулахгүй байх;”

“10.1.6.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг Газрын тухай хуулийн 21.4.5, 21.4.6-д заасны дагуу ашиглуулахад хяналт тавих;

10.1.7.тухайн жилийн бэлчээрийн гарц, байгаль, цаг уурын урьдчилсан төлөв байдлыг харгалзан өвөлжилт, хаваржилтын

бэлтгэл хангах, гамшигаас хамгаалах нөөц бүрдүүлэх;

10.1.8.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.5.1-7.5.3-т заасан шаардлагыг хангасан, халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй мал оруулах, дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих;”

“10.2.Газрын тухай хуулийн 52.7 дахь хэсэгт заасан газарт тэжээлийн ургамал тариалж болно.”

“10.5.Анхдагч холбооны гишүүн бус малчин өрх Анхдагч холбооны гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг ашиглах тохиолдолд нийтийн эрх ашгийг хүндэтгэн түүнийг зохистой ашиглаж, хамгаална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 аравны, 51,1 хувийн саналаар санал дэмжигдсэн байна.

9.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8.4 дэх хэсэг болгон шилжүүлж, мөн зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.4.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн цаг үеийн шинжтэй, нэмэлт ажиллах хүч шаардагдах ажлын үед Анхдагч холбооны гишүүд харилцан тусалж, хамтран ажиллана.”

“11 дүгээр зүйл.Малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах

11.1.Анхдагч холбоо нь малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:

11.1.1.малын чанар, ашиг шимийг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

11.1.2. тухайн бүс нутгийн онцлогт дасан зохицсон, баталгаажсан үүлдэр, омгийн малыг үржилд ашиглах, үржлийн мал бойжуулах, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг технологит хугацаанд хэрэгжүүлэх;

11.1.3. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг бүртгэх;

11.1.4. мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх арга хэмжээнд малаа товлосон хугацаанд бүрэн хамруулах, эрүүл мэндийн бүртгэлийн дэвтрийг тогтмол хөтлөх;

11.1.5. малын индексжүүлсэн даатгалд хамруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Батлут гишүүн.

Д.Батлут: Би дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү.

Г.Занданшатар: Батлут гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. Тэр Батлут гишүүнтэй хэн саналыг нь үймүүлээд зогсоод байгаа юм бэ? Оюунчимэг гишүүн саналаа өг. Батлут гишүүн саналаа өгөөч. Оюунчимэг гишүүн. 53,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тэгээд Эрүүл мэндийн хууль батлагдсаны дараа энэ Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд бас ингээд байж болохгүй шүү. 13, 11. Батлут гишүүний санал дэмжигдэж саналыг хүчингүй болсонд тооцсон учраас дахин санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. 64,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “хийж, чанар, гарал үүслийг хянан баталгаажуулах” гэснийг

“хийх, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх,” гэж өөрчилж, мөн заалтын “мал,” гэснийг хасаж, 12.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.1.2. стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, борлуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль батлагдсаны дараа гараад явснаа эргээж орж ирлээ, суудалдаа суугаарай. 58,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 13, 14, 19 дүгээр зүйлийг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулж 13 дугаар зүйл болгох:

“13 дугаар зүйл. Анхдагч холбооны удирдлага, зохион байгуулалт

13.1. Анхдагч холбооны эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал, түүний чөлөөт цагт Тэргүүлэгчид байна.

13.2. Анхдагч холбоо нь таваас дээшгүй Тэргүүлэгчтэй байх бөгөөд тэдгээрийг хоёр жил тутамд бүх гишүүдийн хурлаас сонгоно.

13.3. Анхдагч холбооны бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах Ахлагчтай байна.

13.4. Ахлагч нь сумын малчин өрхийн холбоонд болон бусад этгээдийн өмнө Анхдагч холбоог төлөөлнө.

13.5. Анхдагч холбооны Тэргүүлэгчдийн шийдвэрээр Ахлагчийн эрх, үүргийг аль нэг Тэргүүлэгчид түр шилжүүлж болно.

13.6. Анхдагч холбооны Тэргүүлэгчдийн энэ хуульд зааснаас бусад эрх, үүргийг тухайн холбооны

онцлогт тохируулан дүрмээр тодорхойлно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64,6 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалтын “гишүүн малчин өрх гэрээт бэлчээрийн газрыг ашиглах” гэснийг “бэлчээрийг гэрээгээр ашиглах хүсэлтийг сумын Засаг даргад гаргах, бэлчээрийг” гэж өөрчилж, 15.2, 15.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Гэрээгээр ашиглаж байгаагаас бусад бэлчээрийг ашиглах, отор нүүдэл хийх асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн хүсэлтээ сумын Засаг даргад гаргана.

16.3.Шинээр өрх тусгаарласан болон шилжиж ирсэн малчин өрхийг Анхдагч холбоонд элсүүлэх шийдвэрийг бэлчээрийн даацад тохируулан сумын Засаг даргын саналыг үндэслэн бүх гишүүдийн хурал шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “холбооны” гэсний өмнө “малчин өрх Анхдагч” гэж нэмж, 16.2 дахь хэсгийн “этгээдийн” гэснийг “малчин өрхийн” гэж өөрчилж, 16.6 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 18 дугаар зүйлд шилжүүлж, 17 дугаар зүйлийг хасах:

“18.2.Бүх гишүүдийн Хурлын тов, хэлэлцэх асуудлыг Ахлагчийн саналыг үндэслэн Тэргүүлэгчид тогтоох бөгөөд дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн хурлын зарыг хурал болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргэнэ.

18.3.Анхдагч холбооны нийт гишүүдийн гуравны нэгээс дээш хувийн саналаар бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 69,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. 59,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 18 дугаар зүйлийн 18.6, 18.7 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.5, 18.8 дахь хэсгийг тус тус хасах:

“18.7.Бүх гишүүдийн хурлын тэмдэглэлийг хөтлөх бөгөөд тэмдэглэлд хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 31 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. 63,3 хувийн саналаар.

16.Төслийн 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь заалтын “жил бүр” гэсний дараа “хуульд заасан журмын дагуу гаргаж,” гэж нэмж, 20.3.1 дэх заалтын “холбооны өдөр тутмын” гэснийг “Анхдагч холбоо болон Тэргүүлэгчдийн” гэж өөрчилж, 20.3.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Мөнхбаатар даргыг дуудаарай. 63,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “БОЛОН УЛСЫН” гэснийг “МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБОО,” гэж өөрчилж, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 63,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “удирдлагад” гэснийг “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад” гэж, 23.1.3 дахь заалтын “гишүүдийн” гэснийг “стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 29 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

19.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 27 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

20.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Адьшаа гишүүнээ картаа хийгээд, саналаа өгөөрэй. 27 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа, хуулийн төсөл санал батлагдлаа, дэмжигдлээ.

21.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “Нэгдсэн” гэснийг “Малчин өрхийн” гэж, мөн хэсгийн “бүх” гэснийг “зохих” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Үнэнбат даргаа хуулийн төслөө аваад ир дээ. 27 гишүүн дэмжиж, хууль эцэслэн, санал батлагдлаа.

22.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “өвс тэжээлийг хөнгөлөлтэй үнээр олгох болон бусад” гэснийг “төрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.5 дахь хэсгийг хасах:

“32.1.Холбоо нь хууль, дүрэмд заасны дагуу үйл ажиллагаа, санхүүжилт, түүний зарцуулалтыг гишүүддээ тайлагнана.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Гишүүд анхааралтай саналаа, сүүлийн хэдэн санал үлдсэн байна. 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 33 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн гарчгийн “МАЛЧИН ӨРХИЙН” гэсний дараа “НЭГДСЭН” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг,

санал хураалт. Саналаа. 33 гишүүн дэмжиж, 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 62 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос дэмжээгүй санал. 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний дараа, гэсний өмнө “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй. Ажлын хэсэг санал дэмжигдэж Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль бол заалт нь орж байна.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулна. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:

“19.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.3.1.бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

19.3.2.бэлчээрийн даац тогтоох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Газрын хуулийг уу, тэр чигээр нь үү? Яах вэ тэгээд уялдаж л байвал сайн биз. Дараа нь таны хууль батлагдахад нэг том алхам болж байна. 2 хуульд ороод эвлэвэл бүтнэ. 2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.1, 62 хувийн саналаар түрүүний санал дэмжигдсэн.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 3.1.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмж, 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 4 дэх заалт болгох:

“3/20 дугаар зүйлийн 20.2.10, 20.2.11 дэх заалт:

20.2.10.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас отрын бэлчээр, бусад аймаг, сумын бэлчээрт түр хугацаагаар мал оруулах, гаргах асуудлыг холбогдох аймаг, сумын Засаг даргатай хамтран шийдвэрлэх;

20.2.11.энэ хуулийн 20.2.10-т заасны дагуу шийдвэрлээгүй бол уг асуудлыг дээд шатны Засаг дарга, Засгийн газар шийдвэрлэх.”

“4/21 дүгээр зүйлийн 21.4.4, 21.4.5, 21.4.6, 21.4.7 дахь заалт:

21.4.4.бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээ байгуулах;

21.4.5.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед тухайн сумын малчдад бэлчээрийн даацад тохируулан түр

хугацаагаар ашиглуулах асуудлыг шийдвэрлэх;

21.4.6.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас бусад аймаг, сумын малыг отрын бэлчээр болон бусад бэлчээрт түр хугацаагаар оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх;

21.4.7.өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зун, намрын улиралд малаас чөлөөлөх хугацааг тогтоож, мөрдүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Ажлын хэсэгт нөгөө танай ажлын хэсгийн Энхбаяр, Найданхүү нар байгаа шүү дээ. Тэд нар оруулсан юм байгаа. Энхбаяр бас. 62 хувийн саналаар санал дэмжигдлээ. 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 23.4.7 дахь заалтын “бэлчээрийн даацыг” гэсний дараа “хөдөө, аж ахуйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан аргачлалын дагуу” гэж нэмж, мөн заалтын 23.4.9 дэх заалтын “бэлчээр ашиглалтын” гэснийг “уг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 52.2 дахь хэсгийн “, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн зориулалтаар ашиглуулах

газрын зааг, байрилын талаар шийдвэр гаргах,” гэснийг “гэрээгээр ашиглах бэлчээрийн зааг, байрилын талаар Малчин өрхийн анхдагч холбооноос гарсан саналыг хэлэлцэх,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Яг энэ санал дээр үү? Тогтохсүрэн гишүүн. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Үгүй ээ энэ бас энэ хуульд нэг бас нэг учиртай хандаж баймаар байна. Дураараа ингэдгээ болимоор байна. Энэ 1 дүгээрт Хоршооны тухай хуулийн маш олон заалт орчихсон юм. 2 дахь юм нь энэ газартай холбоотой бас Батжаргал гишүүнээ би Батжаргал гишүүн Байнгын хорооны даргад яриад байна шүү дээ. Тэгээд энэ 52-ын Газрын хуулийн 52.2 гээд хамгийн чухал заалтыг хасаад хаячихлаа та нар иргэдийн хурлын шийдвэрийг үндэслэнэ гэдгийг. Иргэдийн хурлын шийдвэрээ үндэслэхгүй газар олгоно гэж юу яриад байгаа юм бэ?

2 дахь юм нь энэ чинь малчин өрхөд газар эзэмшүүлэх тухай биш, үгүй ээ малчинд газар эзэмшүүлэх тухай биш малчдын холбоонд газар эзэмшүүлэх гээд байна шүү дээ. Нутаг дэвсгэрийн нэгжсийн хууль дээр биччихэж байна. Одоо оруулж ирж байгаа санал чинь ийм л санал байгаа байхгүй юу. Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн зориулалтаар ашиглуулах газрын зааг, байрилын талаар шийдвэр гаргана гэж оруулж байгаа байхгүй юу. Юун байхгүй гэж. Тэгээд цаашаагаа явахаараа гэрээгээр ашиглах бэлчээрийн зааг, байрилын талаар малчин өрхийн анхдагч холбооноос гаргасан саналыг хэлэлцэх.

Энэ дээр 2 юм байгаа юм. 1 дүгээрт нь тэр Батжаргал гишүүнээ, Батжаргалаа би чамд юм хэлээд байна шүү дээ. Танай Байнгын хороо ийм хариуцлагагүй асуудалд ханддагаа болих хэрэгтэй шүү дээ. Хоршооны хуулийн талыг нь авчихсан. Бид нарын өргөн барьсан Газрын тухай хуулийн бүх

заалтыг энэ рүү аваачаад оруулчихсан. Тэгэх юм бол та нар хамтатгаад хэлэлцчих л дээ. Танай дээр чинь ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа шүү дээ. Тэгэхгүй тэгээд нэгнийхээ болохоор нь зэрэг хэлэлцэхгүй, нэгийг нь нэг дээр нь аваачиж оруулаад, тэгээд хэрэгтэй, хэрэгтэй заалтуудыг нь бүгдийг нь хасаж хаяад, одоо нөгөө Газрын хуульд байгаа Иргэдийн хурлын эрх мэдлийг авч хаяад ингээд яваад байж болохгүй шүү дээ энэ. Ингээж дураараа хандаж болохгүй шүү дээ.

Холбооны эрх зүйн байдлын хууль гэсэн мөртөө яг дотор нь ороод харахаар бэлчээрийн асуудал болоод явчхаж байгаа байхгүй юу. Ингээж болохгүй шүү дээ, энэ наадах чинь.

Г.Занданишатар: Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ. Та одоо Эм, эмнэлгийн хэрэгслийн хуулийг чинь явуулчихад байна.

Ж.Батжаргал: Тогтохсүрэн гишүүний яриад байгаа зүйл дээр тайлбар өгье. Угаасаа энэ хуулийн зорилго малчин, мал, бэлчээр 3-ын харилцан шүтэлцээ дээр нь энэ уламжлалт мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах, тэрнийх нь үүднээс хамтын эрх ашгаа хангадаг үйл явцыг нь л зохицуулж байгаа хууль энэ. Тэр хүрээндээ бүх асуудал яригдсан. Хэн нэгний хуулиас хуулсан барьсан эд нар гэж ямар юм байх вэ дээ энэ чинь. Угаасаа харилцаа чинь л зохицуулагдахаар хаанаасаа ч ирсэн л нэг л юман дээр бууна шүү дээ. Би танд хэлсэн шүү дээ. Энэ та бидний хамт өргөн барьсан Газрын тухай хуулийнхаа асуудлыг энэ хуулийг дагаж орж ирж байгаа Газрын тухай хуультай хамтатгаад хэлэлцээд явъя гэхээр зэрэг үгүй ээ гэсэн шүү дээ. Тэгэхээр бид өөрийнхөө өргөн барьсныг ажлын хэсэг ажиллаад нэмсэн заалт нь л энэ байна.

Г.Занданишатар: Аюурзанын Энх-Амгалан Бодлого, судалгааны төвийн

тэргүүн нэмэх юм байгаа юу? 4 номер. Энэ санал дээр бас тодруулж болно гэдэг дэг болсон. Тайлбар хэлж болно гэж байгаа юм. Асуулт асууж болохгүй л дээ. Санал хураалт явуулъя. Энэ болбол бэлчээр биш бэлчээрийн зааг байршлын талаар Малчин өрхийн анхдагчийн холбооноос гаргасан саналыг хэлэлцэнэ л гэж байна ИТХ, ЗДТГ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Тэр нь Засаг дарга болоод түрүүчийнх чинь газрын асуудал биш байна, яг шигтгээд юмаа уншаад үз, тийм аюултай юм байхгүй энэ. Хилийн цэс байхгүй. Энийгээ Байнгын хороон дээр ингээд яагаарай. Энэ дээр буруу зөрүү ойлголт үүсээд яваад байх шиг байна.

Төслийн 3 дугаар зүйлийн “бэлчээрийн газрыг” гэснийг “бэлчээрийг” гэж, “гэрээний” гэснийг “гэрээ байгуулах,” гэж тус тус өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ ингээд буруу ойлголт төрөөд, энэ багийн чиг үүрэг гэсэн заалт байхгүй юу. Тэгээд угаасаа энэ дээр бусдын эзэмшил ашиглалтад олгоогүй хадлан тариалан, бэлчээр, ус цэгийн хамгаалалт, ашиглалт зохицуулалт гэсэн заалт байхгүй юу. Тэгээд энэ бэлчээрийн ашиглалт зохицуулалтаа энэ дээрээ болбол гэрээгээр ашиглах бэлчээрийн зааг байршилд малчин энэ саналыг үндэслээд энэ ус цэгийн хамгаалалт, ашиглалт, зохицуулалтаар зохицуулна гэсэн заалт байгаа юм. Эд нарыг ингээд юу яагаад байна л даа. Нөгөө шигтгэсэн заалтаа уншихгүй болохоор буруу ойлгоод үгийг нь, бэлчээрийн газрыг бэлчээрийг л гэж нэрлэж байна л даа энэ дээр чинь.

Сумаасаа бэлчээрийн газар заадаггүй байхгүй юу даа. Үгүй ээ үндэслэнэ гэж байхгүй. Угаасаа бэлчээр чинь тусдаа зохицуулалттай. 52.2-ыг хасаагүй. Хасаагүй, хасаагүй. 52.2 чинь байна шүү дээ, 52.2-т бэлчээр, түүний зохистой ашиглах, хамгаалах гэсэн бүлэг байхгүй юу. Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх

асуудлыг энэ хуульд заасны дагуу Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий болон сумын тухайн жилийн төлөвлөгөөт, төлөвлөгөөнд үе шаттай төлөвлөж хэрэгжүүлнэ гээд сая өөрчлөлт орсон байхгүй юу. Энэ л, ийм л агуулга орж байгаа юм. Засаг дарга тогтоодог байсныг засаг, сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тухайн нутаг бэлчээрийг талхлахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац чадавхыг харгалзан Багийн иргэдийн төлөөлөгч, Багийн ИНХ-ын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно гэсэн заалтыг, одоо саяынхаар бэлчээрийг талхлахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацыг харгалзан сумын Засаг дарга Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийн газрыг гэрээний дагуу ашиглуулж болно гэж зааж байгаа юм.

Үгүй ээ үгүй. Хэсэг бүлгээр ашиглуулж болно гэдгийг холбоо ашиглуулж болно л гэж, анхдагч холбоонд ашиглуулж болно. Хуучин хэсэг бүлгээр ашиглуулж болж байсан юм чинь холбоо ашиглуулж болно л гэж зааж байна шүү дээ. Ингээд доторх нюанс нь, деталь нь ийм байгаа байхгүй юу. Үгүй ээ малчдын бүлэгт ашиглуулж болно гэдгийг Малчдын анхдагч холбоонд ашиглуулж болно гэж байгаа энэ хоёрын хооронд зохион байгуулалтад оруулж байгаа юм чинь энийгээ юу яахгүй болбол бас ийм юугаар хандаж болохгүй л дээ. Үгүй ээ үгүй, хуучин хуульд нь хэсэг бүлгээр ашиглуулж болно гээд заачихсан байна л даа. Тэр нь хэсэг бүлэг гэдгийг нь Малчдын анхдагч холбоо нь буюу анхдагч холбоо 10 гэр нь ашиглаж болно л гэсэн заалт байгаа юм. Энийг ингээж ойлголцоод Байнгын хороон дээрээ гүйцээж боловсруулъя.

Дараагийнх нь Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал. Төслийн 1 дүгээр зүйлийн “ажлыг зохион байгуулах” гэснийг “малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх эдийн засгийн хөшүүрэг нэвтрүүлэх,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, гишүүдээ анхааралтай байгаарай. Санал хураалт. Тэгээд л эсрэг өгч байгаа улсууд нь малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх асуудлыг дэмжихгүй байгаа юм байна гэж ойлголоо. Ингээд дэмжээгүй гишүүд нь тэгээд энэ тэр. Энэ олон гишүүн гараад явчихсан, тэгээд зарим нэг гишүүд эсэргүүцээд ингээд энэ хуульд ингэж амбицаар хандаж болохгүй л дээ энэ чинь, мал аж ахуй дээр тийм.

Хоршооны тухай хуульд бол ганцхан заалт орж байна. Тэрнийг унагавал унагаасугай. Дөрөв.Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол, БОХХАА-н байнгын хороо дэмжсэн санал. Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Ингэвэл одоо тэгээд нөгөө Шинэ хоршоо хөдөлгөөн л зогсох юм байна. Энийг дэмжихгүй бол. Засаг төрийн бодлогоор. Хуулиуд чинь хоорондоо уялдана л даа. Энэ шигтгэсэн энэ юмаа ойлгохгүй, зоргоороо яриад байна. Ерөөсөө шигтгэсэн заалтаа уншихгүй, ерөөсөө нэг өөр өөрсдийн өнцгөөр хараад. Шигтгээд үзээд ирэхээр энэ дандаа хэрэгтэй заалтуудыг унагалаа шүү. Энэ малчин өрхөө дэмжихгүй л гэж, малчдаа дэмжихгүй л гэж байгаа юм байлгүй энийг.

Байнгын хорооноос саяын саналуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлж байна. Саяын саналуудыг ойлголтыг нэгтгэж, гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

11.47 цаг

Гурав.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд орё. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа Учрал гишүүнээ хэлэлцүүлэгт бэлтгэх хэрэгтэй байна, өнөөдрийн дотор.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэндээ бас энэ өдрийн мэнд хүргэе дахиад. Тэгэхээр Монгол Улсын мал аж ахуй өөрөө нийгэм, эдийн засгийн өөрөө тулгуур салбаруудын нэг. Тэгэхээр хүн амыг гол нэрийн хүнсээр, уул уурхайн бус салбарын үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах эх үүсвэр нь болж, олон мянган өрхийн өдөр тутмын амьжиргаа хэрэглээ энэ үйлдвэрлэлээс болбол хамааралтай байгаад байгаа. Тэгэхээр манай улсын ДНБ-ий 11 хувь, экспортын орлого энэ 5,6 хувь энэ мал аж ахуйн салбараас болбол бүртгэгдэж байгаа. Орон нутгийн нийт 80 орчим хувь нь энэ мал аж ахуйн, мал аж ахуйд суурилсан эдийн засагтай. Нийт ажиллах хүчний 25,5 хувь нь болбол энэ салбарт ажиллаж байна.

Манай улсын нийт газар нутгийн 71,2 хувийг хамарсан мал аж ахуйн

үйлдвэрлэлийг 246,3 мянган малтай өрх эрхэлж, үүнээс жилийн 4 улирлын туршид болбол мал маллаж байгаа 188,6 мянган малчин өрх байна. Одоог хүртэлх энэ эрх зүйн орчныг аваад үзэх юм болбол үндсэндээ энэ 300 мянган малчдын эрх ашгийг хамгаалсан тодорхой тоймтой бодлого байхгүй, эрх зүйн орчин байхгүй байгаагаас үүдэж болбол цаашид бид нар энэ 300 мянган малчдын эрх ашгийг хамгаалах тодорхой бодлогын тухай хуулийг болбол боловсруулах шаардлагатай байна гэж үзсэний үндсэн дээр Малчны тухай хуулийн төслийг болбол боловсруулсан.

Үндсэндээ энэ хуулийн төслийг боловсруулахад хөдөө аж ахуйн их, дээд сургуулийн эрдэмтэн, багш нар болон ахмад малчдын саналыг 2 жил гаруйн хугацаанд тусгасны үндсэн дээр малчдын ажиллах, амьдрах, тэр дундаа тогтвор суурьшилтай ажиллаж хөдөлмөрлөх энэ эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс болбол хуулийн төслийг боловсрууллаа.

Зөвхөн энэ харилцаанаас гадна цаашид энэ үндэсний тулгуур салбар болсон мал аж ахуйн салбарыг хэрхэн эдийн засагжуулах вэ, тогтвортой мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжлийг хэрхэн бид нар хангах вэ гэдэг үндсэн дээр байгальд ээлтэй, бүтээмжтэй, эрсдэлгүй мал аж ахуйг хөгжүүлэх үндсэн дээр болбол малчдынхаа мэдлэг боловсролыг дээшлүүлэх мөн үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх үндсэн дээр энэ хуулийг төслийг боловсруулсан байгаа.

Ингээд хуулийн маань хамрах хүрээний хүрээнд болбол мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлого болбол төрөөс баримтлах бодлогууд болбол тодорхой болж, төрийн хүлээх эрх, үүргүүд болбол тодорхойлогдохоор байгаад байгаа. Мөн энэ салбартаа хамааралтай төрийн байгууллагуудын мал аж ахуйн талаар хийх үүргүүд болон хууль хоорондын уялдаа холбоог хангах,

тэр дундаа Малын эрүүл мэнд болон Малын генетик нөөцийн тухай хууль, Хоршооны тухай хууль хоорондын уялдаа холбоонууд болбол хангагдах боломж бололцоо бүрдэнэ.

Бид бүхний хувьд бас энэ хуулийн хүрээнд энэ малчны хөгжлийг дэмжих хүрээнд мэдлэг боловсролтой малчныг бий болгох энэ үндсэн дээр болбол мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтын нэгдсэн стандарт хөтөлбөртэй болж, мөн их, дээд сургуулиуд болон аймаг, сумдын төвүүд дээр байгаа МСҮТ-үүдээр дамжуулж малчдыг мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх харилцаа оруулж өгч зохицуулсан байгаад байгаа.

Нөгөө талдаа бид нар бас малчныхаа эрх зүйн байдлыг тодорхой болгож, хариуцлагатай малчинд тавигдах шалгуур шаардлагуудыг болбол бас хуулийн хүрээнд бий болгож, цаашидаа хариуцлагатай мал аж ахуйг хөгжүүлэх үндсэн дээр болбол малчин хүний хүлээх 4 үүрэг, мөн зохистой дадлын 28 дадлын болбол нэвтрүүлэхээр болбол оруулж ирсэн. Үүн дотроо бэлчээр, тэжээл, ус хангамж ашиглалттай холбоотой, арчилгаа, маллагаа арга барилтай холбоотой, малын үржүүлэг технологийн ажлуудтай холбоотой мөн малын эрүүл мэнд болон түүхий эд, бүтээгдэхүүний чанар, бэлтгэн нийлүүлэлттэй холбоотой зохистой дадлуудыг болбол малчны эрх зүйн байдлын хүрээнд болбол тодорхойлж оруулж өгсөн байгаа.

Мал аж ахуйн салбарыг бид бүхэн цаашид эдийн засагжуулъя, энэ салбараас хүртэх үр өгөөж, бүтээмжийг нэмэгдүүлъя гэвэл мал аж ахуйн салбар болоод малчин хүний нэгж малаас авах бүтээмжийг, үр ашгийг зайлшгүй тооцох шаардлагатай байгаа. Энэ үндсэн дээр хуулийн хүрээнд малчны бүтээмж болон үр ашгийг тооцох арга зүйг бий болгож, үндэсний хэмжээнд нэвтрүүлэхээр болбол бас хуульчилж

оруулж өгч, малчны бүтээмжид нөлөөлөх хүчин зүйлүүдийг болбол хуулийн хүрээнд тодорхойлж, тэр дундаа малчны боловсрол, технологийн ажлууд болоод мал маллагаа мөн дэд бүтцүүд болох хашаа хороо болон мал аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх шинэ арга технологи мөн тэжээл хангамжтай ч гэдэг юм уу эдгээр асуудлуудыг болбол хуулийн хүрээнд тодорхойлж оруулж өгч, цаашид малчны бүтээмж үр ашгаас үндэслэж, түүхий эдийн нэр төрөл болон чанарын үнэлэмжээс хамаарсан урамшуулал үнийн үнэлгээг тогтоох энэ тогтолцоог болбол бас хуулийн хүрээнд хуульчилж оруулж өгсөн байгаад байгаа.

Мөн эдгээр малчны бүтээмж болон үр ашгийг тооцож, цаашидаа тухайн урамшуулал шагнал болон дэмжлэг санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлэх энэ харилцаанд болбол зохицуулалтыг бас нэвтрүүлж өгөхөөр болбол зохицуулалтыг бас хийж өгснөөр бол онцлогтой болж байгаа.

Ингээд энэ хууль маань бас цаашидаа бий болсноороо эргээд бид бүхэн энэ мал аж ахуйн салбарынхаа бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог илүү бас өндөр түвшинд гаргах, малчин хүн мал аж ахуйн үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэх боломжийг бүрдүүлэх, нөгөө талдаа бас ухаалаг мал аж ахуйг бий болгох боломжийг болбол бүрдүүлэхээр болбол гаргаж ирсэн байгаад байгаа. Бид бүхэн цаашид энэ эргээд энэ салбарын хөгжлийг дэмжих гол суурь анхдагч хууль болох хуулийн төслийг болбол бас өргөн барьсан гэж болбол бас үзэж байгаа. Тэгээд нийт Улсын Их Хурлын гишүүд энэ хуулийн төсөл болон үзэл баримтлалыг бас хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн даргад баярлалаа. Төслийн талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүнээс 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг БОХХАА-н байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хуулийн төсөлд малчдын залгамж халааг бэлтгэх, малчдад насан туршийн боловсрол олгох, мэдлэгжүүлэх, малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх, малчдыг дэмжих үйл ажиллагааны зарчим, цар хүрээ, дэмжлэгийн хэлбэр, төрийн оролцоог тодорхой болгох, хариуцлагатай малчдыг хөнгөлөлттэй зээлийн болон татварын бодлогоор дэмжих, малчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн эрхлэх өвөрмөц онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, зан заншлыг хадгалах, хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлэх, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хууль ёсны, ашиг сонирхлоо хамгаалах малчдын зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэхээр хууль санаачлагчид уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Дээрх хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хөдөө орон нутгийн иргэд, малчдад төрөөс үзүүлэх эм,

эмнэлгийн үйлчилгээний хүртээмжтэй байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун малчдын нийгмийн асуудлыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, байгалийн нөөц, бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулахад хил хязгаар тогтоох эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах хүрээнд малчдын эрх зүйн байдлыг тодорхойлж, малчдын мал маллах арга ажиллагааны чадамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн зохистой ашиглалт, мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх, малчдын эрх, үүргийг тодорхой болгож, малчдад төрөөс үзүүлэх дэмжлэг зэрэг асуудлыг төсөлд тусгасан бөгөөд хэлэлцүүлгийн явцад төслийг нарийвчлан ярилцаж, сайжруулах боломжтой талаар үг хэллээ. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, ХХААХҮЯ-ны Мал эмнэлгийн бодлогын асуудлаар эрхэлсэн ахлах шинжээч Хөхөөгийн Алтангэрэл, ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Цэвэгмэдийн Мөнхнасан нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Тогтохсүрэн, Чинзориг гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүнийг нэмье. Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүн юм уу? Гочоогийн Ганболд, Энхтүвшин, Гочоогийн Ганболд. Гочоогийн Ганболд гишүүнээр тасаллаа. Асуултаа асууя. Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Малчдын тухайд бол сүүлийн үед үнэхээр хүндрэлтэй юу энэ байгаль цаг уурын эрсдэлтэй холбоотойгоор хүндрэлтэй байдлууд бий болоод байгаа л даа.

2 л том асуудал байгаа юм. 1 дүгээр асуудал нь сүүлийн үед энэ ган, зудын давтамж их ойрхон болчихсон. 2 дугаарт нь байгалийн аюулт үзэгдэл онцгой нөхцөлүүд байнга өвөл, зун гэхгүй бий болчихсон. Энэтэйгээ холбогдуулаад 1 дүгээрт нь малчдын хувьд болбол эрсдэлтэй нөхцөл байдлууд бий болчихож байгаа юм. 2 дахь асуудал нь тийм учраас энэтэй холбогдуулж би хуулийн төслийг санаачилж боловсруулсан гэж бодож байгаа юм.

2 дахь асуудал нь юу байна вэ гэхээр малчдын хувьд нөгөө орлого нь тогтвортой биш болчихоод, малчдын орлогын үндэс нь юу юм гэхээр түүхий эд, малын түүхий эд. Гэтэл энэ малын

түүхий эд нь үнэ нь байдаггүй. Экспорттой ч холбоотой юм бий, үйлдвэртэй ч холбоотой юм бий. Энэ 2 асуудал дээр л бид нар онцгой анхаарал тавих ёстой зайлиггүй. Тэгэхээр би Малчны эрх зүйн байдлын тухай хууль дээр 2 зүйлийг тодруулах гээд байгаа юм. Энэ 2-той холбогдуулаад. 1 дүгээр асуудал нь хамгийн том асуудал нь энэ малын бэлчээртэй холбоотой асуудал байхгүй юу. Байгаль цаг уурын эрсдэлтэй холбоотой асуудал чинь бэлчээр тэжээлтэй холбоотой л асуудал байгаа юм. Тэгэхээр бэлчээр тэжээлтэй холбоотой асуудлыг эрх зүйн хүрээнд нь энэ хуулиар зохицуулж байгаа асуудлууд байна уу?

Бид бэлчээр тэжээлтэй холбоотой асуудлаа эхэлж ярихгүй, эхэлж дандаа малынхаа генетик нөөц, мал эмнэлгээ яриад байдаг байхгүй юу. Юу идүүлэх тухайгаа дараа нь ярьдаг байхгүй юу. Тэгэхээр эхэлж энэ талаар яг хуулийн төсөлд тусгаж байгаа тодорхой заалт байна уу гэж асуух гэж байгаа юм.

2 дугаарт нь энэ малын түүхий эдийг үнэтэй болгохтой холбоотой асуудал хамгийн том асуудал. Энд ерөөсөө бодлогын хүрээнд нь нөгөө үйлдвэрүүд эсвэл экспорт 2 л байгаа юм. Энэ чиглэлээр ер нь хуулийн төсөлд тодорхой ЗГ-ын чиг үүрэг дээр ч юм уу тодорхой оруулж байгаа чиглэлүүд байна уу гэсэн ийм 2 зүйлийг асууя гэж бодож байна.

1 санал хэлмээр байгаа юм Батжаргал дарга. Энэ хуулийг түрүүний хэлэлцдэг тэр мөн Холбооны хууль 2-ыг хамтатгаж явмаар байгаа юм. Малчны тухай 2 хууль хэрэггүй байхгүй юу. Энэ хууль чинь малчны эрх зүйн байдлын хууль, тэр нөгөөдөх нь Малчдын холбооны тухай хууль байгаа юм. Малчдын холбооны хууль нь энэ малчны эрх зүйн байдлын хуулийнхны нэг бүлэг болоод л явчих байхгүй юу. Бүлэг болоод л явчих ёстой. Малчин яаж нэгдэх юм бэ л гэдэг харилцаа. Харин сүүлдээ бүр

нэгдэх харилцаа нь бүр өөр болоод бэлчээр ашигладаг холбоо болоод, хоршоо явуулдаг холбоо болоод явчхаж байгаа байхгүй юу холбоо маань.

Холбоо болбол зөвхөн ТББ-ынхаа хуулиар малчдынхаа эрх ашгийг хамгаалсан л юм л явна уу гэхээс биш бэлчээр ашиглаад л ингээд явах ёсгүй байхгүй юу. Гэтэл тийм болоод яваад өгчхөж байгаа юм. Тийм учраас болбол би энэ 2 хуулийг ер нь цаашидаа Байнгын хороо нэг санал хурааж, хууль санаачлагч нартай ярьж байж, санал хурааж энийг нэг тодорхой хүрээнд шийдэж явах ёстой шүү гэдгийг би санал хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүний асуултад хариулъя. Хууль санаачлагч Ганзоригийн Тэмүүлэн хариулъя.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бас энэ үндсэндээ 2 гол үндсэн асуудлыг болбол бас Тогтохсүрэн гишүүн асуулаа. 1 дүгээрт бид бүхний хувьд энэ ган, зудтай холбоотойгоор давтамжтай холбоотойгоор энэ бэлчээр талхалж байгаа асуудалтай холбогдуулж, бэлчээрийн зөв менежментийг бас хэрхэн нэмэгдүүлэх вэ? Үндсэндээ бас яг энэ бэлчээрийн асуудал маань болбол энэ Монгол Улсын мал аж ахуйн салбарын онцлог маань өөрөө бэлчээрийн мал аж ахуй. Бэлчээрийн мал аж ахуйн гол амин сүнс нь өөрөө бэлчээр байгаа.

Тэгэхээр бид нар үүнээсээ хамаарч бэлчээрийнхээ зөв менежментээс хамаарч зохион байгуулалт болоод хамтын зөв ашиглалт шийдвэрээс хамаарч цаашид энэ нэгж малаас авах ашиг шим нэмэгдэх үү эсэх үү гэдэг асуудал болбол бүрэн хамааралтай асуудлууд бол байгаа. Энэ хуулийн хүрээнд бид бүхний хувьд хуулийн төсөл дээр гол оруулж өгсөн зүйл маань болбол мал аж ахуй болоод энэ байгаль цаг уурын эрсдэл даах чадварыг бүрдүүлэх мөн түүнчлэн яг үүнтэйгээ

уялдуулж мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, боловсруулалтын түвшнийг ахиулах цогц бодлогыг хэрэгжүүлэх гэдэг энэ үүргийг болбол Малчдын талаар төрөөс авах бодлого дээр, Монголын төрөөс авч хэрэгжүүлэхээр болбол тусгаж өгсөн.

Томоор нь авч үзэх юм болбол анх удаагаа бид нар бас энэ малчдын талаар төрөөс баримтлах цогц бодлоготой, тухайн тэр юу гэдэг юм өмнөх алдаа оноогоо бас засаж залруулах бодлогын болоод хандлагын өөрчлөлтийг бий болгох, суурь харилцаа болбол бас үүгээрээ орж ирж байгаа гэдгийг болбол бас хэлэх байна.

Саяын тэр ган, зуд давтамжтай холбогдуулаад ер нь болбол энэ одоогийн тухай хууль, одоо мөрдөгдөж байгаа Газрын тухай хуулиар 52.7 дээр үндсэндээ болбол тухайн тэр өвөлжсөө, хаваржааны газрын доорх газрыг болбол Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно гэж болбол заасан байдаг. Үүнтэй уялдуулж бид нар ер нь тэр мал сүргээ идээшлүүлэх зориулалтаар энэ өвөлжсөө, хаваржааныхаа энэ газар нутгийг, зуслан намаржааныхаа бэлчээрийн эдэлбэр газрыг улирлын онцлогтой уялдуулж, орон нутгийн тэр бэлчээр ашиглалтын журмын дагуу хязгаарлалттай хүрээнд хамтын оролцоонд тулгуурласан байдлаар болбол гэрээгээр болбол ашиглуулж болно л гэсэн суурь зарчмыг болбол хийж өгч байгаа.

Тэгэхээр болбол энэ болбол нэг талдаа одоогийн байгаа Газрын тухай хуульд тусгагдсан тухайн тэр бэлчээрийн даац, төлөв байдлыг болбол бас бууруулахгүй байх үндсэн дээр хамтын оролцоонд суурилж мөн хуучин сум, сангийн аж ахуйн нэгдлийн үед байсан шиг багийнхаа оролцоо дээр суурилж энэ ашигладаг байх энэ тогтолцоог болбол оруулж өгсөн.

Үүнтэй уялдуулж бас нэг зүйл нь болбол уур амьсгалын өөрчлөлт болоод эрсдэлийн нөлөөллийг бууруулах үүднээс болбол 15 дугаар зүйлийг болбол бас нэг талдаа оруулж өгч, цаашидаа болбол малчид бас хамтарч энэ дээрээ хамгаалдаг байх ч гэдэг юм уу энэ зүйлийг болбол бас тусгайлж болбол бас оруулж өгсөн байгаа.

Түүхий эд бэлтгэн нийлүүлэлттэй холбоотойгоор үндсэндээ үйлдвэрүүд болбол бас түүхий эд авахдаа чанартай бэлтгэн нийлүүлсэн, технологийн горимын дагуу шаардлага хангасан түүхий эд авах шаардлага байна гэдэг зүйлүүдийг ярьж байгаа. Бид нар бас энэ малчин хүний хариуцлагатай машины зохистой дадлын хүрээнд түүхий эд бэлтгэх дадлуудыг бол бас тусгаж өгсөн байгаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Чинзориг асуултаа асууя.

С.Чинзориг: Яах вэ ер нь болбол энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийн талаар төрөөс баримтлах бодлогынхоо бичиг баримтыг бид нар шинэчилмээр л байгаа юм л даа. Энэ сүүлийн үед болж байгаа энэ байгалийн гамшиг, зуд давтамж маш их ойрхон болж байна. Уламжлалт аргаар энэ нүүдлийн мал аж ахуй эрхлэх боломжгүй болчихлоо гэдэг нь болбол харагдаад л байгаа юм л даа. Манай нөгөө ард түмний үг, ахмадуудын ярьж ирсэн хаяа багтвал бууж, хамар хатгавал иднэ гэдэг зарчмаар энэ мал аж ахуйн үйлдвэрлэл явахдаа больчихлоо гэдэг нь бол хэнд ч л ойлгомжтой байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ малчны тухай ярихаасаа өмнө ер нь энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийнхээ талаар ямар бодлого явуулах ёстой юм бэ? Яг энэ уламжлалт аргаар чинь энэ нүүдлийн мал аж ахуйн эрхэлнэ гэдэг чинь болбол явахгүй болчихлоо гэдэг нь маш тодорхой байна шүү дээ. Тэгэхээр бид

нар ерөөсөө яг үндсэн үйлдвэрлэлээ ер нь яаж явуулах юм бэ? Энэ байгаль цаг агаарын эрсдэлт нөлөөллөөс яаж хамгаалах юм, яаж энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийг явуулах юм, мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн яаж үнэтэй болгох юм эд нар гээд энэ үндсэн үйлдвэрлэлийнхээ асуудлыг л ярихгүй л байна л даа. Тэгэхээр энэ хөдөө мал аж ахуйн талаар баримтлах бодлого бид нэг юмтайгаа энэ Малчны хууль чинь хэрхэн яаж ингээд уялдах юм бэ? Тэр мал аж ахуйн талаар баримтлах бодлого юмаа шинэчлээд, тэрэнтэйгээ хамт энэ Малчныхаа тухай хуулийг хамт ярих тийм боломж байгаагүй юм уу гэж нэг асуулт байгаа юм.

2 дахь асуудал чинь бид сүүлийн үед нэг малчны тухай энэ жилийн зуд турхантай холбоотойгоор мал аж ахуйн талаар нэлээн яриад байна л даа. Ингээд Их Хурлаас чинь ингээд 3 саланг бодлого л явлаа даа. Саяхан бид нар чинь энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийг байгаль цаг агаарын нөлөөллөөс хэрхэн яаж хамгаалах вэ гээд нэг хууль гаргаад, тэр хуулийн чинь хүрээнд Шинэ хоршоо гээд баахан ажил яриад яваад байдаг. Шинэ хоршоо байгуулна, хоршоо шинэ хоршоо байгуулбал хөрөнгө оруулалтын зээл олгоно гээд баахан юм явж байгаа. Сая энэ хуулийн өмнө бид нар Малчин өрхийн холбооны тухай гээд бас нэг хууль бас ярьчихлаа. Тэгээд Малчны тухай хууль гээд бие даасан хууль дахиад оруулаад ирлээ. Тэгэхээр энэ бодлогуудыг нэгтгээд нэг бодлого болгож л Их Хурал Монгол төрийн бодлого болгохгүй л бол саланги тусдаа юм шиг 3 янзын юм л я явлаа шүү дээ. Энэ чинь яаж амьдрал дээрээ, хөрсөн дээрээ яаж буух юм бэ?

Тэр шинэ хоршоотойгоо энэ маань яаж уялдах юм, сая бидний ярьсан тэр мал аж ахуйн Малчин өрхийн холбооны тухай хуультайгаа энэ чинь яаж уялдах юм бэ? Тэгээд одоо энэ Малчны хууль гээд бие даасан хууль. Тэгээд Их Хурлаас нэг чиглэлийн асуудлаар 3 янзын өөр шийдвэр бол

гаргах гэж байгаа юм уу? Энэ чинь тэгээд яг одоо сүүлдээ амьдрал дээр хэрэгжих үү үгүй юу гээд тэгээд асар их тийм эргэлзээ тээнэгэлзэл бий болгоно шүү дээ. Тэгэхээр энэ бодлогуудаа нэгтгэх талаар энэ Байнгын хороо, ажлын хэсэг яаж бол ажиллах юм бэ? Ядаж л саяын ярьсан тэр анхны бэлтгэлийг нь хийчихлээ л дээ. Малчин өрхийнхөө холбоотой энэ хуулиа яаж уялдуулах юм, хамтад нь хэлэлцээд явах тийм боломж байхгүй юу?

Өмнө нь тэр батлагдсан хууль бий шүү дээ. Нөгөө Мал аж ахуйн үйлдвэрлэлийг байгаль цаг агаарын сөрөг нөлөөллөөс бас хамгаалах тухай хууль. Энэ хуультайгаа эд нар энэ чинь яаж уялдаж байгаа юм бэ? Тэгэхгүй л бол ингээд Их Хурлаас гаргаж байгаа 3 янзын л малчидтай холбоотой 3 янзын л бодлого гарах нь байна шүү дээ. Нэг нь болохоор баахан шинэ хоршоо гээд л баахан юм явсан. Дараагийнх нь ингээд залгаад Малчин өрхийн холбооны тухай хууль гээд дахиад нэг юм явах нь. Тэгж байтал залгаад бид Малчны тухай хууль гээд дахиад нэг юм явах нь. Тэгээд ингэж бас төрийн бодлого явмааргүй л байна даа.

Яах вэ малчны талаар арга хэмжээ авах ёстой гэдгийг би болбол дэмжиж байна. Байнга л ярьдаг хүн нэг. Гэхдээ энэ бодлогоо нэгтгэж, нэг нэгдсэн нэг ойлголттой, нэг Монгол төрийн бодлого болгож явахгүй болбол ийм 3 саланги, нэг асуудлаар 3 саланги л бодлого Их Хурал гаргахаар л явж байна шүү дээ. Тэгэхээр сүүлдээ энэ чинь амьдрал дээр хэрэгжих үү, үгүй юу, жаахан хүндрэх нь дээ. Энийг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Байнгын хороо хариулах юм уу? Хууль санаачлагч Ганзоригийн Тэмүүлэн хариулъя. Байнгын хороо дараа нэмж болно тийм.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр би энэ Малчны тухай хуулийн талаар ер нь үндсэн гол агуулгыг нь бол хэлчихье гэж бодоод байна. Сая Улсын Их Хурлаас баталсан нэг хууль байгаа. Хэлэлцүүлгийн шатад явж байгаа бас нэг хууль байгаа. Энэ өөрөө агуулгын хувьд болбол өөр юм Чинзориг гишүүнээ. 1 дүгээрт өмнөх энэ шинэ хоршоотой холбоотой асуудал болбол цэвэр ашгийн үйл ажиллагаа буюу аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд байгаа. Төрөөс энэ юу гэдэг юм хоршоог дэмжих, хамтарсан нэгдсэн нийлсэн тохиолдолд шинэ хоршоог хэрхэн бий болгох вэ гэдэг энэ харилцааны асуудал явж байгаа юм.

Сая бид бүхний өмнөх хэлэлцсэн Малчин өрхийн холбооны тухай хууль болбол цэвэр ерөөсөө л холбооны гишүүдтэй холбоотой. Тэнд хамрагдаж болно, хамрагдахгүй байж болно. Тэр болбол бид нар хүчээр бас юу гэдэг юм холбоонд болоод хоршоонд хүчээр нэгтгэж нийлүүлж болохгүй асуудал байхгүй юу. Тэгэхээр энэ өөрөө суурь зүгээр юу гэдэг юм холбоонд нэгдвэл гишүүдийнхээ эрх ашгийг бид нар хэрхэн хамгаалах юм бэ гэдэг л холбооны л ТББ-тай холбоотой л харилцааны асуудал.

Энэ бол өөрөө анхдагч харилцаа, анхдагч хууль Малчны тухай хууль. Нөгөө нэг одоо юу гэдэг юм Багийн хөгжлийг дэмжих тухай ч гэдэг юм уу эсвэл Хуульчийн эрх зүйн байдлын тухай, прокурор, шүүгчийн эрх зүйн байдлын тухай гээд хуулиуд байдаг шүү дээ. Тэгэхээр үндсэндээ бусад салбар болгон тэр салбарынхаа ажиллаж байгаа ажилчид, албан хаагч нар дээрээ тавигддаг шаардлага, үүрэг, хариуцлага, төрөөс хүлээх, үүрэг дэмжлэг туслалцаа ч гэдэг юм уу энэ бүх харилцаанууд нь байдаг.

Гэтэл үндсэндээ нэг ч бодлогын зохицуулалтгүй, эрх зүйн орчингүй байгаа салбар болбол мал аж ахуйн салбар байна. Мал аж ахуйн салбар

байна. Энэ 300 мянган малчдын эрх ашгийг хамгаалах хууль зайлшгүй шаардлагатай байна. Тэгэхээр үндсэндээ Монгол төрийн энэ бодлого болбол энэ салбарт дутагдаж байгаагийн бодит илэрхийлэл би өнөөдөр гарч байна гэж байгаа юм. Яг ингээж үлгэн салган явж байгаа энэ салбарыг бид нар ингээж бодлогоор дэмжихгүй юм бол төр нь ямар хариуцлага хүлээх юм, энэ бодлогыг нь тодорхой болгохгүй юм бол үндсэндээ уялдаа холбоог нь хангахгүй болбол мал аж ахуйн салбар гэж энэ зөнгөөрөө явдаг, бодлоготой ч юм шиг, бодлогогүй ч юм шиг ийм салбар байж бол болохгүй. Тэгэхээр энэ үндсэн дээр болбол энэ Малчны тухай хуулийн төслийг өргөн барьсан. Энэ болбол анхдагч хууль.

Энэ хууль гарч байж цаашид энэ 1 дүгээрт бид нар энэ хүнийхээ эрх ашгийг хэрхэн хамгаалах юм гэдэг асуудал гарч ирж байгаа юм. 2 дугаарт бид нар энэ салбарыг хэрхэн эдийн засагжуулах юм, энэ хөгжлийг нь хэрхэн хангах юм гэдэг суурь харилцаа гарч ирж байгаа. Энэ дотроо бид нар энэ түүхий эд бэлтгэн нийлүүлэлттэй холбоотой, үйлдвэртэй холбоотой, малчин хүний хүлээх үүрэг хариуцлагууд ч гэсэн тодорхой гарч ирж байгаа.

Нөгөө талдаа бид нар мэдлэг боловсролтой, ухаалаг мал аж ахуйг хөгжүүлэх, илүү юу гэдэг юм чадавхтай малчин хүнийг хөгжүүлэхэд төрөөс нь хүртэл дэмждэг байх зохицуулалтуудыг болбол бид нар гаргаж өгч байгаагаараа онцлогтой болчхож байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол таны хэлээд байгаа саяын тэр юу гэдэг юм үйлдвэртэйгээ хэрхэн холбох юм барих юм гэдэг юм уу энэ асуудлуудыг болбол бас цогцоор нь тусгаж өгч, уялдаа холбоог нь хангаж, түүхий эд бүтээгдэхүүний тэр чанар, бэлтгэн нийлүүлэлттэй холбоотой асуудлуудыг ч гэсэн, магадгүй технологийн гэх асуудлуудыг хүртэл бид нар хуульчилж оруулж өгч, эргээд болбол магадгүй малчин хүний хүлээх зохистой

дадлыг болбол бий болгож ирж байгаа юм.

Бид нар бусад салбар дээр болбол энэ тухайн салбарын эдийн засгийн үр өгөөж, бүтээмж гэдэг асуудлыг ярьдаг, үр ашгийг ярьдаг. Мал аж ахуйн салбар дээр бид нар огт ярьдаггүй. Тэгэхээр анх удаагаа бид нар энэ үндэсний хэмжээнд ерөөсөө малчны бүтээмж болоод мал аж ахуйн салбарын үр ашгийг тооцох арга зүйг бий болгож, үндэсний хэмжээнд нэвтрүүлэе. Үүгээрээ дамжуулж шагнаж урамшуулдаг байя, үнэлгээг гаргадаг байя.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүн тодруулж асууя. Чинзориг гишүүний микрофоныг өгөөрэй.

С.Чинзориг: Малчны хөдөлмөр бас амаргүй хүнд хөдөлмөр. Малчин хүний хөдөлмөр асар их биеийн хүчний зарцуулалт ихтэй хөдөлмөр. Хадлан тэжээлээ бэлдсэн ч, хонио хяргасан ч, ямаагаа самнасан ч асар их биеийн хүчний зарцуулалт ихтэй хөдөлмөр. Тийм учраас бол энэ малчдын хөдөлмөрийг бас жаахан хөнгөвчлөх, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, механикжуулах гэдэг ийм чиглэлийн бодлого энэ Малчны тухай хуульд байна уу, үгүй юү? Ийм юман дээр л бид нар нэлээн анхаармаар байгаа юм.

Тэгэхгүй бол бүхий л үйл ажиллагаа нь дандаа хөдөлмөр биеийн хүчний зарцуулалт ихтэй гар ажиллагаа шаарддаг ийм хөдөлмөр шүү дээ. Энийг нь бас шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, хөнгөвчлөх, механикжуулах ч гэдэг юм уу ийм чиглэлийн юм энэ хуульдаа орж байна уу үгүй юү?

Л.Мөнхбаатар: Чинзориг гишүүний тодруулгад хариулъя. Хэн хариулах вэ? Ганзоригийн Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга хариулъя.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр бид нар яах вэ яг санхүүгийн харилцаатай нь сая асуудлыг болбол уяж өгсөн. Яг үндсэндээ таны хэлж байгаагаар үндсэндээ яг ёстой өдөр, шөнийн ээлжсгүй, ажил, амралтын горимгүй, халуун халж, нөгөө хүйтэнд нь хөрч, гадаа гандаж хөдөө хөхөрч ажилладаг хүн болбол ерөөсөө малчин л хүн байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ хүний, энэ салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс, үр ашгийг нь дээшлүүлэх үүднээс бид нар яг яалт ч үгүй хөдөлмөр хөнгөвчлөх дэвшилтэт технологийг энэ салбарт нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм. Энэтэйгээ уялдуулж би санхүүгийн харилцаатай зохицуулж байгаа гэдэг нь зүйл нь болбол ерөөсөө төрөөс малчдад нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийг болбол олгодог байя. Гэхдээ энийг болбол төрөөс олгож байгаа, бий болгож байгаа хөнгөлөлттэй зээлийг зөвхөн зүгээр өдөр тутмынхаа ахуйн хэрэглээнд хэрэглэж болохгүй. Машин техник авахдаа хэрэглэж болохгүй. Энэ зориулалт нь болбол заавал ч үгүй саяын тэр юу гэдэг юм 1 дүгээрт таны хэлж байгаа хөдөлмөр хөнгөвчлөх дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд зориулалт нь байя.

Мөн дээрээс нь одоо юу гэдэг юм үүн дээрээс нь нэмэх нь тухайн тэр мал аж ахуйн салбарын гол үндсэн бүтээмжид нөлөөлөх дэд бүтцүүд болсон хашаа саравчийг ч гэдэг юм уу барих эсвэл малын тэжээл тариалахтай холбоотой эсвэл тухайн тэр хадлан тэжээлээ бэлтгэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж худалдан авахад гэдэг юм уу ийм зориулалтуудаар болбол бас оруулж өгч байгаагаараа болбол онцлогтой болоод байгаа юм. Энэ дээр би зүгээр нэмээд нэг зүйлийг хэлэхэд бид нар ер нь шинэ технологи нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай. 2-т хуучин байсан юу гэдэг юм нөгөө малчны амьдрал ахуйтай холбоотой уламжлалт эд эдлэл хийдэг, тоног хэрэгсэл хийдэг ч

гэдэг юм уу, уламжлалт юу гэдэг юм анхан шатан дээр бид нар өөрсдөө бас нэг анхан шатын ангилал тордолт, бэлтгэн нийлүүлэх энэ үйл ажиллагаа явуулдаг байсан маань болбол орхигдоод байгаа.

Адаглаад нэг юу гэдэг юм тухайн эмээл, хазаараасаа авхуулаад эсвэл олбог ширдэг мөн нэхий эдлэл зүйлээ ч гэсэн хийдэг байсан зүйлүүд нөгөө малчны амьдрал ахуй, уламжлалт ахуйтай хамааралтай эд эдлэл, тоног төхөөрөмж хэрэгсэл хийдэг байсан зүйлүүд байхгүй болчихсон зүйлийг бид нар энд оруулж өгөөд мөн юу гэдэг юм ийм хэмжээний үйлдвэрлэл эрхэлбэл төрөөс болбол нэн хөнгөлөлттэй зээлд ч гэдэг юм уу хамруулдаг байя гэсэн зориулалтыг болбол тусгаж өгснөөрөө цаашид малчин өрх үйлдвэрлэл эрхлэгч болох боломжийг болбол бас бүрдүүлж өгч байгаа юм.

Л.Мөнхбаатар: Саяын 2 хуулийг нэгтгэж болох уу гээд түрүүн Чинзориг гишүүн асуугаад байсан. Энэ нөгөөдөх Малчин өрхийн холбооны хууль чинь бол нөгөө анхны хэлэлцүүлэг нь явчихсан учраас нэгдэх боломжгүй байгаа шүү дээ. Энэ хэдийгээр. Энэ Малчны тухай хууль бол хэлэлцэх эсэх нь байгаа. Тэгэхээр Байнгын хороон дээрээ нэгтгэх санал гараагүй бөгөөд одоо чуулганд ороод ирсэн учраас нэгдэх боломжгүй байгаа шүү гэдгийг хэлье. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд асуултаа асууя.

Н.Энхболд: Яах вэ яг малчдадаа хандсан энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжиж болно, дэмжье гэж бодож байгаа. Хэдэн зүйл тодруулмаар байна. Энэ хуулиар малчдыг бүүр тусгайлан хуулиар заасан эрхтэй, хуулиар заасан үүрэгтэй болгож байна тийм ээ. Үүрэг дотроо энэ үүргээ биелүүлэх гээд заавал ийм дадалтай байна гээд заачихсан. Жишээ нь 6.4.1 дээр байгаа юм. 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс, нэмэгдэл тэжээл бэлтгэж нөөцөлсөн

байна ийм болзлыг заавал хангасан байна гэж. Биелүүлэхгүй болбол яах юм бэ? Биелүүлээгүй, энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд жишээ нь төрөөс үзүүлдэг тусламжууд зуд турхан болохоор хөнгөлөлттэй аваачиж өгдөг, үнэгүй аваачиж өгдөг асуудлууд энэтэй нь уялдаж яригдах уу? Нэг ийм асуулт байна.

2 дугаарт энэ Малчны хөгжлийн сан гэж байна 17.1. Ийм сан заавал байгуулна. Эх үүсвэрүүд нь гээд малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтэд төрөөс олгож байгаа мөнгөн урамшууллын нэг удаагийн орлогын хуваарилалт. Энэ яг юу гэсэн үг вэ? Нэг удаагийн хэчнээн хэмжээний юм орох юм бэ? Урамшуулаасаа хүн өөрөө сайн дураараа өгөх юм уу эсхүл болбол хуульд заасан учраас тэдэн хувийг нь заавал авч энэ малчныг Малчны хөгжлийн санд бүрдүүлнэ гэх юм уу?

Тэгээд араас нь бас юунууд байгаа юм. Татварын, тоо толгойн албан татварын орлогын төвлөрүүлэлтээс хуваарилах хөрөнгө. Хэдэн хувиар яаж хуваарилах юм бэ? Заавал хуваарилах уу? Тэгж байж энэ санг бүрдүүлэх үү гэх мэтчилэн. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах үндэсний үйлдвэрийн хувь нийлүүлэх хөрөнгө. Энэ үндэсний үйлдвэрүүд нь эргээд малчдынхаа санд заавал юм оруулдаг байх ийм заалт болчхов уу, хэрэгжихгүй болбол яах вэ? Сайн дурын үндсэн дээр байх юм уу, заавал байх юм уу?

2 дахь асуудал. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө гэж байна. Энэ дээр жишээ нь санхүүжилтээр энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт. Энэ дээр Сангийн яаман дээр очоод энэ нэг нөгөө зардлын ангилал код гээд юмнууд байдаг шүү дээ. Тэгэхээр энд ямар ангилал кодоор жишээ нь энэ Малчны хуулийг санхүүжүүлэх мөнгийг улсын төсөвт, орон нутгийн төсөвт тусгахаар байна.

Сумын хоршооны сан гэсэн байна. Би хэрэв андуураагүй бол энэ хоршоо хөгжүүлэх сан гэж байх ёстой. Нэг минут авчихъя дарга, байж байгаа юм уу? Тэр нэрснүүдээр нь үү эсхүл дахиад өөр бас хоршоо сум дээр байдаг Хоршоо хөгжүүлэх сангийн хажуугаар дахиад сумын хоршооны сан гэж байна уу? Зүгээр нэр юуны хувьд андуурагдчихсан байж магадгүй тэрийг нэг анхаараарай.

Тэгээд 3, 4 дэх асуулт нь энэ малчдын холбоо, малчин өрхийн холбоо, малчдын хоршоо 3-ын яг ялгаатай тал нь яаж харах вэ хэдүүлээ, давхардахгүй юу? Нэг малчин гурвууланд нь байж болох уу? Малчдын холбооны ч гишүүн, Малчин өрхийн холбооны ч гишүүн, Малчдын хоршооны ч гишүүн. Энэ зүйлүүдийг бас зохицуулах хэрэгтэй болов уу. Энэ тэгээд миний нөгөө түрүүн сая Чинзориг гишүүний асуудалтай ойролцоогоор ингээд давхар, давхар юмнууд болчихоор хүмүүс яаж ашиглах юм бол доо гэж бодоод, холбоондоо орох уу, хоршоонд орох уу? Өрхийнхөө холбоонд орох уу гэхээс эхлээд л асуудал гарах юм биш байгаа?

Л.Мөнхбаатар: Энхболд даргын асуултад хариулъя. Хуулийн төсөл санаачилсан Ганзоригийн Тэмүүлэн гишүүн хариулъя. Ажлын хэсэг нэмж болно.

Г.Тэмүүлэн: Энэ хууль дээр ерөөсөө малчин хүний хүлээх үүрэг гэж 4 л үүргийг бид нар оруулж өгсөн юм. Зүгээр тэр үүргийг юу гэдэг юм хүлээхдээ магадгүй дараах юу гэдэг юм зохистой дадлуудыг хэрэгжүүлсэн байж болно гэсэн дадлыг л бид нар оруулж өгсөн байгаад байгаа юм. Тэгэхээр дадал гэдэг маань болбол ерөөсөө зүгээр зөв дадал. Тэгэхээр тэр зөв дадлыг хэрэгжүүлээгүйн улмаас хүлээлгэх ямар нэг хуулийн шууд хариуцлага бол байхгүй. Угаасаа хүлээлгэх ч боломжгүй.

Бид нар юу хийж байна вэ гэхээр үндсэндээ магадгүй технологийн шинж

чанартай, хуучин нөгөө нэг хаврын 13, намрын 8 гээд гэдэг ч юм уу малын эрүүл мэнд үржил технологитой холбоотой ажлууд, мөн түүхий эд бэлтгэлтэй холбоотой, бэлчээр ашиглалттай холбоотой ч гэдэг юм уу тухайн магадгүй хариуцлагатай гэж болох, зөв задлалтай гэж хэлж болох малчдын дадлуудыг хуульчилж өгч, малчин хүн маань юу гэдэг юм энэ зөв дадлуудыг мал аж ахуй дээр та нэвтрүүлээч. Тэгвэл таны юу гэдэг юм ажил амьдралд болоод үйл ажиллагаа чинь илүү бас хэрэгтэй байна л гэсэн ийм дадлыг болбол оруулж өгч байгаа юм. Тэгэхээр таны хэлж байгаа саяын тэр юунууд чинь болбол юу вэ гэхээр 1 дүгээрт үүрэг дотроо бид нар оруулж байгаа нэг 4 үүргийн нэг л ерөөсөө л нутаг орноо хамгаалах, бэлчээр усан хангамжийг зөв зохистой ашиглах ашиглах гэдэг нэгдүгээр асуудал. Хоёрдугаарх нь болбол мал маллагаатай холбоотой асуудал. Гуравдугаарх нь технологийн ажлуудтай холбоотой малын эрүүл мэнд болоод үржил технологитой. Дөрөвдүгээрт нь түүхий эд бэлтгэн нийлүүлэхтэй холбоотой.

Тэгэхээр саяын тэр яг мал маллагаатай холбоотойгоо ер нь бид нар яах юм бэ гэхээр малчин хүний зөв зохистой дадал гэдэг дотроо л бид нар мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг өөрийн тоо толгой малд нийцүүлэн бүрэн хангаж, 90-ээс доошгүй хоногт хүрэлцэхүйц өвс тэжээл, нэмэгдэл тэжээл бэлтгэж нөөцлөх гэдэг асуудлыг оруулж өгч байгаа. Тэгэхээр энэ маань болбол нэг талдаа ийм л юу гэдэг юм зөв дадалтай малчин маань болбол эрсдэлийг даван туулах юм. Энэ болбол малчин хүний зохистой дадал юм гэдгийг нэг талдаа болбол бас оруулж өгч байгаагийн бодит жишээ болж гарч ирж байгаа.

Тэрнээс манайхан болбол нэг талдаа мянган малтай нь ч, 500 малтай нь ч нэг өвөлжилтийнхөө бэлтгэлийг хангачихлаа, 6 портёр өвс авчихлаа гэж яриад байдаг. Энэ болбол бас боломжгүй

болчхоод байна. Өөрөө өөрсдийнхөө тоо толгой малдаа нийцүүлж, тухайн юу гэдэг юм 3 сар ч гэдэг юм уу хүндэрлээ барилаа гэхэд болбол мал аж ахуйгаа аваад яваад байх энэ бэлтгэлийг хангаж байгаа ч гэсэн энэ зохицуулалтыг болбол бас оруулж өгсөн.

Ер нь болбол яах вэ зүгээр ер нь л уламжлалт мал аж ахуйтай холбоотойгоор авч хэрэглэж байсан ахмадуудын маань бас нэвтрүүлж байсан олон, олон бас арга аргачлалуудыг болбол бас нэвтрүүлж бас оруулж өгснийг болбол бас энэчээ хэрэгжүүлж өгөх байна. Ер нь ингэж байж цаашидаа бид нар энэ дадлуудыг харин үүрэг хариуцлага хүлээх гэхээсээ илүүтэй зөв дадлыг нэвтрүүлсэн энэ юу гэдэг юм магадгүй тодорхой үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлсэн малчин хүн маань цаашид энийг нэвтрүүлснээрээ төрөөс явуулж байгаа тодорхой урамшуулал болоод санхүүжилтийн дэмжлэг хөтөлбөрүүдэд хамрагдах, улсын болоод аварга малчдыг шалгаруулахдаа ч гэсэн энэ зөв зохистой дадлууд дээр болбол хэмжиж, нэвтрүүлдэг байх гэдэг энэ зохицуулалтыг болбол бас оруулж өгснөөрөө болбол онцлогтой байгаад байгаа юм.

Тэгэхээр болбол энэ зөв зохистой дадал болбол цэвэр тэр малчин хүний бүтээмж үр ашиг, цаашидаа тухайн тэр хүнийг шагнаж урамшуулах, түүхий эд бүтээгдэхүүний үнэлгээнээс болбол илүү.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшин асуултаа, яасан нэмж хариулах юм уу? Ганзоригийн Тэмүүлэн гишүүн нэмж хариулъя.

Г.Тэмүүлэн: Энэ хууль дээр бас нэг онцлох зүйл болбол та яах вэ энэ Малчны тухай хууль гараад ирлээ. Энэ хууль маань юу гэдэг юм холбоотойгоо ч гэдэг юм уу эсвэл малчин өрхийн холбоо,

хоршоотойгоо ч гэдэг юм уу хэрхэн уялдаж байгаа вэ гэдэг асуудлууд. Бид нар болбол энэ хууль дээр зүгээр суурь зарчмыг нь суулгаж өгч байгаа юм. Энэ суурь зарчим маань суулгаж өгч байгаа юу юм бэ гэхээр ерөөсөө малчин хүн нэгдэж нийлэх, хамтрах хорших гэдэг юм уу энийг болбол зүгээр төрөөс дэмжинэ. Бүүр бүлэг болгоод 5 дугаар бүлгийг нь болбол малчны хамтын санаачилгыг дэмжих гэдэг зохицуулалтыг оруулж өгөөд, энэ дотроо болбол малчны хамтын санаачилга, хоршил, тэр кластерын үйл ажиллагааг болбол бид нар тусгайлж оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр болбол энэ тал дээр ямар нэг юу гэдэг юм зөрчилдөх зүйлүүд бол байхгүй. Тэр хүн хоршоонд элсэнэ үү, холбоонд элсэнэ үү, тэр хүнийх нь үүрэг хариуцлага. Үүрэг хариуцлага гэнэ, тухайн хүнийх нь өөрийнх нь эрхийн асуудал болчхож байгаа юм. Энэ хуулийн хүрээнд бол бид нар юу болж байна вэ гэхээр нэгдсэн ч, нэгдээгүй ч, нийлээгүй ч зүгээр төрөөс юу гэдэг юм тэр малчин хүний суурь харилцааг нь л зохицуулж байгаа асуудал байдаг юм. Тэр хоршоо нь болбол Хоршооныхоо хуулиар, Малчин өрхийн холбооных нь тухай хууль нь болбол гишүүд нь болбол тэр хуулиараа ингээд явна. Энэ дээр бид нар зүгээр суурь харилцаа малчид нэгдэж нийлж болно. Ингэвэл болбол тодорхой магадгүй төрөөс дэмжлэг тусалцаа нь холбогдох хуулиудынхаа хүрээнд болбол зохицуулагдаад явна л гэсэн ийм зүйлүүд байгаа.

Саяын тэр Малчны хөгжлийн сан гэдэг зүйлийг болбол ер нь сум болгонд байгуулъя гэдэг зүйлийг зохицуулалтыг бас тавьж өгсөн. Хуучин сум хөгжүүлэх сан байсан гэдэг маань болбол Хоршоог дэмжих сан болчихсон. Үндсэндээ хоршоог дэмжих сан болбол нэг талдаа малчдаасаа болбол бас хол хөндий болчихсон. Зөвхөн хоршооны гишүүн хүн л тодорхой юу гэдэг юм малжуулах хөтөлбөрт хамрагдах эсвэл тэр тодорхой зээл дэмжлэг тусалцаа авах

гэдэг юм уу, тодорхой хөтөлбөрт хамрагдах боломж бололцоо нээгдээд байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө хязгаарлаад байгаа учраас бид нар малчин хүний тэр үйлдвэрлэлийг дэмжих тодорхой хөнгөлөлттэй зээл дэмжлэг тусалцаа гаргах, малчны хөгжлийн санг нь байгуулъя. Тэрэнд болбол тэр хоршооны гишүүн байхгүйгээр хамааралгүйгээр тухайн тэр юу гэдэг юм малчид хамрагдаад явах боломж.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тэмүүлэн дарга одоо Сум хөгжүүлэх сан маань бол Хоршоог дэмжих сан болонгуут нөгөө өрхийн үйлдвэрлэгч нар маань хамрагдахгүй байгаад байгаа шүү дээ. Тэгээд тэрийг бол оруулах юм уу? Энэ хуулиараа нээгдэнэ гэж ойлгож болох уу? Нээгдэж байгаа юу тийм ээ? Ойлголоо. Улсын Их Хурлын гишүүн Төмөртөгоогийн Энхтүвшин асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Малчид маань ингээд нэг бие даасан хуультай болж байгаа. Бид нар чинь Эмч нарын тухай хууль, Багш нарын тухай хууль гээд маш олон хуультай. Тэгвэл Малчдын тухай хууль гэж малчид маань бие даасан хуультай болж байгаа юм. Малчин өрх гэж яг хэнийг хэлэх юм, малчид гэж хэнийг хэлэх юм, туслах малчин гэж хэнийг хэлэх юм? хот айл хэнийг хэлэх юм гээд энэ зүйлүүдийг бол нэлээн тодорхой хуульчлаад ингээд нэр томъёотой болгоод оруулж ирж байгаа юм.

2 дугаар асуудал бол Монгол Улсын ЗГ-аас яг ямар ажил, бодлого хэрэгжүүлэх юм, Монгол Улсын төрөөс ямар бодлого хэрэгжүүлэх юм, малчдын залуу халааг яаж бэлдэх юм бэ гэдэг энэ асуудлыг бас нэлээн тодорхой тусгаж ирсэн байж байгаа. Тэгээд энэ хууль бол ямар ч байсан малчдад маань зайлигүй шаардлагатай ийм хууль байж байгаа юм. Тэгээд гарсан тохиолдол хамгийн гол нь олон нийтэд хүргэх, малчдад таниулах, сурталчлах энэ ажлыг л манай

Хүнс, хөдөө аж ахуйн болон аймаг, нийслэлийн сум, дүүргийн Засаг дарга нар нь маш сайн зохион байгуулах хэрэгтэй байгаа юм. Маш олон хууль гаргадаг. Харамсалтай нь юу гэдэг юм доод шатдаа хүрдэггүй, хөрсөндөө буудаггүй ийм зүйлүүд байдаг.

Тэгээд сая чинээлэг, малчин, Шинэ хоршоо гээд ийм томоохон хэмжээний ажил бас ЗГ-аас зохион байгуулаад явуулаа. Тэгээд энэ бол бүх шатад юу гэдэг юм энэ сургалтыг зохион байгуулж, энэ хуулийг сурталчлах, хоришиж нийлэх энэ ажлыг сайн зохион байгуулаа шүү дээ. Яг энэтэй адилхан л юу гэдэг юм энэ Малчдын тухай хуулийг олон нийтэд хүргэх, сурталчлах ажлыг л сайн хүргэх хэрэгтэй байгаа юм.

Энэ дээр тэгээд би бас энэ ажлын хэсэгт ажиллаж байсан. Энэ 5.2.6 дээр малчид маань жил болгон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт орохоор бас ийм заалт орсон байж байна. Монгол Улсын ЗГ-аас шийдвэр гаргаад ер нь Монгол Улсын иргэн болгон 2 жилд нэг удаа үнэ төлбөргүйгээр урьдчилан сэргийлэх ийм үзлэгт орохоор бас ингэж орсон байж байгаа. Тэгэхээр 1 жил гэдэг зүйлүүдээ бас эргэж нэг хараад, ингээд юу гэдэг юм ЗГ-аас гаргасан шийдвэртэйгээ уялдуулаад явах нь бас зөв болов уу гэсэн ийм бодолтой байж байна.

2 дахь асуудал маань энэ малчид маань ерөөсөө энэ Тэтгэврийн даатгалын сангийн тухай асуудлыг маш сайн ярьдаг. Ерөөсөө энэ тэтгэврийг нийгмийн даатгалыг нөхөн төлөх хугацааг сунгаж өгөөч гэдэг ийм асуудал тавьдаг. Харин энэ хууль дээр малчдын НДШ-ийг тэтгэврийг нөхөн төлөх хугацаа гээд 2026 оны 12 сарын 31 хүртэл оруулж өгсөн ийм бас сайн заалт орсон байна. Тэгээд ер нь энэ хуулийг яаралтай гаргах ёстой. Тэгээд яаралтай энийг юу гэдэг юм сайн сурталчлах, олон нийтэд хүрэх ёстой гэдэг ийм байр суурьтай байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энхтүвшин гишүүн дэмжсэн байр суурьтай үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд асуултаа асууя. Дараа нь санал хураалт явагдана. Гишүүд танхимд байраа эзлээрэй.

Г.Ганболд: Би асуулт асуухгүй. Би хууль санаачлагчийн нэг байгаа юм. Хуулийн төслийг өргөн барьсны дараа орон нутагт явж байхад бас иргэдээс, малчдын зүгээс нэлээн олон саналууд ирсэн учраас хууль санаачлагчид Байнгын хорооны даргад бас зарим нэг зүйл дээр анхаараад, хэлэлцүүлгийн явцад бас хэлэлцүүлэгт оролцуулбал гэсэн бодлоор хэлж байгаа юм.

Малчдын хувьд бол нэг заавал төрөөс ингээд л нэг зээл тусламж ч гэдэг юм уу нэг юм хүсээд байгаа юм алга л даа. Өмнөх баталсан шийдвэрүүд нь нэг жаахан амьдрал дээр жаахан хэрэгжээсэй билээ гэсэн хүсэлтүүд их байгаа юм. Тухайлбал ингээд ноос, арьс ширний урамиуулал гээд байна. Өнгөрсөн жилийн ноосны урамиууллаа ерөөсөө хөдөө орон нутгийнхан авч чадаагүй юм билээ. 30 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр байсан. Өнгөрсөн жил улсын хэмжээнд ерөөсөө 4.5 тэрбум төгрөгийг л нэг арай мэдээлэлтэй малчид нь авсан. Ихэнх нь зайлуул хөдөө мэдээлэл байхгүй. Тэгээд энэнээсээ болоод ингээд бүх ноосны урамиууллын эх үүсвэрүүд нь буцаагаад хураагдчихаад байгаа юм. Тэгээд нэгэнт малчид авч чадахгүй байгаа юм болбол энэ ноос, арьс ширний урамиууллын энэ мөнгөнүүдийг шууд энэ сандаа хийгээд явчихвал, сангийнхаа эх үүсвэр болгоод явчихвал яасан юм бэ гэсэн нэг ийм бодол байгаа юм Тэмүүлэн даргаа.

2 дугаарт нь болбол энэ бид нарын энэ хуулийн гол санаа нь болбол бас энэ малчид ер нь энэ байгалийн давагдашгүй хүчин зүйлээс болоод эрсдэлд их орж байна. Энэ дээр төр засгийн зүгээс ямар нэгэн шийдвэр гаргахгүй байна гэдэг ийм

зүйл байсан учраас хуульд нэг заалт оруулсан юм. Жишээлбэл онцгой байдлын албан хаагч ажил үүргээ гүйцэтгэж яваад амь нас нь эрсдэх юм болбол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин буюу 330 орчим сая төгрөгийн нөхөн олговор авч байгаа. Бага хүүхэд нь 18 нас хүртэл цалин хөлс урамиууллыг нь авч байгаа. Гэтэл малчид мал сүргийнхээ араас явж байгаад эрсдэлд орж байна. Энэ болбол хэдийгээр хувийнхаа хөрөнгийг хамгаалах гэж явж байгаа ч гэсэн Үндсэн хуулиар болбол мал сүрэг төрийн хамгаалалтад байх ёстой. Тэгэхээр төрийн хамгаалалтад байх ёстой тэр өмч хөрөнгийг хамгаалж яваад эрсдэлд орчихоод байгаа юм. Тэгээд энэ дээр нэг багахан хэмжээний урамиуулал оруулж байгаа. Энийг болбол бас жаахан нэмэгдүүлэх ёстой юм шүү гэдгийг өнгөрсөн жил ингээд Төв аймгийн Эрдэнэсант сумд гэхэд идэрхэн насны 4 эмэгтэй ингээд эрсдэлд ороод, 6 хүн нас барсан. Тэгээд энэ дээр төрөөс ямар нэгэн дэмжлэг тусалцаа байдаггүй. Тэгээд энэ асуудлыг ер нь болбол бас бид нар энэ хууль дээрээ жаахан нэмэгдүүлэх ёстой юм байна гэдэг энэ санааг хэлэх гээд байгаа юм.

Нөгөө талаар энэ ипотекийн зээлийн нэг санал оруулсан бид нар энэ хуулийн төсөл дээр. Энийгээ бас нэг жоохон тодорхой болгохгүй болбол ипотекийн зээл маань одоо бид нар заавал нэг инженерийн шугам сүлжээтэй барилга байгууламжууд гээд байдаг. Гэтэл хөдөө орон нутгийнхан чинь болохоор нэг сумын төвдөө нэг байшин бариад, хашаа байшин аваад бас нэг тэр зээлд хамрагдчих саналтай байдаг. Тэгэхээр энэ малчдын яг олгох гэж байгаа ипотекийн зээлийн нөхцөлийг заавал Улаанбаатар юм уу, аймгийн төвд инженерийн шугам сүлжээтэй орон сууц гэхээсээ илүүтэй эсвэл бүүр малчид өөрсдөө өвөлжсөө, хаваржсаа дээрээ бас ая тухтай орчинд амьдрах гээд бас аятайхан байшин барилга барьчихсан олон айлууд байна шүү дээ. Тэгээд ийм хэмжээний барилга

байгууламж барих юм болбол энэ ипотекийн зээлд хамрах асуудлыг энэ хууль дээрээ жаахан нарийвчилж оруулахгүй болбол бид нарын энэ өргөн барьсан хууль дээр бас нарийвчлагдаагүй ийм зүйлүүд нэлээн байгаа учраас энийгээ анхаарах ёстой юм байна гэдгийг би хамтарч хууль өргөн барьсан Тэмүүлэн гишүүнд, бас Байнгын хорооны дарга эд нарт энэ хэлэлцүүлгийн явцад нэлээн анхаарах ёстой юм байна гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүн бас хууль санаачлагчдын нэг байгаа. Энэ хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа бол Байнгын хороон дээр хэлэлцэх үед бол Ганболд гишүүний саналуудыг бас анхаарах нь зүйтэй байх. Их чухал санаанууд хэллээ. Ипотекийн зээлийг шугам сүлжээгүй малчны хотонд ч гэсэн хүргэх талаар бүлгийн дарга Тогтохсүрэн дарга анхаарах нь зүйтэй. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооны саналаар Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн хуульд оруулах тухай.../үг тасрав/

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр бас хуулийн төслүүдийг бас нэлээн мэтгэлцээнтэй, өргөн хэмжээнд хэлэлцэж байна. Өчигдөр бас зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр 69 хууль баталсан гэдгийг хууль баахан бөөндөөд байна гээд л явуулаад байна лээ. Энэ чинь хууль бөөндөж байгаа юм биш. Хууль эцэслэн батлах санал хураалтыг нэгтгэж явуулж байгаа шүү дээ. Тэгээд 1 хууль батлахад дагасан 9, 8 хууль, нэр томьёоны өөрчлөлт ч юм уу орж ирдэг. Заримдаа 10, 20-иод хууль орж ирдэг. Тэрнийг нэгтгээд хувилахаар

л баахан хууль, хуулийг машиндаад байгаа юм шиг. Долоо хоногт нэг удаа ингээд хурааж байгаа. Заримдаа 2 долоо хоног, 3 долоо хоногийн хуулиуд нэгтгэж ингэж эцэслэн батлах санал хураалт хийж, хураадаг. Энэ бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 39-өөс дээш гишүүн санал өгч, дэмжиж, хураадаг болсон. Хурууны хээгээр.

Энэ шүүмжлээд байгаа улсууд бол 12-оос 16 онд 7, 8-хан гишүүн сууж байгаад л 20 хүний кноп дараад л, бусдынхаа кнопыг төгөлдөр хуурдана гэж дараад л, тэгээд л хууль баталчихдаг байсан. Тэгвэл одоо болбол 39-өөр бөөндөж ингэж эцэслэж баталдаг энэ заалтыг бол буруу ойлгоод байгаа юм шүү.

Ингээд санал хураалт явуулъя. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж дууссан. Үг хэлж дууссан, дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууссан. Ингээд малчны эрх зүй, Байнгын хорооны саналаар Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 51,3 хувийн саналаар санал дэмжигдэж, хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлж байна.

12.36 цаг

Дөрөв.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн

**найруулгын төсөл болон хамт өргөн
мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн
газар 2024.05.15-ны өдөр өргөн
мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна. Танхимын хууль.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн 86-д Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах гэж заасныг үндэслэн тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан танилцуулж байна.

Улсын Их Хурлаас 1995 онд ХАҮТ-ын тухай хуулийг батлан мөрдүүлсэн бөгөөд эдийн засаг бизнесийн хурдацтай хөгжиж байгаа өнөөгийн орчин нөхцөлд тус танхим зохицон ажиллах, ААНБ-ыг төлөөлөх чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа нь энэхүү хуулийг боловсронгуй болгох практик шаардлагыг бий болгож байна. Хуулийн төслийг дээрх үндэслэл шаардлага болон олон улсын сайн туршлагыг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд ХАҮТ-ын бүтэц, тогтолцоог сайжруулах, чиг үүргийг шинээр тодорхойлох, төрийн шийдвэр гаргах ажиллагаанд бизнес эрхлэгчдийн оролцоог хангахтай холбоотой зохицуулалтыг тусгасан болно.

ХАҮТ нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах зорилгыг хэрэгжүүлэх бөгөөд Монголын Үндэсний танхим, аймаг, нийслэлийн болон салбарын танхим, гадаад улс дахь төлөөлөгчийн газраас бүрдэхээр тусгалаа.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оролцох, бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн холбогдох байгууллага албан тушаалтанд төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, тэдгээрийн үйл ажиллагаа, шийдвэрийн үр нөлөөг сайжруулахтай холбоотой санал зөвлөмж хүргүүлэх болон зөвлөл, хороо, комисс, ажлын хэсэг зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах замаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар тусгалаа.

Аймаг, нийслэлийн танхимын тухайд тухайн аймаг нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуй үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэн зохион байгуулахаар. Харин салбарын танхимыг эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа мөн тооны хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэн зохион байгуулахаар тусгаж, үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэхээр заалаа. Түүнчлэн аймаг, нийслэлийн болон салбарын танхимууд нь Монголын үндэсний танхимын гишүүн байх ба харин аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь Монголын Үндэсний танхимд гишүүнээр элсэхгүй бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн

засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим, эсхүл аймаг, нийслэлийн өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг нийслэлийн танхимд сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэх замаар Монголын үндэсний танхимын үйл ажиллагаанд оролцохоор боловсрууллаа.

Мөн ХАҮТ-ын санхүүгийн бие даасан байдлыг хангах хүрээнд Монголын үндэсний танхимын үзүүлэх үйлчилгээ болох гарал үүсэл тодорхойлох, гэнэтийн буюу давагдашигүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлыг гэрчлэх бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх баримт бичиг олгох, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ болон арбитр эвлэрүүлэн зуучлал зэрэг үйлчилгээний хөлсний хэмжээг Монголын үндэсний танхимын удирдах зөвлөлд тогтоохоор тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар ХАҮТ-ын бие даасан байдлыг хангах, аж ахуй эрхлэгчдийн хууль эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, төр, хувийн хэвилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцөл боломж бүрдэнэ гэж үзэж байна. Иймд хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданишатар: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн тэнхимийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 5 сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн зорилго, үйл ажиллагааны зарчим, бүтэц, удирдлага, зохион байгуулалт, үндсэн чиг үүрэг, гишүүнчлэл, санхүүжилтийн эх үүсвэр, төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах, улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид бие даасан хараат бусаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгчдийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор хуулийн төслийг шинэчлэн боловсруулжээ. Хуулийн төслийг *d.parliament* цахим сайдад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хурал хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг монополийг задлах, чөлөөт зах зээлийг дэмжих, санхүүжилтийн асуудлыг олон улсын жишигт хүргэх, бие даасан байдлыг хангах чиглэлээр ямар зохицуулалт орсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Ундрам хуулийн төсөл салбарын танхим нь аймаг, нийслэлд нэг байхаар туссан нь хүн ам болон идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ААН цөөн аймагт хэрхэн хэрэгжих, боловсон хүчний асуудал, хуулийн төслийг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуультай хэрхэн уялдуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин танхимын зүгээс ААН болон ажиллах хүчний эрх ашгийг хамгаалах асуудлыг Хөдөлмөрийн хуультай хэрхэн уялдуулсан, АМНАТ-ийн асуудлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт хэлэлцээрийг хийхэд танхимын төлөөллийг оролцуулах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг хуулийн төслийг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуультай хэрхэн уялдуулсан талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Ундрэм эдийн засгийн бизнесийн чиглэлээр хуулийн төслийг хэлэлцэн батлахад танхимын төлөөллийг оролцуулдаг байх, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин ААН-үүдийг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүнийг баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн талаар идэвх санаачилгатай ажиллах, эдийн засаг, бизнесийн салбарын хууль тогтоомжийг орон нутагт мэдээлэх, сурталчлан таниулах ажилд идэвхтэй оролцох, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танхим Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих хуулийн сайн багтай болж энэ талаар бодлогын түвшинд саналаа илэрхийлдэг байх, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг хууль хоорондын нийцлийг хангах, аливаа хууль урт хугацаанд тогтвортой үйлчилдэг байх гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

ХАҮТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, ХАҮТ-ын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол,

сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ганболд гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд би нэг зүйл хэлье. Энэ удаагийн Улсын Их Хурал, ЗГ-аас бол тухайлбал бизнесийн харилцаанд ажил олгогч, үйлдвэрчний эвлэл, ЗГ-ын 3 талын оролцоотой нэлээн хамтын ажиллагаа сайн явагдаж байгаа гэж би бол ингэж ойлгож байгаа юм. Тэгээд энэнээс ч өөр арга байхгүй.

Тэгэхээр би юу асуух гээд байна вэ гэхээр зэрэг энэ Их Хурал дээр ч яригдах юм, тэгээд Их Хурал дээр яригдаж байгаа учраас олон нийтэд бол нэг тийм янз бүрийн ойлголт төрүүлээд байна л даа. Тухайлбал ингээд төр бизнесийг бүгдийг нь булааж авч байна, төрийн оролцоог нэмэгдүүлээ гэх мэтчилнээр ийм асуудлууд яригдаад байх юм. Үүнтэй холбоотойгоор жишээлбэл татварын орчин асар их муудсан, татварыг нэмж байна үндэслэлгүйгээр нэмж байна гэх мэтчилэнгээр ийм зүйлүүд яриад байгаа юм. Энэ дээр та бүхэн маань ингэж ЗГ-тайгаа хамтарч ажиллаж байгаа нэг оролцогч талын хувьд энэ дээр энэ ажлын хэсэгт орсон хүмүүсээс нэг тодорхой хариулт өгөх бололцоо байх уу гэж нэг ийм зүйл.

Дараагийнх нь юм болбол ер нь энэ ёс зүйн тухай асуудлыг бол Монголын нийгэм тэр чигээрээ ер нь бараг ярихгүй гэж, ярихгүй болчихсон байсан гэж хэлэхэд болно л доо. Тэгээд энэ Улсын Их Хурлаас, ЗГ-аас энэ ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой, авлигал ашиг сонирхлоос ангид байх энэ томоохон бодлогын хүрээнд бол ер нь нийгмээрээ энэ ёс зүйн тухай асуудлыг ярьдаг болжээ. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо энэ шатны гишүүрийг дээрээс нь шүүрдэнэ, Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ, бид өөрсдөөсөө эхлэх ёстой гээд Их хурлын гишүүний ёс зүйн дүрэм, хуулиа баталж авсан. Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хууль батлагдсан. Энэ хуулиар заагдсан том хороо ТАЗ зөвлөлийн дэргэд байгуулагдсан. Тэгээд би сайшааж хэлэх гэж байгаа юм болбол Монголын ХАҮТ дэргэдээ Ёс зүйн төв байгуулсан гэж би ингэж мэдээлэл авсан. Энэ бол би сайшааж, талархаж, баяр хүргэж хэлэх гээд байгаа юм.

Үүнтэйгээ холбогдуулаад нэг айхтар юм болбол энэ улс төрийн сонгуулийн үеэр энэ мөнгөний хамааралтай байдаг ийм асуудлууд их байна. Энэ яригдаж байгаа зүйлүүд бол энэ улс төрийн намууд энэ жагсаалтад орж байгаа хүмүүсээсээ бүүр санаанд багтахааргүй ийм мөнгө байршуулахыг шаардаж байгаа, өгөхийг шаардаж байгаа ийм зүйлүүд яригдаад байна гэх юм. Сонгуулийн хороо бол бас нийтэд мэдээлэл хийсэн. Энэ сонгуулийн тойргуудад зарцуулагдах мөнгөний дээд хэмжээ гээд бас л мөн дааж давахгүйгээр, хүний санаанд багтахааргүй ийм мөнгөн дүн хэлсэн. Ингээд бид нар болбол энэ сонгуулийг ард иргэд маань энэ ардчилсан Үндсэн хуулийнхаа суурь зарчмаар чөлөөтэй энэ засаг төрөө байгуулах, энэ саналаа өгөх, сонгуульд оролцох ийм боломжийг нь хангах, ерөөсөө бид нарын зовлонгийн шалтгаан бол энэ авлигал, ашиг

сонирхолтой холбоотой л юм байгаа шүү дээ. Энэ нийгэмд салахгүй буглаад байгаа энэ хатгийг яаж арилгах вэ гэдэг л ийм асуудал.

Гэтэл нөгөө талдаа эргээд энэ сонгууль маань ерөөсөө мөнгөний хамааралтай. Мөнгөний хамааралтай байна гэдэг бол цаанаа авлигал, ашиг сонирхлын хүлээсэнд байна гэсэн үг. Тэр мөнгө өгсөн эздэдээ үйлчилнэ. Энэ нийтийн эрх ашгийн төлөө болбол ямар ч байр суурь илэрхийлэхгүйгээр ингээд сууж байдаг улс шүү дээ. Үе үеийн парламентад сууж байгаа нэг хэсэг улс нь болбол дарга юу гэж хэлнэ, мань дагана. Нөгөө нэг хэсэг улсууд нь болбол тэгээд л ашиг сонирхлын энэ зөрчилдөө баригдсан, нийтийн эрх ашгийн төлөө ган хийдэггүй ингээд л сууцгааж байдаг л улсууд бий шүү дээ. Харин ч.../минут дуусав/

Г.Занданиатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна.

Б.Энхбаяр: Тэгэхээр танхим бол манай хувийн хэвшил, баялаг бүтээгч бизнес эрхлэгчдийн хуульчлагдсан олон нийтийн ийм бүтэц байгаа. Тэгэхээр энэ албан ёсны бүтэцтэйгээ төр нь ойлголцож 1 дүгээрт ажиллах, 2 дугаарт ер нь энэ бүтэц рүүгээ төр өөрийн бас олон чиг үүргүүдийг шилжүүлж, өөрийн дотоод ардчилсан тэр удирдлагад нь бас нэлээн эрхүүдийг нь өгье гэдэг ийм үзэл баримтлалаар батлагдсан. Тэр утгаараа хувийн хэвшил бизнесийн байгууллагуудаас таны хэлсэнчлэн нэлээн их хариуцлага энэ хуультай хамт бас нэхэгдэж цуг очно. Эрхтэй хамт хариуцлага нь цуг очно.

Тэр ч утгаараа манай бизнес эрхлэгч байгууллагууд бас нэлээн энэ хууль батлагдсаны дараа дотоод зохион байгуулалт дээрээ бас анхаарах байх гэж бодож байна. Таны хэлсэнчлэн ер нь одоо бид нар чинь даваа гарагт улс төрийн намууд нэр дэвшигчдээ тодруулж

дуусна. Зарим намууд бол нэр дэвшигч зөвлөлөө байгуулаад байгаа асуудлууд байгаа. Ер нь бол хувийн хэвшил маань өөрөө их өндөр ёс зүйтэй байх шаардлага тулгарна. Ер нь урьд урьдын сонгууль дээр гарч байсан шиг хүмүүсийг нэр дэвшингүүт нь хонгилддог барьдаг, хуулийн байгууллагууд сонгуульд ийм байдлаар дам нөлөөлдөг ийм юмыг бол гаргахгүй. Аль ч намын тухайд бол Ерөнхий сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тухайд нэр дэвшигчийг ингээд нэр дэвшсэн хойно барьж саатуулдаг, сонгуульд нь нөлөөлдөг ийм зүйлийг гаргахгүй гэдэг дээр би бас нэг үг хэлмээр байгаа юм.

2 дугаарт энэ зарим намууд мөнгө цагаан, нүд улаан болоод жагсаалтаа ялангуяа жагсаалтын эхний 5-ыг 10-аас 15 тэрбумаар зарж байгаа мэдээлэл бол байгаа. Энэтэй холбоотой хувийн хэвшлийн томоохон бизнесийн байгууллагуудаас мөнгө цуглуулж байгаа асуудал бас авагдаж байгаа. Тийм учраас би бол урьдчилаад хэрэг төвөгт орсных нь дараа биш, хэрэг төвөг гарахаас нь урьдчилан сэргийлүүлж, ялангуяа улс төрийн намууд, намын удирдлагууд, мөн бизнесийн компанийн тодорхой захирлуудад хандаж яг өнөөдөр, маргааш, нөгөөдөр гэсэн энэ 3 өдрүүдэд хэрэгт орж гогодуулав. Энэ тохиолдолд бол саяын ярьж байгаа асуудал яригдахгүй шүү. Яагаад гэхээр энэ бол төрийн эрхийг хууль бусаар авах гэмт хэрэг байгаа.

Тэгэхээр олон тэрбум төгрөгөөр жагсаалтыг наймаалж, баялаг бүтээгчдээс мөнгө байгаа авч байгаад гардуулбал тухайн нам, намын удирдлага, тухайн компанийн захирал битгий харамсаарай, хууль өөрөө үйлчилж таарна шүү гэдэг зүйлийг бас урьдчилаад хэлчихье гэж бодож байна.

Г.Занданишатар: 3 номер Энхтүвшин Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга.

Д.Энхтүвшин: Бат-Эрдэнэ гишүүнд асуулт асуусанд баярлалаа. Тэгээд ер нь 1 дүгээр асуулт дээр эдийн засаг дахь энэ төрийн оролцооны талаар бас хариулт хэлье. Одоогийн байдлаар ер нь өнгөрсөн хугацаанд ААН-үүд маань өөрсдөдөө тулгарсан асуудлаа нэг нэгээрээ ч юм уу эсвэл ингээд цаг, зардал мөнгөтэйгөө асуудлаасаа болоод өөрсдөө нэг нэгээрээ ингээд асуудлуудаа шийддэг нь өөрөө энэ авлигал, төрийн байгууллагуудын энэ хүнд суртал гээд энэ юмнуудыг бас нэлээн өөгшүүлж байгаа. Тэгэхээр энэ байдлыг өөрчилж, энэ танхимын хуулиар нэг ААН компанийн асуудлуудыг ярьдаг биш, салбарын нийтлэг эрх, хууль зүйн эрх ашгаа хамгаалдаг энэ чиглэл рүүгээ илүү болгоё гээд, танхимын гишүүн нь өмнө компаниуд байдаг байсныг болиулаад, энэ тухайн эдийн засгийн салбар дээрх холбоо юм уу, танхимууд нь гишүүн нь байдаг.

Тэгэхээр өөрөөр хэлбэл тухайн салбарын асуудлуудаа тэр танхим юм уу, холбоон дээрээ ярьдаг. Нийтлэг эрх ашгуудаа татвартай ч юм уу, улсын хөгжил, салбар хоорондын уялдаатай холбоотой асуудлуудаа энэ үндэсний танхим дээрээ ярьдаг. Тэгэхээр энэ илүү нийтлэг эрх ашгаа ярьдаг болё гэсэн. Тэгэхээр энэ идэвхтэй ингээд оролцоод ирэхээр энэ хувийн хэвшлийн юу оролцоо нь илүү зөв болоод, илүү тодорхой хамтын ажиллагаа нь энэ үр дүндээ төрийн байгууллагуудтай ямар салбарт төр нь орох юм, орохгүй юм гэдэг юмнуудыг нь илүү тодорхой болгож өгье гэсэн бодолтой байгаа.

2 дугаарт нь энэ ёс зүйтэй холбоотой асуудал та бас их зөв юу чухал асуудал хөндөж байна. Сүүлийн үед бас энэ анхны компаниуд бараг 30 гаруй жил болоод үе шилжилттэй холбоотой асуудлууд явагдаж байгаа. Тэгээд энэ үед нь бас энэ үе шилжилтийг зөв хийх талаар танхим ААН-үүддээ тусалъя. Тэгээд энэ боломжийг ашиглаад энэ ёс зүйг дараагийн үед нь юм уу, энэ

бизнесийн ёс зүй илүү нээлттэй болгох, ил тод болгох чиглэл рүү нь тусалж ажиллая гэсэн ийм чиглэлээр ажиллаж байгаа. Тэгээд энэ чиглэлээр аль болох олон компаниудыг.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн асуулт асууна.

Г.Амартүвшин: Баярлалаа. Танхимын тухай хууль орж ирж байгаад баяртай байна, дэмжиж байна. Өмнө өргөн барьсан хуулийг миний бие Ундрам гишүүн, Ганхуяг гишүүн бид хэд өргөн барьсан, нэлээн хэл амтай бас улс төржсөн тийм асуудал өрнөсөн. Тэгээд одоо бид нар бол тэр хуулиа эргүүлэн татсан. Тэгээд ямар ч байсан шинэ удирдлага нь томилогдоод нэлээн хурдан, богино хугацаанд ажиллаад энэ хууль орж ирж байгаад талархаж байна.

Ер нь бол танхим бол манай ААН, хувийн хэвилийнхний танхимаар дамжиж төр засагтай харьцдаг гол холбоос нь байх ёстой ер нь бол. Chamber of commerce-н гол зорилго нь тэр 1 дүгээрт. 2 дугаарт бид нар лобби, лобби гэхээрээ их л муу буруу юм гэж ярьдаг, лоббид өртчихлөө. Гэтэл баруунд ялангуяа Америкт бол лоббиг бол хуульчилчихсан. Компаниуд нь танхим юм уу, холбоодоороо дамжуулаад өөрийнхөө тэр парламент юм уу, сенатдаа ингээд нөлөөлөөд явдаг, өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалдаг. Тэгэхээр манай танхим энэ дээр энэ ААН-үүдээ төр засгийн өмнө ялангуяа хууль баталж, хэлэлцэж баталж байхад илүү хүчтэй орж ирэх дуу хоолойтой баймаар байна. Энэ талаар шинэ төсөлдөө яаж тусгасан бэ?

2 дугаарт танхим болохоор бизнесүүдийг хооронд нь уулзуулдаг бас ингээд салбар дундын харилцааг сайжруулдаг ийм бас нэг тавцан байх хэрэгтэй. Энэ тал дээр ямар шинэ зохицуулалт орж ирж байна вэ? Бизнесүүд бол Монгол Улсдаа үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдээ

гадаадад болон дотоодод сурталчлах бас гол үүрэг роль байдаг. Энийгээ ямар байдлаар хэрэгжүүлэх вэ? Үйлчилгээ үзүүлдэг. Зарим орнуудад ялангуяа Европт энэ танхимууд нь бүүр компанийн бүртгэлийг нь хийдэг. Би жишээлбэл очоод аль нэг Европын улсад очоод бизнес нээе гэхээр танхимаар нь дэмжээд, тэнд нь бүх бүртгэлийг нь хийгээд, тамга тэмдэг, данс, банкны данс энэ тэр нээх бүх заавар тусалцааг нь үзүүлдэг. Тэгэхээр энэ тал дээр бас танхим маань яаж ажиллах гэж байна гэдгийг би асууя.

Бид нарыг өмнө бас энэ танхимын хуулийг хэлэлцэж байхад энэ олон улсын гадаад компаниудыг төлөөлдөг танхимууд байна шүү дээ. Атчат, Eurochamber гээд бусад энэ танхимуудад энэ өмнө хуучин хуулийн төсөлтэй нэлээн тийм сөрөг эсрэг байр суурьтай байсан. Тэд нарын эрх ашиг, тэд нарын бас сонирхлыг энэ шинэ төсөлтэй яаж тусгасан бэ гэдгийг би асууя.

Ер нь бол энэ жишээ нь Хөдөлмөрийн хууль, Зөвшөөрлийн хууль, Татварын хуулиуд дээр бол уг нь энэ ААН-үүд энэ танхимаараа дамжаад нэлээн сайн оролцмоор байгаа юм л даа. Бид нар бол Зөвшөөрлийн хууль болж байна, хэрэгжиж байна үгүйг мэр сэр компаниудтай өөрсдөө уулзаад мэдэж байгаа боловч яг бид нарт ийм байдлаар хэрэгжиж байна, хэрэгжихгүй байна гэдгийг бас бид нарт бас мэдээлж баймаар байна. Хөдөлмөрийн хууль ч гэсэн. Одоо уурхайн компаниуд 14, 14 дээр нэлээн лобби орж байгаад бид нар баталсан. Гэтэл яг амьдрал дээрээ энэ хэрэгжихдээ нөгөө ААН-үүд бол уурхайн компаниуд чинь эсрэг болчихсон байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ тал дээр бас нэг тодорхой хариу өгнө үү? Баярлалаа.

Г.Занданшатар: 3 Энхтүвшин ХАҮТ-ын дарга.

Д.Энхтүвшин: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгээд

хуулийн төсөл дээр 6.1 дээр энэ танхимын энэ хууль тогтоох хэмжээнд яаж оролцох талаар бас заалтууд оруулсан байгаа. Тэгээд энэ улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл бодлогын, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оролцох, мөн аж ахуй эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, мөн 6.1.5-д эдийн засгийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд хуульд заасан журмын дагуу санал өгөх, холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах гээд заалтуудыг нь оролцоог нь нэлээн тодорхой заагаад өгчихсөн байгаа. Энэ чиглэлээр бас хууль батлагдвал илүү идэвхтэй оролцох бололцоонууд байгаа.

Дээр нь түрүүн хэлсэн. Нэг компанийн тухайлсан компанийн асуудлууд биш нийтлэг эрх ашгуудыг ярьж байгаа учраас энэ чиглэлээр илүү бодлогын түвшинд оролцох боломжтой болно гэж бодож байна.

2 дахь асуудлын хувьд танхим хоорондын уялдаануудын үндэсний танхим дээр энэ Үндэсний удирдах зөвлөлд нь үндэсний салбар танхимууд болон аймаг, нийслэлийн танхимуудын ерөнхийлөгч нар нь байхаар байгаа. Тэгэхээр энд болбол өмнө нь бол нэг тухайлсан компанийн асуудал ярьдаг байсан бол салбар хоорондын асуудал, эдийн засгийн хөгжил, нийтлэг татвар, нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцаа, хөрөнгө оруулалт гэх мэтчилэн нийтлэг арга хэмжээнүүдээ авахаар ийм өөрчлөлтүүд орж байгаа. Тэгэхээр энэ нь энэ бололцоонуудыг илүү хангах байх гэж бодож байна.

Amcham болон бусад гаднын худалдааны танхимууд бас Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Amcham, Auscham, Eurochamber гээд.

Тэгээд энэ байгууллагуудтай бас хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг, ярилцлагууд хийсэн байгаа. Тэгээд энэ дээр гол асуудал бол нэрийн хамгаалалтын асуудал байсан. Танхим гэдэг нэрийг өмнөх хуулийн төсөл дээр бас нэрийг хамгаалахаар заасан байсан, түүн дээр нэлээн энэ заалтаа авчих, бусад тал дээр болбол бас гол энэ асуудал бол нэрийн хамгаалалтын асуудал байна гээд. Тэгээд эд нартай ярилцаад, нэрийн хамгаалалттай холбоотой заалтыг хассан байгаа.

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Танхимын хууль өмнө нь нэг орж ирээд, одоо шинэчилсэн нь орж ирж байх шиг байна. Өмнөх болбол үнэхээр социалист цаашаа тийм хууль байсан. Заавал танхимд элсэн, элссэн нь заавал татвар төлнө, тэгээд яана, яана ч билээ. Харин тэрний хажууд бас нэлээн арай чөлөөлөгдсөн маягийн ийм хууль байх шиг байна. Тэгэхдээ л бас энэ хуулийг ингээд эргүүлээд харахаар нэлээн тийм нэг их тийм шаталсан бүтэцтэй, бараг л төрийн байгууллага шиг л орон нутгийнх байна, нийслэлийнх байна гэсэн үү, тэгээд салбар танхимууд, нэгдсэн танхимууд, айхтар их тийм их зохион байгуулалтын бүтэц рүү шахсан, яг энэ бизнесийн бизнесүүд эвлэлдэн нэгдэж байгаа, бизнесийн байгууллага гэхэд бас нэлээн тийм захиргааны байгууллагын шинжтэй ингээд энэ дээр харагдаж байна. Энэ яагаад үзэл баримтлал нь бас энэ тал руугаа ингээд явчхав 1 дүгээрт нь.

2 дугаарт нь тэр Мэргэжлийн нэгдсэн холбооны хууль гэж өмнө нь саяхан батлагдсан. Тэр хууль дээр чинь салбарт зөвхөн нэг салбарын төлөөлөх нэг л мэргэжлийн холбоо байна. Энэ нь төрийн байгууллагатай бараг гэрээ хийнэ, хамтарсан гэрээ хийгээд, гэрээгээ дүгнэнэ, яана ч билээ. Бараг л яамны сайд томилчихоор шахуу тийм салбарын нэгдсэн холбоо байна гэсэн хууль

батлагдсан санагдаж байна. Тэгэхээр энэ чинь яг энэ бүтэц зохион байгуулалт, тэр төрийн байгууллага чинь тэр салбарын нэгдсэн холбоотойгоо хамтран ажиллана гэсэн санаатай хууль батлагдчихсан. Тэгэхээр энд танхимын энэ давхардал чинь яаж гарах юм бэ? Бас л танхим дээр тухайн нэг мэргэжлийн холбоо, мэргэжлийн салбар зөвлөлүүд, мэргэжлийн салбар танхимууд энэ дээр байгуулагдах байх л даа. Тэгэхээр энэ давхцал, энэ зөрчлүүд илт харагдахаар л ийм л зүйлүүд л харагдаж байна л даа. Энэ давхцалыг яг яаж гаргах гэж байгаа юм бэ?

Тэгээд тэр юутай илүү тийм нэг захиргааны бүтэц рүү энэ танхимын энэ бүтэц, зохион байгуулалт чинь орчхоод байгаа юм биш үү? Захиргааны шаталсан, нэг ер нь энэ бүтэц чинь яг яагаад ингэж ийм арай илүү эрх чөлөөтэй тал руу нь, бизнесүүдийг нь илүү тийм эвлэлдэн нэгдэж байгаа, бодлогоороо нэгдэж байгаа, үйл ажиллагаагаараа нэгдэж байгаа энэ сайн дурын үндсэн дээр гэдэг шинжээс яагаад ингээд холдоод байгаа юм бэ? Энэ 2 асуултад тодруулга өгөөч.

Г.Занданишатар: 3, Энхтүвшин Монголын ХАҮТ-ын ерөнхийлөгч, ажлын хэсэг.

Д.Энхтүвшин: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Өмнө өргөн барьсан хуулийн төслийн хувьд бол бас нэлээн нэг байгууллага дээр хүч төвлөрүүлсэн ийм шинжтэй байсныг энэ сүүлд оруулж ирж байгаа энэ хуулийн төсөл дээр нэлээн тараасан ийм байдалтай болгож байгаа. Тэгээд өмнөх хуулиар энэ бүс, орон нутгийн зохион байгуулалтаар аймаг, нийслэлийн танхим байхаар зохицуулсан. Гэхдээ өнгөрсөн хугацаанд бас энэ нь хангалттай бий болж чадаагүй. Тэгээд энэ дээр шинэ хуулийн зохицуулалтын саналаар болбол эдийн засгийн тухайлсан салбарт 50 дээр нэмэх ААН-үүд өөрсдөө сайн дурын үндсэн дээр

эвлэлдэн нэгдэж, тухайн эдийн засгийн салбарын танхимыг байгуулж болохоор заасан байгаа. Тэгэхээр энэ байгууллага нь бол тусдаа бие даасан үйл ажиллагаа явуулахаар ийм бүтцүүд байгаа.

Тэгэхээр энэ бие даасан бүтцүүд нь нийлээд танхимыг жишээлбэл бүрдүүлж байгаа. Өөрөөр хэлбэл доороосоо дээшээ маягтай. Дээрээс захиргаадсан ч юм уу ийм бүтэц нь бол өмнөхийг бодвол харьцангуй өөр болсон гэж болгосон. Мэргэжлийн холбоодын хувьд сайн дурын, 2 дахь асуудал чинь юу билээ, мэргэжлийн?

Г.Занданишатар: Энхтүвшин, 2 номер, товч тодорхой хариулъя.

Л.Загдаа: Тодруулж хариулъя. Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хуультай бол яг зөрчилдөж байгаа зүйл байхгүй. Тухайлбал Мэргэжлийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулагчид нь болохоор иргэн, ААН, тухайн салбарын мэргэжилтнүүд нийлж байгуулж байгаа бол салбарын танхим, аймаг, нийслэлийн танхимыг бол ашгийн төлөө хуулийн этгээд буюу ААН, компаниуд байгуулж өгч байгаа.

2 дугаарт ХАҮТ-ын тухай хууль дээр яг энэ мэргэжлийн нэгдсэн холбоотойгоо уялдаж, хамтарч ажиллахаар заалтыг 11 дүгээр зүйлийн 11.6 дээр оруулж өгсөн байгаа. Тухайлбал тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН, бизнес эрхлэгчдийн дийлэнх олонхыг хамруулсан ТББ-д тухайн салбарын чиг үүргийг хэрэгжүүлэх эрхийг нь шууд гэрээний үндсэн дээр Үндэсний танхимаас шилжүүлж өгөх тийм зохицуулалт байгаа. Тэгэхээрээ тухайн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоотойгоо ХАҮТ нь энэ 2 хуулийнхаа хүрээнд хамтраад, тухайн салбарын асуудлыг нэгтгээд, нэг дор ярилцах ийм боломж бүрдэж байгаа гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Ням-Осорын
Учрал гишүүн.

Н.Учрал: Энэ Мэргэжлийн нэгдсэн холбооны хуулийн төслийн бас санаачлагчийн хувиар Мэргэжлийн нэгдсэн холбоо болбол Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд заасан эдийн засгийн салбар ангилуудаар байгуулагдана. Тэгээд мэргэжлийн холбоонууд нэгдээд мэргэжлийн нэгдсэн холбоогоо байгуулах буюу үүнд хувийн хэвшил, ААН-үүд, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоонууд, мэргэжлийн салбарын экспертүүд нэгдэж байгуулахаар хуульчилсан. Тэгэхээр мэргэжлийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн танхим 2 болбол яг хамтарч ажиллах ёстой. Тэгэхээр болбол мэдээж танхим бол өөрийн чиг үүрэгтэй.

Тэгэхээр Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимыг болбол бид нар илүү бяртай л болгох хэрэгтэй юм шиг байгаа юм. Тэгэхгүй бол үнэхээр Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимыг зүгээр нэг ТББ-ын хэмжээнд авч үзээд байхаар л өнөөдрийн асуудлууд үүсээд байна шүү дээ. Жишээ нь зах зээл рүү бүдүүлгээр довтолдог халдлагуудыг хэд хэдэн удаа хийх гэж энэ парламент оролдож байна шүү дээ. Тэгэхээр өнөөдөр бид Эмийн хуулийг хэлэлцэж байхад эм ханган нийлүүлэгч нарыг оролцуулахгүйгээр шийддэг байдлаа болих л ёстой шүү дээ. Банкны хуулиудыг хэлэлцэж байхад арилжааны банкнуудынх нь төлөөллийг оролцуулахгүйгээр шийддэг байдлаа болих л ёстой шүү дээ.

Тэгээд янз бүрийн сонсгол хийгдэж байна. Тэр сонсголд ашиг сонирхол нь зөрчигдөөд байгаа салбарын төлөөллийг оролцуулахгүйгээр зах зээлийг зохицуулж, эдийн засгийг өргөжүүлнэ гэж угаасаа байхгүй шүү дээ. Тэгэхээр өнөөдөр яг энэ чөлөөт зах зээлийг дэмжих бодлогыг авч явъя гэвэл төр зарим чиг үүргээсээ татгалзаад л,

мэргэжлийн холбоонуудаараа шилжүүлээд л. Танхим өөрөө тэр ААН-үүдийнхээ тусламжтайгаар энэ хууль, эрх зүйн орчин дээр дүгнэлт хийхгүй бол өнөөдөр бизнесийн салбарыг яамны 4 мэргэжилтэн тодорхойлоод хуульчилж өгчхөөд, одоо өрсөлд гэвэл ийм механик засварууд болбол өнөөдрийн энэ чөлөөт зах зээлийг боомилсон олон шийдвэрүүд бол цаашидаа үр дүнд хүрэхгүй.

Тийм учраас ямар ч үед бай, ямар ч парламентын үед бай, ямар ч ЗГ-ын үед бай Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим илүү хүчирхэг байх ёстой. Тэгээд тэр салбарын хуулиудаа зохицуулдаг, чөлөөт зах зээлээ аварч үлдэх дээрээ үргэлж хатуу зогсож байх ёстой. Хувийн хэвшилд эргэлдэж байгаа мөнгө төгрөгийг нэмэгдүүлэх ёстой болохоос төрийн төрд өөрөө эргэлдээд байгаа мөнгө төгрөг нэмэгдээд, төрийн оролцоо зах зээл болгон руу ороод эхэлсэн цагт болбол энд бол хөгжил дэвшил ярих бололцоогүй болно. Тийм учраас энэ танхимын хуулийг парламентын гишүүдийг бас бүгдээрээ дэмжээд, энэ хуулийг илүү энэ танхимд эрх, үүргийг нь өгөөд хийгээд өгөх нь болбол цаашидаа энэ улс оронд хэрэгтэй гэж харж байна.

Дээрээс нь танхимтай хамтраад энэ Цахим хөгжлийн яамны зүгээс бол бид нар өнгөрсөн хугацаанд зөвшөөрлүүдийг цахимжуулах ажлуудыг хийсэн.

Сая ebiznes платформ жилийн хугацаанд 17 мянган хэрэглэгчтэй болсон. 500 гаруй компаниуд байгуулагдсан. Дээрээс нь энэ арбитр гэдэг Арбитрын хуулийн дагуу арбитрын үйл ажиллагааг тэр явуулах эрх бол танхимд хадгалагдаж байдаг. Тэгэхээр арбитр болбол өөрөө тийм дэвшилтэт шүүх л дээ. Тэгэхээр НҮБ-ын загварт нийцсэн Арбитрын хууль өнгөрсөн парламентын үед батлагдахад миний бие бас ажлын хэсгийг нь ахалж байсан. Тухайн үед арбитрыг цахимаар шууд хүсэлтээ тавиад л, арбитраар асуудал хэрэг маргаанаа шийдүүлдэг байх юм бол өнөөдөр энэ нэг шүүхийн үүд

сахиж, зарлан мэдэгдлээ хүлээдэг байдал бол таслан зогсох учраас танхим энэ арбитрыг илүү амилуулах тал руу нь ажиллах ёстой. Тийм учраас энэ хуульд ч гэсэн уг нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлэхэд тулгараад байсан асуудлуудаа шийдэх ёстой гэж ингэж үзэж байгаа.

Энхбаяр сайдаас нэг зүйлийг асууя. Хувийн эрх зүйн шинэчлэл хийе, одоо энийг хэзээ хийх вэ? Өнөөдөр Дампуурлын хуулийг гаргамаар байна. ААН-үүдийгээ дэмжсэн энэ татварын бодлого руугаа ормоор байна. Хувийн эрх зүйн шинэчлэл хийхгүй бол эрүү, зөрчил ярьсаар байтал энэ чинь хувийн хэвшил чинь эрх ашгаараа хохироод байна шүү дээ.

Г.Занданишатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Сүүлийн ер нь 30 жил бид нар чинь эрх зүйн шинэтгэлдээ мэдээж олон шинэтгэлүүд хийж байгаа. Гол төлөв нийтийн эрх зүйн шинэчлэлээ хийсэн. Нийтийн эрх зүйн хуульчид бэлдсэн гэдэгтэй би санал нэг байдаг. Сүүлийн 8 жил буюу 2016 оны ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2020 оны мөрийн хөтөлбөр, 2016 оны ХЗДХЯ-ны тэргүүлэх чиглэл, 2020 оны ХЗДХЯ-ны тэргүүлэх чиглэл нь хувийн эрх зүйг хөгжүүлэх асуудал байгаа.

Хувийн эрх зүйг хөгжүүлэх хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Арилжааны хууль, Иргэний процессын хууль, Газрын шинэтгэл, Дампуурлын хууль, Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн барьцааны хуулиуд зэрэг олон хуулиуд үе шаттайгаар явж байгаа. Хувийн эрх зүйн хуульчдаа бэлдэх асуудал тулгамдсан асуудал болж байна. Энэ хүрээнд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд хуульч, эрх зүйч бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн 30-аас доошгүй хувь нь хувийн эрх зүйн чиглэлийн хичээлүүд

байна гэдэг асуудлыг ярьж явж байгаа. Тэгэхгүй бол манайх таны хэлсэнчлэн сургуулиуд 70, 80 хувьд нь ерөөсөө эрүү, энэ нийтийн эрх зүй, төр засаг гэсэн ийм хуулиуд яриад, яг бизнес арилжаа, хувийн хэвшлийнхээ зовлон, жаргал энэ асуудлыг ойлгодог эрх зүйчид байхгүй болчихсон байгаа.

Өнгөрсөн онд Монгол Улсын ЗГ Ром хотод төвтэй Олон улсын хувийн эрх зүйн хүрээлэнгийн гишүүн байгууллага болсон. Энэ байгууллага болбол дэлхийн хувийн эрх зүйн судалгаа хүрээлэн бүх эрх зүйн гэрээ эрх зүйн уураг тархи байгаа. Манай улс өнгөрсөн онд л гишүүнээр элссэн. Би энэ онд тодорхой асуудлууд тавиад, энэ олон улсын эрх зүйн хүрээнд Монгол Улс мөнгө гаргаад, жилдээ хувийн эрх зүйчдээ мэргэшүүлэх бодлого барьж байгаа юм. 2025 оны төсөв дээр хамгийн багадаа би 1 тэрбум төгрөг тавих гэж байна. Өөрөөр хэлбэл хувийн эрх зүйчдээ бэлдэхгүй болохоор энэ бизнес, эрх зүй, арилжаа, гэрээ энийг ерөөсөө ойлгодог, зөв бичдэг, эрсдэлээс сэргийлдэг, хуульчидгүй болчихоод байна.

Энэний үр төлөөс аягүй өндөр байгаа. Олон улсын том, том корпорацуудтай Оюу толгой мэтийн ийм том гэрээ хийхэд манай талаас бэлтгэгдсэн хуульчгүй байгаа. Тийм учраас гаднын олзонд ороод байна гэсэн үг. Төлөөс нь маш өндөр байгаад байна. Тийм учраас энэ дээр.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр ХАҮТ-ын хуулийг бол дэмжиж байна. Бизнесийг дэмжих, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг хурдасгах, тэгээд бизнесийн салбар дахь ажилтнуудын, бизнес эрхлэгчдийн нийтлэг дуу хоолойг төрд бодлого үндэслэлтэйгээр хүргэхэд болбол энэ хууль бол нэлээн чухал үүрэг гүйцэтгэнэ. Тэгээд хууль санаачлагч болон танхимаас 2, 3 асуулт байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд улс орныг бүсчлэн хөгжүүлэх, тухайн салбар бүсийн онцлогтой уялдуулан бизнесийн болон уурхай, хөдөө аж ахуй тодорхой бүсийн онцлогууд байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөлд танхимын бүтэц, бодлого дээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай хэр уялдаж байгаа вэ? Үүнтэй холбоотой ямар зохицуулалт орж байгаа вэ гэдгийг нэгд асууя.

2 дугаарт нь дөнгөж саяхан манай Улсын Их Хурлаас Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан. Миний бие бас ажлын хэсэгт ажилласан. Баттөмөр гишүүн ахлан батлуулсан энэ хуульд маань яг эдийн засгийн салбарын бизнесийн салбарын төлөөллүүд төрд дуу хоолойгоо хүргэх, тодорхой эрх ашгаа хамгаалуулах, мөн нөгөө төрийн ажил үйлчилгээг гэрээгээр шилжүүлэх зэрэг нэлээд өргөн хүрээтэй дэвшил бол гарсан байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл маань Мэргэжлийн нэгдсэн холбоодын хуулийн төсөлтэйгөө бас хэрхэн уялдах вэ?

Ер нь бол энэ 2 хууль маань яг нэг зохицуулалттай, нэг үр дүнд хүргэхээр явж байгаа. Түрүүнд бас зарим гишүүд маань хэлж байна. Ер нь төрөөс бас хувийн хэвшил дэх оролцоо, бизнесийн салбар дахь тодорхой эрх ашгийг хөндсөн, хэт орсон ийм өмнөх практикуудыг засах чиглэлээр, төр дэх бизнесийн дуу хоолойг нэмэгдүүлэх чиглэлд энэ 2 хууль маань яг нэг агаартай явах ёстой гэдгийг онцолж байна.

3 дахь нэг хуулийн төсөлд маань энэ бизнесийн болон тодорхой иргэдийн хоорондын эдийн засгийн шинжтэй маргаануудыг эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаагаар дамжуулан зохицуулна гэж орсон нь бол үнэхээр бас сайшаалтай заалт байна. Ер нь эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа маань сайн явах, тэр дундаа жижиг бизнесүүд, компаниудын хоорондын асуудлыг шүүх

гэхгүйгээр тодорхой зуучлалын үндсэн дээр шийдэх нь болбол их олон талын ашигтай. Цаг хугацаа, бизнес, хөрөнгө мөнгө.

Дээр нь нөгөө Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, шүүхийн ачаалал процессыг ч гэсэн хөнгөлөх ийм сайхан зохицуулалт орж байгаа юм байна. Тэгэхээр яг танхим яг энэ эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн бүтэц байгуулах уу? Энэ дээр яг ямар зохицуулалт орж байгаа юм гэдгийг асууя.

Г.Занданшатар: 3 номер, ХАҮТ-ын ерөнхийлөгч Энхтүвшин, Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөлд аймаг дундын танхим байгуулж болохоор ийм заалт зохицуулалт орсон байгаа. Тэгэхээр салбар дунд болон аймаг дундын энэ танхимууд байгуулагдаж болохоор зохицуулалтууд байгаа. Өнгөрсөн хугацаанд бас яг энэ бүс орон нутгийн зохион байгуулалтаар бас амжилттай яг хуулийн хүрээнд бүтцүүд бас хангалттай бий болж чадаагүй, 2 л Улаанбаатар хотын танхим болон хот Дарханы танхим гээд 2 л танхим бий болсон. Тэгээд энэ нөгөө эдийн засгийн бололцоо боломжуудаасаа хамаардаг учраас ер нь сая энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гарсантай уялдуулаад энэ аймаг дундын юм уу, энэ бүсийн шинжтэй энэ танхимууд байгуулах бололцоо энэ хуулийн заалт дээр тусгасан байгаа.

Эдийн засгийн Мэргэжлийн нэгдсэн холбоодын хуультай энэ хууль маань танхимын хууль маань уялдаж ажиллана. Тухайн эдийн засгийн салбарт 50-аас дээш ААН-үүд нэгдэж танхим байгуулж болно. Эсвэл тухайн салбарт олонхын төлөөллөө авсан төрийн бус байгууллагуудтай холбоотой хамтарч ажиллахыг гэрээний үндсэн дээр хамтарч ажиллахаар ингээд заасан

байгаа. Тэгэхээр энэ Мэргэжлийн нэгдсэн холбоодын хууль гарснаар саяын тэр тухайн салбарын олонх төлөөллөө авсан эдийн засгийн энэ чиглэлийн байгууллагуудтай шууд хамтарч ажиллах ийм бололцоотой болсон байгаа. Тэгээд 11.6 дээр яг энэ талаар заалтууд тусгасан байгаа.

Бизнесийн эвлэрүүлэн зуучлах бүтэц бол ер нь болбол бизнесийн маргаан болбол яг бизнесд маргаан шийддэг процесс маань бизнесийн хурдтай бол бас нэлээн нийцэхгүй бараг энэ шүүхээр явахад компаниуд маань дампуурах ийм хэмжээнд байгаа. Тэгэхээр энэ наана нь өөр хурдан шийддэг ийм бүтэц зохион байгуулалтуудыг бас илүү ашиглах ёстой юм байна гээд энэ арбитр болон арбитрын наана бизнесийн эвлүүлэн маргаан, маргаан эвлэрүүлэн зуучлах төвийг ажиллуулах нь зүйтэй юм байна гээд хууль гарахаас өмнө бас танхимын дэргэд бизнесийн маргаан эвлэрүүлэн зуучлах төв гээд байгуулаад, хүмүүс тодорхой хэмжээнд бид нар хуулийн төслүүд дээр бас саналууд өгөөд ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хууль хэрвээ батлагдвал энэ чиглэлээр илүү бодитой бүтцүүд бий болж, ААН-үүд компаниуддаа бас нэлээн ойлголтууд өгөх болов уу гэж бодож байна.

Энэ бизнесийн харилцааг бас хариуцлагажуулах бас юу чухал шаардлагатай байгаа. Тэгэхээр энэтэй холбогдуулаад Арилжааны хууль ч гэдэг юм уу, зарим нэг хуулиудыг бас зохицуулалтуудыг энэ бизнесийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой энэ харилцаануудыг илүү хурдан шийддэг ийм зохицуулалтууд бас хийх шаардлагатай байгаа харагдаж байгаа. Тэгээд энэ яваандаа бизнес эрхлэгчдийн зүгээс энэ саналуудыг бас холбогдох дэд бүтцүүдээр, холбогдох байгууллагуудаар дамжуулж тавина гэсэн ийм бодолтой байгаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. ХАҮТ-ын тухай хуулийг дэмжиж байгаа юм. Гэхдээ энд бид нар бодмоор, бодмоор зүйлүүд байгаад байгаа юм ишг байгаа юм. Би бол тэгж хараад байдаг. Бид энэ бизнесийн салбарын хөгжлийг хангах энэ эрх зүйн орчин юман дээрээ нэлээн нэг бодитой дүн шинжилгээ хийж, тэгээд саад тотгор болоод байгаа юмнуудаа хэрхэн зөв зохицуулах вэ гэдэг асуудлаа нэг гаргаж ирэх ёстой. Тэгэхээр энэ хуулиар ХАҮТ-д ер нь энэ чиглэлийн эрх, үүрэг нь ямархуу байдлаар орж байгаа юм бэ гэдэг асуудал байна л даа. Энэ Монгол улсын эдийн засгийн гэдэг юм уу, бизнесийн таатай орчин бүрдүүлэлтдээ ямархуу байдлаар үнэлгээ хийх юм, тэр үнэлгээнийхээ дүнг ямархуу байдлаар энэ төр засагтаа тавьж шийдүүлж явах ёстой юм гэдэг нэг ийм зүйл байгаа гэж.

2 дугаарт энэ бизнесийн байгууллагууд гэдэг юм уу, энэ томоохон компаниудаа энэ дэлхий нийтийн чиг хандлага руу нь явуулах талаар ер нь ямар эрх эдэлцгээх юм бэ энэ ХАҮТ? Энэ чинь олон нийтийн засаглалтай, ил тод, эрүүл, ёс зүйтэй бизнесийн тухай л яриад байна шүү дээ дэлхий нийтээрээ. Тэгэхээр манайхан чинь тэгэхгүй, төр тусгайлан хууль гаргаж байж сая нэг банкны салбарын монополыг задлах, олон нийтийн засаглалтай болгох хэлбэр лүү нь шийдэж байна. Тэгэхээр энэ цаашид энэ хэт төвлөрлүүдээ ер нь юу гэж үзээд байгаа юм бэ? Одоо наадах чинь эргээд явж, явж жаал олон жил ноцолдож байж, үндэсний үйлдвэрүүдээ босгож ирэх гэж явсан юм маань буцаагаад үнэ ханиш, монополчлолоосоо болоод дахиад наад үндэсний үйлдвэрүүд чинь унах хэлбэр лүүгээ явах гээд байна шүү дээ. Одоо наад гурилын талынхаа юмнуудыг хар, цементийн талынхаа юмнуудыг хар.

Энэ Монголын энэ зах зээл жижиж зах зээл юм. Тэгээд дээр нь энэ дотоодын

үйлдвэрлэлээс гарч ирж байгаа бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээлийн үнээсээ бараг хэд дахин өндөр шахуу юм болчихоод байна шүү дээ. Тэгэхээр үүн дээр ямархуу байдлаар энэ ХАҮТ тэр салбарын мэргэжлийн холбоод гэдэг юм уу, тэр салбарын танхимуудынхаа хүрээнд яаж ажиллах юм бэ? Энэ ер нь ямар асуудал байх юм гэж.

Дараагийн нэг зүйл ер нь энэ Монгол олигтой хөгжиж чадахгүй, эдийн засаг нь тэлж чадахгүй байгаа юм. Дэлхий рүү гарчихсан том компани бүтээгдэхүүнгүй болчихоод байна шүү дээ бид. Тэгэхээр үүнийгээ хөгжүүлэх тал дээр ер нь ямар бодлогын чиг барьцаах юм бэ? Яаж эд нарыгаа хооронд нь кластер хоршилтой явуулах юм бэ гээд бидэнд хиймээр гэдэг юм уу, загварчилмаар зүйлүүд их байна. Тэгээд үүнийг ер нь энэ хуулиар ХАҮТ-д ямархуу байдлаар эрх, үүргийнх нь харилцаанд тусгал оруулж өгөөд байгаа юм бэ гэдэг асуудал.

Нөгөө талд энэ бизнесийн байгууллагуудын хамгаалалтын тухай асуудал байгаа юм. Тэгэхээр наад ХАҮТ-ын дэргэдэх арбитр чинь эвлэрүүлэн зуучилна гэхээсээ илүүтэйгээр бас тэр бизнесийн салбарынхныгаа хамгаалах чиглэлийн юм нь юу байх юм гэдэг юм байгаад байна л даа. Энэ чинь нэлээн л тал бүрээс нь л нэлээн сайн харж асуудлаа зөв шийдэхгүй бол энэ ер нь цаашид эдийн засгаа тэлэх, ажлын байраа нэмэгдүүлэх, тэгээд өөрсдийнхөө хэрэглээг тодорхой хэсгийг нь дотоодоосоо хангаж чаддаг чадамжийн тухай, тэгээд гадагшаа гарсан урсгалтай валют дотогшиллуудаг бүтээгдэхүүнүүдийн тухай энэ тэр гээд бид олон л юм бодмоор байгаад байдаг. Тэгээд үүн дээр бол би хамгийн гол үүрэг гүйцэтгэх, төртэйгөө хамтрах ёстой байгууллагыг нь бол би ХАҮТ-ыг юм байна. Дэлхийн улс.../минут дуусав/

Г.Занданишатар: ХАҮТ-ын Ерөнхийлөгч Энхтүвшин хариулна.

Д.Энхтүвшин: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Яг таны хэлдгээр бусад улс орнуудад эдийн засгийн гол ачааг хувийн хэвшил нь үүрч явдаг. Тэгээд энэ хувийн хэвшил нь өөрийнхөө дуу хоолой болон төр засагтай хамтран ажиллахад, энэ бодлогын түвшинд хамтарч ажиллах бүтэц нь болбол ХАҮТ гэдэг бүтцүүд дэлхийн бүх улсууд бараг ийм байгаа. Зарим нь ач холбогдлоосоо хамаараад зарим нь бараг төрийн байгууллагын хэмжээнд хүртэл байдаг.

Тэгээд бүх компаниудаа жишээлбэл заавал гишүүнчлэлтэй гэдэг ийм бүтцүүдээр хүртэл шахдаг. Тэгэхээр танхимын төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны яг энэ бүтцүүд дээр энэ танхимын харилцаа бүтцийг нь зөв болговол илүү тодорхой жишээлбэл болгох, дээр нь энэ чиглэлийн тэр бодлого болон судалгаатай холбоотой чадавхуудад нь бэхжүүлэх ийм боломжууд бий болно. Тэгээд танхимын хувьд болбол дэргэдээ энэ судалгааны чиглэлийн, судалгааны бүтэц, тэгээд дээр нь судалгааны байгууллагуудтай болон бусад энэ мэргэжлийн судалгаа хийдэг ийм байгууллагуудтай хамтарч ажилладаг. Тэгээд энэ чиглэлээр дүн судалгааны тайлангаа жишээлбэл бизнесийн орчны судалгааг бол 3 жилд нэг удаа хийж танилцуулдаг. Энэ нь Алсын хараа 2050 бас хөтөлбөрт энэ судалгааны үзүүлэлтүүд бас орчихсон явж байгаа. Тэгээд энэ чиглэлээр гарсан судалгааны дүн мэдээгээ бол төрийн бас байгууллагууд болон бусад оролцогч талуудад өгч тавьдаг байгаа.

Тэгээд энэ чиглэлийг энэ шинэ хуулийн төслөөр илүү мэргэжил, тухайн эдийн засгийн салбарын холбоод болон танхимуудтай хамтарч ажиллах болсноороо тухайн эдийн засгийн салбарын асуудлууд нь мэргэжлийн тэр холбоо болон танхимууд дээрээ нэлээн чадавхжиж, нийтлэг саяын татвартай холбоотой, хөрөнгө оруулалттай

холбоотой, хөдөлмөрийн харилцаатай холбоотой, улсын эдийн засгийн чиглэл, бодлого, экспорттой холбоотой асуудлуудаа үндэсний танхим дээрээ нэгтгэж, энэ чиглэлийн судалгаа болон тинк танк гэдэг энэ чадамжуудаа нэмэгдүүлэх боломжтой болж байгаа.

Тэгээд бизнес хамгаалах чиглэлээр ер нь бол өнгөрсөн хугацаанд бас ингээд харахаар 30 гаруй жил Үндсэн хууль батлагдсанаас хойш ингээд харахаар хувийн хэвшлийн бас бүтэц маань бас хангалттай сайн өөрчлөгдөж чадаагүй байгаа. Монгол Улсын хамгийн том компани бол ТӨК хэвээрээ байна. Нийт топ 100 ААН болон төрийн 5 компани нийлээд нийт эдийн засгийн эргэлтийн 90 гаруй хувийг жишээлбэл хийж байгаа. Тэгээд энэ топ 100 ААН-ийн бараг 80 гаруй нь төрөөс олгодог зөвшөөрөл, лиценз дээр үндэслэсэн ийм бизнесүүд байгаа юм. Өөрөөр хэлбэл жишээлбэл уул уурхайн лиценз, тэгээд телеком, банк ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ харилцаанууд маань бас энэ компаниудын өрсөлдөх чадварт тодорхой хэмжээгээр бас ингээд нөлөөлдөг. Зах зээлийн хэмжээний хувьд бол бас гадагшаа гарах бололцоо, боломжуудад нь яг энэ дээр бол дорвитой бас ахиц хийж чадахгүй байгаа.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн. Байж байгаарай. Дараа нь ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Нармандахын Жамъянхүү. Түрүүнээс хойш энэ хувийн эрх зүйтэй холбоотой асуудлуудаар саяын Батжаргал гишүүний асуултыг бодоод, нэгмөсөн хариулчхаарай. Тийм. Ганболд гишүүн.

Г.Ганболд: Миний цаг ч нэлээн явчихлаа. Би бол өөрөө яг тийм бизнесийн салбарын хүн биш учраас танхимын үйл ажиллагааг бол сайн мэдэхгүй. Орон нутгийг нь бол сайн мэднэ. Орон нутгийн танхимын салбарууд бол жилд нэг орон нутагтай хамтарч нэг үзэсгэлэн худалдаа хийдэг.

Тэрнийхээ түрээсээр оршин тогтнодог. Жилд нэг хэдэн шилдэг байгууллагад шалгаруулдаг ийм л байгууллага. Тэрний гишүүн байсныхаа төлөө давуу эрх эдэлж байгаа юм алга, хамгаалуулж байгаа юм алга, өөр ямар ч санхүүжилтийн эх үүсвэр байхгүй. Энэ агуулгаараа бол би төв холбоо нь ч гэсэн миний иргэн хүний хувьд анзаарахад бол би тэгж л ойлгодог юм шүү дээ. Ерөөсөө нэг топ 50-ийг хэдэн ААН шалгаруулдаг юм байна, нэг үзэсгэлэн худалдаа хийдэг юм байна. Гадаадад нэг төрийн айлчлалд нэг хэдэн бизнес оруулдаг юм байна. Түүнээс өөрөөр би 4 жил болоход яг танхим гишүүн байгууллагуудынхаа эрхийг хамгаалж, салбарын хуулиуд хэлэлцээд ингээд явж байхад би нэг ч удаа танхимыг би орж ирж байгааг хараагүй.

Түрүүн эрүүл мэндийн салбарынхан дээр бид нар, хувийн хэвшил, төрийнхний бас нэлээн маргаан болсон. Тэрний танхим ямар ч дуу хоолой гаргаж байгаагүй. Тэгээд энэ хуулийн оруулж ирж байгаа яг хууль санаачлагчийн илтгэлээс харах юм болбол байгууллагын гол орлого ордог арбитр, эвлэрүүлэн зуучлах, тэр гадаад худалдааны янз бүрийн зөвшөөрөл өгдөг юмнуудынх нь тарифыг, үнэ тарифыг нь өөрсдөө тогтоох ийм эрх авах гэж л орж ирж байгаа юм байна гэсэн миний зүгээр ойлголт байна. Энэ агуулгаараа болбол би юу хэлэх гээд байна гэхээр жоохон нийгэмд энэ байгууллагын үүрэг оролцоог нэг жоохон тодорхой болгоод, энэ гишүүн танхимын гишүүн болсноороо энэ ААН өөрсдийнхөө эрх ашгийг яаж хамгаалуулах юм бэ? Өөрсдийнх нь эрх ашиг хөндөгдөж байгаа аливаа салбарын хууль чуулганд орж ирэхэд тэд нарын өмнөөс танхим өөрөө дуу хоолой болж орж байж, энэ гишүүн байгууллага болохын мөн чанарыг 1 дүгээрт ойлгуулах.

2 дугаарт нь энэ гишүүн байгууллагууд олон гишүүнчлэлтэй болсноор энэ танхим өөрөө бас өөрөө

эдийн засгийн хувьд чадавхжих, тэгээд нөгөө талаасаа бас энэ дээр болбол би орж ирж байгаа энэ хуулиуд дээр нэлээн анхааралтай танхим дуу хоолой болдог байх ёстой байх гэж ингэж бодож байгаа юм. Орж ирж байгаа хууль дээр бас энэ орон нутгийн салбаруудыг бүсчилнэ гэдэг болбол амаргүй. Бүсийн гэхээсээ илүүтэй орон нутгийн энэ танхимууд ХАҮТ-ын байгууллагуудыг яаж орон нутагт нь бас арай жаахан нэр хүндтэй, энэ бизнесийн салбарынхныхаа төлөө ингээд явдаг нэг тийм юм руу л оруулахгүй ингээд л хуучнаар нь орон нутгийг ингээд орхиод явах юм болбол нэг их айхтар тийм өөрчлөгдсөн хууль гэж бол би харахгүй байна. Тэгээд энэ тал дээр та хэд маань ер нь орон нутгийг дэмжих тал дээр ямар бодлого барьж байна вэ?

Нөгөө талаар энэ байгууллагын хувьд бол яах вэ зүгээр энэ үйл ажиллагааны зардал мэдээж байдаг байх. Би бүтэц бүрэлдэхүүнийг нь мэдэхгүй юм. Ер нь бол ямархуу хэмжээний бүтэц бүрэлдэхүүнтэй байдаг байгууллага вэ ер нь? Тэр нөгөө талаасаа бол нэг барилга байгууламжийн хувьд бол бас харьцангуй гайгүй барилга байгууламжтай, энэ төрийн өмчийн юм байна уу, яг танай өөрийн гишүүн байгууллагуудынхаа санхүүжилтээр барьсан зүйл байна уу? Өмчлөл нь яг хаанаа явдаг юм бэ? Эндээс орж байгаа орлого нь болбол нэг иймэрхүү хэмжээний барилгатай ААН бол үйл ажиллагаагаа аваад явчих хэмжээний л байгаа л даа. Тэгэхээр би гол ярих гээд байгаа юм нь түрүүний эрх шилжүүлэх гээд байгаа тэр хэдэн хураамжуудаа бас өөрийнхөө мэдэлд очингуут их өндөр хэмжээгээр нэмчихгүй гэх баталгаа байгаа юу? Одоогийн байгаа түвшинд нь аваад явчих тийм боломж.../минут дуусав/

Г.Занданшатар: ХАҮТ-ын ерөнхийлөгч Дашицэрэнгийн Энхтүвшин 3 номер хариулна.

Д.Энхтүвшин: Ганболд гишүүний асуултад хариулъя. Танхимын хувьд бол бүтэц бүрэлдэхүүний хувьд нэг одоогийн байдлаар 100 орчим хүний ийм бүтэцтэй. Тэгээд бүх аймгуудад салбартай ийм бүтэцтэй ажиллаж байгаа. Байрны хувьд болбол энэ Хятадын буцалтгүй тусламжаар баригдсан ийм байр байгаа. Тэгээд өмчлөлийн хувьд болбол төрийн өмчийн бүртгэл нь төрийн өмч дээр байдаг. Тэгээд энэ дээр яах вэ ашиглалтын байдлаар бид нар ингээд явдаг, яг танхим дээр бол өмчлөл нь байдаггүй ийм байгаа.

Таны бас яг хэлж байгаа асуудалтай бол тодорхой хэмжээнд бас яг санал нийлж байгаа. Энэ танхимын хувьд болбол бас ер нь бол жижиг, дунд ААН-үүдийн хувьд болбол эрх ашиг жишээлбэл угаасаа илэрхийлээд ч сонсохгүй гэдэг утгаараа ер нь болбол энэ бизнесийн төлөөллийн байгууллагуудад нэг их оролцдоггүй. Тэгээд өөрөө өөрсдөө дангаараа яваад байдаг. Жишээлбэл хурал, шийдвэр гаргагч нартай уулзахдаа яг өөр өөрсдийн компанийнхаа асуудлуудаа ингэж илэрхийлж явдаг. Илүү том гэх юм уу ийм компаниудын хувьд болбол энэ төлөөллийн байгууллагуудаараа дамжуулж, ассоциаци, энэ холбоо, тэгээд танхим, chamber-уудаараа дамжуулж ингээд илэрхийлж байгаа.

Тэгээд энэ дээр болбол танхимын хувьд болбол бас нөгөө энэ шинэ хуулийн төслөөр илүү төвлөрлийг нь сааруулж, дотоод танхимтай, танхимгүй жишээлбэл үйл ажиллагаагаа явуулж байгаа энэ мэргэжлийн салбарын төрийн бус байгууллагуудтай нэлээн ойрхон ажиллахаар ингээд өөрчлөлт тусгасан байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ болбол танхимын чадавх бол илүү сайжирна. Ялангуяа бодлогын өмгөөллийн чиглэлээр болбол илүү сайжирна гэсэн тийм хүлээлттэй байгаа.

Ер нь орон нутгийн өнгөрсөн Танхимын хууль бол орон нутгийн

танхимууд байгуулагдахаар заасан боловч яг энэ бүтцүүд ажиллаж чадахгүй байгаа. Тэгээд танхимын дэргэдэх салбарууд болбол яг энэ орон нутаг болон танхимын энэ төлөөллийг тодорхой хэмжээнд хангах төдийд л танхимаас төв танхимаасаа санхүүжилт авдаг, тодорхой хэмжээний орон тоонууд, цөөн тооны орон тоотой. Зарим нэг аймгуудын хувьд бол бас өөрийн байр савтай болох гээд, тэнд бизнесийн идэвхжилүүд нь өндөр байдаг учраас ажиллах гэж байгаа ийм цөөхөн аймаг л байгаа. Ихэнх нь болбол бас төлөөлөгчийн шинжтэй, төртэй холбоотой зарим нэг хувийн хэвилийн асуудлууд дээр оролцох ийм төдий ийм шинжтэй байгаа. Тэгэхээр яг хангалттай болбол бас төлөөлөл юмнууд нь хийж чадахгүй байгаа юм.

Тэгээд ер нь болбол энэ бизнесийн салбарт бас асар олон төрийн бус байгууллагууд байдаг. Тэгээд энэ чиглэлийн заримдаа жишээлбэл шийдвэр гаргагч нарын хувьд болбол төлөөллийн байгууллага нь хэн гол төлөөлөх юм бэ гэдэг дээр бас асуудалтай тулгардаг. Асар олон төрийн бус байгууллагууд байдаг учраас танхимыг бас зүгээр нэг бусад ТББ гэдэг байдлаар хандах хэмжээнд жишээлбэл хууль, эрх зүйн орчин нь одоо ийм байгаа учраас ийм байдлаар ханддаг. Тэгээд энэ хуулийн өөрчлөлтийн дараа илүү.../минут дуусав/

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Худалдааны танхимын хуулийг бол дэмжиж байна. Энийг хэлэлцээд батлаад явах нь зүйтэй гэж. Манай Худалдааны танхим болбол хамгийн анх удаа Монголд бол Ёс зүйн танхимыг байгуулсан. Ёс зүй гэдэг асуудал бол хөгжлийн суурь нь болж өгдөг. Энэ утгаараа болбол маш зүйтэй алхам болсон. Шинэ ерөнхийлөгч Энхтүвшин Ерөнхийлөгчийн хувьд бол маш зөв харсан байна гэж ингэж бодож байна.

Танхимын үүрэг болбол шийдвэр гаргалтад л нөлөөлөх, ЗГ, салбарын яамнуудын гарч байгаа шийдвэрийг бизнес эрхлэгчдэд ээлтэй, хөгжлийн төлөө зөв шийдвэр гаргахад л нөлөөлж яах ёстой гол үүрэг нь болов уу гэж ингэж бодож байгаа юм. Энэ болбол энэ хуульдаа бол ингээд тусаад явах байх гэж бодож байгаа юм. Танхим болбол улс төржиж болохгүй. Танайхны үгэн дотор их сонин, сонин үг явж байгаа шүү. Төр хувийн бизнесийг дээрэмдэж булааж авлаа гэж байгаа. Булааж авсан юм байна уу та нар хэлээч? Би бол бодохдоо Эрдэнэтийн 49 хувь, Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хөтлийн цемент шохойн үйлдвэр, Монрос гээд цаашаагаа юу байдаг юм, дээрэмдэж авсан зүйлийг төр буцааж авсан гэж ойлгож байгаа юм. Дээрэмдээд авчихсан юм байгаа юу та нар энийг тодорхой жишээ байвал хэлээч гэж.

Дараагийн асуудал энэ тоогоо жаахан нягтлаарай. 22 он хүртэл та нар энэ ДНБ-ий 28,5 их наяд гэж байна. Одоо чинь 74 их наяд болж байгаа шүү дээ жнэ жилийн юугаар. 23 оны статистикаар бол 68 их наяд болчихсон явж байгаа. Тэгээд энэ тоо зөв байна гэдэг чинь бол цаашидаа болбол бас тооцоо судалгаанд хэрэгтэй гэж ингэж үзэж байна энийг. Улсын Их Хурлын дарга Занданшатар нэг тооцоо хийгээд энэ Монгол Улсад энэ НӨАТ-ын татвар болбол бас аж ахуй эрхлэгчид дарамт болж байна, хувь хүнд ч бас дарамт болж байна гэж ингэж үзээд татварын цогц реформ хийе гээд ажлын хэсэг байгуулаад, тэгээд энэ Төсвийн байнгын хорооны даргаар ахлуулаад энэ ажлын хэсэг ажиллаж байгаа. Та нар энд хэр зэрэг оролцож байгаа вэ? Гол ажил чинь энд явж байна шүү дээ тийм ээ. Татварын зөв, шударга тогтолцоог бүрдүүлэх асуудал өнөөдрийн хамгийн тулгамдсан асуудал.

Дараагийн асуудал энэ ААН-үүд маань юу энэ 73,2 хувь нь хотод төвлөрчихсөн байна. Хөдөөгийн

хөгжлийг дэмжье гэж бид яриад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хөдөө үйлдвэрлэл явуулж байгаа энэ бизнесийн харилцааг сайн болгохын тулд та нар энэ хуулиараа яаж оруулж ирж байна гэж? Манай эдийн засаг болбол түүхий эдэд суурилсан. Яг яс ярих юм бол нүүрсэнд суурилсан эдийн засаг болчихсон байна шүү дээ. Тэгэхээр энэ ер нь энэ яг тодорхой үйлдвэрлэл явуулдаг ААН компанийн тоо ингээд л багасаад байгаа байхгүй юу. Тэр үйлдвэрлэл явуулж байж үйлдвэрлэл дээр суурилсан эдийн засаг хүчтэй байна. Өсөлт нь өгөөжтэй, хүртээмжтэй, ажлын байрыг бий болгоно. Энэ чиглэлээр та нарт Худалдааны танхим дээр хийсэн судалгаа тооцоонууд байна уу гэж?

Төрийн оролцоо их байна гэж, байдаг байх энийг сайн мэдэхгүй байна. Төрийн зохицуулалт болбол үнэхээр зайлшгүй чухал шүү оновчтой зохицуулалт. Харамсалтай нь бид нар төрийн зохицуулалтыг оновчтой хийж чадахгүй байгаа. Чөлөөт зах зээл гэж бид их ярьдаг тийм ээ. Чөлөөт гэдэг үгээ орхиод зах зээлийн эдийн засаг гэж ярьж байх нь илүү ач холбогдолтой гэж ингэж үзэж байгаа юм. Тэгээд энэ хамгийн гол нь болбол аливаа зүйл ориш тогтнох үндэс нь санхүүгийн асуудал байгаа тийм ээ. Энэ олон хуваагдаад 50 ААН, тэгээд л цаашаага энэ аймаг, нийслэл гээд явахаар энэ санхүүжилтийн энэ хураамжийн тооцоогоо та нар яаж хийж байгаа вэ?

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Дашцэрэнгийн Энхтүвшин, 3 номер ХАҮТ-ын ерөнхийлөгч.

Д.Энхтүвшин: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн хувьд бол өмнө нь нөгөө ААН-үүд нь танхимын гишүүн байгаад, төлбөр хураамж жилийн гишүүнчлэлийн татвар хураамж төлдөг байсан бол одоо эдийн засгийн салбарууд болон аймаг, нийслэлийн танхимууд гишүүн болохоор байгаа. Тэгэхээр энэ

гишүүнчлэлийн хураамж нэг жилдээ 500 орчим сая төгрөгийн ийм хураамж орж ирдэг байсан. Тэгэхээр энэ нөгөө салбаруудын тоо аваад үзэхээр аймаг, нийслэл 21, тэгээд 30-аас 40 танхим эдийн засгийн салбараар байгуулагдах болов уу гэсэн ийм юу багцаа байгаа. Тэгэхээр 50, 60 ААН гээд харахаар нэг нь нэг жишээлбэл танхим юм уу, гэхээр салбарын байгууллагууд гэхээр нэг байгууллага 10 орчим сая төгрөгийн жишээлбэл хураамж төлөхөөр иймэрхүү зүгээр багцаа гарч байгаа. Тэгэхээр энийг болбол шийдэх бололцоотой тооны хувьд бол харьцангуй боломжийн гэж харж байна.

Бусад үйл ажиллагааны үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг хэлбэр нь түрүүн энэ дурдагдсан арбитрын үйл ажиллагаа, экспертизийн үйл ажиллагаа, гарал үүслийн гэрчилгээ, мөн сургалт хийдэг гэх мэтчилэн бусад үйл ажиллагаануудаасаа ингээд олоод үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэгээд цаашидаа болбол энэ чиглэл түрүүн бас Амартүвшин гишүүн бас хэлж байсан. Энэ лоббины чиглэлийн гэдэг ч юм уу ийм нэмэлт хуулийн зохицуулалтууд бас орж ирвэл санхүүжилтийн бололцоо боломжууд нэлээн нэмэгдэх болов уу. Тэгэхээр энэ чиглэлээр, Үндэсний танхим дээр болбол нийтлэг эрх ашгууд ярьж байгаа учраас бас бодлогын өмгөөлөлтэй холбоотой ажлууд нь харьцангуй салбарын бодлууд нь салбарын танхим болон салбарын тэр холбоод руугаа тарж байгаа учраас ачаалал нь бас нэлээн тарж байгаа гэж бодож болно.

Үйлдвэрлэлийн хувьд болохоор бид нарын хувьд бол ер нь бизнес эрхлэх орчныг л илүү чөлөөтэй, илүү боломжийн болгоод өгчихвөл энэ зах зээлийн зарчим боломжоо хараад үйлдвэрлэлүүд хаана нь ямар бололцоо боломжууд гарах вэ гэдгийгээ өөрөө зах зээл тодорхой хэмжээнд зохицуулах боломжтой гэж харж байна. Тэгээд зарим нэг өнгөрсөн хугацаанд сайн харахад хөдөө орон нутгийн хувьд болбол бас яг жижиг, дунд

үйлдвэрлэл гээд явахаар зарим аймгуудын хувьд бол бас яг үйлдвэрлэл гэдэг явуулах эдийн засгийн бас бололцоо боломжууд нь ийм хязгаарлагдмал байгаа учраас бас бүх юмыг өөрсдөө үйлдвэрлэнэ гэхээсээ илүү зах зээлийн бололцоо бол боломждоо тааруулж илүү эдийн засгийн зохицуулалтаар явсан нь илүү зөв болов уу гэсэн бодолтой байгаа.

Тэгэхээр энэ боломжуудыг нь илүү эдийн засгийн энэ харилцааг, боломжуудыг нь нээх энэ нь бол зөвхөн хууль, эрх зүйгээс гадна нөөцийн зах зээлүүд дээр санхүү, хүний нөөц, энэ бодлогын гэх мэтчилэн энэ нөөцүүд дээр энэ бололцоо боломжуудыг нь илүү нээж өгснөөрөө эдийн засгийн энэ үйлдвэрлэл, бизнес хөгжил дэх энэ асуудлууд нь илүү зохицуулагдах байх гэсэн ийм бодолтой байна. Татварын зохицуулалт бол одоо бизнес эрхлэгчдийн судалгаа хийхээр хамгийн.../минут дуусав/

Г.Занданшатар: 3 номер Дашицэрэнгийн Энхтүвшин гүйцээж хариулъя, товч тодорхой.

Д.Энхтүвшин: Бизнесийн орчны судалгаагаар болбол хамгийн бизнес эрхлэгчдэд тулгамдаж байгаа асуудал болбол татвар, нийгмийн даатгал, тэгээд зээлийн хүүгийн асуудал, тэгээд хүний нөөцийн асуудал байгаа. Тэгэхээр татвартай холбоотой бол зайлиггүй өөрчлөлтүүд хийхгүй бол эдийн засгийн өмнө нь бол тодорхой хэмжээнд ингээд эдийн засгийн бололцоо боломжууд байдаг байсан болбол одоо ер нь зах зээлүүд жишээлбэл зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулаад ирэхээр өрсөлдөөнүүд нэлээн нэмэгдээд, ашигийн түвшинүүд нь буураад, тэгээд энэ үйл ажиллагаануудын хувьд бол зарим нэг жишээлбэл өмнө Татварын хуулиар зохицуулж байсан жишээлбэл татвар ноогдох зардалд тооцохгүй гээд хасдаг байсан зардлууд гэх мэтчилэнгээр гээд бизнесийн харилцаанаас өөр энэ зохицуулалтууд нь ашиггүй ажиллаж

байгаа ч гэсэн ашигийн татвар төлөх ийм нөхцөлүүд бий болоод байна.

Тэгээд хуулийг илүү татварын энэ цогц хуулийг, өөрчлөлтийг эдийн засгийн өөрчлөлт, өсөлтийг бий болгодог хэрэгсэл байдлаараа ашиглаасай гэсэн ийм хүсэлт бол ААН-үүдэд байгаа. Одоо болбол илүү төсөв бүрдүүлэгч шинжтэй учраас ер нь болбол тийм дарамт ихтэй юм шиг ийм дүр зургууд харагдаж байна. Тэгэхээр ААН-үүд бизнесээ хийгээд ямар ч асуудалгүй ийм айдасгүйгээр татварын дарамтгүйгээр үйл ажиллагаа хийгээд ашиг мөнгө олоод ирэхээрээ татвар төлдөг энэ харилцаа руу ордог. Тэгэхээр энэ нь өөрөө албан бус секторуудыг ер нь бол татвар төлөхгүй бас нэг хэсэг энэ бүлгүүд бий болчихоод байгаа. Энэ нөгөө татвар төлдөг хэд нь илүү ачаалал үүрээд байхаар төлдөггүй хэсэг нь улам орохгүй байх энэ хандлага энэ чиглэл рүү яваад байгаа учраас энэ татварын ялангуяа жижиг, дунд ААН-үүдтэй холбоотой энэ өөрчлөлтүүдийг бол зайлиггүй хийх шаардлагатай.

Тэгээд энэ дээр болбол хэлэлцүүлгүүд жишээлбэл танхим дээр энэ хуулийн энэ холбогдолтой хэлэлцүүлгүүд хэд, хэд хийсэн. Тэгээд үргэлжлүүлээд энэ чиглэлээр бас судалгаанууд бас хийж байгаа. Татварын мэргэшсэн, Мэргэшсэн нягтлан болон Татварын нягтлан бодогчдын зөвлөл, тэгээд олон улсын энэ санхүүгийн чиглэлийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөр гишүүн тодруулж асууя 1 минут.

Б.Баттөмөр: Улсын Их Хурал дээр татварын цогц реформ хийх энэ ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ дээр манай худалдааны танхим маш сайн оролцож, дуу хоолойгоо гаргаж, тооцоо судалгаа хийж, татварын яг өнөөгийн нөхцөлд яг зөв тэр хувь хэмжээг тогтоох ийм энэ ажилд бол идэвх гаргаж

ажиллацгаагаарай гэж 1 дүгээрт хэлье гэж бодож байгаа юм.

2 дугаарт болбол сая Улсын Их Хурлаар энэ Мэргэжлийн нэгдсэн холбооны хуулийг баталсан. Энэ болбол танай ажилд маш их ач холбогдолтой ийм хууль болсон шүү. Холбоод нэгдээд тэр НӨАТ-ын ангиллаараа нөгөө 8.2-т зааснаар салбар болгон ангиллаараа нэг салбарт бол нэг холбоо байна гээд, Дээд шүүх бүртгэнэ. Улс төржилтөөс ангид байя гэж. Тэр хоорондоо хуралдаад тэр дарга цэргээ сонгодог, удирдах зөвлөлөө сонгодог ийм эрх зүйн орчныг бүрдүүлсэн шүү. Тийм учраас энэ байгууллагуудтайгаа их сайхан хамтарч ажиллах ийм шаардлага бол байна гэж үзэж байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулна, гишүүд чуулганы танхимд цуглая. Үг хэлэх гишүүн байхгүй, дэмжсэн, дэмжээгүй хоёр. Гишүүд чуулганы танхимд цуглая. Энэ гишүүдийн асуулттай холбогдуулаад ажлын хэсэг, Байнгын хороод анхаарч ажиллах хэдэн зүйлийн талаар санал хэлье.

Энэ хууль болбол анх 2 жилийн өмнө өргөн баригдаад, энийг бол бид бас онцлон анхаарал тавьж санаачлаад, хамтран хэлэлцээд, танхимтай өргөн бариад, тэгээд хэлэлцэх явцад бол үзэл баримтлалын зөрүү гарсан учраас буцаагдсан, буцааж татсан, санаачилсан гишүүд. Тэгэхдээ энэ бол нэг ийм үзэл баримтлалын 2 зөрүү байгаа юм. Францад анх 1599 онд ХАҮТ үүсээд, тэгээд их газрын эрх зүй буюу нийтийн эрх зүйн ХАҮТ-ын систем бол заавал гишүүнчлэлтэй байхыг шаарддаг. Хувийн эрх зүй буюу Англи саксоны эрх зүйн модельд ХАҮТ болбол илүү сайн дурын шинжтэй. Ингээд энэ 2-ын дундуур одоо орж ирэхдээ илүү нэг hybrid маягтай Хятад, Куба энэ тэрийн загвар шиг ингээж hybrid болж л орж ирж байна л даа.

Тэгэхээр ер нь бол 1599 онд анх ХАҮТ байгуулагдаад явсан түүх, загвар болбол лессис фэйр буюу төрөөс үл оролцох, чөлөөтэй орхих гэсэн нэг ийм зах зээлийн зарчмыг ХАҮТ-уудын нийтлэг зарчим болгож ер нь анх эхэлсэн байгаа юм тэр бол. Төрөөс бол энэ бизнесийн хөгжил дэвшилд оролцож болохгүй, чөлөөтэй орхих гэсэн агуулгатай ийм Франц тодорхойлолт 1700-аад оны үед гарч ирж. Ингээд энэ зарчим болбол ерөөсөө бизнесийн эрх ашгаа хамгаалах зорилгоор байгуулагдаад, тэгээд Үйлдвэр, худалдаа гэж яагаад нэрлэсэн юм бэ, Үндэсний үйлдвэр, худалдаа, аж үйлдвэрийн танхим гэж яагаад нэрлэж байгаа юм бэ гэхээр яах вэ манайх худалдаа нь дандаа өмнө нь орчихдог боловч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн чинь борлуулагдаж байж баялаг болно. Борлуулалт, худалдаа, үйлдвэрлэл хоёрын холбоог танхимууд хангаж ажиллахгүй бол энэ 2 тусдаа юм шиг байснаас дараа нь Англид ч юм уу, энэ англи саксоны эрх зүйд үүссэн бэрхшээлүүд бол нөгөө зах зээлийн нэг том давллагааны зөрчилд болгож ингээж өөрчлөлт олгосон.

Тэгээд сүүлийн үеийн танхимуудын энэ зарчим Япон энэ тэр болбол төрийн энэ төрөөс үл оролцох зарчмын зэрэгцээ, төрөөс зөв оролцох буюу танхимын оролцоог энэ хууль тогтоох ажиллагаанд, ЗГ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд хангах ийм модель зарчим руу нийцүүлж, 2 жилийн өмнөөс энэ хуулийг боловсруулж гаргаж, хувийн хэвшилээ дэмжих, тогтвортой орчин бүрдүүлье гэж бид Их Хурал анхаарсан. Танхим ч гэсэн Дүүрэн дарга байсан, анхаарч ажилласан. Тэгэхээр энэ сууриа засаж байж, фундаментаа засаж байж цаашаа явахгүй бол ингээд татварын реформ хиймээр байдаг, бизнесийнхэнд тулгараад байгаа хөрөнгийн хамгаалалт, хувийн эрх зүй гэж их Хууль зүй, дотоод хэргийн яам хэлтэс, газартай болсон.

Энэ хувийн эрх зүйн ойлголт, ийм социалист эрх зүйд байдаггүй байсан ойлголт учраас манайд үлэмж хаягдаад, ингээд Үндсэн хуульд заагдсан өмчлөх эрхийн асуудал, хөрөнгийн хамгаалалтын асуудал, үндсэн эрхийн асуудал, нөгөө “баяжих тун” гэсэн уриа лоозонгууд чинь лоозон болж үлдээд байгаа учраас танхимын үүрэг ролийг өндөрт гаргах гэж энэ хуулийг бол 2, 3 жил шахаж байж, одоо л нэг юм хэлэлцэж байна. Өнөөдөр ч гэсэн бас дараалал дайруулж, 2 жилийн өмнө хэлэлцэж байсан гэдэг агуулгаар нь оруулж ирж байна.

Тэгэхээр энэ бизнесийнхний дунд тулгарч байгаа нэг хамгийн том асуудал бол 1 дүгээрт энэ татвартай холбоотой асуудал байгаа юм. Үүгээр НӨАТ-ын санал санаачилгатай холбогдуулаад Улсын Их Хурлаас Төсвийн байнгын хорооны даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулаад, татварын реформын суурь баримт бичгийг санаачилчихсан. Энэ нийгмийн даатгалын шимтгэлийг оновчтой болгох, хамгийн гол татварын дарамт үйлдвэрлэгчид дээр байна. Нийгмийн даатгалын шимтгэл, НӨАТ болбол нийт объёмоороо харьцангуй нөгөө тэгш шударга ёсны зарчимтайгаа нийцүүлэх юм болбол худалдаа импортлогчдоос харьцангуй өндөр татварын дарамттай гэж үзэж болно. Та нар гааль, нөөц энэ бизнес дээр байж байгаа юмнуудыг сайн мэдэж байгаа. Тийм учраас энэ татварын реформ Тэмүүлэн гишүүн нараас санаачлаад ойрын үед бэлэн болгочихсон ЗГ-т өгч байгаа. Энэ дээр эхлээд дуу хоолойгоо өргөж, ерөөсөө бизнес эрхлэгчдийн өмнө тулгамдаж байгаа 1 дэх асуудал.

Тэгээд 2 дугаарт хөрөнгийн хамгаалалт, хувийн бизнесийн чөлөөтэй энэ лессис фэйр гэдэг шиг тэр төрөөс оролцох, оролцохгүй салбарыг тодорхой зааж ялгах, тэгээд хувийн хөрөнгийн хамгаалалт, үндсэн эрхийн хамгаалалтуудыг найдвартай болгох гээд энэ бизнес эрхлэгчдийнхээ дуу хоолойг хангаж ажиллахгүй болохоор

танай танхимын чинь тэр мандаторын буюу нөгөө заавал гишүүнчлэлтэй байх зарчмыг чинь дэмжихгүй байгаад байна шүү дээ. Уг нь болбол эх газрын эрх зүйд бол манай улсын эрх зүй чинь эх газрын эрх зүйдээ илүү хамаарах улс. Тийм учраас заавал гишүүнчлэлтэй байж, тэгээд тэднийхээ эрх ашгийг хамгаалж ажилладаг ийм дуу хоолой чинь үгүйлэгдээд байгаа учраас танхим бол зүгээр нэг ингээд цөөхөн компаниудын төлөөлөл юм шиг харагдаад байгаа бас. Өөрсдөө өөрчлөгдөх хэрэгтэй байгаа юм. Энэ татварын нийтлэг дарамт, энэ зарчим дээр.

Төр засаг бол бас хувийн хэвилийнхээ дуу хоолойг сонсохгүй биш сонсдог. Тэгээд алаг цоог зөрөөтэй, зөрчилтэй бодлууд чинь хууль номд тусгагдаж чаддаггүй. Тийм учраас PPP нөгөө public private partnership гэж төр хувийн хэвилийн түншлэл биш, dialogue гэж PPD public private dialogue гэдэг энэ системийг энэ Хэрэг эрхлэх газар дээр уг нь байгуулж байсан юм, энэ ажиллахаа больчихсон юм байна лээ. Одоо энийг бол ингээд Их Хурал дээр энэ хуулиар бас бий болгох ёстой юм байгаа юм. Ингэж байж нөгөө мэргэжлийн холбоод танхимын саналыг нэгдсэн саналыг хууль тогтоомж дээр авна. Тэгэхгүй бол нөгөө лобби гэж манай Ганибал гишүүн бас их зөв тодорхойлсон л доо.

Лобби гэдэг чинь бол Английн парламентын үүдний танхим лоббид хуульд Их Хурлын гишүүд, парламентын гишүүд бүхнийг мэдэгч нар учраас тэдэнд ятган тэнхрүүлдэг танхим байсан байхгүй юу. Ятган ухуулж, энийг ингэж хэлбэл зөв, энийг яагаад дэмжих ёстой юм, дэмжих ёсгүй гэдгийг тайлбарладаг газраас лобби гэдэг үг үүссэн. Лобби гэдэг чинь үүдний танхим гэсэн агуулгатай үг шүү дээ. Энэ нь сүүлдээ ингээд буруугаар лоббидох гэдэг чинь их буруу зүйлийн агуулгатай юм шиг ойлгогдоод, энэ чинь зөв ном журам хэмжээнд нь биш тайлбарлаж тэр бизнес, аль нэг салбарын эрх ашгийг

хөндөж байгаа хүмүүсийн дуу хоолойг сонсдог энэ механизмыг энэ хуулиар бас бий болгож, танхим энэ дээр хэлэлцэж байгаа бизнесийн эрх зүйн орчны хууль болгон дээр саналаа өгчихмөөр байгаа юм.

Тэгээд энэ систем чинь ажиллахгүй болохоор мянга гоё хөрөнгө оруулалтын орчин, хууль баталлаа гээд тэр хэрэгждэггүй. Яг хэрэгжих шат дээрээ л мянга гоё бизнесийн орчин тогтвортой гээд хэрэгждэггүй. Хамгийн гол бизнес эрхлэгчдийн, гадна, дотнын хөрөнгө оруулагчдын санаа зовж байгаа юм энэ бүх судалгаагаар бизнесийн орчны тогтворгүй байдал, гэнэт өөрчлөгддөг. 2 дугаарт хөрөнгийн хамгаалалтгүй байдал, шүүх, тэгээд л Дампуурлын хууль энэ тэрээс авхуулаад л, хувийн эрх зүйн чинь маш олон асуудлууд ингээд бизнесийн хамгийн том бэрхшээлүүд ингээд. Бараг 10, 20-т нь тэр газар юуны асуудлууд.

Тийм учраас энэ юмнуудыг чинь ингэж эрэмбэлээд, танхим ингэж нэг нэгээр нь шийдэх цогц систем, институтийг нь бүрдүүлэх гэж л танхимын хуулийг бид яаруулаад байсан юм. Даанч харамсалтай нь ингээд удаж, удаж, тэр дор нь өргөн барина гэж буцааж татуулаад л, тэгээд л удаж, удаж нэг үхрийн сүүлэн дээр хутга гэж одоо л орж ирж байгаа. Ийм учраас энэ дээр анхаарах хэрэгтэй.

Тэгээд сая бас чухал асуудал Энхбаяр сайд хөндлөө л дөө. Энэ Бат-Эрдэнэ гишүүн асуув уу? Ийм шаардлага нь байхгүй болохоор бизнесийнхэн улс төр лүү хошуураад байдаг. Энд орж ирж эрх мэдэлтэй болж, бизнесээ хамгаалуулах гэсэн. Тэгээд энэнээсээ болоод сая бас тэр жагсаалт, намын жагсаалтад асар их мөнгө төлж орж байна, 3 сая доллар л гэнэ, сая доллар гэж намууд босго тогтоочоод оруулаад ингээд бизнесийнхэн нэг их гоё сайхан нэртэй залуучуудыг төлөөлүүлж оруулаад, ингээд төрийн эрх мэдлийг

авах гэж байна гэсэн ийм асуудлыг Бат-Эрдэнэ гишүүн, Энхболд гишүүн, олон гишүүд хөндөөд, ийм асуудал бол Сонгуулийн хууль зөрчинө гэдгийг сая Энхбаяр сайд онцлоод, ийм жишиг байна, ийм яриа яваад байна. Зарим намууд бүүр босго тогтоочихсон, тэдэн сая доллар, тэдэн тэрбум төгрөг төлбөл жагсаалтын тэд дээр бичигдэнэ, эд дээр бичигдэнэ гэж яриад байгаа юм байна.

Ингэж мөнгөний сонгууль хийвэл энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, ард түмний засаглах, эрх сонгуулийн мөн чанар алдагдана. Энийг ч гэсэн бас танхим болбол ёс зүйн кодынхоо хүрээнд бизнесийнхэндээ, гишүүддээ бас анхааруулж хэлж ажиллах нь зүйтэй. Танхимын хууль гарах юм бол танхим тэдний эрх ашгийг төлөөлдөг, хамгаалдаг л тэр эрх мэдлээ энд сайн суулгаж авах ёстой. Тэгэхгүй бол төрийн эрх мэдэл бол дандаа хүчтэй байдаг, яаж ийж байгаад хувийн эрх мэдэлд халдаж болно. Хувийн өмч хөрөнгө, юу ч байдаг юм. Тэрнээс хамгаалдаг институт болох гэж л тэр Марсельд бараг нөгөө Марселийн тунхаг энэ тэрийг та бүхэн мэднэ биз дээ. Эрх чөлөөний хөшөө энэ тэр боссон түүх энэ тэр чинь бүгд энэтэй холбоотой. Тэр лессис файр гэдэг төрөөс үл оролцох энэ тэр гэсэн бүх зарчим чинь эндээс үүдэлтэй.

Ньюйоркт байгаа хөшөө энэ тэр чинь ч гэсэн бараг холбогдох ийм л агуулгатай байгууллага гэдэг үндсэн философи, үзэл баримтлал дээрээ танхим өөрсдөө ч ойлгож, ингэж ажилладаг болмоор байгаа юм. Тэгэхгүй бол ингээд л нэг хүн ямар ч системд босож ирээд л, хүний хөрөнгийг хураагаад байвал яаж бизнесийн тогтвортой орчин байх вэ гэдэг шиг энэ юмаа л хуульдаа анхаарч сайн ажиллах ёстой. Тийм учраас энийг бол богино хугацаанд бас ажлын хэсгийг байгуулж, ажиллуулна. Их Хурлын даргын захирамжаар байгуулж ажиллана, өмнө нь ч гарч байсан улсуудыг.

Ингээд гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хураалт явуулна. 2 цаг болж байна, цайны цаг өнгөрсөн. Одоо энэ хуулийн төсөл дээр бас манай Хассуурийн Ганхуяг гишүүн, Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн, Ганибалын Амартүвшин гишүүд бас их анхаарч 2 жил ажилласан юм тэгээд одоо. Тэгээд Зөвшөөрлийн хууль ер нь бас нэлээн либералчлалын, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль гээд олон хуулиуд батлагдсан. Энэ бүхэн чинь заавал танхим бас амилж байж, бодит эрх мэдэлтэй болж байж, мэргэжлийн холбоодод сая эрх мэдлийг нь өглөө. Лиценз, зөвшөөрлөөс авхуулаад, зарим тусгай зөвшөөрлүүдийг олгох, төрийн зарим чиг үүргүүдийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлнэ. Ингээж байж нөгөө авлига, хүнд суртал, чирэгдэл чинь багасна. Төрийн оролцоо бас бизнест багасаж байж нөгөө авлига, хүнд суртал чинь багасна.

Тэгээд яг ямар салбартаа мэдээж оролцох ёстой, хянах ёстой зүйлүүд байна. Тэрэнд нь танхим нөгөө хяналт тэнцэл гэдэг шиг л ийм институт болж байж л энэ амьдрах юм байгаа юм. Тэгээд энэ Японы туршлага ч гэсэн онцлоод байдаг нь бол шийдвэр гаргах түвшинд танхим г... энэ тэр нь оролцож байгаа байхгүй юу, бид юу хийх юм бэ. Жинхэнэ утгаараа төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бий болж байна. Жижиг улсын эдийн засаг том төслүүдээ хөдөлгөж урагшлах юм билээ. Энэ дээр л онцгой анхаарах хэрэгтэй.

Санал хураалт, бүлгийн дарга нарыг дуудъя. Тогтохсүрэн дарга. Байнгын хороо одоо хуралдаагүй биз дээ? Дэмжсэн, дэмжээгүй үг түрүүн авчихсан л даа. Яаралтай гишүүдээ дууд. Дэмжсэн, дэмжээгүй бол үг хэлэх гишүүн байна уу? Булгантуяа гишүүнээр тасаллаа. Бусад нь асуулт асуусан учраас. Хойшдоо хоцорч ирж болохгүй. Булгантуяа гишүүн, өглөө үг хэлнэ гэсэн яасан бэ? Парламентын, өсвөрийн парламентын хүүхдүүдийн дуу хоолой

хэлнэ гэсэн яасан бэ? Битгий олон юм зэрэг төлөвлөж бай. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Карт чинь уншигдаагүй байна, картаа уншуулсан уу сая.

Х.Булгантуяа: Энэ хууль бас нэлээдгүй хоцорч орж ирж байгаа юм. Сая манайх Нийгмийн даатгалын багц хуулиа батлуулсан. Дээрээс нь нэмээд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчдын төлөөлөлтэй манай салбар бол маш их хамтарч ажилладаг. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөл гээд ингээд олон зөвлөлүүд дээр хувийн хэвшлийн оролцоотой хамтран ажиллана гэхээр энэ танхимын эрх зүйн байдлын асуудал үнэнийг хэлэхэд өнөөдрийг болтол их бүрхэг явсан, бас их нөлөөлсөн. Тэгээд тийм учраас бид нар энэ хуулийг нэлээн эрт батлуулаад өгөөч гээд манай зүгээс ч гэсэндээ ер нь Улсын Их Хурлын дээр, Улсын Их Хурал, ЗГ дээр бас нэлээдгүй хамтран ажилласан.

Тун удахгүй Үйлдвэрчний эвлэлийн хуулийг бид нар бас өргөн барих гэж байна ЗГ-аас. Энэ 2 хууль бол ер нь яг ингээд толгой дараалан хамтдаа явж байх ёстой. Нэг нь ажил олгогчдыг төлөөлж, нөгөөдөх нь ажилтнуудыг төлөөлж бас ингээд хууль, эрх зүйн орчны шинэчлэл дээр ингээд хамтдаа орж ирж байх ёстой.

Тэгээд би бол энэ хуулийг яаралтай хэлэлцээч, 126 гишүүнтэй болохоос өмнө, ялангуяа дараагийн парламентыг орохоос өмнө, дараагийн томоохон хэмжээний бизнесийн салбарын эрх зүйн реформуудыг хийхээс өмнө, бизнесийн салбараас яг хэнтэй, ямархуу байдлаар яриа хэлэлцээ хийх юм бэ гэдгийг энэ хуулийн энэ хууль батлагдаж байж манай Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүй бол улам сайжирна. Тэгээд маш нэлээн удлаа, үнэнийг хэлэхэд танхим. Тэгээд энэ хуулийг бас хэлэлцүүлж байх явцад анх эхлээд орж ирсэн цагаасаа

авхуулаад л улс төржиж байна, улс төржихгүй байна гэдэг асуудал их гарсан. Танхимынхандаа хэлэхэд танай салбар бол энэ танхим бол эсрэгээрээ хамгийн их улс төржих ёсгүй салбар шүү. Хамгийн их улс төржих ёсгүй энэ байгууллага шүү.

Ингээж байж танхимын бас нөгөө талдаа эрх зүй бизнесийнхэн дотроо хүлээн зөвшөөрөгдөх байх гэж бодож байна. Тэрнээс биш хуулиа дөнгөж оруулж байхад нь авхуулаад л энэ улс төржсөн байгууллага болох гээд байна, үгүй байна эсхүл үүгээр дамжуулж улс төрд нэр дэвших шат дамжлага болох гээд байна гэдэг өнцгөөр харах юм бол хэн хэндээ хэцүү болно. Тэгээд манай салбарын реформуудын хувьд бол энэ хууль, эрх зүйн орчин сайжрах нь нэн чухал байна. Тийм учраас бас дэмжиж үг хэлж байгаа юм даргаа.

Г.Занданшатар: Одоо санал хураана. Энэ Адъяасүрэн гишүүн маань хаачсан бэ? Адъяаа гишүүн байна. Алтанхуяг гишүүн хаачсан бэ? Амарсайхан хаачсан бэ? Амартүвшин гишүүн байна. Анандбазар гишүүн хаачсан бэ? Анужин гишүүн өглөө хуулиа батлуулахад байсан, хаачсан бэ? Аубакир гишүүнийг эрэн сурвалжил гэсэн яасан бэ? Яаралтай олж ир. Баделхан гишүүн яасан бэ? Бат-Амгалан яасан бэ? Жигжидийн Батжаргал гишүүн сая байсан. Гочоогийн Ганболд гишүүн байсан, дуудъя. Тийшээ орчихсон уу? Зэрэг, зэрэг ингээд. Батлут, Батсуурь, Баттөмөр гишүүн сая байсан хаачив? Батиугар гишүүн байна, Сарангэрэл гишүүн байна, Мөнхцэцэг гишүүн байна, Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн байна, Нанзадын Наранбаатар гишүүн байна, Цэндийн Мөнх-Оргил байна, Дамдины Цогтбаатар байна, Балжсиннямын Баярсайхан байна, Цэндийн Мөнх-Оргил гишүүн байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн байна. Бусад гишүүдийг дуудъя, түргэл.

Энэ хооронд нэг мэдээлэл танилцуулъя. Өнөөдөр их ачаалалтай 15 хууль хэлэлцэж байгаа. Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулах тухай. Албан ажлын зайлиггүй шаардлагыг харгалзан Улсын Их Хурлын чуулганы 24 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай Шил ажиллагааны хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийн товыг хойшлуулж, хойшлуулахаар шийдвэрлэлээ албан бичиг ирсэн учраас. Өнөөдрийн мэдээллийг хойшлуулсан болохыг мэдэгдье. Ганибалын Амартүвшин гишүүн үг хэлнэ.

Г.Амартүвшин: Танхимын хуулийг бол бид нар яаралтай ер нь заавал батлах ёстой. Энэ бол яг манай ААН-үүд хувийн хэвшлийнхний эрхийг хамгаалдаг, дуу хоолой нь болдог гол хэрэгсэл байгууллага нь. Тэгэхгүй бид нар чинь бас арай зарим хуулиуд дээрээ ААН-үүдийнхээ эрх ашгийг хамгаалахаас биш харин ч ААН-үүдийн чөлөөтэй бизнес эрхлэх орон зайг нь бүр хумиад байгаа зарим тохиолдлууд байгаа шүү. Өөрөөр хэлбэл нэг жоохон вакумжсан байдалтай хууль батлах тийм эрсдэл байна. Тийм болохоор энэ дээр бас манай Энхтүвшин Ерөнхийлөгч болон танхимын удирдлагууд сайн анхаарч ажиллаарай.

Ер нь бол гаднын бас сайн туршлагууд байдаг. Жишээлбэл *Amchat*-ийнхан бол ингээд *door knock* ингээд л нөгөө өөрсдийнхөө америк компаниудаа ч дагуулж ирээд тойруулдаг, төр засгийнхантай уулзуулдаг, компаниудаа уулзуулдаг. Манай *Amchat*-ийн гишүүд компанийг ч гэсэн Америк руу дагуулж явж бас тэр сонирхож байгаа салбарын төлөөлөлтэй нь уулзуулдаг бас их зөв тийм жишээ байдаг юм байна лээ шүү. Тэрийг та нар бас анхаарна биз. Тэгээд одоо Хөрөнгө оруулалтын тухай хууль ингээж чухал хууль байна. Ашигт малтмалын тухай хууль ингээж чухал хууль байгаа. Одоо Хөдөлмөрийн хуулиа

бид нар бас эргээж харах ёстой цаг нь ирсэн болов уу гэж бодож байна. Мэдээж хэрэг дараагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд энийг ярилцах байх.

Тийм болохоор энэ дээр татвар Их Хурлын дарга бас татварын цогц реформ хийх, хийгдэх бэлтгэл ажил нь явагдаж байна. Энэ дээр бол эртхэн та нар бас оролцоод яваарай гэж хэлэхээр байна. Ингээд дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Төслийг. Төсвийн байнгын хороо дууссан уу? Үгүй ээ үгүй эмч нар биш, одоо орж ир. Төсөв, төсвийг завсарлуулаад дуудаад, санал хураалт явуулчихаад, буцаад. Тэмүүлэн гишүүнд хэлээд түр завсарлуулаад наашаа орж ирж санал хураалт явуулна. Төсвийн байнгын хороог дуудчих. Энхтүвшин гишүүн суу. Цаанаас хэнийг, Төсвийг түр завсарлаад, буцаад ороод ир гэж хэл. Мөнхбаатар даргыг дууд, Одонтуяа, Цогтгэрэл хаачив? Сугалж болохгүй. Тийм. Бүлгийн даргын үүрэг гүйцэтгэж байгаа юм, энэ Адьшаа гишүүнээр ер нь АН-ын бүлгийн дарга тавья.

Бүртгэлийн санал хураалт. Үдээс хойших чуулган эхэлж байгаа учраас бүртгэлийн санал хураалт. Сая бүртгэсэн. Бүртгэлд ороогүй хүмүүсийг хасна. Төсвийн байнгын хороо түр завсарлачихсан байна. Түр завсарлачхав уу? Тэгээд санал хураалтын дараа та хэд юугаа яая. Эднийх чинь Төсвийн хүрээгээ өглөө хэлэлцчихсэн. Санал хураалт явуулна. Гишүүн суудалдаа.

Байнгын хорооны саналаар Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ХАҮТ-ын хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 24 гишүүн дэмжиж, 55,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Ажлын хэсэг бас шуурхай ажиллах шаардлагатай.

14.10 цаг

Тав.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд орно. Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 5-д Монгол Улсын иргэн хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй. 19 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн хэргийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж тус тус заасан байна.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг хуулийн үйлчлэх хүрээ гэсэн 3 дугаар зүйлд энэ хуулийн үйлчлэлд 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь 1 нас хүрсэн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан нөхцөлийг хангасан эх хамаарна гэж заасан бөгөөд энэ мөн хуулийн 3.2-т энэ хуулийн 3.1.1-д заасан 4 болон түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн гэдэгт бага хүүхэд нь 1 нас хүрэхэд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд хамаарах, харин эхийн төрүүлж, бусдад үрчлүүлсэн хүүхдэд хамаарахгүй гэж тус тус заасан.

Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу зургаа ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд Алдарт эхийн 1 дүгээр зэргийн одон, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд алдарт эхийн 2 дугаар зэргийн одонг олгож байгаа бөгөөд ингэхдээ хамгийн бага хүүхэд нь нэг нас хүрэхэд 4 болон 6-аас дээш хүүхэдтэй байсан бөгөөд эдгээр хүүхдийн тоонд 3 хүртэлх насанд үрчлэн авсан хүүхдийг хамруулан ойлгож байна, олгож байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газраас газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан үзэхэд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийн нийгмийн

халамжийг сайжруулах, алдарт эхийн одонг авахад дэмжлэг үзүүлэх, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийн урамшуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, нийтдээ 4 буюу 6-аас дээш хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан нэг ба түүнээс дээш настай хүүхдийг хүүхдийн тоонд оруулан тооцож алдарт эхийн одон олгох зэрэг асуудлуудыг, саналууд ирээд байна. Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, 4 болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед 3 хүртэлх насанд нь үрчлэн авсан эсвэл байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан нэг ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулахаар, түүнчлэн Эхийн алдар 1, 2 дугаар зэргийн одонгийн шагнах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батлах зэрэг асуудлыг эрх зүйн зохицуулалтуудыг нэмж тусгалаа. Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх

асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас эхчүүдийг Алдарт эхийн одонгоор шагнах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батлахаар, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, 4 болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн гэдэгт байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан нэг ба түүнээс дээш настай хүүхдийг хамруулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг *d.parliament.mn* цахим хуудаст байриуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд төсөлд үрчилж авсан болон бусад шалтгааны улмаас одоо одонгийн шаардлагад хүрч чадахгүй байгаа эхчүүдийн асуудлыг хэрхэн зохицуулахаар тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг хуулийн төсөл батлагдсанаар хэдэн эх хамрагдах тооцоо судалгаа болон өмнө нь шалгуурт тэнцэхгүй байсан эхчүүд хамрагдах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа хүн амаа дэмжих бодлогын хүрээнд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийн урамшууллыг нэмэгдүүлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 77,8 хувиар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын

хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Янгугийн Содбаатар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Рагчаагийн Батрагчаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх, Сархадын Зулпхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Болдын Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах дарга.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Баярсайхан гишүүнээр тасаллаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Иргэдтэйгээ уулзаж байхад, тойрогтоо ажиллаж байхад байнга хөндөгддөг нэг сэдэв, нэг асуудал бол энэ асуудал байгаа юм. Олон хүний амьдралд янз, янз байдаг, олон ээжүүд, олон гэр бүл бас яг энэ 4 хүүхэд буугаад түүнээс дээш хүүхэд төрүүлсэн ч гэсэн нэг хүүхэд нь эндсэн юм уу эсвэл янз бүрийн гунигтай гашиудалтай явдлууд болсон тохиолдол байгаа хэр нь алдарт эхийнхээ одонг авч чадахгүй байна. Энийг авах бололцоо байдаг юм уу? Төрүүлсэн нь үнэн шүү дээ гээд ингээд зовлон, жаргалаа бидэнтэй хуваалцаад ярьж байдаг. Тэгээд энэ дээр бас эмэгтэй гишүүд нэлээд асуудлыг хөндөж тавьж байсан. Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгч энэ хуулийн төслийг санаачлаад, Улсын Их Хуралд хаврын чуулганаар оруулж ирж байна. 2 гараа өргөөд дэмжиж байна. Энэ тухай бас иргэдтэйгээ уулзахдаа ярьж байхад ч гэсэн талархан хүлээж авч байна нэг талаасаа.

2 талаасаа бас энэ алдарт эхийн одонгийн урамшууллыг бас 2 дахин нэмж,

гэхдээ энэ нь ирэх оноос хэрэгжиж эхлэх талаарх мэдээллийг ч гэсэн алга таашаад баярлалаа гэж хэлээрэй гэж байгаа. Яг үнэнийг хэлэхэд үнэхээр чухал асуудлыг бид орж ирж, иргэдийнхээ нийгмийн асуудал дээр бол анхаарч байна. Ялангуяа Монгол Улсын хүн амаа өсгөх бодлоготой энэ өөрөө уялдаж байгаа учраас төрийн том хайрцгийн бодлого гэж бол харж байгаа. Тийм учраас би бол дэмжиж байна.

Одоо бол удахгүй бол Алдарт эхийн одон гардуулах ёслол болно. Олон ээжүүд бас энийг хүлээж байгаа юм байна лээ. Тэгэхээр цаашидаа ер нь бусад улс орон ч гэсэн гэр бүлийг дэмжих бодлогын хүрээнд хүн амаа дэмжих бодлого явдаг. Тэгэхээр энэ бодлогын бас нэг хэсэг нь энэ өнөөдөр орж ирж байгаа учраас би дэмжиж байгаагаа илэрхийлэх гэсэн юм. Асуулт байхгүй.

Г.Занданишатар: Асуулт байхгүй, үг хэллээ. Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Юуны өмнө энэ хуулийг санаачлан орж ирж байгаа Ерөнхийлөгчийн Тамгын газар Содбаатар дарга болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд талархаж байгаагаа илэрхийлье. Энэ талаар өмнө нь бас дуу хоолой болж дуугарч байсан. Тэгээд бас Монголын үрсийг маш олон болгохын төлөө Монгол Улсын хүн амыг бас өсгөхийн төлөө зүтгэж байгаа энэ үр хүүхдээ хараад гэртээ суугаад, өөрсдийнхөө карьер, өөрсдийнхөө хүсэл мөрөөдлийг хүртэл золиослоод ингээд Монгол Улсад иргэн бэлдэж өгч байгаа залуу гэр бүлүүддээ чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Миний хувьд бол би өөрөө одонтой ээж. Дөнгөж бага хүүхдээ гаргасны дараах сонссон зүйл бол нэг жилийн дараа хүүхдээ нэг нас хүргэсний дараа одон авна гэдэг ийм шаардлагыг тавьдаг. Ямар ч ээж, аав бол амин хайртай, энэ бурхны бэлэг болсон амин

үрээ өөрсдийнхөө гараар юм уу эсвэл ямар нэгэн байдлаар үл хайхрах гэдгээс болж алдахыг хэзээ ч хүсэхгүй. Гэтэл энэ дээр баталгаа шаардаж байгаа юм шиг нэг нас хүрсний дараа одон авах ёстой гэдэг ийм зүйлийг сонсоход л хэцүү байдаг юм байна лээ. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад ямар нэгэн байдлаар хүүхдээ цаг бусаар алдсан, өвчнөөр алдсан, ослоор алдсан юм уу эсвэл үрчилж авсан гээд энэ Монгол Улсын хүн амыг өсгөхийн төлөө ингээд зүтгэж байгаа ээжүүдэд бол энэ ярихын ч эцэсгүй, сонсох ч, сонсоход ч хэцүү ийм асуудал байдаг. Тийм учраас энэ хуулийн алдааг засаж орж ирж байгаад бол үнэхээр олон, олон ээжүүдийнхээ өмнөөс бол талархал илэрхийлж байна.

Тэгээд урамшуулал хэдийгээр 2 дахин нэмэгдэж байгаа боловч энэ бол дэрсхэн 4 хүүхдээ хараад байж байгаа ээж жилд 200 мянган төгрөг бол яг амьжиргааны түвшинд бол хүрэхэд хэцүү байдаг. Харин манай ЗГ-аас энэ ковидын үед хүүхдийн 20 мянган төгрөг байсныг 100 мянган төгрөг болгож, өнөөдөр хүртэл энэ арга хэмжээ хэрэгжиж байгаагаараа олон айлын, гэр бүл үр хүүхдүүдэд маш том дэмжлэг болж байгаа. Одонтой байна уу, одонгүй байна уу хүүхдийнхээ тоогоор сар болгон 100 мянган төгрөг авч байгаа энэ арга хэмжээ бол бас нүдээ олсон ийм сайхан арга хэмжээ гэж ингэж дэмжиж хардаг.

Дээрээс нь энэ цалинтай ээжийн цалинг нэмэх асуудлыг бас маш олон ээж нар хүсэж байгаа. Тэгэхээр 2-оос 3 настай хүүхдүүд цэцэрлэгт сураад хувьсах зардал нэгэнт төрөөс авч байгаатай адилхан энэ цалинтай ээжийн бас сарын цалингийн асуудлыг өнөөдөр 50 мянган төгрөг байгаа энэ асуудлыг ч гэсэн цаашидаа нэмээд явах ийм шаардлагатай гэж ингэж хардаг.

Ингээд энэ сэтгэл эмзэглүүлсэн маш нарийн мөртөө ийм хэцүү асуудал шийдэгдэж, өнөөдөр ээжүүд маань энэ

одонгоо авах ийм эрхтэй болж байгаад бол баяртай байна. Тэгээд Улсын Их Хурал энэ хуулийг бүхэлдээ хүн болгон дэмжинэ гэдэгт итгэж байна. Тэгээд энэ хуулийг санаачлан оруулж ирж байгаа та бүхэнд баярлалаа. Хуулийг дэмжиж байна. Мааш их баярлалаа.

Г.Занданишатар: Үг хэлчихлээ тийм ээ, дэмжсэн үгнүүд хэлчихлээ. Тэгэхээр одоо болбол үндсэндээ үг хэлсэн. Үг хэлэх гишүүн байхгүй гэж ойлголоо. Олон хүүхэдтэй үг хэлэх хүн байна уу? Ашиг сонирхлын зөрчилтэй та 2 чинь. Олон хүүхэдтэй хүмүүс л үг хэлнэ. Даваажсанцангийн Сарангэрэл гишүүн үг хэлнэ. Тэгээд энэний дараа, Сарангэрэл гишүүний үг хэлсний дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд. Та ашиг сонирхлын зөрчилтэй.

Д.Сарангэрэл: Баярлалаа. 2010 оноос хойш энэ одонтой ээжийн асуудал яригдсан юм. Ингээд 14 жилийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгч энэ асуудлыг ингээд амьдралд нийцүүлэн олон ээжүүд, аавууд, аавуудын энэ хүсэлд нийцсэн ийм шийдэл гаргахаар Улсын Их Хуралд хууль өргөн барьсанд их талархаж байна. Сая асуултын цаг дээр бас асуултаа асуулгүй орхичихсон байна, Их Хурлын даргаа уучлаарай.

Хамгийн гол нь Содбаатар даргаа энэ хуулийн хүрээнд хэдэн ээжийн асуудлыг шийдвэрлэх ийм тооцоо судалгаа гарсан бэ? Энэ талаар бас би олон нийтэд мэдээлэл хүрвэл их чухал гэж бодож байгаа.

Дээр нь энэ одон, одонгийн хажуугаар одонтой ээжийн энэ мөнгөний талаар бас их олон жил ярьсан юм байгаа юм. Тэгээд 14 жилийн дараа энэ асуудлыг ингээд цогцоор нь шийдвэрлэх ийм хуулийн төсөл оруулж ирсэнд бол бусад гишүүдийнхээ нэгэн адил талархаж байна. Тэгээд би олон нийтэд мэдээлэл өгөх үүднээсээ саяын шалгуурууд болон энэ мөнгө хэрхэн нэмэгдэж байгаа талаар тодруулга

авах, түүнээс гадна хэдэн ээж хамрагдах ийм бололцоо нээгдэж байгаа талаар хариулт өгнө үү гэж хүсэж байна.

Г.Занданишатар: Үгээ л хэлнэ. Мэдээлэл сая хууль санаачлагчийн илтгэл дээр энийг сая тодорхой дурдсан. Байнгын хорооны санал, дүгнэлт дээр ч гэсэн тодорхой дурдсан. Санал хураалт явуулна, гишүүд чуулганы танхимд. Дэг зөрчигдөнө. Алх цохичихсон учраас. Санал хураалт явууллаа. Яах вэ тэгээд эсрэг дарсан хүмүүс нь тэгээд. Битгий эрхэлцгээгээд бай энэ чинь, гэнэт л би үг хэлцгээе. 4-өөс 5 хүүхэд төрүүлээд нэг хүртэлх насандаа хүүхэд нь нас барсан 8463 ээж байгаа гэж хэлсэн. 1930 ээж зургаа ба түүнээс дээш, 6 хүүхэдтэй. Тэгээд 1-ээс дээш хүүхэд нь нас барсан 1930 ээж байгаа гэж түрүүн таницуулгад хэлсэн. Нийтдээ 10400, 10403 гэсэн үг үү, тийм л үг хэлсэн. Өргөсөн чинь болдоггүй юм гэсэн, өргөсөн чинь ингээд нөгөө хамаатан саднууд бие биедээ өргүүлээд ингээд алдарт эх болоод байдаг магадлал ихтэй учраас өргөж авахыг бол тооцдоггүй. Тэгээд ер нь тэгвэл алдарт эхчүүдийн тоо эрс өснө.

Санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 67,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Балжиннямын Баярсайхан гишүүнийг дэмжсэнд тооцож. Аубакир гишүүн хаагуур яваад байна вэ та? Тэгээд л олон хүүхэдтэй эхийн хууль болохоор ороод ирдэг та чинь. Өглөөнөөс хойш хаагуур байсан юм бэ? Тэр Хүмүүнлэгийн боловсролын хууль яасан бэ өглөөнөөс хойш нэхлээ. Та аваад хав дарчихсан. Энэ хөдөөгийн ард түмэн нэхээд байдаг. Дараагийн асуудал.

Ингээд төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул

төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

14.29 цаг

Зургаа.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд орвол орлоо. Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2024 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэх хэлэлцүүлэгт бэлтгэх, хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин, бүрэлдэхүүнд Улсын Их

Хурлын гишүүн Ганбат, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Сандаг-Очир нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ. Ажлын хэсэг хуулийн төсөлд туссан нийслэл дэх дүүргийн анхан шатны шүүхийг эрүүгийн хэргийн тойргийн 3, иргэний хэргийн тойргийн 3 буюу тойргийн нийт 6 шүүхийг байгуулж, нутаг дэвсгэрийн алслагдмал байдлыг харгалзан Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Багануур дүүргийн иргэний анхан шатны шүүхийн одоогийн зохион байгуулалтыг хэвээр үлдээх, Багахангай, Налайх дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхийн тойргийн зарчмаар байгуулж, Налайх дүүрэгт байршуулах. Нийслэлийн хэмжээнд дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх 1, нийслэл дэх гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх 1 байхаар тусгасан саналыг хэвээр үлдээж, ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Авлигын хэргийн давж заалдах шатны шүүх, анхан шатны журмаар, хяналтын шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэх талаарх зохицуулалтыг хуулийн төслөөс хасах, Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж мөрдөх хугацааг тодорхой болгох зэрэг 26 зарчмын зөрүүтэй санал гаргаснаас 23 саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс гаргасан Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх 3 зарчмын зөрүүтэй санал, хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх 1 зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан. Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан зарчмын зөрүүтэй саналыг, саналын томъёолол болон хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 26 санал байгаа. Анхны хэлэлцүүлгээр 26 саналаар санал хураалт явуулна. Тэгээд энэ Байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй санал, санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Адьшаа гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьшаа: Шүүх байгуулах тухай энэ хуулийн төслийг зарчмын хувьд хэлэлцэх нь зүйтэй гэсэн ийм

бодолтой байгаа. Гэхдээ шүүх эрх мэдэл тасралтгүй явагдах ёстой, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа явагдах нь энэ зүйтэй гэсэн ийм бодолтой байгаа.

Тэгэхдээ өнөөдөр энэ Шүүхийн тухай хууль бол төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг алдагдуулсан. Би энийг удаа дараа хэлж байгаа юм. Шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдлийн харьяанд авч ирээд, тэгээд өнөөдөр шүүхийн тухай асуудал, шүүх эрх мэдлийн тухай асуудал, шүүхийн нэр хүндийн тухай асуудал, шүүх бие даасан байх, шүүх хараат бус байх тухай энэ ойлголт өнөөдөр энэ парламентад алдагдсан шүү, алдагдсан шүү. Өнөөдөр шүүхийн тухай нийгэмд маш их зөрүүтэй ийм ойлголтууд гарч байгаа. Энэ хариуцлагыг энэ Шүүхийн тухай хуулийг баталсан энэ Улсын Их Хурал бас энэ хариуцлагыг хүлээх ёстой.

Шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд авч ирсэн. ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо гэдэг энэ Үндсэн хуулийн бүтцийн 2 байгууллагыг Улсын Их Хурлын 1 гишүүн ахлаад байгуулсан. Гэтэл Улсын Их Хуралд өнөөдөр сонгон шалгаруулалт явж төрийн албыг шүүх эрх мэдлийн удирдах байгууллагыг томилох ийм давуу байдлыг Улсын Их Хурал Шүүхийн тухай хуулиараа олгож энэ асуудлыг шийдсэн. Тэгээд өнөөдөр бүх юм хэдхэн тэр 500 хэдэн шүүгчийн буруу мэт нийгэмд харагдаж байгаа бол ийм тогтолцооны гажгсийг бий болсон, төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг алдагдуулсан энэ Улсын Их Хуралд бид бас хариуцлага хүлээх ёстой. Энэ болбол бодит үнэн.

Энэ асуудлыг бид цаашидаа дараагийн парламент энэ шүүх эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдлийн асуудалд парламентын засаглалын тэр үндсэн зарчим Ром, Германы парламентын засаглалын энэ зарчмыг бид баримталж, шүүх бие даасан байх, шүүх хараат байх энэ зарчмыг жинхэнэ утгаар нь

хэрэгжүүлэх ёстой гэсэн ийм асуудал байгааг энд зориуд тэмдэглэж хэлье. Энэнийг би протоколд тэмдэглэж үлдээж байгаа юм.

Яагаад гэхээр энэ өнөөдөр энэ гажуудал, өнөөдөр энэ шүүх эрх мэдлийн асуудал, шүүгчдийн асуудал өнөөдөр нийгэмд ямар байдал бий болчихоод байгаа билээ. Өнөөдөр шүүхийн тухай асуудал, шүүх бие даасан байх шүүх хараат бус байх өнөөдөр алдагдсан энэ асуудал бол энэ Шүүхийн тухай хуулийг төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчмыг алдагдуулж баталсан энэ Улсын Их Хурал бид бас хүлээх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Ингээд энэ хуулийн төслийг дэмжиж байна. Яагаад гэхээр зөвхөн шүүхийг байгуулж, шүүх болбол Монгол Улсын хэмжээнд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх асуудлууд өнөөгийн шаардлага, энэ бол төрийн шийдэх ёстой асуудлын нэг гэсэн ийм байр суурьтай байна. Надад асуулт байхгүй. Би үг хэлсэн шүү.

Г.Занданишатар: Үг хэлнэ ч гэж байхгүй. Энхбаяр сайд хариулахад бэлдэж байгаарай. Би эхлээд ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг протоколд тэмдэглэгдэнэ. Адъяаа гишүүн сууж бай, сууж бай, наадах чинь Үндсэн хуулийн зөрчилтэй юм ярьчихлаа. Лхагвадоржийн Энхбилэг ШЕЗ-ийн дарга, Амгалангийн Насандэлгэр ШЕЗ-ийн гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүн Сономдовчингийн Энхтөр, Отгонбаярын Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, Ганзоригийн Эрдэнэбулган ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Эрдэнэбулган аман дахь бохио авчих, шүүхэд хүндэтгэлгүй хандах, Улсын Их Хурал парламент хүндэтгэлгүй хандах гэсэн тийм зүйл ангитай байдаг юм шүү дээ. Энэбишийн Бадамсамбуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга, Шагдарсүрэнгийн Цолмон ХЗДХЯ-

ны ахлах шинжээч. Нямаагийн Энхболд гишүүн асуулт асууя.

Н.Энхболд: Би нэг яг энэ шүүхийн энэ заалттай холбоотой байж магадгүй, гэхдээ шүүхийнхнээс нэг юм асуугаадахъя гэж бодсон юм, тийм. Шүүх засаглал биеэ даасан байх ёстой. Шүүгч нар хуулийн хүрээнд итгэл үнэмшилээрээ шийдвэр гаргадаг байх ёстой. Сая Адъяаа гишүүн хэлж байна. Нэг шүүхэд Их Хурал нөлөөлөөд байгаа л юм шиг, шүүх заримдаа улс төрд нөлөөлөх гээд байгаа юмнууд гардаг. Би ганцхан жишээ хэлье, 2 жишээ хэлье.

Өвөрхангай аймагт болсон сонгуулиар Чинзориг, Төмөрхүү нар сонгогдсон байсан. Маргаан үүсээд, тэгээд түүнийг нь шүүхийнхэн дотроо ярьж байгаад би тэгж ойлгосон тэр үед. Харьяаллыг нь өөрчилж Улаанбаатар хотод авчирч байгаад шүүгээд, тэр 2 сонгогдсон гишүүний эрхийг нь байхгүй болгоод, оронд нь өөр хүмүүс оруулж ирсэн 1 дүгээр жишээ нь.

2 дугаар жишээ уг нь шүүх итгэл үнэмшилээрээ асуудал шийдэх ёстой л доо. Тэгэхдээ хуулийн хүрээнд л байх ёстой. Жишээ нь Улсын Их Хурлын гишүүн газар дээрээ л гэмт хэрэг хийчхээд, хийж байгаад баригдчихаагүй болбол тэр хүнийг баривчлах, хорих ийм хориотой хуулиар Улсын Их Хуралд нэр дэвшээд явж байгаа хүн бас ийм дархлаатай. Гэтэл Ж.Эрдэнэбат гишүүнийг 1 дүгээрт Их Хурлын гишүүнийхээ дархлаатай, баталгаатай. 2 дугаарт нэр дэвшигчийн баталгаатай явж байхад нь одоо би нэрийг нь мартчихаж. Нэг шүүгч энэ хүнийг баривчилна гээд. Үгүй ээ наадах чинь ийм Их Хурлын гишүүний, парламентын гишүүний халдашгүй байдал гэдэг ойлголт байдаг юм.

Дархлаанууд нь байдаг юм хуулиар олгогдсон. 2 давхар дархлаатай хүн явж байхад наадхыг чинь ингэж барьж хорьж болдоггүй юм гээд байхад тэр

дархлаа гэдэг чинь гишүүний дархлаа биш, Улсын Их Хурлыг бүхэлд нь хэлдэг юм гэж хэлээд шоронд хийгээд, ингээд сонгуулийг нь тасалдуулж байсан. Дундуур нь баривчлаад явчихсан. Ийм, ийм зүйлүүд гарахгүй гэх баталгаанууд цаашидаа байна уу? Тэр шүүгч ер нь би нэрийг нь мартчихаж, хэн гэж байлаа даа? Сүүлд нь шүүгчээс, Идэр гэсэн байх. Шүүгчээсээ больсон гэсэн, ял хүлээсэн үү? Зүгээр шүүгчээсээ болиод л, тэгээд л тэр нь шийтгэл болчихдог юм уу? Цаашидаа ийм юм гаргахгүй байх тал дээр нь тухайлбал ШЕЗ энэ тэр ямар арга хэмжээ авч, яаж ажиллаж болох вэ? Уг нь их ойлгомжтой зүйл шүү дээ. Дэлхийн хэмжээнд нийтлэг мөрддөг тийм юм байж байхад. Наадхыг чинь гишүүнийх биш, Их Хурлын баталгаа гэдэг юм гэж хэлээд, тийм тайлбар бид нарт өгсөн байсан. Ингээд нэг ийм юм болж байсан. Энэ дээр би нэг хариулт авмаар байна.

2-т сонгууль болох гэж байна. Түрүүн бас хууль ярьж байхад энэ мөнгөөр жагсаалтад орох эрхээ худалдаж авч байгаа, тэгэхдээ бүүр асар их мөнгөөр гэсэн ийм ярианууд яваад байх юм. Энэ талаар Энхбаяр сайд танд мэдээлэл янз бүрийн юм байна уу? Та нар энэнийг бас хянаж л байх ёстой. Энэ чинь мөнгөөр, одоо ингээд тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүсийн гаргаж байгаа зардлаас зардлын 50 хүртэл хувиар жагсаалтаар дэвшиж байгаа хүмүүс зардал гаргаж болно гэсэн хуулийн заалттай. Гэтэл юун тэр байтугай тэрнээс санаанд оромжгүй тоонууд тэгээд ингээд намууд суудлаа тойрогт худалдаад байна гэсэн ийм мэдээллүүд байгаад байх юм. Энэ дээр бас, энэ чинь мөнгөөр хүний төрөө байгуулах эрхийг худалдаж авч байгаа хэрэг буюу төрийн эсрэг, хууль бусаар төрийн эрхийг авах оролдлого гэж үзэж болохоор ийм юмнууд яригдаад байна шүү дээ.

Тэгээд бид нар уг нь Их Хурлаа чанартай болгоё, сайжруулъя гээд

хуулиа өөрчлөөд, Үндсэн хуулиа өөрчлөөд, Сонгуулийнхаа хуулийг өөрчлөөд хууль хийгээд байдаг. Ямар ч тийм нүх цоорхойгүй л хийлээ гэж бодсон. Гэтэл зүгээр өөрснөө том нүх гаргаж байгаад, тэр нүхээрээ баахан мөнгө чихээд гэдэг ийм асуудлыг бол энэ сонгууль чинь юу болж таарах вэ? Энэ ч ШЕЗ-ийнхөнд нэг их хамаагүй л байх л даа. Зүгээр Энхбаяр сайд бас нэг энэ дээр хэлэх юм байвал би бас асуучихмаар байна.

Г.Занданшатар:

Эхлээд

Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя. Парламент Улсын Их Хурал бол ард түмний төлөөллийн дээд байгууллага. Ард түмний сонголт бол эцсийнх байдаг. Шүүхэд ард түмний сонголтыг засварлах эрх бол байхгүй. Тэр тусмаа нэг шүүгчид. Таны хэлсэнчлэн Өвөрхангай аймагт болсон сонгуулийн үр дүнг нэг хоногийн дараа, нэг хоногийн дотор харьяаллыг нь өөрчилж байгаад нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүгч засварлаж, Өвөрхангай аймгийн 100 гаруй мянган иргэдийн сонголтыг нэг шүүгч засварлаад, аль нам нь парламентдаа олонх болох вэ буюу Ерөнхий сайд, Засгийн газраа аль нам нь саналаа гаргах вэ гэдэг Үндсэн хуульд заасан ард түмний төрөө мэдэх энэ эрхэд халдаж байсан асуудал байдаг.

Одоо энэ өдрүүдэд шүүх засаглал ямар хэмжээнд хонгил угсрагдаж, явж байв гэдэг асуудал илүү тодорхой болж байна. Бидний 2001 онд Шүүхийн тухай хуулийг баталсан нь зөв байжээ гэдэг нь улам бүүр тодорхой болж байна. Шүүхийн тухай хуулийн үзэл санаа болбол нэг хүний буюу Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч зэрэг өндөр албан тушаалтнуудаас шүүх эрх мэдлийг хараат бус, дарга хэв шинжтэй байдлыг нь халахад бүх зорилго нь чиглэгдэж байсан. Дургүй хүрсэн шүүгчээ хөдөө томилоод явуулчихдаг эсвэл Ерөнхийлөгч нь 13 шүүгчийг зарлиг гаргахдаа орхигдуулаад мартчихдаг. Таалагдахгүй, үгэнд нь ороогүй шүүгчдээ мартчихна

томилохоосоо. Үгэнд ордог шүүгчээ дэвшүүлдэг, гавьяат хуульч өгдөг, шагнадаг. Одоо энэ бүхэн тодорхой болж байна.

Би түрүүчийн чуулган дээр бас хэлж байсан. Монгол Улсын шүүгчдийн тал нь Элбэгдорж гэж хүний томилсон шүүгчид байгаа. Шүүгчдийг мэдээж аль нэг нам, аль нэг гишүүн шууд оролцох, нөлөөлөх боломж хязгаарлагдмал. Ялангуяа Шүүхийн хуулиар бид үүнийг хатуу хориглосон. Улсын Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн шүүн таслах ажиллагаанд оролцохыг хориглосон. Гэхдээ энэ нь шүүгч Үндсэн хуулиасаа давсан данхайрал байж болохгүй. 2004-өөс 2008 оны парламент 2 гишүүний сандлын зөрөөтэйгөөр аль нам нь парламентад олонх болох вэ гэдэг нь шийдэгдэж байсан. 2 хүнийг нь хонгилдоо чирэхэд сөрөг хүчин байсан нам нь олонх болж байсан.

Өөрөөр хэлбэл засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх, ард түмний сонголт эцсийн байх энэ Үндсэн хуулийн эрхэд шүүх нөлөөлж байсан. Энэ явдлыг давтан гаргуулахгүй байх дээр онцгой анхаарч байгаа. Би түрүүн хэлсэнчлэн Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчдийг ямарваа нэгэн байдлаар улс төрийн шалтгаанаар баривчлах, саатуулах, ард түмний сонголтод нөлөөлөх оролдлогыг Хууль зүйн сайдын хувьд гаргахгүй.

Харин жагсаалтаа зараад, зарах гээд байгаа, зарж байгаа нөгөө уул уурхайн том компаниудаас мөнгө гуйгаад явж байгаа, би жагсаалтын 5-д орохоор болчихлоо, 15 тэрбум төгрөг хэрэгтэй байна, 10 тэрбум төгрөг өгчихвөл би орох гээд байна гэж явж байгаа хүмүүс энэ санаархлаа одоо зогсоогоорой.

Г.Занданишатар: 3 номер, ШЕЗ-ийн дарга Энхбилэг хариулъя.

Л.Энхбилэг: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энхболд гишүүний асуултад хариулъя. ШЕЗ Шүүхийн тухай хуулийн 70.2-т заасны дагуу шүүгч, шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг хүний нөөцөөр хангах, шүүгчийн хараат бус, бие даасан, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Тэгэхээр шүүн таслах ажилтай холбоотой асуултауд асуусан учраас надад бол хариулах боломжгүй байна.

Г.Занданишатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя. Шүүхийн сахилгын хорооноос асуувал.

Н.Энхболд: Тэр чинь улайм цайм шүүгч биш хүн ч хүртэл ойлгомоор л тийм заалт шүү дээ. Би тэр Эрдэнэбат гишүүн тэр үед яг хулгай хийж яваад газар дээрээ баригдчихаагүй гэж бодож байна. Нэр дэвшигчсэн байсан хүн нь дархлаатай гэдгийг мэдсээр байж худлаа тайлбар хийгээд, тэгээд баривчилчихсан ийм шүүгчид Сахилгын хороо, ШЕЗ-ийн зүгээс авсан арга хэмжээ гэж юм байна уу? Авч байх юм уу цаашидаа? Тэр нь бидэнд хамаагүй, тэр Ерөнхийлөгч нь өөрөө шийддэг юмаа юм орхичихдог юм уу? Энэ нэг жишээ нь энэ хүн сууж байна л даа. Тийм. Түүн дээр хариулт авмаар байх юм.

Г.Занданишатар: Хууль хэрэглээний асуудалтай л. Шүүхийн сахилгын хорооны гишүүний гишүүн 1 номер. Энхтөр, Сономдовчингийн Энхтөр танай дээр тийм гомдол ирсэн үү? Хууль хэрэглээний асуудал ямар байна вэ?

С.Энхтөр: Манайд бол 21 оны 3 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар тус Шүүхийн сахилгын хороо болбол бүрэн бүрэлдэхүүнээрээ 11 сарын сүүлээр Их

Хурлын хуульч, шүүгч бус хуульч гишүүд сонгогдсоны дараа болбол 9 гишүүнтэй болсноор үйл ажиллагаагаа явуулсан. Энэ үед болбол 283 өргөдөл өмнөх Шүүхийн ёс зүйн хороонд болбол хуримтлагдаж хүлээгдэж, шийдвэрлэгдээгүй байсныг болбол 9 гишүүн өөрийнхөө хэрэг өргөдөл мэдээллийг хуваарилах журмаа баталж байж, ингээд тохиолдлын санамсаргүй тохиолдлоор хуваарилж авахад болбол саяын Энхболд гишүүний ярьж байсан энэ өргөдөл ийм асуудалтай холбоотой өргөдөл бол нэг ч ирээгүй. Тэгэхээр зэрэг энэ нь болбол Сахилгын хороо байгуулагдахаас нэлээн олон жилийн өмнөх энэ сонгуулийн үйл ажиллагаа, тэр үйл ажиллагаатай холбоотой.../минут дуусав/

Г.Занданишатар: 1 номер гүйцээгээд хариулчихъя.

С.Энхтөр: Тэр өмнөх тэр энэ Сахилгын хороо байгуулагдахаас өмнөх тэр сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой байсан юм байна. Ийм өргөдөл болбол яг ирээгүй байгаа. Бид нар энэтэй холбоотой шалгах ажиллагаа явуулаагүй. Шаардлагатай болбол энэ талаараа болбол өргөдөл гаргах юм болбол Сахилгын хороо болбол шалгах ажиллагаа явуулж байж, тухайн шүүгчийн гаргасан эрх зүйн акт болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой материалуудыг хүлээж авч байж, энэ талаар болбол хүлээж авсан илтгэгч гишүүн болбол санал, дүгнэлтээ аль нэгийг бичиж байж болбол Сахилгын хорооны хуралдаанаар оруулж байж, сахилгын зөрчил мөн биш, мөн болбол сахилгын шийтгэл оногдуулах асуудлыг болбол шийдвэрлэх боломжтой. Тэгэхээр одоогоор болбол яг таны ирсэн хэлсэн асуудлаар болбол тийм өргөдөл болбол ирээгүй байсан учраас тэр шалгах ажиллагаа бол явагдаагүй шүү. Тийм. Ингээж хариулъя.

Г.Занданишатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн, сайд хариулъя. Ажлын хэсэг.

Б.Энхбаяр: Өнгөрсөн онд би ХЗБХ-ны даргаар ажиллаж байх үедээ 2022 оны Шүүхийн сахилгын хорооны тайланг ХЗБХ сонссон байгаа. Энэ тайлангийн үеэр Шүүхийн сахилгын хороо ажиллаж эхэлсэн нэг жилийн хугацаанд сүүлийн 10 жилийн хугацаатай дүйцэхүйц хэмжээний шүүгчдэд хариуцлага тооцсон дүн мэдээлэл гарсан. Өөрөөр хэлбэл 2019 онд Шүүхийн сахилгын хороог Үндсэн хуулийн өөрчлөлтөөр хараат бус, бие даасан байдлаар байгуулсан нь үр дүнгээ өгч эхэлж байгаа юм байна гэдэг ийм дүн мэдээ гарсан.

Харамсалтай нь шүүгчид өөрсдөө хариуцлага тооцуулахгүй байх лобби одоо хүртэл хүчтэй явсаар байгаа. Энэ сарын 24-ний өдөр буюу энэ долоо хоногийн 4 дэх өдөр Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа.../минут дуусав/

Г.Занданишатар: Энхбаяр сайд гүйцээгээд хариулчихъя. Цаг нэмчих. Дараа нь санал хураалттай, гишүүд.

Б.Энхбаяр: Ирэх долоо хоногт Монгол Улсын ҮХЦ-ийн 2 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаа, 3 гишүүний. Энэ бүрэн эрх нь хугацаа нь дуусаж байгаа гишүүн шүүгчдэд хариуцлага тооцдог Шүүхийн тухай хуулийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж маргаан үүсгэж, бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаасаа өмнөх хамгийн сүүлийн өдөр ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаан зарласан байгаа. Өөрөөр хэлбэл чоно борооноор гэгчээр шүүхийн шүүгчдэд хариуцлага тооцдог болсон энэ заалтыг нөгөө хонгилын ҮХЦ-д шургалсан гар, хөлүүд нурааж унагах ажиллагааг хийх гэж байгаа. Би энэ мэдээллийг бас Улсын Их Хуралд хийж байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 26 санал байгаа. Зарчмын зөрүүтэй 26 саналаар санал хураалт явуулна. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7, 12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 7, 8, 13, 14 дэх заалт болгох.

7.Дархан-Уул аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг, Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж, Дархан-Уул аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Дархан-Уул аймаг, Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж.

13.Орхон аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Орхон аймаг, Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж.

14.Орхон аймгийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Орхон аймаг, Орхон аймгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн бүх нэгж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Дашдондогийн Ганбат, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Цэндийн Сандаг-Очир цаашид ажлын хэсэг гэнэ. Нутаг дэвсгэрийн хуваарилалт шүүхийн тойрог ч нэг юм дараа нь их маргаан дагуулна даа. Энэ одоо ингээд. Санал хураалт. Үндсэн хуульд заачихсан юм. Орхон, Дархан 2 дээр. Энэ санал, энэ санал дэмжигдсэнгүй. Энэ санал дэмжигдсэнгүй. Орхон, Дарханых нь гишүүд өөрсдөө дэмжсэнгүй. Тэгээд одоо яая гэх вэ, яая гэх вэ. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ янзалъя. Санал дууссан.

Дараагийнх. 2.Төслийн 1 дүгээр зүйлийн Нэг дэх хэсгийн 22, 23 дахь заалтын “тойргийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал

хураалт. Дараагийнх нь санал хураалт. Дараагийнх нь санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа суу, Ганбаатар гишүүн. Санал хураалт. Хуучин тойрог нь байж байгаа л. 53,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн Нэг, Хоёр дахь хэсгийн 3 дахь заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Налайх дүүрэг ” гэж, Нэг, Хоёр дахь хэсгийн 4 дэх заалтын “Улаанбаатар хот” гэснийг “Улаанбаатар хотын Багануур дүүрэг” гэж, мөн зүйлийн Гурав, Дөрөв дэх хэсгийн “Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Налайх, Багануур дээр. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал явуулна. Энэ Чинзориг сайд өөрийнхөө хуулийг батлуулчихаар ингээд хурал үймүүлдгээ болиорой. Энэ Ганбаатар та хоёрт удаа дараа сануулж байгаа шүү. Одоо.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хэрэг маргааныг” гэснийг эрүү, иргэний хэрэг шүүх, “эрүү, иргэний хэрэг, маргаан,

эрүүгийн хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэрэг, маргааныг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 56,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “20... оны дүгээр сарын ...-ны өдрийн дотор” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсэг, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсэгт заасан анхан болон давж заалдах шатны шүүхэд шүүгчийг томилуулах тухай саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт, мөн зүйлийн Гурав, Зургаа дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. ХЗБХ дэмжсэн санал байна. 1.Төслийн 2 дугаар зүйлийн тухайн шүүхэд 4-өөс доошгүй жил ажилласан

бол гэснийг тухайн шүүхэд 4-өөс доошгүй жил ажилласан шүүгчийг албан ажлын шаардлагаар гэж өөрчлөх. Албан ажлын зайлиггүй шаардлагаар гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжсэн, дэмжээгүй 2 гишүүн. Баттөмөрийн Энхбаяр, Ганибалын Амартүвшин гишүүд үг хэлнэ, тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр сайд, гишүүн.

Б.Энхбаяр: ХЗБХ-ны дэмжсэн энэ саналыг миний хувьд бол дэмжихгүй үг хэлэх гэж байна. Энэ шүүх 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хуулиар яах вэ бүхэлдээ хонгилыг нураах өөрчлөлтүүд хийгдсэн юм. Дотроос нь ч тэр, гаднаас нь ч тэр нөлөөлдөг нөлөөлөл, шүүгчдийг атгадаа авдаг, өөрөөсөө хамааралтай болгодог нүх сүвнүүдийг бүх л талаас нь бөглөхийг чармайсан. Энэ дотор хийсэн нэг өөрчлөлт болбол Монгол Улсын Ерөнхийлөгч ШЕЗ шүүгчдийг дураараа ингээж сэлгээдгийг болиулсан юм, үзэмжээрээ. Тэгээд таалагдахгүйгээ хөдөө юм уу, ингээд өөр тийш нь цөлчихдөг. Тэгээд яг тухайн хэрэг маргааныг шийдэх үедээ үгэндээ орох номхон хүнийг өөр газраас шилжүүлж авчирч байгаад тэр хэрэг маргаанд оруулж хонгилддог ийм зүйлийг таслан зогсоохын тулд дур зоргоороо тайлбарлагдах, үзэмжээрээ тайлбарлагдах ийм үндэслэлээр шүүгчийг шилжүүлж ажиллуулдаг явдлыг хаасан юм.

Зөвхөн өөрийнх нь саналыг авна. Гарцаагүй тэр удаан жил ажилласан гэдэг үндэслэл байгаа болбол тодорхой хэмжээний ажилласан жилийн шаардлага тавь гэж байгаа. Тэгээд энэ Шүүх байгуулах тухай хуулийг ЗГ-аас өргөн барьсан хууль байгаа. Энэ явцад зүгээр ямар саналууд Ерөнхий зөвлөлөөс ирээд байсан бэ гэхээр албан ажлын зайлиггүй шаардлагаар бид нар бас ингээд шилжүүлдэг баймаар байна гээд байсан юм. Тэгээд албан ажлын зайлиггүй шаардлага гэж яг юу хэлээд байгаа юм бэ? Энэ барих барьцтай үндэслэл мөн үү? Энэ бол субъектив

үндэслэл, дур зоргоор тайлбарлагдах үндэслэл. Тийм учраас ШЕЗ-ийн дур зоргод шүүгчдийг бас оруулж болохгүй.

Тэгэнгүүт сая энэ Их Хуралд өргөн барьсны дараа энэ ШЕЗ-ийнхний лобби л юм шиг байгаа юм. Албан ажлын зайлиггүй шаардлагаар гээд нэмж өөрчлөх ийм санал дэмжигдчихээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг унагаж өгөөч гэж би хүсэх гэж байгаа юм. Унагаж өгвөл энэ албан ажлын шаардлагаар шилжүүлдэг гэдэг ийм барьцгүй үндэслэл байхгүй болно гэсэн үг байхгүй юу одоо тийм. Тийм учраас би энэ саналыг унагаад өгөөч гэж шууд дэмжихгүй санал хэлж байгаа юм.

Г.Занданшатар: Дэмжихгүй үг хэллээ. Ганибалын Амартүвшин гишүүн үг хэлнэ.

Г.Амартүвшин: Яах вэ энэ заалт бол 2 талтай л даа. Бид нар ажлын хэсэг дээр бол аль болохоор ШЕЗ-д шүүх, шүүхүүдийн ачааллыг уян хатан зохицуулах тийм боломжийг нь өгье гэсэн логикоор энэ саналын томъёоллыг оруулж ирсэн юм.

Гэхдээ яах вэ Энхбаяр сайдын бас хэлж байгаа зүйл бол ор үндэслэлтэй байж магадгүй гэдэг үүднээс даргаа энэ саналын томъёолол дээр гүйцээн боловсруулах чиглэл авчихъя.

Г.Занданшатар: Албан ажлын зайлиггүй шаардлагаар гэж байгаа юм. 4-өөс доошгүй жил ажилласан бол гэж байгаа юм. Үг хэлэх байхгүй. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Дэмжсэн, дэмжээгүй саналыг зөвхөн гишүүд үг хэлнэ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын “Улсын дээд шүүхтэй зөвшилцөж” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн “89 дүгээр зүйлийн” гэсний дараа “89.1 дэх хэсгийн “, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан” гэснийг,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ХЗБХ-ны дэмжээгүй санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Дэмжээгүйг дэмжинэ. Үгүй ээ дэмжихгүй гэсэн үг биз дээ энэ чинь. 43.1, биш. 70 хувиар бослоо шүү дээ. Одоо нөгөө санал, дараагийн санал дээр л хэлнэ л дээ. Саналыг дэмжсэн, дэмжээгүй л санал хэлэх болохоос биш. ЗГ-ын саналаар авагдаж байгаа юм. Үгүй л дээ. Хасах гэснийг дэмжээгүй байхгүй юу. Дэмжээгүйг дэмжихээр хасах гэдэг нь дэмжигдэж байгаа юм. Өөрсдийнхөөрөө ойлгоцгооё. Энийг Байнгын хороон дээрээ ахиж ярьцаагаарай.

Гурав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. ХЗБХ дэмжсэн санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 1 дүгээр зүйл хасагдсаныг Байнгын хороон дээрээ эргэж яриарай. Тэр зайлиггүй хасагдах. Хасагдчихаж байгаа юм. Үгүй ээ үгүй, хасах гэдэг саналыг нь Байнгын хороо дэмжээгүй байхгүй юу. Тэгээд тэр дэмжээгүй гэдэг хасахгүй гэсэн саналаар санал хураалт явуулсан чинь хасъя гээд эсрэгээрээ гарчхаж байгаа байхгүй юу. Дараагийн саналыг санал хураалт явуулъя. 3, бүүр 70 хувиар хасагдсан, одоо яалт ч үгүй болж байна.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 17 дугаар бүлэг гэсний дараа 1 дүгээр дэд бүлэг гэж гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Даргаа энэ Шүүхийн хуулийн саяын ХЗБХ-ны дэмжээгүй саналыг дэмжихгүй санал хураагдсаны, хураагдсан нь өөрөө Үндсэн хуультай холбогдоод байгаа юм. Яагаад гэхээр.../үг тасрав/

Г.Занданшатар: Төслийг нь аваад ир дээ.

Б.Энхбаяр: Улсын дээд шүүхээс бид нар чинь ШЕЗ болон Шүүхийн сахилгын хороо гээд Үндсэн хуулийн байгууллага 2019 оны өөрчлөлтөөр байгуулсан. Ингээд энэ Үндсэн хуулийн байгууллага байгуулаад, энд нь Улсын дээд шүүхээс 1 шүүгч томилогдоно гээд хууль нь гарчихсан. Шүүхийн тухай хууль 21 онд батлагдаад хэрэгжиж байгаа. Гэтэл ШЕЗ сүүлийн 3 жил ШЕЗ болон Шүүхийн сахилгын хороонд Улсын дээд шүүхээс томилогдсон 1, 1 шүүгчийн сул орон тоог зарлахгүй байгаад байгаа. Энэнээс болоод Монгол Улсын Дээд шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллахгүй байгаад байгаа.

ШЕЗ яагаад Улсын дээд шүүхийн өөр Үндсэн хуулийн байгууллагад томилогдчихсон сул орон тоог зарлахгүй байна вэ гэхээр Ерөнхий зөвлөлд Улсын дээд шүүхээс томилогдсон энэ хүмүүс өөрийнхөө орон тоог хадгална гээд зарлахгүй байгаад байгаа юм. Гэтэл энэ Улсын дээд шүүхээс томилогдсон хүмүүс чинь ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо гэсэн өөр байгууллагад 4-өөс 6 жилийн хугацаагаар томилогдчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр 4-өөс 6 жил Улсын дээд шүүх орон гарсан шүүгчийнхээ орон тоог бөглөхгүй, дутуу орон тоотой ажиллаад байх юм уу, дутуу орон тоогоор.

Тэгээд энэ өөрөө Монгол Улсын Дээд шүүхийн, Дээд шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах энэ зарчимд нийцэхгүй байгаад байгаа. Монгол Улсын төрийн тэргүүн энэ дээр бас бодлого нь тодорхой байгаа. Улсын Их Хурлын дарга өнгөрсөн онд чуулганы нээлт дээр

ШЕЗ-ийг Шүүхийн хуулиа хэрэгжүүлээч гэдэг шаардлагыг бас хэлсэн үгэндээ онцолж хэлж байсан. Зөвхөн 1 шүүгч өөрийнхөө орон тоог хадгалж байна гээд Улсын дээд шүүхийг орон тоогоор нь ажиллуулахгүй, орон тоог нь зарлахгүй байгаад байгаа юм. Тийм учраас Шүүхийн тухай хуульд ШЕЗ болон Сахилгын хорооны гишүүнээр томилогдсон шүүгчийн орон тоог зарлана гэдгийг нь үүрэгжүүлж өгөх гэж байгаа энэ заалтыг сая Улсын Их Хурал унагачихлаа.

Тийм учраас энэ өөрөө их зарчмын асуудал болчихоод байгаа юм. Тийм учраас Улсын Их Хурлын дарга энэ дээр чиглэл өгч өгөөч. Яагаад гэхээр энэ Үндсэн хуулийг хэрэгжүүлэх гээд байгаатай холбоотой заалт байхгүй юу 2019 оны.

Г.Занданшатар: Энэ Ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд хяналтын шүүх болон сэлгэн ажиллах боломжгүй давж заалдах шатны шүүхээс энэ хуулийн 76.2, 95.4-д заасны дагуу шүүгч гишүүнээр сонгогчихсон тохиолдолд тухайн шүүгчийн сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлана гэдэг заалт чинь болбол хөндөгдөөгүй шүү дээ тийм ээ. Тэгэхдээ 32.7-д, 32.6-д заасан шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг жилийн дотор сонгон шалгаруулалт зарлахгүй гэдэгтэйгээ зөрчилдөж байгаа учраас эцсийн хэлэлцүүлэг дээр энийг Байнгын хороон дээр анхаарч, хууль хоорондын зөрчлийг засаж, энийг дахиж хэлэлцэх бололцоотой юм байна. Тэрүүгээрээ ахиж хэлэлцье.

Санал хураалтыг цаашид үргэлжлүүлнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор хурааж байгаа.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь хэсэг нэмсүгэй:

13. Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагаа, Арван долдугаар бүлэгт заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийг нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх хянан шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 51,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн “14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “шүүхийн” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны, 3 дээр үг өгчхөөд хураагаагүй байж тийм ээ. Тэгэхдээ энэ 3, танилцуулчихъя. 3 дугаар, Төслийн 2 дугаар зүйлийн ““АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ” гэсний дараа “НЭГДҮГЭЭР ДЭД БҮЛЭГ” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт. Цэрэнпунцаг гишүүн санал хураалт, Одонтуюа гишүүн санал хураалт. 51,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сэргэлэн, Ундрам, Энхтүвшин гишүүдийг дуудаарай.

Төслийн 3 дугаар зүйлийн “14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “шүүхийн” гэсний дараа “, нийслэлд эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” гэснийг мөн зүйлийн “31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж, 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шүүх” гэсний дараа “, нийслэлд Дүүргийн эрүү, иргэний

хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Одонтуюа гишүүн. Сэжигтнээс мэдүүлэх болгочихлоо. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх. Энэ хуулийг 2024 оны дугаар сарын тэдний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Суу, Цэрэнпунцаг гишүүн суу, хаачих нь вэ?

Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. ХЗБХ дэмжсэн санал байна. 1. Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын нэмэлт гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Баттөмөр гишүүн санал. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Би энэ заалтыг дэмжиж байгаа юм. Тэгээд сая энэ аппарат ажилласангүй. Дахиж санал хураалт явуулж өгөөч.

Г.Занданишатар: Баагаагийн Баттөмөр гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 55 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт хүчингүйд тооцогдсон учраас санал

хураалтыг дахиж явуулна. Санал хураалт. Тогтохсүрэн дарга, Тогтохсүрэн дарга саналаа өгөөрэй. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3 дахь дэд заалт нэмэх. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн, зориулалтын шаардлага хангасан шүүхийн байраар хангах хүртэлх хугацаанд нийслэл дэх зарим шүүхийг байраар ханган хангаж, шүүн таслах ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Тогтоолын төслийн 1 дэх заалтад дор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх.

4.Нийслэлд гэр бүл, хүүхдийн хэргийн анхан болон давж заалдах шатны тойргийн шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган, Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Өмнөх санал 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ тэгэхдээ байна шүү дээ заавал 25 оны хаврын ээлжит чуулганд гэж заахгүй 2024 оны намрын чуулганаар ч хэлэлцэж болно шүү дээ. Төсөв энэ тэртэйгээ уялдуулах шаардлагатай байж магадгүй. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай.

5.Тогтоолын төслийн 1 дэх заалтад дор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх.

5.Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн давж заалдах шатны шүүхийг тойргоор байгуулах асуудлыг судалж, холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их

Хуралд өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 69,8 хувийн санал, 59,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 1 дэх заалтад дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэгжийн орон тоо, төсвийг нэмэгдүүлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй. Яах вэ энэ тэгээд ЗГ-т өргөн мэдүүлэх, юунд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд энэ өмнө л мэдүүлэх ёстой л доо. Энэ намартаа ч юм уу. Тийм.

7.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах. Яах вэ энэ, үгүй ээ, үгүй энэ хуулийн зохицуулалтын хувьд бас алдаатай байгаа. Яагаад гэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар чинь ЗГ-ын харьяа агентлаг, шууд Улсын Их Хуралд хуулийн төслөө боловсруулж оруулах, орон тоо нэмэгдүүлэх энэ тэр ХЗДХЯ-ны харьяа ХЗДХЯ-ндаа ЗГ-ын түвшиндээ шийдүүлээд, төсөвтөө оруулаад, энийгээ харин гүйцээн боловсруулж, эцсийн энэ дээр болбол ЗГ-т төсөвтөө суулгаад оруулж ирэхгүй бол 25 оны 10 сарын 15-нд чинь төсөв өргөн баригдчихсан, тэрэн дотроо тусахгүй энэ чинь хэрэгжихгүй заалт болчихоод байгаа байхгүй юу агуулгын хувьд. 25 оны төсөвтөө тусахгүй болчихно гэсэн үг. Хэрвээ энийг тусгая гэж бодож байгаа бол энийг өөрчлөөд ХЗДХЯ-ндаа үүрэг чиглэл болгоод явах, юу ЗГ-таа.

7.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга баталсантай холбогдуулан прокурорын байгууллагын орон тоо, төсөвт өөрчлөлт орох эсэхийг судлан үзэж, шаардлагатай бол саналаа боловсруулж, Улсын Их Хуралд хүргүүлэхийг Улсын ерөнхий прокурор Жаргалсайханд. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ХЗБХ дэмжээгүй санал байна. 1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дэмжээгүйг дэмжиж байж энэ санал босно шүү дээ тийм ээ. Санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Болорчулуун, Оюунчимэг гишүүн 2 хаагуур зугаалж байгаад ирсэн бэ та хоёр? Хууль хэлэлцэж, баталсны дараа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлж байна.

15.29 цаг

Дараагийн асуудалд орно. Ганбат гишүүн асуулт асууна гэсэн билүү Хууль зүйн сайдаас. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль. Шүүхийнхэн сонсож байгаарай. Сая олон асуулт асуучихсан. Тэгээд шүүх маргааны асуудлыг шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг Улсын Их Хурал, ЗГ-ын гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгчид хориглоно гэсэн заалттай. Ийм учраас энэ шүүхийн нэр хүндийг өргөх, шүүхэд итгэх ард түмний

итгэлийг сэргээх зорилгоор Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын бидний гишүүд шүүхийн ил тод байдлыг хангахтай холбоотойгоор Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг өргөн мэдүүлсэн. Энэ дээр ХЗДХ-ийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөл хамт оролцсон. Энэ хуулийн хэлэлцүүлгийг сайн зохион байгуулж, ард иргэддээ зөв мэдээлэл өгөөрэй. Явж болно. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалд орёе. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны, 26-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Хүрэлбаатар сайд яасан бэ? Сайд байхгүй учраас дараагийн асуудлыг хэлэлцье.

Долоо.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх, төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд эдийн засгийн тэргүүлэх 16 чиглэлд

мэдээлэл технологийн салбарыг хамааруулж, тус салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх, гадаадын зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн антрепренёр гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, үндэсний тоон контентыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилтуудыг дэвшиүүлсэн.

Монгол Улс НҮБ-аас 2 жил тутам шинэчлэн гаргадаг Цахим засаглалын хөгжлийн индексээр 2018, 2020 онуудад тус байгууллагын гишүүн 193 орноос 92 дугаар байранд орж байсан бол 2022 онд 74 дүгээр байранд орж 18 байраар урагшилсан. Харин Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг улс орнуудын инновацын чадавх амжилтаар нь эрэмбэлдэг Дэлхийн инновацын индексээр 2022 онд 71 дүгээр байрыг эзэлж, өмнөх онуудаас 10 гаруй байраар хойшилж, 2023 он 132 улсаас 68 дугаар байранд жагсалаа.

Статистик мэдээллээс харахад мэдээллийн технологийн үйлдвэр, үйлчилгээнээс эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа хувь нэмэр 0,24 хувь байна. Энэ нь мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ихэнх нь дэлхийн бусад улс орны энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудтай харьцуулахад бүрэн төлөвшиж амжаагүйг, манай улсад инновац, нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын талаарх хууль, эрх зүйн таатай орчин бүрдээгүй, төрөөс үзүүлэх дэмжлэг хангалтгүй байгаатай холбон тайлбарлаж болно. Мэдээллийн технологийн хөгжил нь инновацыг идэвхжүүлж, тухайн салбарын үйлдвэрлэл, экспортыг дэмжиж, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд ашиг тус, үр шимээ өгч, цахим эдийн засгийг бий болгон энэ нь нийгмийн бүхий л салбарт нэвтэрч, бүтээмжийг нэмэгдүүлэн,

өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийг авчирч байна.

Тухайлбал Бүгд найрамдах Казахстан улс 2000-гаад оноос хойш мэдээллийн технологийн салбарт дэмжлэг үзүүлэх хууль, эрх зүйн таатай орчноо бүрдүүлэх, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч, Дижитал Казахстан улсын хэмжээний хөтөлбөрийг 2017 оноос хэрэгжүүлж, 655 сая гаруй америк долларын хөрөнгө оруулалтыг зарцуулсан байна. Тус улс нь 2017 онд тус хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжлийн түвшинээр 175 орноос 52 дугаар байрт эрэмбэлэгджээ.

Түүнчлэн Бүгд найрамдах Солонгос улсын мэдээлэл харилцаа холбооны технологийн салбар нь 2022 онд Солонгосын ДНБ-ий 13 хувийг бүрдүүлж, улсын эдийн засгийн өсөлтийг тэргүүлж байна. 2022 онд мэдээллийн технологийн экспорт 233 тэрбум ам.доллар-т хүрсэн байна.

Бүгд найрамдах Турк улс 2023 онд үндэсний технологи, хүчирхэг үйлдвэрлэл гэсэн алсын хараатай стратегийн баримт бичгийг боловсруулан баталж, Турк улс даяар программ хангамж хөгжүүлэгчдийн тоог 140 мянгаас 500 мянгад хүргэхээр, дор хаяж 23 ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх зорилтыг дэвшиүүлсэн. Иймд Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан мэдээллийн технологийн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлэх, мэдээллийн технологийн үйлдвэр хөгжүүлэлтийг дэмжих зорилтын хүрээнд Хууль тогтоомжийн хуульд заасан журмын дагуу Монгол Улсын ЗГ-аас Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хуулийн төслийн 1 дүгээр бүлэгт хуулийн төслийн зорилт, үйлчлэх хүрээг тогтоож, хуульд хэрэглэсэн нэр томъёогоо тодорхойллоо. Энэ хүрээнд сэндбокс орчны талаар тодорхойлолт тодорхойлж, хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын орчныг бий болгон холбогдох журмыг ЗГ батлахаар тусгалаа.

Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт салбарын бодлого чиглэлийг тодорхойлоход мэргэжлийн холбоо, хувийн хэвшил, мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх, ЗГ, нутгийн өөрөө удирдах байгууллага мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар хүлээх үүргийг тодотгож, салбар хоорондын уялдаа холбоог хангах, Мэдээллийн технологийн үндэсний паркийн чиг үүргийг тодорхой болгож, гарааны бизнесийг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар тусгалаа.

Түүнчлэн төрийн байгууллагын худалдан авсан программ хангамжийн их кодын эзэмших эрхийг харилцан тохиролцож, тендер шалгаруулалтын баримт бичигт авахаар, Мэдээлэл технологийн үндэсний парк нь виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний хуулийн 22 дугаар зүйлд заасан Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр зохицууллаа.

Мөн энэ хуулийн хүрээнд ИМонгол мэдээлэл технологийг дэмжих виртуал бүсийг байгуулж, татварын бүх талын дэмжлэг үзүүлэхээр тусгалаа. Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд мэдээлэл технологийн виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх татварын бус дэмжлэгийг мөн тодотгож, хөрөнгийн үнэлгээ буюу материаллаг бус баялгийг үнэлэх, олон улсад технологийн

компаниудыг өрсөлдөх чадварыг дэмжих бодлогуудыг зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Г.Занданшатар: Төслийн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Инновац, цахим бодлогын байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар цахим эдийн засгийг дэмжих зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадамжийг дээшлүүлэн, мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн

үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс үзүүлэх дэмжлэг тодорхой болох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлд хүн, хуулийн этгээд тэгш эрхтэй, чөлөөтэй оролцох нөхцөл бүрдэх, мэдээллийн технологийн салбарт хөрөнгө оруулалт татах боломж сайжирч, олон улсын хамтын ажиллагаа нэмэгдэх, мэдээллийн технологийн салбарын оролцогч талуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжрах ач холбогдолтой гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг *dparliament.mn* цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтийн санал авч байгаа болно. Хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Байнгын хорооны гишүүдээс санал, асуулт, санал гараагүй бөгөөд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Инновац, цахим бодлогын байнгын хорооны дүгнэлтийг танилцууллаа. Өнөөдөр бас энэ 7 хоногт

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Энхбаярын Батиугарын төрсөн өдөр энэ 19-нд болно, бүтэн сайн өдөр. Батиугар 5 сарын 19-нд Намбарын Энхбаяр, Ононгийн Цолмон нарын ууган хүү болж эхээс мэндэлсэн байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батиугарт төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэр өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Саранчимэг гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Батаагийн Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын энэ чинь 2 бодлого, төлөвлөлтийн газрын даргатай газар юм уу? Энэ буруу танилцуулсан байна шүү энэ. Энэ дээр буруу бичсэн байна. Энэ яагаад ингэж алдаа гаргаад байна вэ сүүлийн үед. Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Өнөөдөр 3 дахь удаагаа алдаа давтагдлаа. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Мэдээлэл технологи буюу цахим шилжилттэй холбоотой асуудлаар бид нар бас нэлээн энэ сүүлийн 4 жилийн хугацаанд олон хуулиуд батлууллаа. Ер нь бол цахим засаглал бол нэлээн гайгүй үр дүнтэй яваа юм. Тэгээд яах вэ мэдээлэл технологийн энэ салбарын өөрчлөлттэй холбоотой 5 асуулт байгаа юм.

1 дүгээрт болохоор яг нөгөө сэндбокстой холбоотой нэр томъёо орж

ирсэн байна лээ. Тэгэхээр яг нөгөө бүрэн гүйцэт утгаараа орж ирж чадсан эсэх, нөгөө компаниудыг бойжуулах тал дээр яг арга хэмжээгээ авч чадах эсэхийг нэг тодруулчихмаар байна.

2 дугаарт Монголын энэ зах зээл дээр байгаа мэдээлэл технологийн компаниудын бас нэг гол тулгамддаг асуудал нь болохоор нэг зах зээлийн асуудал их яриад байдаг. Тэгэхээр энэ тал дээр ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Энэ хуульдаа ямар зүйл, заалт тусгасан бэ? Бас нэг магадгүй зүгээр ирээдүйд бол манай бас нэг экспортын буюу аутсорс хийдэг ийм салбар болж хөгжих бас боломжтой салбар байхгүй юу.

3-д болохоор энэ ажиллах хүчний асуудалтай холбоотойгоор нэг асуудал нь юу байна вэ гэхээр бид нар мэдээлэл технологийн ажилчид бол хомс байдаг. Гаднаас орж ирэх бас төдийлөн квот нь бас олддоггүй хүн оруулж ирэх нь. Тэгэхээр энэ тал дээр ямар шийдэл гаргаж байгаа юм бэ?

Мөн бид нар энэ боловсрол, ерөнхий боловсролын сургуульд уг нь яг мэдээлэл технологийн хичээлийн хөтөлбөрүүдээ нэг шинэчилчихвэл их зүгээр байна лээ л дээ. Сая ингээд ерөнхий боловсролын сургуулиудаар явангуут бид нар чинь нөгөө л нэг дээр үеийн ms-dos, windows гэсэн л хичээлүүд яваад байгаа байхгүй юу. Тэгээд уг нь одоогоос уг нь update хийгээд, тэгээд нэг арай нэг сүүлийн үеийн цаг үетэйгээ хамт алхаж явах энэ хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх тал дээр Боловсролын яамтай бас нэг ярилцах, хэлэлцээр хийх, шинэчлэх ийм асуудал бас үлдчихээд байгаа харагдсан.

Мөн яам болгон цахим шилжилт хийж байгаа гээд нөгөө цахим эрүүл мэнд, цахим юу гээд л яваад байдаг. Тэгээд ер нь цаашидаа яг төр ер нь өөрөө бүх ийм программ хангамжаа хийх гээд байна уу эсвэл хувийн хэвшлийг ашиглаж

явдаг байх уу? Энэ тал дээр нэг хариу авчихъя даа. Баярлалаа.

Г.Занданишатар: Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Энэ харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарыг хамтатгаж авч үзээд жилийн борлуулалтын орлого бараг 1,7 их наяд гээд Зохицуулах хорооны тайлан дээр дурдсан байдаг ч яг мэдээлэл технологийн оруулж байгаа салбарын оруулж байгаа хувь нэмэр бол 0,24 хувьтай гэдэг бол чамлалттай. Тийм учраас энэ хуулиар энэ мэдээлэл технологийн салбарыг дэмжье гэдэг зорилгоор сэндбоксын орчныг оруулж өгч байгаа. Нэг ёсондоо шинэ технологи Монгол Улсад нэвтрүүлэх гэж байгаа бол, нутагшуулах гэж байгаа бол сансрын бүх төрлийн технологи, хиймэл оюун ухаан, их өгөгдөл дээр шинэ технологи нэвтрүүлэх гэж байгаа бол сэндбоксын орчинд буюу нөгөө туршилтын орчинд үйл ажиллагаа явуулах, дүрэм журмын тэр саадаас гарч үйл ажиллагаа явуулах бололцоог энэ хуулиар нээж байгаа. Ер нь банк санхүүгийн салбарт яаж энэ цахимжилт технологи их хурдан нэвтэрсэн бэ гэвэл сэндбоксын орчин юм билээ. Тийм учраас хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансар дээр болбол сэндбоксын орчныг энэ хуулиар нээнэ.

2-т бол мэдээлэл технологийн виртуал бүсийг байгуулах буюу ИМонгол дээр шууд IT-ийн компаниудыг бүртгэлжүүлэх юм. Тэгээд бүртгэлжүүлээд л орж ирсэн компаниудыг татварын болон татварын бус дэмжлэгүүдийг шууд үзүүлээд явдаг ийм хуультай болбол болж байгаа гэсэн үг. Тэгээд мэдээж ЗГ-аас өргөн мэдүүлсэн учраас ААНОАТ, НДШ, бусад төрлийн татваруудаас хөнгөлөх, дээрээс нь grant-уудыг олгох асуудлууд. Хиймэл оюун ухаан дээр жишээ нь үйл ажиллагаа явуулсан болбол төсөл, арга хэмжээнийх нь өртгийн 60

хувийг нь буцаан олгох, патентын зардлыг буцаад олгох, дээрээс нь яг нөгөө бодитой хөрөнгийн үнэлгээ буюу оюуны өмчийн үнэлгээг нь үнэлээд, компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх бололцоог энэ хуулиар нээж байна.

Тэр төр, хувийн хэвшлийн түншил дээр болбол энэ хуулиар нэг том дэвшил гарч байгаа нь бол төр өөрөө систем хөгжүүлэхгүй гэдэг зохицуулалтыг энэ хуульд тусгаж өгч байгаа. Төр систем хөгжүүлэхгүй буюу одоо болбол төр тендер зарлаад жишээ нь худалдан авалт хийлээ гэхэд систем хөгжүүлээд өглөө гэхээр их кодыг нь төр авах хуультай байсан. Энэ хуулиар их кодыг нь харилцан тохиролцоод хувийн хэвшилдээ үлдээж болох зохицуулалтыг болбол бас хийж өгч байгаа юм. Тэгэхгүй болохоор одоо төр систем хөгжүүлэхгүй гэж хэлчээд, тендер зарлаад байхаар хувийн хэвшил хэрэгжүүлсэн их кодыг нь төр буцааж хүлээж авахаараа түүнийхээ ашиглалт, тэр үйл ажиллагааг нь авч явж чаддаггүй. Тийм учраас их кодыг нь хэрвээ хувийн хэвшил аваад явах нь бололцоотой болно.

Дээрээс нь нөгөө үйл ажиллагааны явцад тухайн байгууллага сар болгон гүйцэтгэх гэрээ хийгээд ч юм уу, тэр системийнх нь нөгөө бүрэн бүтэн, тогтвортой үйл ажиллагааг нь хувийн хэвшил хийх бололцоог хуулиар нээж байгаа. Одоо болбол төр их кодоо авчхаад, хувийнхнаар тэр үйл ажиллагаагаа хариуцуулъя гэхээр хууль, эрх зүйн боломжгүй учраас төр дэргэдээ нөгөө IT-ийн мэргэжилтнүүд ажилд аваад байдаг. Ингээд хувьтайгаа өрсөлдөх нөхцөл бол хуулиар үүсчээд байгаа юм. Тэгэхээр энэ түгжээнүүдийг болбол гаргаж байгаа гэсэн үг.

Боловсролын яамтай болбол манай яам бол энэ цахим ур чадвар дээр хамрах хүрээгээ хамтатгаж тогтоогоод тэгээд ажиллаад явж байгаа.

Г.Занданшатар: Түрүүн Ганхуяг гишүүн байгаа үед тэр нөгөө технологийн дэвшилд лессис файр гээд тэр Францын аж үйлдвэрийн I дүгээр хувьсгалын нөгөө дулааны хөдөлгүүрээс авхуулаад технологийн дэвшилд бол төрөөс үл оролцох зарчимтай л явж байж дэмжигддэг юм байна лээ. Тэгэхгүй бол энэ хувийн хэвшлийн зүгээс төр бүх юмыг урдуур нь орж хийх гээд байна гэсэн л, бүтээл санаачилга хувийн хэвшлийн санаачилгыг л энэ нэн ялангуяа технологийн хувьсгал, технологийн өөрчлөлтүүд дээр чөлөөтэй тавьж өгч тэгж байж л энэ дэвшилүүд гаргадаг юм байна лээ л дээ. Түүн дээр л сайн анхаармаар юм байна гэсэн. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Бид нар бас дэлхийтэй хөл нийлүүлж, улс орныхоо хөгжлийг ингэж авч явах нь зүйтэй. Мэдээлэл технологийн Байнгын хороо, яам энэ тэр бол бас боломжийн ажиллаж байна гэж үзэж байна. Гэхдээ Силиконы, силикон хөндий гээд л иймэрхүү парк энэ тэр гээд л хийдэг тийм ээ, бусад улс орнуудад. Ийм төрлийн юм хийж барьж байгаа ийм зүйл байгаа юу? Энэ хуулиудыг баталж барьснаараа энд нөлөөлөх ийм зүйл байна уу, байхгүй юу? Нөгөө талаар бол маш богинохон хугацаанд хүлээгдэж байгаагаар бол хиймэл оюун ухаан орж ирснээр бол маш олон ажлын байрууд гарч ирнэ, маш олон ажлын байрууд байхгүй болгоно. Эдийн засаг бол 2, 3 дахин өснө гэсэн ийм хүлээлт байгаа. Тэгээд энэ тал дээр судалгаа, бэлтгэл, юм хум ямаршуухан явж байна вэ?

Ер нь манайд MIT гээд Массачусетсийн технологийн сургууль төгссөн хэр олон хүн байдаг юм бэ? Ирээд ажиллаж барьж байгаа ийм улсууд байна уу? Боловсон хүчний нөөцөө ингээд судлаад гаргаад ингэчихсэн юм байна уу? Нэг худал, үнэн нь мэдэгдэхгүй дандаа л нэг улс төрийн сургууль төгссөн Харвардын юу ч гэнэ нэг тиймэрхүү л хүмүүс л илүү, дутуу олон юм ярьсан ийм л юм харагдах юм. Тэрнээс биш тэр

Microsoft-ийг бол Gates бол залуудаа байгуулж байсан. Zuckerberg бол бас facebook-ийг маш залуудаа байгуулж, технологийн компанийг байгуулж саятан тэрбумтан болж байдаг. Энэ сонгуулийн дуулианаар харж байхад бас нэг би тэр ХЗДХ-ийн сайдын хийж байгаа, хэлж байгаа юмыг бол маш зөв гэж бодож байна. Энэ намууд анхаарах ёстой. Нөгөө талаараа бол гэмт хэргээс ч гэсэн урьдчилан сэргийлж байна.

Нөгөө талаараа бол бас Пол Потын дэглэм гэж байсан. Маогийн улаан хамгаалагчид гэж байсан. Манай Бошгыг халах залуучуудын эвлэл гэж байсан. Тэр нударгыг нь тастаад л, халимаг үсийг нь аваад л тийм ээ ингээж нугалаа гаргадаг ийм залуучуудыг сонгуульд олноор нь оруулж ирж энэ улс орныг нэг тал руу нь бас нөгөө хуучны депутат маягтай, олон газрын төлөөлөл нэрээр хэдэн хүүхэлдэйнүүд, кнопчид ийм зүйл байлгаж болохгүй нөхдүүд ээ бас туйлиирч. Би бас нам, эвслүүд сонгуульд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа явж байна. Энийг би бас зориуд анхааруулж хэлье ингээж бас туйлиирдаг.

Одоо бол ер нь дундаж нас 80 болчихсон шүү дээ. Тийм ер нь 40-өөс 70 насны хооронд бол ямар ч ялгаагүй болчихсон ийм байгаа шүү. Эхлээд цэргийн албаа хаа, хал үз, халуун чулуу долоо, амьдрал мэд, бас ардын зүйр цэцэн үг ч байна шүү дээ эхлээд өөрийгөө зас, дараа нь гэрээ зас, дараа нь төрөө зас гэж байгаа. Энэ улсууд хэдэн залуучууд дандаа Монголд л хамаг юм толгой нуруу явчих юм. Төрөө засаж, төрөөс төрсөн тэрбумтан болох гээд байхаас биш технологиос тэрбумтан саятан ингээж төрдөг ийм юм алга байна шүү манай Монгол улсад. Энийг манай Цахим хөгжлийн яам наад талаас нь ажиллах ёстой.

Тухайлбал тэр бусад улс оронд хэрэглэж амжаагүй байгаа Starlink-ийг бол манайд их түрүүнд оруулж ирлээ. Энэ мэтчилний сайн туршиллагууд байна.

Дараа ямар ээлжийн юу хүлээж байна, юу оруулж ирэх гэж байна гэдгийг нь бас асууя бодитой технологийн салбаруудаас.

Г.Занданшатар: Учрал сайд Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Ганбат гишүүнд баярлалаа. Манай мэдээлэл технологийн салбарын өрсөлдөх чадвар болбол нэг үеэ бодвол маш их дээшилж байгаа. Тэгээд манай залуучууд бол олон улсын түвшинд дэлхийн нэр хүндтэй компаниуд тэр Google, Meta бусад компаниудад болбол инженерээр ажиллаж байгаа залуучууд олон байна. Дээрээс нь Монголдоо ч гэсэн бас ажиллахаар ирсэн олон залуучуудыг болбол бид энэ цаашидаа бол энэ төрд заавал ажиллуулах гэхээсээ илүүтэйгээр энэ мэргэжлийн холбоогоороо дамжуулаад бас ажиллуулъя гэдэг ийм л бодолтойгоор бол урагшилж байгаа. Тэрнээс биш төр, хувийн хэвшилтэй өрсөлдөөд, цалин цавууг нь тавиад энэ технологийн залуучуудыг бүх асуудлыг нь шийднэ гэж бол байхгүй. Тэгэхээр мэргэжлийн холбоогоороо дамжуулаад ажиллах бололцоо бол бүрэн дүүрэн байгаа.

Жишээ нь мэдээлэл технологийн салбараас манай хэд хэдэн компани олон улсын листэд компани болоод, бүртгүүлээд Сингапурт бол сайн мэдээнүүд дуулдаж байгаа. Жишээ нь сая Казахстаны тэргүүн дэд сайд ирэх үеэр ч гэсэн манай системүүдийг сонирхож байна. Манай компаниудад бас хөрөнгө оруулах сонирхол байгаа гэдгээ ч илэрхийлсэн. Эхнээсээ дэлхийн олон орнуудад шилдэг start-up-ууд тодорсон. Жишээ нь Казахстанд гэхэд л Монголын нэг компани бол шилдэг start-up болоод л data төвийг нь cloud болгож л байна. Ер нь start-up-ууд бол олон улсаас санхүүжилтүүдийг их татдаг болсон.

Тэгэхээр энэ хуулиар Ганбат гишүүний яг асууж байгаагийн дагуу олон улсад байдаг нөгөө Цахиурын

хөндий гэдэг шиг чөлөөт бүсүүдийг байршил заахгүйгээр бий болгож байгаа гэсэн үг. Нэг ёсондоо онлайн орчин дахь буюу виртуал орчин дахь ийм чөлөөт бүстэй Монгол болж байгаа. Яг ИМонголиа гэдэг платформ дээрээ бид нар виртуал бүсийг бий болгоод, мэдээллийн технологийн компаниудаа бүртгэлжүүлээд, шаардлага тавиад, орж ирсэн компани болгонд нь татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх гэж байгаа. Жишээ нь тэр мэдээлэл технологийн салбарт нь ноогдох орлогын албан татвар дээр нь дэмжлэг үзүүлнэ. Дээрээс нь түрүүн хэлсэн энэ мэдээлэл технологийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын холбогдох байгууллагууд патентлуулах зардлыг нь санхүүжүүлэхэд тодорхой grant-уудыг бүсэд бүхлээр нь болон хэсэгчлэн тавина.

Виртуал бүсэд бүртгэгдсэн тэр IT компаниудын төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговрыг олгоно. Хиймэл оюун ухаан дээр хэрвээ суурилах юм болбол сэндбоксын орчинд үйл ажиллагаа явуулаад, тэр патент эзэмшигч нарт нь бас тэр grant-уудыг нь олгоно. Экспортод гаргасан болон оюуны өмчид бүртгүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ бүрд судалгаа, хөгжүүлэлтийн зардлын 70 хүртэлх хувьд тэнцэх нэг удаагийн дэмжлэгийг мэдээлэл технологийн гарааны бизнест олгоно гээд маш олон ийм дэмжлэгүүдийг тусгаж өгсөн. Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа Монгол Улс онлайн орчин дахь, виртуал орчин дахь цахиурын хөндийтэй болж байна гэж ер нь бол ойлгох бүрэн боломжтой ийм хууль юм.

Г.Занданишатар: Дашидондогийн Ганбат гишүүн тодруулж асууна.

Д.Ганбат: Тэр МИТ төгссөн ийм хүмүүс хэр байна, хэр ярьж ирж ажиллаж байна гэсэн асуулт асуусан байгаа. Энийг бас нэг та тодорхой тайлбарлачхаарай. Тэгж байж

мэргэжилтнүүд байж л энэ ажлууд явна л даа.

Нөгөө талаар бол бас би сонгуультай холбогдуулаад тэр яагаа ч үгүй байгаа хэдэн залуучууд янз бүр болоод л ингээд орж ирэх гэж байгааг би хэллээ. Тэрэн дээр намууд анхаарахаас гадна, энэ мэдээлэл технологийг ашиглаад ер нь улс орныг хооронд нь талцуулдаг, ард түмнийг талцуулдаг, тэгээд шантааж хийдэг, нийгмийн сэтгэл зүйг яг тийм байгаа юм шиг тийм сэтгэгдэл төрүүлж чаддаг ийм мэдээлэл технологиуд байна л даа. Энэ бас буруу талаар ашиглаж байгаа. Энийг Улсын Их Хурал дотор оруулж ирэх, хууль тогтоох байгууллагад ийм аюул байна. Та бүхэн энэ дээр хэр зэрэг анхаарч байна вэ? Манай Байнгын хороо, яам.

Г.Занданишатар: Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Энэ Ганбат гишүүн их чухал асуудал хөндөөд байгаа юм. Мэдээллийн технологийн салбарынхан бол Төрийн албаны хуулийн босгыг бол давах бололцоо байхгүй. Төрийн албаны шинэчлэлийг хийхгүйгээр бид мянга МИТ төгссөн хүнийг ажилд авах гэхээр бололцоо байхгүй. Жишээ нь ингээд яаман дээр болбол бид нар чинь яаманд мэргэжилтэн авъя гэхээр МИТ төгссөн байна уу, технологийн том сургууль төгссөн байна уу авъя гэхээр төрийн албаны шаардлага нийцэхгүй гээд буцаачхаж байгаа. Тэгэхээр энэ хуулийг болбол нэг шинэчилж салхи оруулах бололцоог хангахгүй болбол үнэхээр төвөгтэй болсон.

Жишээ нь энэ Тэнгис гээд энэ залуу гэхэд л миний зөвлөх л гээд байгаа болохоос энэ чинь уг нь яамны газрын дарга, хэлтсийн дарга хийж болох л хүн шүү дээ. Гэтэл ингээд олон жил инженер хийчихсэн, олон компанид ажиллачихсан, гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлчихсэн залуу ажилд авъя гэхээр төрийн албаны шаардлагад нийцдэггүй,

нөгөө төрд ажилласан жилээ хангадаггүй. Тэгэхээр бид нар болбол цаашидаа ер нь Төрийн албаныхаа хуулийг шинэчлээд, мэдээлэл технологийн салбарынхныг төрд оруулж ирэх бололцоогоор хангах, дээрээс нь нөгөө мэргэжлийн холбоогоороо дамжуулж ажиллуулах бололцоогоо их тодорхойлж өгөх ёстой.

Ер нь бол цаашидаа төр систем хөгжүүлэхгүй зүгээр бодлого боловсруулдаг л ийм л болох зарчмаар л бид ажилласан. Тийм учраас энэ хууль гарснаараа систем хөгжүүлэхээс татгалзаад, яам бол зөвхөн бодлогоор дэмжлэг үзүүлдэг л ийм хэлбэр лүү шилжиж байгаа. Дээрээс нь болбол Google-тэй хамтын ажиллагаа их сайн явж байна. Тэгээд Google-тэй хамтын ажиллагаа их сайн явж байгаагаар мянган мэргэжилтний бэлтгэх ажлын хүрээнд эхний 350 мэргэжилтэн болбол бэлтгэгдээд, энэ 6 дугаар сард сертификатаа авах гэж байна. Ингээд дэлхийн нэр хүндтэй олон компаниудтай мэргэжилтэн бэлтгэж байгаа. Японтой болбол кибер аюулгүй байдлын чиглэлээр хамтарч ажиллаж байна. Мөн бусад орнуудтай болбол олон ажлаар болбол нээлттэй ажиллаж байгаа. Дэлхийн бүх л технологийн компаниудтай. Сая Арабд Хиймэл оюун ухааны сайдтай гэрээ зурсны дагуу бас мэргэжилтэн бэлтгэх ажлууд өрнөж байна гээд манай салбарт бол сайн мэдээ их байгаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Манай улсын хувьд яг өнөөдөр бодит байдлыг харахад энэ мэдээллийн технологийг хөгжүүлэх, бүх салбарт нэвтрүүлэх асуудал бол ус, агаар шиг хэрэгтэй байна, бүх салбарыг харахад. Сая бид нар эрүүл мэндийн сонсголыг хар. Бүх юм нь хаалттай, цахимжих гэхээр зогсоочихдог. Хил гааль бас тийм, банк санхүү бас тийм, мэдээллийн нэгдсэн платформ ч байхгүй байна л даа. Тэгэхээр энэ асуудлыг

хөгжүүлэх асуудал бол үнэхээр чухал байгаа.

Харин ямар ч байсан сүүлийн 4 жилд энэ Инновац, цахим бодлогын байнгын хороо гэж Улсын Их Хурлын дэргэд Байнгын хороотой болсон. Тэгээд Цахим хөгжлийн яам бий болсон нь бол маш чухал алхам боллоо гэж би үзэж байгаа. Би бас Учрал сайдыг сайн ажиллаж байна гэж бодож байгаа. Бид нар сая Америк руу тэр айлчлалынх нь бүрэлдэхүүнд орж явж байхад тэр Америк болон тэр өндөр хөгжилтэй орны байж болох бүх томчуудтай нь уулзалтууд зохион байгуулж, Монголд хөрөнгө оруулалт хийх энэ чиглэлээр яаж ажиллах вэ гээд л үнэхээр цаг наргүй л уулзалтууд хийгээд яваад байсан. Ийм жишжиг Монгол Улсын хувьд энэ тэдэнд мэдээж тоогдож эхлээд өөрсдийгөө таниулах гэдэг бол том алхам. Дараа нь энэ хөрөнгө оруулалтыг нааш нь татах гэдэг бол хамгийн чухал үр дүн гэж бол харж байгаа.

Тэгээд Америкт ажиллаж байгаа яг энэ нөгөө Цахиурын хөндийд болон Америкийн том компаниуд бүр SpaceX нөгөө Elon Musk-с өгсүүлээд л том компаниуд Meta энэ тэрт мундаг Монгол залуучууд ажиллаж байна. Тэд Монголыг ярьж байгаа байхгүй юу. Монголд очихоор ямар ч ажиллах бололцоо байхгүй шүү дээ, дэмжихгүй. Тэгээд том компаниудаас жишжиг ийм мэдээллийн технологийн компаниуд бойжоод гараад ирэнгүүт нөгөө барын зулзагыг бага дээр нь гэдэг шиг бас ингээд дарчхаад хөгжүүлэхгүй байгаад байх тэр сонирхол хүртэл монопол компаниуд нь байгаад байдаг нь өөрөө аягүй хэцүү гээд ярьж байсан л даа.

Тэгэхээр би Учрал сайдыг энэ салбарыг бас шинээр нь авч яваад энэ зах зээл рүү орж байна. Яг энэ саяын, аливаа юм чинь ингээд тэр silicon valley-с бойжиж гараад, тэр нь том болоод, тэгээд тэр нь улс орныхоо мэдээллийн технологийн салбарыг бүүр Сансар

судлал руу хүртэл хөгжүүлээд явж байна лээ. Бидэнд энэ хүртэл сая хэлээд байх юм, орон зай нэлээд хэцүү зүйлүүд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр таны энэ хууль батлагдан гарснаар яг саяын хэлээд байгаа тэр бойжиж гараад, Монголын мэдээллийн технологийн салбарыг бүх салбарт хөгжүүлээд бид технологи дээр суурилсан энэ салбаруудаа хөгжүүлмээр байна шүү дээ. Тэгэхгүй бол авлигын индексээр өндөр л байгаад байдаг, салбар болгон нь мэдээлэл нь хаалттай, архив нь зарим нь олдохоо байчихсан гээд. Үнэнийг хэлэхэд яг энэ чиглэл дээр манай улс бол ёстой нээрээ үнэхээр хэцүү байгаа. Хамгийн хоцрогдож магадгүй л байгаад байна шүү дээ.

Тэгсэн хэр нь гар утасны хэрэглээ, facebook-ийн хэрэглээгээр дэлхийдээ бас дээгүүр толгой цохичих гээд л байгаад байгаа юм. Тэгээд яаж энийг харин энэ технологийг хүний амьдралд ойртуулах вэ, яаж энийг Монгол Улсын хөгжилд ойртуулах вэ энэ асуудал өөрөө туйлын чухал байгаа. Тэгээд та энэ дээр 2 дахь зүйл дээр нь энэтэй холбоотой татвар санхүүгийн дэмжлэгийн тухай заалтууд нэлээд оруулж ирсэн байна. Энэ бол зөв байх. Тэгээд энэтэй холбоод одоо энэ өчигдөр, өнөөдрөөс бид нар хэлэлцээд байна л даа. Нэгдсэн төсвийн 25, Төсвийн хүрээний мэдэгдэл 26, 27 оны төсвийн төсөөлөл болоод Монгол Улсыг 25-аас 27 онд хөгжүүлэх төлөвлөгөөний тухай өчигдөр бид нар бас ярьсан. Яг энэтэй хэр уягдсан бэ? Энэтэй.../минут дуусав/

Г.Занданишатар: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ одоо ер нь бол дэлхийн топ 10 борлуулалттай компанийн бараг 8, 9 л технологийн компаниуд бол болсон. Тэгэхээр манай улсын эдийн засгийг төрөлжүүлэх бас гол салбар болбол ер нь технологийн салбар бол болох нь бол дамжиггүй. Тэгэхээр бид яг ийм олон улсын зах зээл дээр өрсөлдөөд байгаа энэ технологийн

компаниудыгаа өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэхийн тулд хөрөнгийнх нь үнэлгээг бодитой болгох ёстой юм байна лээ. Жишээ нь материаллаг бус баялгийг үнэлэхгүй байна гэдэг болбол тэр технологийн компанийн 5 компьютер, 5 ширээ, сандлыг үнэлчхээд, энэ компани тэдэн төгрөгийн үнэлгээтэй компани гээд зохиогчийн эрхийн гэрчилгээгээр баталгаажуулсан программ хангамжийг нь үнэлэхгүйгээр тэд олон улсад өрсөлдөх бололцоо байхгүй.

Тийм учраас тухайн компанийн бүтээсэн бүтээгдэхүүнүүд буюу оюуны өмчийг нь буюу материаллаг бус үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний хуулийг дагалдуулаад энэ хуулиар тодотгож өгч байгаа. Тэгээд компаниуд өөрөө үнэлэгдсэнээрээ оюуны өмчийн болон материаллаг үнэлгээгээ нэгтгээд компани өөрөө дүрмийн сангаа нэмэгдүүлж өрсөлдөх бололцоо нэмэгдэнэ.

2-т болбол бид төр өөрөө нэгэнт худалдан авагч байгаа тохиолдолд систем хөгжүүлэхээс татгалзаад, хувийн хэвшилээрээ хийлгэнэ гэдэг бол тухайн компанид нь маш том туршлага түүхийг нь бүтээж өгнө. Дээрээс нь бид нэг тийм тодорхой байриил заагаад чөлөөт бүстэй болъё, Монгол нэг ийм Цахиурын хөндийтэй болъё гээд бас олон жил ярьсан л даа. Гэхдээ нэг тийм тодорхой байриил заах нь одоо зохимжгүй болчихлоо. Ер нь болбол онлайн орчинд, виртуал орчинд л энэ компаниуд чинь үйл ажиллагаа явуулаад л оюутны ширээ, сандлаас өнөөдөр дэлхийн том компанид өндөр цалин аваад сайн программ бүтээж байгаа зөндөө залуучууд байна. Тэгэхээр тэр хүмүүсийг дэмжихийн тулд бид нар зүгээр л нэгэнт хөгжүүлсэн 1,8 сая хүнтэй ИМонгол платформ дээрээ технологийн компаниудыгаа бүртгэж аваад, одоо үйл ажиллагаа явуулж байгаа IT park дээр инкубац хийж байгаа тодорхой компаниудыгаа бүртгэж аваад л, хаанаас ч орон зай үл хамаараад энэ

татварын болон татварын бус дэмжлэгүүдийг олгодог ийм л хуультай болж байна.

Тэгээд ер нь бол цаашидаа олон улсад ч гэсэн хаанаас ч үл хамаараад технологийн компаниуд Монголд ир, та нарт чөлөөт ийм бүсийг виртуал орчинд байгуулсан. Заавал байр сав хаана байрлаж байгаагаас үл хамаараад та нар энэ үйл ажиллагаанд оролцоо гэж байгаа. Сая өнөө хөгжлийн бодлого төлөвлөлт, ирэх оны төлөвлөгөөтэй холбогдуулаад бас ярилцаж байх үед ч гэсэн мэдээлэл технологийн салбарыг дэмжих асуудлууд болбол ордог. Тэгээд энэ хүрээнд болбол бидний зорьж байгаа зорилт бол энэ Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжих гэж байгаа энэ сансрын үндэсний хиймэл дагуулыг хөөргөх ажил болбол яг нөгөө ТЭЗҮ-ээ боловсруулаад, Их Хуралд өргөн мэдүүлэх гээд ажиллаж байгаа. Тэгээд Монгол Улс үндэсний хиймэл дагуултай болсноороо сансрын уудам орон зайг эдийн засгийн эргэлтэд оруулах, шинэ эдийн засгийг бүтээх ийм бололцоо болбол бас үүнээс бол бүрдэнэ. Тийм ч учраас сансрын бүх төрлийн технологи, хиймэл оюун ухаан, их өгөгдөл дээр үйл ажиллагаа явуулж байвал технологи нэвтрүүлж байвал сэндбоксын орчинд үйл ажиллагаа явуулахыг энэ хууль нээж байна.

Г.Занданшатар: Батсүхийн Саранчимэг гишүүн. Дараа нь санал хураалт.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр цахим шилжилт бол дэлхий төдийгүй Монгол Улсад маш хурдтай хөгжиж байна. Ялангуяа бас энэ Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдаж, Учрал сайд бол маш олон ажлуудыг хийж чадаж байна. Улсын Их Хуралд Инновац, цахим бодлогын байнгын хороо байгуулагдаж маш олон энэ цахим шилжилтийн хууль, эрх зүйн орчныг бас бүрдүүлж баталж өгсөн. Өнөөдрийн энэ орж ирж байгаа хуулийн төсөл бол мэдээлэл технологийн

салбарыг дэмжье гэсэн ийм зорилготой гэж байна. Тэгэхээр энэ мэдээлэл технологийн салбарыг дэмжсэнээр эргээд ямар үр өгөөжтэй гэж харж байна вэ?

Нөгөө талаар бол энэ мэдээлэл технологийн компаниудад олон асуудлууд тулгарч байгаа гэж байна. Тэгэхээр энэ дээр энэ хуулийн орчныг дэмжиж ямар заалтуудыг оруулж өгсөн бэ гэсэн нэг ийм асуулт байна.

Нөгөө талаар бол ажиллах хүчний асуудал бол үнэхээр ганц ИТ гэлтгүй Монгол Улсад бас хүндрэлтэй байгаа. Тэр дундаа энэ ИТ салбарын боловсон хүчнийг сайжруулах тал дээр ямар бодлого, ямар шийдэл харж байгаа вэ? Энэ дээр нэг тайлбар авъя. Цаашидаа бол төр энэ программ хангамжийг хөгжүүлэх үү, хөгжүүлэхгүй юу, ямар бодлого баримталж байгаа вэ?

Мэдээлэл технологийн салбарыг бол дэмжиж өгснөөрөө бол үр дүнд хүрнэ гэж харж байгаа учраас та бүхэн яг энэ үр өгөөжийг нь тодорхой гаргаж ирсэн гэж харж байна. Энэ дээр илүү их тайлбарлаж өгөөч. Энэ дээр бас нэлээн олон бас шинэ томъёоллууд орж иржээ Сэндбокс, бүүр цаашилбал энэ их код гэж энэ хуульд тусгайлан заасан байна. Энэ ямар учиртай вэ? Энэ дээр нэг тайлбар авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд хариулна.

Н.Учрал: Бид өнгөрсөн хугацаанд mindgolia гээд mining-гаас mind руу буюу уул уурхайгаас оюун санаа, мэдлэг рүү шингэсэн эдийн засагтай болох зорилтын хүрээнд mindgolia.mn гээд платформ хөгжүүлсэн. Энэ дээр 360 гаруй бүтээгдэхүүн байриччихсан байна. Нэг ёсондоо хэрвээ төрийн нэг байгууллага шинэ систем хөгжүүлэх гэж байгаа бол заавал тендер зарлахгүйгээр бэлэн программ хангамжийн их дэлгүүр лүү ороод шууд худалдан авах нөхцөлийг

бүрдүүлсэн. Энэ хуулиар программ хангамжтай худалдан авалт бол нэг цонхны бүртгэлд шилжиж байгаа. Нэг ёсондоо аймаг, орон нутагт ч гэсэн заавал цагийн бүртгэлийн системийг гэхэд шинэ тендер зарлаад л туршилагагүй хүмүүсээр хийлгэх биш, шууд сонгож байгаад программ хангамжийн их дэлгүүрээсээ худалдан авах ийм нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Дээрээс нь нөгөө тендер худалдан авалтыг төр зарлаад, ийм систем хөгжүүлүүлмээр байна гээд зарладаг, тэгээд түүнийг нь буцаагаад нөгөө компани нь хийж өгөхөөрөө их код буюу тэр тухайн программ хангамжийнх нь үндсэн кодыг нь төр өөрөө эзэмших ийм хуультай одоо. Энэ хууль гарснаараа тухайн хувийн хэвшил өөрөө эзэмших бололцоог нь нээгээд өгөх юм бол зардал үнийн дүнгийн хувьд ч бага байх юм байна лээ. 2-т тэр компани төрд заавал өгчихсөн тэр их кодоо бусдад ашиглуулах, дахиад орлого олох бололцоог нь нээж байгаа. Бид төр өөрөө тэр тендер зарлаж чааад, тэр их кодыг нь аваад угаасаа өөрсдөө хэрэглэж чадахгүй. Тэгээд сар болгон түүнийгээ хөгжүүлж чадахгүй байж энийг авах нь өөрөө зохимжгүй учраас энэ хуулийг ингэж их кодыг ингэж хийж өгснөөрөө хувийн хэвшилээ өрсөлдөх чадварыг нь энэ хуулиар нэмэгдүүлэх гээд байгаа.

Дээрээс нь энэ төсвийн мөнгийг үрэлгэн зардаг байдлыг нь зогсоохгүй бол салбар болгон цахимжилт хийх нэрийдлээр нөгөө нэг олон янзын систем хөгжүүлдэг. Тэгээд юу хүссэнээ зарлаж чадахгүй учраас нөгөө компаниуд нь яг ямар шаардлагад нийцсэн программ бүтээхээ эргээд хэлж чаддаггүй. Үүнээсээ болоод болбол ингээд зөрчил үүссээр байсан. Үүнийг нь шийдвэрлэж байна.

Тэгээд сэндбокс гэдэг болбол ийм туршилтын орчныг хэлж байгаа юм. Жишээ нь, шинэ технологи нэвтрүүлэх, шинэ үйл ажиллагаа явуулах болбол

нөгөө дүрэм журам, хууль, эрх зүйн түгжээнд орохгүйгээр тэр туршилтын хугацаанд үйл ажиллагаа явуулж болохыг нээж байгаа юм. Тэгэхээр сансар ч бай, хиймэл оюун ухаан ч бай, их өгөгдөл ч бай шинэ тутам технологи ойлголтууд. Тэр дэвшилтэт технологийн салбарын хөрөнгө оруулагч нар, инженерүүд шинэ зүйлийг турших гэж байвал сэндбоксын орчинд дүрэм журам, хууль, эрх зүйгээр үйл ажиллагаа явуулчихаад, тэр нь хэрвээ амьдрал дээр нийцэж байвал түүнийг нь нэвтрүүлэх бололцоог нь бий болгож байгаа гэсэн үг.

Тэгээд өнгөрсөн хугацааны энэ банк санхүүгийн салбарын цахимжилт эрчимтэй явсны бас маш том хөшүүрэг бол сэндбокс байсан юм байна. Энэ финтекүүд маш их хөгжсчихлөө. Банк бус санхүүгийн байгууллагуудын маш олон аппликэйшн, зээл тусламж ингээд өгдөг юм шүү дээ. Энэ болбол дандаа финтекүүдийн хөгжил бол дандаа сэндбоксын орчин дээр байсан. Тийм учраас ер нь бол бид нар энэ сэндбоксын орчныг хуульчилснаараа цаашидаа хиймэл оюун ухааны технологийг олон салбарт нэвтрүүлэхэд их дэм өгнө л гэж ингэж ойлгож байгаа.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, Батсүхийн Саранчимэг гишүүн 1 минут.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр ажиллах хүчний хомсдол тэр дундаа энэ ИТ салбарын хүний нөөцийн бас хэрэгцээ хомсдол бас нэлээн байгаа. Тэгэхээр энэ салбарын хүний нөөцийн асуудлыг хэрхэн шийдэх, ямар яаж харж байна вэ? Энэ дээр жишээ нь гадаадаас хүмүүс яг энэ өндөр мэргэжлийн ИТ мэргэжлийн хүмүүсийг авчрахад ч гэсэн хүндрэлтэй гэсэн. Тэгэхээр та бүгд бас энэ дээр нэг шийдэл харж байгаа байх. Энд тал дээр ямар бодлого барьж байна вэ? Тэрэн дээр нэг тодруулаад дахиад хэлээдэх.

3. **Г.Занданшатар:** Ажлын хэсгийн

С.Тэнгис: Ажлын хэсгийн гишүүн, сайдын зөвлөх Тэнгис байна. Яах вэ мэдээлэл технологийн салбарт яг хүний нөөц дутагдалтай байгаа нь бол үнэн. Ялангуяа жирийн кодероос авхуулаад, сайн системийн инженер, хөгжүүлэгч, devoffice, siterelabritы инженер гээд ер нь бүх ажлын байр бол дутмаг байгаа. Тэр бүүр хиймэл оюун ухааны мэргэжилтэн бас дутмаг. Монголд дөнгөж анх удаа энэ жил Холбоо, мэдээлэл технологийн сургуулиас 7 оюутан л анх удаа хиймэл оюун ухааны инженер гэж төгсөж байгаа энэ жил. Яах вэ энэ чамлалттай ч гэсэн бас тодорхой хэмжээгээр явц явж байгаа.

Бусад өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд болбол ажиллах хүчнийхээ энэ асуудлуудыг болбол нөгөө гаднаас нөгөө ажиллах хүч татаж, Америк болбол жишээ нь H-1B визээр ч юм уу ингэж авдаг. Монгол Улс бид нарын хувьд болбол яах вэ ЗГ дээр хуулийн төсөл боловсруулж байхад нөгөө Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хуульд бас заасан шаардлагуудыг бас энэ салбарт тодорхой хэмжээгээр хөндөж болох юм гэж үзсэн боловч яах вэ ЗГ-аас өргөн барихдаа бол бас бид нар оруулж ирээгүй. Яах вэ цаашидаа нөгөө Их Хурал дээр ажлын хэсгийн түвшинд бас ярилцаад, тодорхой хэмжээгээр нөгөө квот, нэмэлт татварын асуудлуудыг бас ярих нь зөв байх гэж манай салбарынхан бас хамгийн сүүлд болсон хэлэлцүүлэг дээр бас саналаа илэрхийлж байсан.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны саналаар Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа

холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Тогтохсүрэн даргаа суучих, суучих зүгээр. Санал хураалт. Шинэ дэгийн хууль 7 сарын 1-нээс хэрэгжинэ. 57,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Байнгын хорооны дарга сууж байгаа, сайн сууж байгаа манай хүн.

16.14 цаг

Найм.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Одоо Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэнэ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Ч.Хүрэлбаатар: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн

тухай хуулийн төслийг та бүхэнд танилцуулж байна. Манай улсын эдийн засаг ковид 19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд 4,6 хувь агишиж байсан бол сүүлийн 2 жилийн хугацаанд 5 хувь болон 7 хувиар тус тус өсөөд байна.

Цаашид Оюу толгойн уурхайн олборлолтын хэсэгт зэс, алтны агууламж нэмэгдэж байгаа экспортын үйл ажиллагаа сэргээж жигдэрсэн, аялал жуулчлал, үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа идэвхжиж байгаа зэргийн нөлөөгөөр эдийн засгийн өсөлт эрчимжиж, 2025 онд 8 хувь, 2026, 2027 онд тус тус 6,5 хувь орчимд тогтвортой хадгалагдахаар байна.

Мөн цар тахал болон Украйнд болж буй геополитикийн зөрчилдөөнт нөхцөл байдлын нөлөөгөөр 2022 онд 16,9 хувь болж өсөөд байсан инфляц 2024 оны 4 дүгээр сард 6,4 хувь болж буураад байна. Цаашид валютын нөөцийг 10 тэрбум ам.долларт хүргэж бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой нэмэгдүүлэн төсөв мөнгөний оновчтой бодлогыг хэрэгжүүлснээр инфляцыг 2025 онд 6 хувь, 2026 онд 4 хувь, 2027 онд 3 хувь хүргэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2025 онд ДНБ-ий 2 хувь, 2026 онд 1,5 хувь, 2027 онд 1 хувьд хүргэж, үе шаттай бууруулах, ЗГ-ын өрийг 2027 онд одоо байгаа 39 хувь, 2027 он гэхэд 40 хувьтай хэмжээнд нь барихаар хуулийн төсөлд мөн тусгалаа. Энэ тус хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан нэгдсэн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл болон ЗГ-ын өртэй холбоотой төсвийн тусгай шаардлагуудыг нэгэн зэрэг хангасан болно. Уг хуулийн төсөлд Төсвийн тухай хуульд заасны дагуу 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, ОУБ, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог ханган

хэлэлцүүлж холбогдох саналыг тусгасан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын ЗГ-аас макро эдийн засгийн нөхцөл байдлын төсөөлөлд суурилан дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын зорилтуудыг тодорхойлох, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлт, төсвийн орлого, зарлагад баримтлах чиглэлүүдтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгжээс хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.1-ээс 6-аас 1.4-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх

танилцуулга, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Улсын Их Хурлын 2024 оны 3 дугаар тогтоолоор баталсан зөвлөлийн дүрмийн 3.1.1 дэх заалтад тусгагдсан бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж гаргасан дүгнэлт, зөвлөмжөө Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт, санал гараагүй болно. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Тэмүүлэн гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Чимэдийн Хүрэлбаатар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Рэнцэнбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн,

Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж алга байна. Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Лувсандоржийн Сонор, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Жамъяншаравын Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Бодлого төсөөллийн хэлтсийн дарга Батхишигийн Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга Тэгшжаргалын Мөнхцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Батчулууны Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Үйлдвэржилт, дэд бүтцийн хэлтсийн дарга Шийрэвдамбын Маргад, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ бид нар ингээд сүүлийн 3 жилээр энэ төсвийн тогтвортой байдлын Төсвийн хүрээний мэдэгдлээ ингээд гаргаж байна л даа. Төсвийн төсөөлөл 22 онд, 24 онд. Тэгээд ингээд гарах болгондоо энэ чинь бүүр асар их өндөр зөрүүтэйгээр ингээд өөрчлөгдөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь ингээд өөрчлөөд байх юм бол ер нь энэ иймэрхүү бичиг цаасны энэ Төсвийн хүрээний мэдэгдэл чинь их хэрэгтэй юм уу үгүй юм уу л гэж бараг хурал болгон дээр л бид нар энэ яг хэлэлцэх үед ярьдаг

юм. Ер нь тэгээд сүүлийн 10 жилд бол бараг 33 удаа ингээд өөрчилчихсөн байгаа шүү дээ энэ хуулиудаа.

Тэгэхээр би Хүрэлбаатар даргаас нэг юм асуух гээд байна. Энэ яах вэ байдал бол юугаараа сайжирсан бэ гэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас хараат бусаар байгуулагдаад энэ бүх зүйл дээр бодит дүгнэлт өгдөг, энэ зөвлөмжүүд өгсөн байна л даа. Энэ зөвлөмжүүдийг нэг бүрчлэн танилцлаа. Тэгэхээр ер нь энэ зөвлөмжүүдийг Хүрэлбаатар сайд ер нь санал нийлж байна уу? Энэ их ингээд энэ харьцуулсан дүнгүүдийг би ингээд нэг бүрчлэн хараад, ингээд өөрчлөлтүүдийг нь улаанаар тэмдэглэхэд 9 үзүүлэлтээс 7 нь бараг ингээд их огцом, огцом дүнгээр өөрчлөгдсөн байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар чинь нөгөө тогтвортой байдал, нөгөө төсвийн дүрмүүд байгаа шүү дээ хэрэгжүүлдэг тэр дүрмүүд бол хэрэгжихгүй байна. Тэгэхээр энэ төсвийн дүрэм чинь хэрэгжихгүй болохоор ямар үр дүнд хүрээд байна вэ гэхээр төрийн оролцоо чинь уг нь бол өмнөх энэ төсвийн дүрмээ барьж байсан бол оролцоо маш бага хэвээрээ л байх байсан. Гэтэл төрийн оролцоо чинь улам л ихсээд байдаг, ихсээд байдаг, ихсээд байдаг. ЗГ-ын хадгаламж чинь яг энэ төсвийн дүрмээ барьсан бол бас өндөр байх л байсан. Эдийн засгийн өсөлтийг нь хувийн сектор чинь бас өсөөд л явах байсан. Тэгээд энэ зүйлүүд чинь ингээд хэрэгжихгүй болохоор энэ ер нь төсвийн хүрээний мэдэгдэл энэ тэр чинь хэрэгтэй ч юм уу даа, ер нь бараг хэрэггүй л юм шиг санагдах юм. Тэгээд энийг боловсруулж байгаа хүмүүс нь ч тэр хаана хамаагүй л ингээд л биччихээд л дураараа, дураараа өөрчлөөд л ороод ирж байна л даа.

Бид нар өмнө нь бас Ирээдүйн өв сангийн хуультай байна. Өнөөдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн хууль нь явсан бол нэлээд л мөнгөтэй, тэгээд л нэг

хууль гаргаад л Ирээдүйн өв сангаа төсвийн юунд төсөвтөө ашиглаад ингээд явчихдаг. Тэгэхээр ер нь зүгээр та яг мэргэжлийн хүний хувьд энэ тийм их хэрэгтэй бичиг баримт мөн юм уу? Ямар ч үр дүнгүй л харагдах юм байна шүү дээ. Орж ирээд л дураараа өөрчлөөд л, өөрчлөөд, энийгээ барьж байгаа ч юм алга, төсвийн дүрмээ мөрдөж байгаа ч юм алга. Тэгээд энэ дээр чинь энэ ЗГ-ын өр төлбөр чинь 15 онд 15 их наяд байсан бол, одоо 23 онд 30,7 их наяд төгрөг болоод л явчихсан байж байна. Тэгээд энэ нэг төсвийн бодлого чинь л ийм нэг сайхан тогтвортой болж өгөхгүй байна. Тэгээд л нөгөө Голланд өвчний шинж тэмдгүүд чинь бүгд илэрсэн байж байгаа. Тийм учраас энэ дээр нэг та яг зүгээр мэргэжлийн хүн хариулж өгөөч. Ер нь иймэрхүү бичиг баримт Их Хурлаар оруулж ирээд л ингээд байх нь ер нь жооохон цаг үрсэн асуудал биш юм уу л гэж бодогдоод байх юм.

Г.Занданишатар: Чимэдийн Хүрэлбаатар Шадар сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Үнэхээр тийм асуудал бол байсан. Харин тэгээд Төсвийн хуульд бол Тэмүүлэн нарын гишүүдийн гаргасан саналаар өөрчлөлт орсон. Ингээд бид нар хуучин Сангийн яам өөрөө Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөллийг боловсруулаад оруулдаг байсан болбол энэ өөрчлөлтөөр анх удаагаа Эдийн засаг, хөгжлийн яам нь оруулж байгаа юм. Дээр нь төсөв өргөчихсөн үед бол Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахыг нь хуулиар хорьчихсон байж байгаа.

Тийм учраас яг таны хэлээд байсан болгоомжлолууд, одоо нэг юм хэлэлцсэн болоод баталчихдаг, тэгээд дараа нь яг төсөв өргөхдөө өөрчилчихдөг тэр бүх зүйл хуулиар хориотой болчихсон учраас одоо ингээд төсвийг төлөвлөдөг энэ механизмд нэлээд тийм зарчмын өөрчлөлтийг бол оруулсан. Тийм учраас

тэр Тэмүүлэн нарын гишүүдийн санаачилсан энэ өөрчлөлт бол үндсэндээ төсвийн сахилга бат, төсвийн төсөөлөл тооцоог бол нэлээд хариуцлагажуулж өгсөн гэж ойлгож байгаа.

Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан зөвлөмжүүдтэй зөрчилдөж байгаа зүйл нь юу вэ гэхээрээ нүүрсний экспортын хэмжээ дээр зөрөөд байгаа юм. Тухайлбал 2024 онд 3Г гаргах нүүрснийхээ хэмжээг 75 сая тонн нүүрс, ирэх жилд 80 сая тонн нүүрс гаргана гэдэг ийм төсөөллийг Эдийн засаг, хөгжлийн яам хийсэн байдаг. Гэтэл манай энэ Тогтвортой зөвлөлийн гишүүд маань энийг 50 саяар тооцож байх жишээтэй. Гэтэл бид нарын хувьд бол энэ өнгөрсөн 2023 онд бол 69 сая тонн нүүрсийг экспортолчихсон байгаа. Тэгээд энэ оны гүйцэтгэлийг аваад үзэх юм бол нүүрсний экспорт нэлээн сайн байгаа. Одоо яг 5 сарын өнөөдөр 5 сарын 17, 5 сарын 14-ний, 15-ны тоогоор аваад үзэх юм бол 23 оны 5 сард бүхэлдээ 23 сая тонн нүүрс гарч байсан болбол одоо 5 сарын 15-ны байдлаар 28 сая тонн нүүрс гарчихсан байгаа юм. Тэгэхээр бид нарын Эдийн засаг, хөгжлийн яам бол энэ өөрсдийнхөө тооцоон дээрээ бол итгэлтэй байгаа 1.

2 дугаарт Хятадын эдийн засгийн өсөлт бас жоохон тааруу байх шиг байна. Тэгээд энэ нь эргээд сөрөг нөлөө үзүүлчих вий гэсэн ийм болгоомжлолыг мөн энэ зөвлөлийн хүмүүс хэлж байна лээ. Хятадын эдийн засаг бол өөрсдөө бол 5 хувиар тооцсон, гүйцэтгэлээр 5,3 гарсан. Монголын экспортод хамгийн чухал байдаг Хятадын хойд хэсгийн эдийн засгийн өсөлт бол дунд, Хятадынхаа дунджаас дээшээ 6-аас 7 хувьтай байгаад байгаа нь манай энэ экспорт өнөөдрийнх шиг ийм өндөр байгаатай нөлөөлж байгаа ийм зүйл учраас бид нар эрсдэл бол харьцангуй бага байна гэж үзэж, өөрөөр хэлбэл Эдийн засаг, хөгжлийн яам өөрийнхөө

тооцоон дээрээ бол итгэлтэй байгаа гэдгийг би та бүгдэд хэлмээр байна.

Г.Занданишатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсвийн төсөөлөлтэй холбогдуулаад 5, 6 зүйлийг тодруулъя гэж бодож байна. Яах вэ жил бүр энд бид нар энийг л хэлэлцдэг л дээ. Тэгээд хэлэлцчихээд л баталчихдаг. Дараа нь бодит тоогоо тавихаар бас жаахан өөрчлөгддөг юм бий. Би нэг Хүрэлбаатар сайдаас 4, 5 зүйлийг тодруулъя. Өнөөдөр эдийн засагт хамгийн чухал асуудал болбол зээл, зээлийн хүүгийн асуудал байгаа юм. Зээлийн хүү асар өндөр байгаа, 12, 13-тай байгаа бодлогын хүү. Арилжааны банкнуудын өгч байгаа нь үндсэндээ 20-оос 22 хувь байгаа дээд тал нь. Ийм өндөр зээлтэй байхад болбол бизнест аягүй хүндрэлтэй байна.

Тэгээд сүүлийн үед яаж байна вэ гэхээр нэг ийм төрөөс банкнуудыг дэмжиж, хөнгөлөлттэй зээлүүд яваад байдаг болчихсон. Энэ болбол их буруу тогтолцоо байгаад байгаа юм. Банкнуудыг дэмждэг, энэ цаанаа үндсэндээ ний нуугүй ярихад нэг ийм л асуудал болчихоод байгаа юм. Тэгэхээр 2025 оны тухайд Эдийн засгийн яам тооцооллоо хийхдээ зээл, зээлийн хүүг ямар хэмжээнд байна гэж үзэж байгаа юм бэ? Банкнууд чинь үндсэндээ зээл гаргахаа больчихоод байгаа байхгүй юу. Үйлчилгээний төлбөр өндөр учраас түүгээрээ амьдардаг болчих гээд ингээд болохгүй байгаад байгаа юм.

2 дахь асуудал болбол эдийн засгийн төлөв байдлын асуудал байгаа. Ирэх онд энэ нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр гээд манай экспортын бүтээгдэхүүнүүд дэлхийн зах зээлийн үнэ ямар хэмжээнд байна гэж тооцож байгаа юм бэ? Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан тооцооллоор болбол өндөр тооцсон

байна гэдэг зүйлийг өглөө Төсвийн байнгын хороон дээр дурдаж байгаа харагдана лээ. Тэгэхээр энэ Эдийн засгийн яам энэ экспортын бүтээгдэхүүний үнийн өсөлтийг буюу үнийг хэр хэмжээнд төлөвлөж, хэр бодитой гэж үзэж байгаа вэ гэдэг асуудал байгаа юм.

3 дахь асуудал үнийн өсөлт, инфляцын асуудал байгаа юм. Үнийн өсөлт ирэх жил 6-аас, 6 хувь гэж авч үзсэн байна хэрэглээний үнийн өсөлтийг. Тэгэхээр үнийн өсөлтүүд бол бид нар үнийнхээ өсөлтөд гүйцэх тухай асуудал байгаад байгаа юм. Инфляц, үнийн өсөлтийг барихгүй л бол өргөн хэрэглээний барааны үнэ өндөртэй холбоотойгоор тэр нь иргэдийн амьжиргаанд сөрөг нөлөөллийг бий болгоод байгаа юм.

4 дэх асуудал энэ цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг ирэх жил хэдэн хувьд авч үзсэн юм бол гэдэг асуудал байгаа юм.

5 дахь асуудал нь хөрөнгө оруулалтыг ямар хэмжээнд гэж авч үзэж байгаа юм бэ? 2024 онд сонгуулийн жил ч байсан хөрөнгө оруулалт их өндөр төлөвлөсөн. Тэгээд хөрөнгө оруулалтууд нь ихэнх нь дөнгөж нэг амсуулах төдий, эхлэлийн төдий санхүүжилтүүдийг нь шийдчихсэн байж байгаа. Тэгэхээр ирэх онд эдгээрийг ямар хэмжээнд авч үзнэ гэж хөрөнгө оруулалтыг төлөвлөж байгаа вэ гэдэг ийм 6 асуултыг Эдийн засгийн хөгжлийн яамнаас асууя. Баярлалаа.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 16 цаг 33 минутаас хуралдааныг даргалав.

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? Монгол Улсын Шадар сайд Хүрэлбаатар хариулъя. Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. Зээлийн хүүг ер нь хэдээр тооцож байгаа вэ, яавал энийг буулгах вэ гэдэг ийм асуулт байгаа.

Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яам бол ерөнхийдөө ийм л бодлого дээр онцгойлон анхаарал тавьж байгаа юм. Инфляцын түвшнийг бага байлгаж чадах юм болбол Монгол Улсад зээлийн хүү бууна. Дээр нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгаж чадах юм болбол зээлийн хүү бууна. Өөрөөр хэлбэл зээлийн хүү өндөр байхад голлож нөлөөлөөд байгаа зүйл бол 3 зүйл байгаа. Инфляцын түвшин, валютын ханшийн тогтворгүй байдал, тэгээд нийтдээ Монголд үйл ажиллагаа явуулж байгаа банкны тоо хэмжээнүүд.

Тэгээд үзэхээр хэрвээ бид нар Монгол Улсынхаа валютын нөөцийг 10 тэрбум долларт хүргэх юм болбол энэ одоо 3380 орчим төгрөг байгаа, 3390 орчим төгрөг байгаа энэ ханш бол илүү тогтвортой байна гэсэн үг. Хэлбэлзэхгүй гэсэн үг. Доошоогоо л унах хандлагатай байна гэсэн үг. Тэгэхээр зээлийн хүү буурах гол нөхцөл нь бол нэг нь энэ.

2 дугаарт нь инфляцыг бид нар 3 хувь дээр ингэж хатуу барина гэдэг бодлогыг нэлээд яриад байгаа. 3 хувь дээрээ байлгачих юм болбол зээлийн хүү чинь угаасаа нэг оронтой тоо руу буугаад ирнэ. Тийм учраас энэ дээр анхаарал тавьж байгаа. Дээд талд нь аль болохоор олон банк Монгол Улсад үйл ажиллагаа явуулах чиглэлээр нь анхаарах ёстой. Бид нарын хувьд бол энэ банкны салбарын либералчлал, гадаадын томоохон банкнуудыг Монголд оруулж ирэх үйл ажиллагааг бид нар зайлиггүй дэмжиж хийх ёстой. Ингэж байж энд мөнгөний зээлд гарах мөнгөний хэмжээнүүд нэмэгдэж байж энэ олдоц нэмэгдэнэ. Ингэж байж хүү буух ийм учиртай байгаа юм. Тийм учраас энэ салбарт гаднын хөрөнгө оруулалтыг татаж, дэмжих нь бол яах аргагүй зайлиггүй бодлого байгаа юм гэдгийг би энд онцолж хэлмээр байна. Ингэж чадвал бид нар зээлийн хүүг нэг хувьд буулгана гэсэн, нэг оронтой тоо руу оруулах ийм боломжтой гэж үзэж байгаагаа энд бол хэлье.

Үүний дараагийн асуудал бол нийтдээ хэчнээн хэмжээний хөрөнгийг хөрөнгө оруулалтад зарцуулах вэ гэж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэлд 2025 ондоо 7 их наяд 273 тэрбум төгрөгийг, 2026 ондоо 7 тэрбум 564, 2027 ондоо 7 тэрбум 866 төгрөг тэрбум төгрөгийг бол төсөвлөнө гэж харж байгаа гэдгийг бол энд хэлье.

Уул уурхайн гол экспортын бүтээгдэхүүний үнийг бол бид нар бол нэлээд нүүрс дээрээ жоохон буулгаж тооцож байгаа. Алтны хувьд, зэсийн хувьд бол бид нар нэлээд боломжийн хэмжээнд өндөр түвшинд төсөвлөж оруулж ирж байгаа. Тэгээд та нарт би удахгүй тоог нь хараад хэлье гэдэг хэлье гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя. 2025 оны Төсвийн хүрээний мэдэгдлийн бүтэц нь бас зөв орж ирж байна гэж харж байгаа. Урьд нь болбол эдийн засгийн өсөлт нь бол инфляцаасаа доошоо орчихсон байдаг. Тэгээд бүтэц буруутай ийм баримт бичиг орж ирдэг байсан. Энэ удаа бол эдийн засгийн өсөлт нь 8 хувь, инфляц нь 6 хувь гэж байгаа. Тэгэхээр энэ бол бүтэц нь зөв байна гэж үзэж байгаа юм.

Ер нь бол Монгол Улс чинь хөгжлийн асар их потенциалтай улс шүү дээ. 22 онд 23 оны төлөвлөгөө энэ Төсвийн хүрээний мэдэгдэл ярих үед төсвийн орлогыг нэмэгдүүлэх гээд ядчихсан юм. Тэгээд аргаа бараад энэ гутранги хүмүүсээр тоо бүү бодуулаач гэж ингэж хүртэл ярьж байсан. 23 онд чинь болбол 4 их наяд төгрөгөөр төсөв давчихсан явж байгаа шүү дээ төлөвлөснөөсөө. Тэгээд энэ бол бид нар их мундаг гавьяа байгуулаад ингээд нэмчхээгүй шүү дээ. Нөгөө л бараа бүтээгдэхүүний үнэ, Биржийн хуулийн үйлчлэл, дутуу төлөвлөж л байгаа байхгүй юу. Тийм учраас болбол би энэ 29,4 их наяд төгрөгийг ч гэсэн би дутуу л төлөвлөж байна гэж бодож байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд бол бид боломжийг бүрэн ашигласан бол өнөөдөр бол 37, 8, 35, 6 их наяд төгрөгийн төсвийг ярих боломж бол байсан. Ингэхгүй л байгаад байгаа байхгүй юу. Тэгээд л нэг бага төлөвлөөд л, их хэмжээний сайн ажиллаад л их орлого бүрдүүлээд байгаа юм шиг л ингээд л харагдаад яваад байгаа байхгүй юу.

Хэд хэдэн асуултууд байна. 1 дүгээрт нь энэ Евро комиссын нэг тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гээд нэг бас нэлээн их мөнгөөр нэг төсөл хэрэгжээд яваад байдаг юм байна лээ. Эд нар та нарт юу гэж зөвлөдөг юм бэ? Өөрөөр хэлбэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр.

2 дахь асуулт энэ халамжаас, халамжид төсвөөс өгөх хөрөнгийн хэмжээ 2,8 их наяд болоод 550 тэрбум төгрөгөөр энэ жилийн төсвөөс ингээд нэмэгдээд явчхаж байна л даа. Бид чинь халамжаас хөдөлмөр эрхлэлтэд гээд ингээд яваад байдаг. Монголд чинь 2,6 сая хүн халамж ямар нэгэн хэлбэрээр авдаг. Гэтэл хөдөлмөрийн зах зээл дээр 300 сая, тийм уучлаарай 300 мянган ажлын байр байна гэдэг. Тэгэхээр энэ халамжаас хөдөлмөр гэдэг юмтай чинь энэ нийцэж байгаа юу? Энэний өсөлт юутай холбоотой вэ?

3 дахь асуулт бол энэ гадаад өрийн дарамт. Яах вэ нийт Монголын өр болбол ойлгомжтой 34,1, 2 тэрбум доллар болчихсон байгаа. 25, 26 ондоо төлөх өргүй ч гэсэн 24 онд чинь 1,2 их наяд төгрөг зээлийн хүүгийн төлбөр төлнө шүү дээ. Тэгээд бид чинь нэг Century 2, Century 3 гээд бас нэлээн өндөр хүүтэй зээл босгочихсон байгаа. 2025 онд зээлийн хүүгийн үйлчилгээнд хэдэн төгрөг төлүүлж байгаа вэ гэж.

4 дэх асуудал энэ Оюу толгой төсөл. Энэ жил 776 тэрбум төгрөг Монгол Улсын төсөвт нийлүүлнэ. Энэ нөгөө Монгол Улсын нийт төсвийн 2,7

хувийг л эзэлж байгаа байхгүй юу. 25 онд Оюу толгой төсөл Монгол Улсын төсөвт ямар хэмжээний үүрэг, ямар хэмжээний мөнгө нийлүүлэх юм бэ? Энэний тооцоо байна уу? Тэгээд алтны хэмжээ. Хил нээгдэхээр алтны хэмжээ багасдаг, хил хаагдахаар нэмэгддэг.

Хамгийн сүүлчийн асуудал эдгээр энэ арга хэмжээний үр дүнд энэ макро эдийн засгийн тогтвортой байдлын нөлөөллийг юу гэж тооцож байгаа вэ? Сая тэр банкны асуудлыг нь Тогтохсүрэн дарга асуучихлаа. Тогтвортой байдал.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Баттөмөр даргын асуултад хариулъя. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Гадаад өрийн дарамтаас бол эхэлье. Ер нь энэ 2016 онд бол ЗГ-ын өрийн хэмжээ ДНБ-ий 79 хувьтай тэнцүү байсан. 2019 онд энийг ДНБ-ий 53 хувь болгож буулгаж чадсан байдаг. Одоо 2023 онд бол ЗГ-ын өрийн хэмжээ ДНБ-ий 39 хувийг эзэлж байгаа. Өөрөөр хэлбэл эдийн засагт дарамт болоод байхааргүй хэмжээнд өрийн хэмжээ 40-өөс доошоо бол буугаад ирчихсэн гэсэн үг. Сүүлийн 12 жилийн хугацаанд энэ бол ЗГ-ын хувьд гарч ирээгүй ийм сайн зүйл. 2024 онд Монгол Улс гадагшаа төлөх нэг долларын ч бондын үндсэн төлбөр байхгүй. 2025 онд гадагшаа төлөх бондын үндсэн төлбөр мөнгө байхгүй байгаа. Ингээд үндсэндээ энэ 2023 ондоо бид нар олон зүйлийг цэгцэлсний дотор нь энэ гадаад өрийн дарамтыг бол бид нар буулгаж чадсан гэж гэдгийг бол хэлмээр байна.

Олон төрлийн бондууд, бондууд ороод ер нь нийтдээ гадаадаас авсан нийт зээлийн хүүгийн төлбөрт бол 2024 онд 1,1 их наяд төгрөг, 2023 онд нэг аравны, 25 онд 1,3 их наяд төгрөгийн төлбөрийг бол төлнө. Нөгөө төсвийнхөө орлогодоо эзлэх хэмжээндээ нийт төсвийнхөө зардлын хэмжээндээ

харьцуулаад аваад үзэх юм бол нэлээд бууж байгаа гэдгийг би бол хэлмээр байна. Үүний дараагаар ер нь энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ер нь юу хийх ёстой вэ гэдэг ийм чиглэл байгаа. Тэгэхээр бид нарт юуны өмнө бид нар хөрөнгө оруулалтын хувьд өөрсдөө ирээдүйд цаашидаа хөрөнгө оруулалт хийх, ажлын байрыг шинээр бий болгоход хамгийн чухал зүйл нь юу вэ гэхээр 1 дүгээрт нь яг түрүүн бол та өөрөө асуулт дотор үгээ хэлчихлээ. Макро эдийн засгийн тогтвортой байдал. Макро эдийн засгийн тогтвортой байдал нь хангагдаж байвал тэнд хөрөнгө оруулах боломж боломж бий болж байна гэж үзэж, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг бол нэмэгдүүлдэг. Дээд талд нь гадаадын хөрөнгө оруулалт.

Тийм учраас энэ цаашидаа бид нар ажлын байрыг дэмжих чиглэлээр бол бид нар энэ хөрөнгө оруулалтыг бол цаашидаа тууштай дэмжиж явах ёстой. Монгол залуучууд гадаадад очиж тэр нэг үйлдвэрт ажилладаг биш тэр очоод ажиллаад байгаа үйлдвэр нь уг нь Монголд орж ирээд үйл ажиллагаа явуулж байх учиртай. Тэр агуулгаар нь бид нар өөрсдийнхөө залуучуудыг гадагшаа гаргахгүй байлгахын тулд ч гэсэн тэр гадаадын хөрөнгө оруулалтыг Монголдоо дэмжиж явах нь болбол энэ хөдөлмөр эрхлэлтийг бол дэмжихэд чухал зүйл гэдгийг бол би энд онцолж хэлмээр байна.

Оюу толгойн хувьд бол өгөх өгөөж бол нэмэгдэнэ. Яагаад вэ гэхээр яах.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Яах юм бэ тодруулах юм уу? Юу яах юм уу, гүйцээж хариулах юм уу? Шадар сайд Хүрэлбаатар гүйцээгээд хариулчихъя.

Ч.Хүрэлбаатар: Оюу толгойн хувьд гэвэл энэ 25 оноос эхлээд нөгөө агууламж сайтай хэсгүүд рүү орж байгаа учраас тэндээс олох орлого бол

нэмэгдэнэ. Эдийн засгийн өсөлт ч гэсэн энийгээ дагаад бол нэмэгдэнэ гэж бол бид нар үзэж байгаа. Оюу толгой ЗГ хоорондын маргаан бол бий. Тэр нь шийдэгддэг журмаараа тэр хөрөнгө оруулагч ЗГ хоорондын маргаан нь шийдэгдэх журмаараа шийдэгдээд явна гэдгийг бол би хэлмээр байна.

Гадаад өрийг нийтэд нь ингээд аваад үзэх юм болбол ЗГ-ын өр 35 орчим хувьтай байсан нь одоо энэ 28 хувь болж буусан байгаа. Гадаад өрийн 28 хувь нь ЗГ-ынх, үлдэж байгаа 72 хувь нь бол хувийн хэвшлийнхний өр байгаа гэдгийг би бол энд онцолж хэлмээр байна.

Орлого дээр илүү орлого олох боломж байгаа юу гэвэл байгаа. Цахимжуулсан, тэгээд дотоод нөөц бололцоо бол бид нар байна гэж үзэж байгаа учраас энэ чиглэлээр нэлээдгүй ажлыг бол цаашидаа үргэлжлүүлээд хийнэ. Сангийн яам, Татварын ерөнхий газар энэ чиглэлээр бол ажлаа бол маш сайн хийж байгаа гэдгийг би бол хэлмээр байна. Доторх нөөц бололцоог бол бүрэн гаргаж ирж ажиллуулах бүрэн боломжтой гэж үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Та тодруулах юм уу? Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр тодруулж асууя.

Б.Баттөмөр: Монгол Улс нүүрсний асар их хэмжээний нөөцтэй. Зөвхөн Эрдэнэс таван толгой гэхэд л 8 тэрбум тонны нөөц байна шүү дээ. Жилд 100 сая тонн гаргана гэхэд 80 жилийн нөөц байна шүү дээ. Энийг бид гаргах л ёстой, авч л байвал гаргах л ёстой шүү дээ. Эхний 4 сарын байдлаар чинь 25 сая тонн нүүрс гарсан мэдээ байгаа шүү дээ. Тэгэхээр үлдэж байгаа хугацаанд болбол ер нь 70, 80 тонндоо хүрэх ийм боломж байгаа байхгүй юу. Тэгээд энийг их сайн тооцож ажиллах ёстой гэж.

Оюу толгойн өсөлт болбол жоохон ээлгүй л байх шиг санагдаад байдаг юм даа. Яах вэ тэр сайн хэсэг

рүүгээ орж л байгаа байх. Гэхдээ эдийн засгийн өсөлтийг үзүүлээд байдаг боловч яг нөгөө Монголын эдийн засагт оруулж байгаа нөлөө болбол бага байгаад байгаа. Тухайлбал зэсээ ямар үнээр зарах тэр гэрээ нууц гэж байгаа юм. Оюу толгойн тэр зэсийг Монголын хөрөнгийн биржээр зарах боломж байна уу, юу уул уурхайн бирж.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Монгол Улсын Шадар сайд Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Санал нэг байна. 100 сая тонн байтугайг бол гаргах боломж бол бий. Ер нь энэ биржийн тогтолцоонд шилжсэнээс хойш биржээр бол байнга бараг өдөр болгон л худалдаа тэнд явагдаж байна шүү дээ. Хуучин Эрдэнэс таван толгой гэдэг ганцхан компани зарж байсан, Энержи ресурс гэдэг компани зарж байсан болбол одоо бирж дээр бол 5 орчим компани зөвхөн нүүрс дээр байнга зарж байна. 130 гаруй компани тэнд бүртгэлтэй болчихсон тэнд байнгын худалдаанд оролцоод эхэлж байна. Энэ биржийн энэ тогтолцоо бол үндсэндээ Монгол Улсыг мөнгөтэй болгох, ковидын дараа 1 жил 7 сарын дотор эдийн засгийг сэргээхэд бол голлох нөлөө бол үзүүлсэн. Үүнд бол Уурхайн яам бол Ганбаатар сайдтай яам бол маш их чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг би бол энд онцолж бас хэлье гэж бодож байна.

Зэсийг бол биржээр зарагдаад эхэлсэн. Ганбаатар сайд нэмээд ярих байх. Ер нь цаашидаа энд бирж дээр Монголын баялаг л байгаа юм болбол бүх бирж рүү худалдаагаа хийе гэдгийг бол шахаж эхэлнэ. Тэгээд бүх татварыг бол бирж дээр тогтсон үнээс нь бүх татвараа аваад явна шүү дээ. Тэгэхээр цаашидаа ялгаагүй хувийнхныг ч гэсэн биржээр оруулж ирж зардаг, биржээр зарагдаагүй болбол Монголын баялгийг дутуу, бага үнээр зарж байна гэж үзэж, үүнд заруулахгүй байх хэмжээн дээр цаашидаа бол анхаарч ажиллах ёстой. Ер

нь биржээр тогтолцоо руу шилжиж байж Монгол Улс бол энэ уул уурхайн салбараас илүү орлого олно.

Хамгийн гол нь энэ биржийн онцлог бол ил тод байдлыг хангаж өгч байна. Компанийн захирал мэдэж үнэ тогтоохгүй байна. Бирж өрсөлдөөний зарчим дээр үндэслэгдэж нүүрсний үнэ тогтоож байна. Компанийн захирал нэг компанийг сонгож гэрээ хийхгүй байна. Бирж дээр хамгийн өндөр үнийн санал өгсөн компани гэрээ байгуулж байгаа учраас энэ бүгдийн эерэг нөлөө нь төсөвт ч нөлөөлж байна, эдийн засагт ч нөлөөлж байна, валютын нөөцөд ч бас нөлөөлж байгааг хэлье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал асуултаа асууя. Батжаргал гишүүний микрофон.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 26, 27 оны төсөөллийг үзэл баримтлалынх нь хувьд бол дэмжиж байгаа юм. Хэд хэдэн тодруулах зүйл байна уу гэж ингэж хараад байгаа.

Бид бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа амилуулна, реформ хийнэ гээд явцааж байгаа. Тэгэхээр энэ Төсвийн хүрээний мэдэгдэл, тэр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг амилуулах чиглэлээр ер нь ямархуу бодлогын өөрчлөлт авч боловсрогдсон бол гэж. Дам дамаа тэр хөрөнгө оруулалт 7 орчим их наядаар ойрын 3 жил явахаар харагдаад байгаа юм. Тэр дотроос энэ бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалтай уялдсан томоохон хөрөнгө оруулалтын юмнууд байна уу гэж. Энийг нэг тодруулмаар байна.

Дараагийн нэг зүйл бид сая Үндэсний баялгийн сангийн хуулиа баталчихсан. Баялгийн сангийн хуулиар 3 том санд баялгийнхаа өгөөжийг татаж төвлөрүүлэхээр ярьцаасан. Үүгээр ер нь хэдий хэмжээний юм орж ирэх, тэрнийг

бид ямархуу байдлаар ашиглах талаар төсөөлөгдсөн юм байна уу? Нэг ийм зүйл байна.

3 дахь зүйл ер нь бодлогын хүүг хэд байна гэж тооцож байна вэ? Бид нар өсөлтөө 8 хувьтай, инфляцаа 6 хувьтай байхаар ингээд тооцогдож байна. Тэгэхээр зэрэг бодлогын хүү ер нь хэдтэй байх юм бэ? Энэ бодлогын хүүгээр дамжиж эдийн засаг идэвхжих, баялаг бүтээх, тэр улсуудад очих хямд өртөгтэй эх үүсвэрийн чинь асуудал яригдах гээд байна. Тэр сонирхлыг нь бид бодлогын зээл гэдгээр төр татвар төлөгчдийн мөнгөнөөс тодорхой эх үүсвэр гаргаад, хүүгийн зөрүү өгчхөөд байгаатай холбогдоод банкнууд ерөөсөө тэр лүү харахаа байчихсан. Тийм учраас үүн дээр ер нь ямар төсөөллөөр та хэд энэ хүрээний мэдэгдэлд авсан юм бэ гэдэг нэг ийм зүйл байна.

Дараагийн зүйл хөрөнгө оруулалтын зардал дотор яах аргагүй энэ хөгжлийг дэмжсэн дэд бүтцийн өндөр өртөгтэй бүтээн байгуулалтын төслүүд байгаад байгаа юм. Жишээ нь Төв аймагт гэхэд энэ баруун хойд талын 3 сум руу чиглэсэн бараг 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай замын асуудал энэ тэр байдаг. Эхлээд 3 жил шахуу, 2 жил гаруй болчихдог. Тэгээд ирэх онд энэ төсвийн хүрээний одоо тооцож байгаа төсөөлөл хүрээн дотор, мэдэгдэл дотор чинь энэ хөрөнгө ер нь ямархуу байдлаар тусаж орно гэж тооцоод байна вэ? Би бол бодоод байгаа сүүлийн 2 жилийн төсвийг уншаад байгаа хүний хувьд бол ихэнх нь дандаа энэ зам, дэд бүтцийн том дүнтэй хөрөнгө оруулалтууд байгаа шүү. Үүнийг урагшлуулах тал дээр бид арай хөрөнгө ахиу нэмэхгүй бол дэндүү хөрөнгө оруулалтын ажил удаашираад, тэрнээс болоод бараг үргүй зардал нэмэгдээд байх магадлал үүсчхээд байгаа нэг ийм зүйл бий гэж.

Дараагийн нэг асуумаар байгаа зүйл, бид хэд бол дандаа мөчлөг сөрсөн

төсвийн бодлогын тухай ярьдаг юм. Тэгвэл одоо эдийн засаг өсөлттэй байна, тэгвэл өсөлтөө дагасан зардлынхаа асуудлыг хумих юм байх уу? Энийгээ дагаж төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн чинь алдагдал буурах бололцоо байна уу? Ер нь би бол аль болохоор бололцоо байгаа бол энэ заавал нэг тодорхой хэмжээнд тэнцлийн алдагдалтай харагдуулж байх ер нь хэрэг байгаа юм уу? Тэртээ тэргүй төлөвлөлт дээр зөв тооцолтоо хийгээд л явчихвал энд тэндхийн эх үүсвэр хайгаад байхгүй, олсон орлого дотроо багтаж зардлаа гаргаж явдаг энэ л.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар асуултад хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Эхлээд энэ юунаас нь эхэлье. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай энэ төсвийн төсөөлөл уялдаж байгаа юу гэж. Одоо бид нар бол голдуу дандаа эдийн засгийн гол ерөнхий үзүүлэлтүүдийг бол оруулж ирж танилцуулж байгаа. Тэгэхээр хөрөнгө оруулалт дээрээ бид нар энэ бүсчилсэн хөгжил дээрээ яаж эрэмбэлэгдэж байгаа төслүүдийг оруулах вэ гэдгийг бол намар төсөв дээрээ бид нар нэлээд дэлгэрэнгүй оруулж ирнэ. Тэгэхээр ерөнхийдөө бид нар энэ гол тэнцлүүдээ бол бариад явж байгаа. Тэгэхээр одоо энд батлагдаж байгаа энэ хүрээнд тоонуудын хүрээнд тэр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлсэн бодлогыг бид нар энэ дотор нь оруулж ирээд хэрэгжүүлээд явах бүрэн боломжтой гэдгийг бол бас хэлмээр байна.

Бодлогын хүүг бол 2 сарын өмнө дотоодын юу бодлогын хүү бол 13 хувь байсан. Үүнийг ингээд хоёрхон сарын дотор 11 болгоод ингээд нэг, нэг функцээр ингээд хурдан буулгаж байна л даа. Уг нь энэ бодлогын хүүг буулгахдаа эдийн засаг нь тогтворжсон, инфляцын түвшин нь тогтворжсон, ханин нь нэлээд

тогтвортой болчихсон үед нь буулгах ёстой. Гэхдээ Монголбанк их яараад байх шиг байгаа юм. Их л хурдан, хурдан буулгаад байна. Уг нь энэ долларын ханин төгрөгтэй харьцах бол 3560 гэдэг тооноос 3500 болж буусан, 3450 болж буусан, 3400 болж буусан. Тэгээд 3370 руу бууж ирчхээд, бодлогын хүүг ингээд огцом, огцом буулгаад эхлэнгүүт эргээд 10, 3390 лүү очоод эргээд өсчихсөн байж байгаа. Энэ чинь өөрөөр хэлбэл хэтэрхий Монголбанк хэтэрхий яараад байгаа юм биш биз гэдгийг л харуулж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэрвээ санал асуудаг болбол арай яарч буулгаж байна гэдгийг би бол хэлмээр байна.

Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яамны барьж байгаа зорилго бол болж л өгвөл инфляцыг 3 гэдэг хувийн түвшин дээр буулгах бодлогыг бол баримтлах ёстой. Ингэхэд яах аргагүй бид нар тэр ханины нөлөө их чухал үүрэг гүйцэтгэх юм байгаа юм. Тийм учраас энэ бодлогын хүүг буулгахдаа тун яарахгүйгээр буулгах ёстой байсан болов уу гэдгийг би бол энд дахиж хэлмээр байна. Тэгээд Монголбанк бол ЗГ-аас үл хамаарч бодлогоо явуулдаг учраас энийгээ хэрэгжүүлээд явж байна.

Баялгийн сантай холбоотой 3 сан байгаа шүү дээ. 1 дүгээрт нь Ирээдүйн өв сан энэ нөгөө өмнө нь байсан Ирээдүйн өв сан дээр хуримтлагдсан мөнгө хэвээрээ байгаа. Тэрийг бол огт зарцуулах юм уу, тийм зүйл байхгүй. Зарим хүмүүс улс төржсөөд Баялгийн сангаа аваад идчих гэж байгаа юм шиг юм яриад байгаа юм. Тэнд байгаа 3 орчим их наяд төгрөг хадгалагдсан хэвээрээ цаашидаа явна. Энд гар хэн ч хүрэхгүй. 2030 он хүртэл, тэр бол хэвээрээ.

Дараа нь Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэж хоёулаа бол байгаа. Энэ нөгөө хуучин байсан зүйлүүдийг нь дотор нь бага зэрэг ялгаж.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хүрэлбаатар сайд гүйцээгээд хариулчихъя.

Ч.Хүрэлбаатар: Бага зэрэг ялгаж байгаа учраас нэг их тийм их онцын бол нөлөөлөл бол байхгүй. Эдийн засаг, хөгжлийн яам 300 тэрбум төгрөгөөр бол энэ дээр нэмэлт орж ирнэ гэж үзэж байгаа. Яагаад гэвэл нөгөө төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ноогдол ашигт хуримтлуулах мөнгөн дээрээс татаж бий болгох зарим сангууд энэ дээр орж ирэх ийм боломжтой гэж үзэж байгаа юм. Нэг их зарчмын тийм томоохон өөрчлөлтүүд бол энэ дээр гарахгүй.

Дараагийн асуудал бол хөрөнгө оруулалтын зардал дээр бол би Батжаргал гишүүний хэлж байгаа байр суурьтай бол ерөнхийдөө нэг байгаа. Яагаад гэвэл энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бид нар дотроо бол Монголчууд мянга наймаалцаад нэг их ач холбогдол багатай шүү дээ. Хамгийн гол нь зах зээл рүүгээ гарч, арилжаа наймаа хийгдэх ёстой. Тийм учраас хилийн боомтуудыг хөгжүүлэх, хилийн боомт руу чиглэсэн авто зам, хооронд нь бүсийн аймгуудын хооронд нь холбосон энэ авто замын сүлжээг сайжруулах ийм ажлуудыг бол нэлээд түлхүү хийж байж энд хөрөнгө оруулалтууд орж ирнэ. Ингэж байж бүсээ хөгжил бол нэлээд түргэсгэх ийм боломж нь бүрдэж өгөх юм.

Тийм учраас энэ 7 орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт дээр нь голлож дийлэнх нь энэ дэд бүтэц рүүгээ чиглэсэн байгаасай. Дээд талд нь хүний хөгжилтэй холбоотой боловсрол, эрүүл мэнд рүү чиглэсэн хөрөнгө оруулалтууд голлох байгаасай гэсэн ийм бол байр суурьтай байгаагаа бол илэрхийлье. Ер нь хэрвээ энэ бодлого чигээрээ цаашидаа үргэлжлүүлээд явуулаад байх юм болбол одоо байгаа валютын нөөцөө нэлээд сайн нэмээд, ингэх юм болбол бид нар бодлогын хүүг мөн нэг оронтой тоонд

оруулаад ирэх бүрэн боломжтой гэсэн ийм тооцоотой байгааг хэлье.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу Батжаргал дарга? Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир асуултаа асууя. 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана.

Ц.Сандаг-Очир: 25 оны нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 26-аас 27 оны төсвийн төсөөлөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ямар дүгнэлт зөвлөмж өгсөн бэ? Тогтвортой байдлын зөвлөлийн даргаас асууя. Энэ өгсөн зөвлөмж дүгнэлтийг хэрхэн яаж тооцсон байна вэ? Эдийн засаг, хөгжлийн яам зөвлөмж, дүгнэлтийг авсан уу, тооцсон уу? Өмнө нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмж, дүгнэлтийг ойшоодоггүй, ач холбогдол өгдөггүй байсан цаг үе саяхан. Тэгвэл өнгөрсөн жилийн Төсвийн хуулиар бид нар бас Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хуулийг бас засаж сайжруулж шинэчилсэн. Энэ хуулийн хүрээнд эхний хууль өргөн баригдаад явж байна. Энэ дээр бас нэг хариулт өгөөч.

Яах вэ энэ бүрэн эрхийн хугацаа яах вэ Улсын Их Хурал, ЗГ сайлуулж, муулуулаад шүүмжлүүлээд байж байгаа ч гэсэн бас Эдийн засаг, хөгжлийн яамтай болсон. Энэ хүрээнд бас амаргүй бүрэн эрхийн хугацааг эхэлж байсан. Эхэлж байсныгаа бодоход 2 аравны 3, 4 сар ингэж ковидтой байсан, хил гааль хаалттай байсан тэр үеийг бодоход цалин, тэтгэврээ яаж улсын төсвийн орлогоо бүрдүүлэх вэ гэдэг байсныг бодоход өнөөдөр бол харин эдийн засгийн өсөлт яриад, ард түмний цалин, тэтгэврийг бараг жилдээ үндсэндээ бараг 2 удаа, 23 оны 7 сар, 24 оны 4 сар гээд ингээд эдийн засгийн өсөлтийг ард түмэнд наалдуулах чиглэлээр бас арга хэмжээнүүд аваад, нааштай эдийн засгийн макро эдийн засгийн үзүүлэлтүүд гарчихсан.

Улсын төсөв анх удаа 90 оноос хойш ашигтай гарчихсан. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарчихсан. Инфляцаа бас 2 оронтой тооноос 1 оронтой тоо руу оруулчихсан. Эдийн засгийн өсөлтөөрөө бас дэлхийд тэргүүлэх хэмжээнд харагдаж байгаа гээд ингээд яриад байвал авсан арга хэмжээ, бодлогын үр дүнгийн нааштай үзүүлэлтүүд байна, байна. Энийг хэлэх нь зөв.

Нөгөө талаар бас төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр бид нар бас цаашидаа 2025 он чинь бас гадаад бондын эргэн төлөлт бас тулчихсан өр бол харьцангуй гайгүй юм байна шүү дээ. Тэгэхээр цаашидаа энэ орлого нэмэгдэхийн хэрээр жоохон бид нар 21, 22, 21 онтой харьцуулахад бид нар бүсээ чангалж байсан үе. Тэгээд орлого жоохон нэмэгдэнгүүт ингээд л зардлаа дагаж өсгөөд байгаа юм. Тэгэхээр бас жоохон зардлаа бууруулж, тэвчиж, жоохон хуримтлалтай болох тал дээрээ ямар бодлого барьж байна вэ? Хуримтлалтай болох тал дээр. Орлого өсөхийн хэрээр л төсвөө бас алдагдаад, сая Батжаргал гишүүн асууж л байна. Төсвийг цаашидаа алдагдалгүй батлах бололцоо боломж бий юу? Ашигтай батлах бололцоо боломж байна уу, гаргах уу? Энийг бас Хүрэлбаатар сайдаас асууя.

Та бүхэн энэ ЗГ-ын өрийг өнөөгийн үнэ цэнээр тооцоод яваад байгаа юм. Тэгвэл энэ Дэлхийн банк, Олон улсын валютын сан чинь ер нь юу гэж зөвлөмж өгч байна вэ? Цаашидаа ер нь нэрлэсэн дүнгээрээ энэ өрийн асуудлыг тооцдог байгааг гэж ингээж зөвлөмж өгсөн гэж байгаа юм. Цаашидаа өнөөдөр ингээд өнөөгийн үнэ цэнээр тооцсоноор ер нь ямар эдийн засгийн сөрөг үр дагавар гарах вэ ирээдүйд? Нэрлэсэн үнээрээ тооцоод явж болохгүй юм уу? Энэ дээр та бүхэн нэг хариулт өгөөч.

Дараагийн нэг асуудал энэ гадаадын банк оруулж ирэх асуудал байна. Өнөөдөр үнэхээр энэ ард иргэд,

айл өрх банканд зээлгүй гэдэг юм уу айл өрх, иргэн ховор байна. Бүгд энэ банкны зээл, хүүд л дарлуулж байна шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Тэгэхээр энэ Монгол Улсад шударга өрсөлдөөнийг бий болгох үүднээс, банкнуудын өрсөлдөөнийг бий болгох үүднээс, энэ зээлийн хүүг бууруулах үүднээс энэ гадаадын.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Монгол Улсын Шадар сайд Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Би Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ер нь засгийн төсвийн алдагдлыг бол ингээд Төсвийн хүрэн дээрээ бид нар тасралтгүй буулгаж байгаа. ДНБ-ий 2 хувь 2025 онд байна, ДНБ 1.5, 1 хувь гэж буулгаж оруулж ирж байгаа юм. Ашигтай гаргаад явж бол болно. Гэхдээ бид нарын хувьд бол дэд бүтцийн хувьд нэлээдгүй олон ажил хийгдэх шаардлагууд байгаад байгаа юм.

Бүсчилсэн хөгжлийн гол концепцыг нь аваад үзэх юм бол бид нар гадаад зах зээл рүүгээ гарах боомт дээрээ хөрөнгө оруулалт хийх, зам дээр хийх, Улаанбаатар хотын түгжрэлийг ч гэсэн тэр дэд бүтцийн тэр Улаанбаатар хотын агаарын бохирдолтой холбоотой ч гэсэн тэр аваад үзэхэд энд бол нэлээдгүй хэмжээний хөрөнгө оруулалтуудыг бид нар хийх ёстой. Тийм учраас бид нар энэ нөгөө төсвийн алдагдлыг бол аажмаар буулгах ийм зорилт бол тавьж байгаа гэдгийг би бол энд онцолж хэлмээр байна.

Дараагийн зүйл бол энэ өрийг яагаад ингээд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлээд байдаг юм бэ гээд. Жилд 10 хувь, 12 хувийн хүүтэй 1 тэрбум доллар нэг өөр, эдийн засагт болон төсөвт ямар дарамт өгөх вэ гэхээр өөр. Жилийн 1 хувийн, 3 хувийн хүүтэй 1 тэрбум доллар жилийн 12 хувийн хүүтэй 1 тэрбум доллар бол эдийн засагт өгөх дарамт болон төсөвт өгөх дарамтууд нь өөр,

өөр байдаг учраас энэний ялгааг гаргах зорилгоор бид нар зайлиггүй өнөөгийн үнэ цэнээр өрөө илэрхийлж явах нь илүү бодитой эдийн засгийн тооцооллыг хийх, дарамтыг харах ийм боломжтой болчихдог. Зөвхөн өнөөгийн үнэ цэнээр биш нэрлэсэн үнээр нь явуулаад эхлэх юм болбол энэ 12-оос 16 онд гарч байсан том дутагдал л даа. Өрийн хэмжээ харахаар энэ нэг тоо байдаг. Тэгсэн мөртөө хүү нь болохоор ингээд 16, 17 хувийн хүүтэй мөнгөнүүд байдаг нь тэр нь эргээд төсөв дээр их дарамт болдог.

Одоо бол яаж байна вэ гэвэл дүн нь байлаа ч гэсэн хүү нь бага байгаа учраас эдийн засагт учруулах дарамт нь бол харьцангуй бага байдаг учраас энэ өрийг бол өнөөгийн үнэ цэнээр илэрхийлээд явах нь бол зөв гэдэг ийм зүйл байгаа. Зүгээр нэрлэсэн үнээр илэрхийлээд явбал тэнд хүүгийнх нь ач холбогдол их бага болчихдог. Хүү дээр их бага анхаарал тавигдаад байдаг учраас өнөөгийн үнэ цэнээр илэрхийлээд явах нь бол зөв гэдгийг бол энэ дээр хэлмээр байна.

Ер нь энэ эдийн засагтаа бол бид нар энэ цаашидаа жил болгон эдийн засгийн өсөлтийг их тогтвортой байлгах дээр л голлож анхаарах ёстой юм байна лээ. Нэг жил учиргүй өндөр хувиар өсөөд л, дараа жил нь эдийн засаг унаж байснаас ерөөсөө жил бүр 6-аас 7 хувийн тогтмол ийм өндөр өсөлттэй явахад эдийн засгийн энэ олон харьцаа, энэ хөрөнгийн зардлууд чинь их дагаад их тогтвортой байдлуудаар явчих нь эргээд энэ эдийн засагт их нааштай зүйлүүдийг бий болгоно гэж үзэж байгаа. Гадаадын банкин дээр бол санал нэг байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу ажлын хэсэг? Ажлын хэсгийн 2 дугаар микрофон уу, 2 уу, 1 үү? Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье. 2 юм уу? Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье, асуултад нэмж хариулъя.

Н.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Сандаг-Очир гишүүний асуултын дагуу цаг бага байгаа учраас би голлох товчхон зүйлүүд дээр та бүхэнд хариулт өгье. Өнгөрсөн онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань оны эхнээс ингээд байнгын орон тоотой ажиллаж байна. Бид хуульд заасан шаардлагын дагуу бас макро эдийн засгийн тодорхой загварууд ашиглаад энэ тооцооллоо хийсэн. Өнгөрсөн 3 сарын 15-ны өдөр эхний энэ төсөөллүүдээ Байнгын хороо болон Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн байгаа.

Бидний өгсөн анхны тооцооллоор бол 2025 оны эдийн засгийн өсөлтийг 6,7 хувь байх бололцоотой гэж үзэж байгаа. Гол агуулга нь юу гэхээр Улсын Их Хурлаас 2020 оны 5 сард баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод цаашидаа эдийн засгаа төрөлжүүлнэ, тогтвортой эдийн засагтай байлгана гэсэн ийм урт хугацааны зорилго байгаа. Харамсалтай нь манай өнөөгийн эдийн засгийн бүтэц маань тогтвортой бус илүү явцуу, төрөлжөөгүй эдийн засаг руу түлхүү явж байгаа.

2009 онд уул уурхайн салбарын эзлэх хувь 20 хувь, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 15 хувь байсан бол одоо уул уурхайн салбарын эзлэх хүү 26 хувь, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь 10 болж багасаж байна. Тэгэхээр эдийн засгийн төрөлжилт маань улам явцуу болж байна. Экспортод 3 нэр төрлийн түүхий эдийн эзлэх хувь нь 82 хувь болж байна 2003 оны байдлаар. Тэгэхээр энэ хамааралтай, маш өндөр хамааралтай байгаа 3 төрлийн түүхий эдээр бид өндөр орлогоороо төлөвлөөд байх тусам эдийн засгийн савлагаа ихэснэ гэсэн үг. Тэгэхээр энэ маань урт хугацааны хөгжлийн бодлоготой төдийлөн уялдаж

байна уу гэдэг дээр бид санаа зовж байгаа юм.

Ирэх оны энэ эдийн засгийн өсөлтийн зөрөөтэй гол шалтгаан бол мэдээж энэ түүхий эдийн үнийн биет хэмжээ болон үнийн, үнэ дээр зөрөөтэй байгаа. Хятад улсын нүүрсний экспортын хэрэглээний тухайд бидний анхаарах ёстой 3 үзүүлэлт байгаа. 1 дүгээрт өнгөрсөн 22, 23 оны байдлаар Хятад улсын нийт нүүрсний экспорт 474 сая тонн байгаа. Энэ дотроо Монгол улсын түлхүү гаргаад байгаа коксжих нүүрсний экспорт нь 103 сая тонн. Тэгэхээр Монгол Улс энэ Хятад улсын худалдан авч байгаа импортын 60 хувийг гаргачихсан байна шүү дээ. Цаашидаа өсгөнө.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбаяр гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

Н.Энхбаяр: Би товчхон ярина. Тэгэхээр бидний нэмэх гээд байгаа зах зээл маань нөгөө маш өрсөлдөөнтэй зах зээл рүү нэмэх гээд байгаа юм. 80, 100 байж болно. Тэгэхдээ тэр бол яг саяын өнгөрсөн 2 жил шиг ийм амар нэмэгдэхгүй. Австрали улс нэмэх нь маш тодорхой байгаа. ОХУ Эльгинскийн нүүрсний уурхай шинээр 530км төмөр зам бариад ирэх онд дуусаж байна, энэ онд. Далайн шинэ боомт барьж байна. Тэгэхээр энэ шинэ боомт далайн төмөр замаар 20 сая тонн нүүрс экспортоо нэмнэ гэсэн ийм зорилттой байгаа. Энэ болгон дээр үндэслээд бид нар илүү болгоомжтой хувилбарыг дэвшүүлж байгаа. Ингээд 6,7 хувь гэсэн санал тавьж байгаа.

Төсвийн зарлага дээр одоогийн оруулаад байгаа төсөл маань болохоор 2019 онд баталж байсан төсвийн зарлагаасаа 2,6 дахин их нөхцөлийг бүрдүүлж байгаа учраас тэлэлт маань төсвийн тэлэлт маань эрчимтэй үргэлжилж байна гэсэн үг. Хэрвээ эдийн

засгийн бүтэц маань зөв тогтвортой байсан бол магадгүй энэ эдийн засгийн өсөлт байж болох байх. Хамгийн гол нь энэ тулгуурлаад байгаа төсвийн орлого, зарлага маань үндсэндээ түрүүний дурдсан 2, 3-хан түүхий эд дээр байгаа учраас маш их эрсдэлтэй, савлагаа ихтэй. Дээр нь энэ Хятад улсын зах зээл дээр нөгөө АНУ-ын зүгээс ч гэсэн гангийн экспорт дээр нэмэгдэл татвар тогтоож байгаа гэх мэтээр гангийнх нь коксжих нүүрсний эрэлт хэрэгцээ буурч байгаа гэдгийг анхааруулахыг хүсээж байна.

Ингээд би зөвлөмж дээрээ төсвийн зарлага дээрээ илүү болгоомжтой хандах ёстой. Төсвийн урсгал зардлыг ер нь ДНБ-ий 28 хувиас доош хувьд хүргэх ёстой гэсэн ийм саналтай байгаа. Яагаад гэхээр Монгол Улстай ижил нөхцөлд байгаа далайд гарцгүй, түүхий эдээс хамааралтай улс орнуудын төсвийн зарлага бол ер нь бүгд 30-аас доош хувьтай байгаа. Гагцхүү ер нь 30-аас дээш хувьтай улс Төв Азид Туркменистан байна уу даа, Монгол Улс 2 гээд маш өндөр зарлагатай байгаа гэдгийг бид анхаарах ёстой. Ингээд товчхондоо санал. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн асуултаа асууя. 1 гишүүн асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимд байраа эзлээрэй.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэл 25 оны орж ирж байна. 2026-аас 27 оны төсвийн төсөөлөл орж ирлээ. Би 1 дүгээрт яах вэ гол асуудал бол бид нар ерөөсөө энэ төсөв мөнгө болоод Монгол Улсын хөгжлийн бодлогод бид нар бас нэг шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, алсын хараатай гол нь хариуцлагатай хандах болбол ёстой. Энэ үндсэн дээр бид нар ЗГ болоод Улсын Их Хурал хамтарч байгаад 2023 оны 7 сард төсвийн шинэчлэлийн бодлогуудыг бас хамтдаа өргөн бариад ингээд болбол нэг гол

өөрчлөлтүүдийг оруулсан. Энэ хүрээнд бас бий болсон гол орон тооны байгууллага болсон манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань болбол анх удаагаа ингээд Эдийн засгийн яамтай хамтарч Монгол Улсын хөгжлийн бодлого болоод Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл дээр бас хамтарч ажиллаж, гол нь 2 талаасаа шинжлэх ухааны үндэслэлтэйгээр энэ асуудлыг бас хандаж Төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг болбол бас хамтарч боловсруулаа. Энэ болбол анх удаагийн тохиолдол гэж болбол харж байгаа.

Би бас Эдийн засгийн хөгжлийн яаманд анх энэ төсвийн сахилга бат болоод хяналттай холбоотой, төсвийн гол шинэчлэлийн бодлогуудаар бас дэмжиж тусалж, мөн саналаа өгч ажиллаж байсанд болбол бас 1 дүгээрт талархал илэрхийлэх ёстой. Цаашидаа бид бүхний гол үндсэн зорилго ерөөсөө энэ Монгол Улсын төсөв мөнгө болон хөгжлийн бодлогод бид нар аль болох шинжлэх ухааны үндэслэлтэй хандах л гол үндсэн суурь зарчим болбол байгаа. Ингэж байж бид нар бас энэ төсөв санхүүгийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эргээд юу гэдэг юм төсвийнхөө тогтвортой байдал дээрээ дүн шинжилгээ хийдэг байх, хяналт хариуцлагаа хэрэгжүүлдэг байх, ил тод байдлыг хангах гэдэг юм уу энэ үндэс болбол бүрдэнэ л гэж болбол харж байгаа.

Өнөөдрийн энэ удаагийн мэтгэлцээн ч гэсэн бид нар бас анх удаагаа Улсын Их Хурлын чуулган дээр манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд маань бас орж ирж, өөрсдийнхөө байр суурийг илэрхийлж, эргээд болбол Улсын Их Хурал нь мэтгэлцээнийхээ зарчмаар дунд болоод төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг болбол бас ингээд шинжлэх ухаанч байдлаар болбол ярилцаж, асуудлыг бас ингээд олон талаас нь хандаж байгаад болбол бас талархалтай байна.

Би энэ дээр яах вэ нэг талдаа нэг зүйлийг бас нэг тодруулж асууя гэж бодоод байгаа юм. ЗГ болоод Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс яг эдийн засгийн өсөлт дээр болбол бага зэрэг зөрөө болбол гарсан байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс эдийн засгийн өсөлт 7 хувь байхаар тооцсон. Тэгэхээр ЗГ-ын хувьд болбол 8 функц гэж байгаа. 1 функцээр зөрөөтэй байгааг ер нь бас хэр бодитой гэж бас ЗГ үзэж байгаа бол? Яг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань бас энэ дээр яг 1 функцийн зөрөөний асуудлыг бас юу гэж үзэж байгаа бол?

ЗГ-аас би 2 дахь асуух асуулт маань болбол төсвийн орлогод маань бол ер нь ямар эрсдэл учирч болохоор байгаад байгаа юм бэ? Бид нар болбол аль болох л муу хувилбартай бэлдэж, аль болох л юу гэдэг юм төсвийн учирч болзошгүй эрсдэлээс болбол сэргийлэх болбол зайлшгүй шаардлагатай. Тэгэхээр Төсвийн хүрээний мэдэгдлийн орлого бол төсвийн орлогын угаасаа доод хязгаар болбол байх учиртай байгаад байгаа. Хэрэв юу гэдэг юм магадгүй зүгээр эрсдэл учирлаа орлого төвлөрөх боломжгүй боллоо гээд хэрэв юу гэдэг юм төлөвлөсөн зарлагаа санхүүжүүлж чадахгүй нөхцөл байдал үүсвэл ер нь юу гэж тооцоолж байгаа бол?

Дэлхийн орчин нөхцөл байдал болбол бас таамаглашгүй болбол хэвээрээ байгаад байна. ОХУ нүүрсний экспортын татвараа тэглэсэн байна. Цаашид манай өрсөлдөх чадварт нөлөөлөх эсэх тооцооллыг ер нь та бүхэн бас тооцож үзсэн болов уу? Бид нар бүхий л хувилбар дээр болбол манай Эдийн засгийн гол хөгжлийн яам маань энэ дээр мэдээж би тооцож үзэж байгаа гэж харж байгаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас мэргэжлийн өнцгөөс энэ асуудлууд дээр болбол бас хандаж байгаа гэж болбол бас харж байгаа.

Энэ удаагийн юугаар бол яах вэ мэдээж өргөн барьсан төсөв дээр инфляцыг 3 хувьд хүргэх, өрийн хэмжээ болоод ДНБ-нд эзлэх хувь хэмжээг бууруулах, төсвийн алдагдлыг хуулийн хязгаарт барих гэдэг юм уу гол үзүүлэлтүүдийг сайжруулах зорилтуудыг болбол бас дэвшүүлсэн байгааг байгаа. Эдгээр асуудлууд бол сайшаалтай байна. Зөв байна. Эдгээр таамаглал нь гэхдээ зөвхөн гадаад худалдаа, эдийн засгийн ихээхэн өөдрөг төсөөлөл биелэгдэх нөхцөлд л болбол хэрэгжих боломжтой асуудлууд байгаа. Тэгэхээр бид нар болбол энийг болбол бас хэрэгжүүлэхийн төлөө, энэ төсөөлөл хэр бодитой эсэх дээр болбол бас шинжлэх ухаанчаар хандах ийм шаардлага байгаа л гэсэн энэ асуудлыг болбол бас тандаж асуух гэсэн юм. Тэгэхээр энэ дээр Хүрэлбаатар Шадар сайд маань бас та нэг тайлбар өгөөч.

Л.Мөнхбаатар: Монгол Улсын Шадар сайд Хүрэлбаатар хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Энэ төсвийн орлогод нөлөөлөх гол эрсдэлээ бол бид нар мэдээж геополитикийн өрсөлдөөнтэй холбоотой гэж харж байгаа. Мэдээж энэ тэнд болж байгаа энэ геополитикийн зөрчилдөөнтэй байдал, зарим нь тэнд дайн үүсэж болох газруудын тоонууд нэмэгддэг ийм зүйл харагдаж байгаа. Гэхдээ энэ зөрчилдөөнүүдийг олон улсын байгууллагууд ерөнхийдөө тийм шийдэхдээ бас хамтарч ажиллах ийм чиглэл нэлээд ажиглагдаж байгаа учраас бид нарын хувьд бол энэ дээр нэг их тийм эрсдэлийг бол ер нь бага харж байгаа.

Гол эрсдэлүүдээ бид нар дотооддоо бол харж байна. 1 дүгээрт нь эрчим хүчний хангамж байна. Энэ жил өчнөөн олон удаагийн таслалууд хийлээ. Энэ нь эргээд эдийн засагт аягүй маш сөрөг нөлөө үзүүлж байгааг бол хэлмээр байна.

Дараагийн гол хүндрэлийг бол энэ байгаль орчны цаг агаарын өөрчлөлттэй бол бид нар холбож харж байна. Мал аж ахуйн салбар дандаа уналттай, 2 жил дараалаад уналаа. Энэ жил тийм учиргүй цаг агаарын нөхцөл байдал эрс сайжраад явчихна гэж тооцохгүй байгаа ч гэсэн бас энэтэй холбоотой нэлээд эрсдэлүүд бас гарч ирэхийг бол үгүйсгэхгүй бол байгаа.

Тэгээд дараагийн энэ 24 оны, 25 онд гол учирч болох эрсдэл бол улс төрийн нөхцөл байдал бас өөрчлөгдвөл яах бол гэдэг ийм болгоомжлол болбол байгаа гэдгийг би бол энд онцолж хэлмээр байна. Эдийн засаг, хөгжлийн яам тооцоо дээрээ бол нэлээд болгоомжтой авдаг, тийм өөдрөг бол бид нар хувь хүнийхээ хувьд ч тэр, Эдийн засаг, хөгжлийн яамны хувьд ч тэр байр суурь нь бол хэтэрхий өөдрөг тийм тооцоолуудыг бол хийдэг ирж явж байгаагүй. Гэхдээ хэт болгоомжилж байна гээд хэтэрхий нөхцөл байдлаасаа доошоо бол хийж бас болохгүй. Өөрөөр хэлбэл хэт өөдрөг төсөөлөх, хэт багаар төсөөлөх бол хоёулаа яг адилхан эдийн засагтаа бол хорлодог ийм зүйл байдаг.

Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яам тооцоонуудыг илүү бодитой хийх дээр бол анхаарсан байгаа. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгч байгаа зөвлөмжүүдийг бол Эдийн засаг, хөгжлийн яам маш анхааралтай ажиглаж харж, тэрийгээ бол байнга нягталж, авахыг нь аваад, гээхийг нь гээх ухаанаар бол явж байгаа гэдгээ хэлье. Бас энэний өмнө нэлээд томоохон хэмжээний хэлэлцүүлгийг бол хуулийн дагуу бид нар хэлэлцүүлэг хийх ёстой Төсвийн хүрээний мэдэгдэл дээр. Тэгэхээр яг энэ дээр бол хэлэлцүүлгээ хийгээд, түүн дээр гарсан саналуудыг бол аваад, тусгаад, өгөх тайлбаруудаа бол өгөөд явж байгаа гэдэг ийм байр суурийг хэлье.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс нэмж хариулах уу, хэн хариулах вэ?

Энхбаяр хариулъя, 2 номерын микрофоныг өгье.

Н.Энхбаяр: Тэмүүлэн гишүүний бас Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гүйцэтгэх үүргийн талаар тодорхой мэдээллийг танилцуулсан явдалд баярлалаа. Ингээд төсвийн 2025 оны төсөөллийн тухайд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамгийн гол нь гадаад зах зээлийн нөхцөл байдлаа бид нар маш олон талаас нь сайн судалж үзсэн байгаа.

Тухайлбал Монгол Улсын гаргаж байгаа нүүрс маань үндсэндээ гол дийлэнх хэсэг маань говийн бүсээр, говийн 3 боомтоор Өвөр Монголын район буюу Бугат, Ордосын төмөрлөгийн үйлдвэрт очиж байгаа. Тэгэхээр бидний экспортын худалдаж аваад байгаа манай гол худалдан авагч болох Бугатын төмөрлөгийн үйлдвэр маань дэлхийн гангийн үйлдвэрийн 29 дүгээрт жагсаж байна. Жилдээ 14 сая тонн ган боловсруулдаг ийм үйлдвэр байгаа. Олон улсын гангийн, гангийн судалгааны байгууллагуудын гаргаж байгаа тайлангаар Хятад улс өнгөрсөн онд 70 сая тонн түүхий ган боловсруулсан байгаа. Одоогийн нөхцөл байдал нь энэ цаашидаа Хятад улсын энэ одоо хүрээд байгаа энэ гангийн үйлдвэрлэлийн хэмжээ бол төдийлөн өсөхгүй байх ийм нөхцөлүүд харагдаж байна.

Нөгөө талаар бидний түрүүний дурдсанчлан эдийн засгийн бүтцийн хувьд болгоомжлох ёстой асуудал бол та бүхэн энэ Үндэсний статистикийн хорооноос гаргасан тоон мэдээлэл дээр ч гэсэн харах байх. Өнгөрсөн 2 жилд манай улсын экспорт нэмэгдэж байгаа гол өсөлт бол үндсэндээ ганцхан нүүрс дээр гарсан байгаа. 2021 онд нүүрс, нүүрс болон зэсийн баяжмалын экспортын орлого адилхан 2,9 тэрбум доллар байсан. Өнгөрсөн 2 жилд ерөөсөө нэмэгдсэн орлого нь ганцхан нүүрс дээр 6 тэрбум долларын орлого нэмэгдсэн байгаа. Тэгэхээр бидний нөгөө гол эрсдэл

нэмэгдээд байгаа экспортын орлого, үүнийг дагаж байгаа төсвийн нэмэгдэж байгаа орлого маань ганцхан төрлийн түүхий эд дээр байна. Энэ түүхий эдийн экспортын цаашидаа өсөх тал дээр 2 том өрсөлдөгч улс орон их хэмжээгээр нөгөө дэд бүтэц нь маш сайн хөгжсчихсэн байгаа учраас энэ дээр. Хэдийгээр бид нар нэмэгдүүлэх хүсэл эрмэлзэл, тэмүүлэл байгаа ч гэсэн зах зээлийн өрсөлдөөн нь маш ширүүн байна гэдгийг бид нар маш сайн анхаарах хэрэгтэй.

Энэ өдрүүдэд ОХУ-ын төр засгийн тэргүүн ч гэсэн энэ Хятад улсын Харбин хотод ажиллаад, Орос Хятадын форум зохион байгуулж байна. Хятадын бүх төр засгийн том бизнесменүүд тэнд очсон байна.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Тэмүүлэн дарга тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Ерөнхийдөө нэг их тодруулах зүйл байхгүй дээ. Би зүгээр Төсвийн хүрээний мэдэгдлийн энэ макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт тооцооллыг болбол бас манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болбол анх удаагаа боловсруулдаг болж байгаа. Би энэ болбол сайн жишиг гэж харж байгаа. Хуучин бол Төсвийн хүрээний мэдэгдлийг зөвхөн Сангийн яам боловсруулаад, өөрсдийнхөө боловсруулсан Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж эсвэл юу гэдэг юм тухайн ирэх жилийнхээ нэг жилийнхээ төсөвтөө нийцүүлж Төсвийн хүрээнийхээ мэдэгдэл буюу урт хугацаа, дунд хугацааныхаа бодлогыг оруулж ирдэг байсан жишгийг бид нар бас өнгөрсөн жилийн төсвийн шинэчлэлийн бодлогын хүрээнд өөрчилсөн.

Одоо болбол мэргэжлийн яам буюу мэргэжлийн байгууллага Эдийн засаг, хөгжлийн яам Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулдаг болж байгаа. Ингээд ирэх оны төсөв 9 сард өргөн баригдаж орж ирэхэд болбол Сангийн яам энэ Эдийн засгийн хөгжлийн яамны

боловсруулсан Төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж, дунд хугацааныхаа бодлогодоо нийцүүлж ирэх оныхоо төсвийг оруулж ирдэг болж байгаа. Нөгөө талдаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бол Эдийн засгийн хөгжлийн яаманд бас тодорхой макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг боловсруулахад нь хамтарч оролцдог, үндсэн үзүүлэлт.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Яах юм, хэн хариулах юм бэ? Ерөнхийдөө санал хэлж байгаа юм байна та. Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд асуултаа асууя. Ингээд санал хураалт явагдана, гишүүд танхимд байраа эзлээрэй.

Г.Ганболд: Ер нь асуултууд бараг давхцаж байна даа. Гол эрсдэл бол сонгууль л даа. Сонгуульд энэ улс төрийн намууд ямар мөрийн хөтөлбөр дэвшүүлэх нь одоогоор тодорхойгүй байна. Дараа нь энэ жилийн сонгууль болбол онцлог, бүс нутгийн хэмжээний хөгжлийн асуудал яригдана. Өмнө нь бид нар бол нэг жижигхэн сумын нэг сургууль, цэцэрлэг ярьж байсан бол одоо бүсийн том хөндлөн, босоо тэнхлэгийн замууд, хөрөнгө оруулалтын хэмжээ бүс нутгийн хэмжээнд бол асар том, том хөрөнгө оруулалтын юмнууд яригдаж ирэхээр эрсдэл үүсэх магадлал их өндөр.

Тэгэхдээ энэ дээр би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтүүдийг харлаа л даа. Тэгээд эдний дүгнэлтээр бол манайх бол нэг эдийн засгийн хувьд бол нэг айлаар яривал нэг малчин айл шиг л байгаа юм байна. Ноолуурын үнэ нэг жаахан өндөр, зуншлага гайгүй бол тэгээд л нэг жаахан тансаглаад л, тэгээд л зуд болох юм бол энэ жил ямар болж байгаа яг л тэрэнтэй адилхан. Нэг улсаас нэг бүтээгдэхүүнээс эдийн засаг маш их өндөр хамааралтай. Энэнээсээ болоод орлогоо хэт өөдрөгөөр төлөвлөсөн. Ирэх онд энэ Австралийн нүүрсний борлуулалт 15-аас 20 хувиар өснө, ОХУ-ын Сахагийн нүүрсний экспорт бас 15-аас 20 сая тонноор өснө

гээд нэлээн бодитой. Нөгөө талаасаа энэ Хятадын коксжих нүүрсний хэрэглээ буурах хандлагатай гээд ийм дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гаргасан байх юм. Тэгээд энийг манай Эдийн засгийн хөгжлийн яам хэр тооцоолсон бэ? Танайх ер нь хоорондоо энэ талаар санал бодлоо солилцож, энэ мэтгэлцээн явуулж, хэр бодитойгоор төлөвлөв гэдгийг асуух гээд байгаа юм.

2-т нь энэ валютын нөөцийг 10 тэрбум долларт хүргэнэ гээд. Цогц арга хэмжээ аваад энд 10 тэрбум долларт хүргэнэ гэсэн байх юм. Энэ цогц арга хэмжээ гэж яг ямар арга хэмжээг хэлээд байна вэ? Цогц арга хэмжээ, ямар арга хэмжээ төлөвлөж байж тэр нь амжилттай болох юм бол энэ хэрэгжих вэ?

Дараагийн асуудал нь энэ төсвийн зардал ДНБ-ий 38 хувь буюу хөгжиж байгаа улсуудын харьцуулах юм болбол 10 хувиар өндөр зардалтай байна гэж ингэж зөвлөлийнхөн дүгнэлт гаргасан байх юм. Энийг Эдийн засгийн хөгжлийн сайд яг хүлээн зөвшөөрч байгаа юу? Энийгээ ер нь бол бид нар энэ нэг улсаас хэт хараат байгаа энэ, нэг бүтээгдэхүүнээс хараат байгаа үед энэ төсвийн зардлаа жаахан бууруулж, эрсдэлээ жаахан хамгаалж явах тал дээр та яг ямар бодолтой байна вэ?

Дараагийн асуудал нь энэ инфляцыг бууруулна гэж тооцсон байна 1 хувиар, 2 хувь ч байсан уу. Тэгэхээр бид нар энэ дайн байлдаантай байгаа үед яг ямар арга замаар энэ инфляцыг бууруулах гээд байна вэ? Бид нарын нэг ганц чадах юм бол нэг махны үнээ л нэг экспортыг нь хязгаарлавал нэг барих байх. Бусдыг нь бол барихад төвөгтэй байна л даа. Тэвэр логиستيкийн асуудал нэлээн өндөр байна. Тэгээд энэ дээр яг ямар тодорхой арга хэмжээ авч, ямар арга замаар энэ инфляцыг, үнийн өсөлтийг бууруулах вэ, бууруулна гэж тооцож байгаа юм бэ? Тэрэн дээр яг Эдийн засгийн хөгжлийн яамныхан яг

ийм хууль тогтоомж гаргаж, ийм зүйлүүд дээр тодорхой арга хэмжээ авч байж бид нар инфляцыг бууруулна гэсэн тийм төсөөлөл яг байна уу?

Тэгээд энэ болгоноос хэдүүлээ ингэж төсөөлж байж явахгүй болбол бид нар ингээд хуулийн дагуу хавар төсвийн хүрээний мэдээлэл гээд Төсвийн хүрээний мэдээлэл мэдэгдлээ бол заавал хуулийн дагуу батална л даа. Тэгээд намар төсвийн төсөл орж ирээд, төсөл хэлэлцээд явах үед энэ маань ингээд л өөрчлөгдөөд явчихсан байж байдаг. Тэгээд энийг яг намар тогтвортой байна гэдэг дээр ер нь Эдийн засгийн хөгжлийн яам нь судалгаа, статистик, тоо баримт дээр бодож тулгуурлаж гаргадаг байлгүй. Хэр бодитой.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Монгол Улсын Шадар сайд Хүрэлбаатар хариулъя. Дараа нь санал хураалттай шүү.

Ч.Хүрэлбаатар: Ер нь бол Монгол Улс 10 тэрбум долларын валютын нөөцтэй болохыг зорьж ажиллаж байгаа юм. Валютын нөөц нэмэгдээд эхлэнгүүт Монголбанк нөгөө Хятадын Ардын банкнаас авсан зээлүүдээ бол аль хэдийн төлөөд эхэлчихсэн юм шүү дээ. Өнгөрсөн жил төлсөн, энэ жил дахиад үргэлжлүүлээд төлөөд явж байна. Өөрөөр хэлбэл энэ нэг жоохон боломж гараад байгаа дээр нь энэ урьд өмнө хуримтлагдчихсан байсан тэр Хятадын ардын банкны өрийг ч гэсэн төлөөд л, бусад бондуудаа бүгдийг нь цэгцлээд л явж байгаа. 24, 25 онд Монгол Улс гадагшаа төлөх бондын төлбөр бол байхгүй байгаа юм. Тийм учраас бид нарын хувьд бол экспортоо нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Тийм учраас бид нар 10 тэрбум долларыг зорьж ажиллаж байгаа.

Коксжих нүүрсний тооцоог бол бид нар нэлээн сайн үзсэн. Австрали бол Хятад руу бол коксжих нүүрс нь бол бага шүү дээ, маш бага. Оросуудаас ч гэсэн

Оросуудаас авч байгаа коксжих нүүрснийх нь хэмжээ нь бас бага Хятадын хувьд. Монголоос бол энэ нь орж ирж байгаа ийм байдаг. Зүгээр нэг зүйл нь Хятад Монголын хооронд худалдааны хэлэлцээр хийгдээгүй байгаа учраас манай эрчим хүчний нүүрс Хятад руу ороход бол 6 хувийн татвартай, коксжих нүүрс Хятадын зах зээл рүү ороход 3 хувийн татвартай бол байгаа.

Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яам Хятадын Хятад талд хандаад чөлөөт худалдааны хэлэлцээрүүдээ хийе гэдэг ийм хүсэлтийг бол өгчихсөн байгаа. Манай яам бол энэ коксжих нүүрсний экспорт дээр огт санаа юу гэдэг юм болгоомжлох зүйл бол байхгүй. Австрали, Оросыг нэг их өрсөлдөгч гэж үзэхгүй байгаа гэдгээ бол дахиад энд хэлье.

Ер нь цаашидаа бол бид нар энэ эдийн засгийн бүтэц ярьж байгаа болбол Монголчууд яах аргагүй бид нар гадагшаа гарах бүтээгдэхүүнээ зарах л ийм боломжуудыг бол яаралтай эрэлхийлэх учиртай юм байгаа юм. ОХУ руу Монгол хоёрын хоорондын худалдааг 100 хувь гээд үзэх юм бол 95 хувьд нь Оросууд Монголд бараагаа зардаг, 5 хувьд нь Оросууд Монголчууд Орост бараагаа зардаг ийм байгаа юм. Монголоос орж ирж байгаа бүтээгдэхүүн 60 юм уу, 60 хувийн татвартай гэдэг чинь маш их өндөр хэмжээний татвартай байгаад байгаа юм. Тийм учраас ЗГ ОХУ руу 375 барааг татваргүй, тоо хэмжээний хязгаарлалтгүй орох энэ гэрээ хэлцлийг бол хийгээд дуусгачихсан байна. Одоо баталгаажуулах түвшиндээ бол явж байгаа гэдгийг хэлье. Энэ өөрөө Монгол Улсын эдийн засагт бүтцийн өөрчлөлт оруулж ирэхэд бол чухал нөлөө үзүүлнэ.

Эдийн засаг, хөгжлийн яам мөн Өмнөд Солонгостой чөлөөт худалдааны хэлэлцээрийг ид хийгээд явж байна. Ингээд Хятадаас хийгээд ирэх юм болбол энэ хэлэлцээрүүдийг хийх юм бол манай

улсын эдийн засгийн бүтцэд бол өөрчлөлтүүд ороод ирэх боломжтой.

Инфляцыг бол ер нь 3 хувь хүртэл бол буулгах боломжтой гэж үзэж байгаа. 1 дүгээрт нь мөнгөний бодлого, 2 дугаарт нь тээвэр логистикийг бид нар маш сайн хийх ёстой. Дээд талд нь дотооддоо зам тээврийн асуудлуудыг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр үг хэлнэ. Үүний дараа санал хураалт явагдана, гишүүд байраа эзлээрэй.

Б.Баттөмөр: Төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэж тухайн жилийн төсвийг хийдэг учраас чухал баримт бичиг. Тийм учраас бол энэ дээр бид их анхаарал хандуулах ёстой гэж.

Энэ орлогыг нэмэгдүүлэх, зардлыг багасгах болбол мөнхийн сэдэв. Бид нар шиг гадна, дотнын зээл тусламжаар бүтээн байгуулалтаа хийчхээд, өөрснөө олсныгоо идчихдэг ийм улс бол ховор шүү дээ. Манай эдийн засаг болбол нэг улсаас, нэг бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа шүү дээ. Тийм учраас бол эрсдэл аягүй өндөр байгаа. Тийм. Бид хуримтлалтай болох ёстой. Алийн болгон гаднын зээл, тусламжаар асуудлаа шийдэх вэ. Хуримтлалтай болж, хөгжилдөө бага ч гэсэн хөгжилдөө хөрөнгө оруулах хэрэгтэй. Эдийн засгийн өсөлт бий болдог тэр салбаруудад. Энийг бид олох ёстой гэж 1 дүгээрт.

2 дугаарт энэ хуримтлалтай болъё гээд байгаа нь бол энэ ядуурлын бууруулах. Энэ чинь 28 дээр нэмэх нь 15, 42 хувийн асуудал яригдаж байгаа шүү дээ. Өвчлөл байна. Олон өвчлөлөөр дэлхийд тэргүүлж байгаа. Эрүүл мэндийн шинжлэх ухааны ололтыг Монголд нэвтрүүлэх шаардлагатай. Дундаж давхарга болбол байнга буурч

байгаа. Ийм, ийм асуудлуудад бид нар хөрөнгө оруулах ёстой гэж. Энэ халамжаас хөдөлмөрт шилжих бодлого болбол мөнхийн сэдэв. Тэгээд энэ халамж хэтэрхий их ихсээд байгаа чинь болбол хөдөлмөр эрхлэлтэд бол сөргөөр нөлөөлж байгаа гэдгийг.

Энэ Баялгийн сангийн хуулийг сая 10-аад хоногийн өмнө баталсан. Үндсэн хуулийн 6.2 хэрэгжих ёстой энэ үндсэн дээр. Тэгээд нийт төсвийн бүрэлдэхүүн хэсэгт л орж явна л даа. Өөрөөр хэлбэл миний ойлгож байгаагаар бол Хөгжлийн сангаас бусад нөгөө 2 нь бол төсвийн бас нэг бүрэлдэхүүн хэсэг байна байх. Тийм учраас энэ дээр бид нар анхаарч, энэ Баялгийн сангаа мөнгөжүүлж, тодорхой үүргийг нь гүйцэтгэх энд төсвийн төлөвлөлт их чухал гэж бодож байгаа.

Энэ Монголд гаднын төслүүд маш их байна, хэрэгждэггүй. Сая миний тэр асуусан тэр Мянганы зорилтод суурилсан төсөвлөлтийг боловсронгуй болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гээд л. Тэгээд энэ, энэ тэр юу гэж зөвлөдөг юм бол доо, яаж энэ төсөвтөө тусгадаг юм бол доо гээд асуугаад, хариулт авсангүй л дээ.

Энэ ашигт малтмалын энэ уул уурхайн биржийг бид нар баталсан. Би бас нэг удирдаж баталсан хүний нэг нь юм байгаа юм. Монголын эдийн засагт үнэхээр ач холбогдлоо өгч байгаа. Боловсронгуй болгох юм бас байна. Монголоос гарч байгаа бүх ашигт малтмал уул уурхайн биржээр гарах ёстой. Сүүлийн үед юу ажиглагдаад байна вэ гэхээр хэдэн нүүрс дээр нэг хэдэн компаниуд орж ирээд бас нэг тийм үнийг нь өсгөхгүй байна уу гэсэн тийм хардлага бол байгаад байна. Хоорондоо яриад байдаг ч юм уу, яадаг ч юм. Тийм учраас энэ нөлөөллүүдийг багасгах боломжууд юу байдаг юм бол. Сая яах вэ Эрдэнэтийн зэсийг арилжиж эхлэх гэж байгаа юм байна. Оюу толгойн зэсийг бас худалдах ёстой. Ер нь бүх ашигт малтмалын бүтээгдэхүүнийг худалдах

ёстой. Тэр БНХАУ-тай тэр худалдааны хэлэлцээрийг хийгээд тэр 3, 6 хувийн татвараа тэглэх энэ ажлыг хийх ёстой гэж.

Далд эдийн засгийг ил болгох ёстой. Далд эдийн засаг бол асар их байгаа шүү энийг хийх ёстой. Зардал бууруулах ёстой. Цахимжиж байна гээд л бид нар их маш их арга хэмжээ аваад л байгаа. Тэр хэмжээгээр зардал бол буурах ёстой.

Энэ банкны шинэчлэлүүдийг бас бид нар хийх ёстой юм байна. Энэ мөнгөний бодлого, төсвийн бодлого, хөгжлийн бодлого 3 хоорондоо уялдаж, энэ макро эдийн засгийн тогтвортой байдал гэдэг юм руу л бид нар сайн ярьж бодож л явахгүй л болбол 22 хувийн хүүтэй, 20 хувийн хүүтэй зээл аваад бизнес хийнэ гэж бол байхгүй шүү дээ. Бизнесийг бол зээл авч хийдэг. Өөрийн мөнгөө бол хөрөнгө оруулалт хийдэг ийм л зарчим байгаа шүү дээ. Тийм учраас энэ банкны шинэчлэлийг хөгжлийн бодлоготойгоо нэлээн уялдуулах ийм шаардлага болбол байна гэж ингээж үзэж байгаа юм.

Гаднын банкнуудыг оруулж ирнэ гээд л яриад байгаа. Түрүүн нэг оруулж ирээд, манай сайд нар дэмжээгүй шүү, энийгээ сайн өөрснөө мэдэж байгаа юм байгаа биз дээ. Танай банканд хөрөнгө оруулалт хийе гээд ингээд нэг хуулийн заалтыг өөрчилжэ гэсэн дэмжээгүй.

Оюун толгойн төсөл бол Монголын энэ уул уурхайн салбарын өсөлтийн 1/3-ийг эзэлнэ гээд энд биччихсэн байгаа. Тэгээд энэ маань хэр зэрэг үр өгөөжтэй байх юм даа. Оюу толгойн худалдааны гэрээ, ашигт малтмалын тэр бүтэц, татварын маргаан гээд асар олон асуудлууд байгаа шүү. Энийг бид шийдэх ийм.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Баагаагийн

Баттөмөр гишүүн үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураая. Санал хураалт. 51,3 хувиар санал дэмжигдлээ. Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. Ажлын хэсэгт баярлалаа.

17.31 цаг

Дараагийнхаа асуудалд оръё. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлэе. Ажлын хэсгийг оруулаарай. Хууль санаачлагчийн илтгэлийг ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун танилцуулна. Байна уу? Сайд нь алга байна. Асуудлыг хойшлууллаа.

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлэе. Хууль санаачлагчийн илтгэлийг Салдангийн Одонтүяа танилцуулна. Хууль санаачлагч алга байгаа учраас хойшлууллаа.

Ес.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа оръё. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай

хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье. Хууль санаачлагчийн илтгэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар танилцуулна. Ганбаатар сайдыг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай. Дараа нь Баделхан гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна тийм ээ, бэлэн байгаа. Баделхан гишүүн маань бол бэлэн байна. Ажлын хэсгийг оруулаарай.

Ж.Ганбаатар: Гишүүдийнхээ энэ оройн амгаланг эрье. Бүгд Найрамдах Энэтхэг улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй дотоодын түүхий эдэд тулгуурласан Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн бүтээн байгуулалт 16, үйлдвэрийн тос дамжуулах хоолойн угсралтын ажил 39 хувьтай гүйцэтгэлтэй явж байна. Үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн асуудалд Улсын Их Хурал, ЗГ-аас онцгойлон анхаарч ЗГ-ын 2021 оны 8 сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст 31 талбайг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-д олгосон бөгөөд уг талбайд өмнө хийгдсэн хайгуул судалгааны ажлын анхдагч мэдээлэл, геологи геодезийн өгөгдөл тайлал хийж, газрын тосны хэтийн төлөвт урьдчилсан байдлаар үнэлгээ хийн ажиллаж байна.

Монгол Улсын газрын тосны олборлолт 2015 онд нэг аравны 1,2 сая орчим тоонд хүрч байсан бол сүүлийн жилүүдэд олборлолтын хэмжээ буурч, 2023 онд 600 орчим мянган тонн газрын тос болж буурсан. Голлох олборлолт хийгдэж буй Тамсаг, Тосон-Уул ордын жилийн олборлолтын хэмжээ 700 мянгаас 400 мянган тонн хүртэл буурах төлөвтэй байгаа нь үйлдвэрлэл ашиглалтад орох үед түүхий эдийн тогтвортой хангамжид эрсдэл үүсгэхээр байна. Газрын тосны хайгуул, олборлолт, хөрөнгө оруулалтын зардал ихээхэн шаарддаг эсвэл өндөр, эрсдэл өндөртэй үйл ажиллагаа бөгөөд газрын

тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд Монголын Газрын тос боловсруулах үйлдвэрийн зүгээс Давст 31 талбайд хөрөнгө оруулалт, хамтран ажиллах тухай урилгыг олон улсын 50 компанид хүргүүлсэн боловч санал ирүүлээгүй байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн тухай хуулийн 21.1-д албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө, 21.1.4-д газрын тосны үйлдвэрлэл бүтээгдэхүүн хуваах гэрээний тус тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчид нь өөрт ноогдох бүтээгдэхүүний олборлолтоос олсон энэ хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого гэж тус тус заасан. Үүнд нийцүүлэн ЗГ-аас олгосон Давст 31 талбайд хөрөнгө оруулалт хийж, газрын тосны хайгуул, ашиглалт, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-тай хамтран ажиллах хөрөнгө оруулагч компанийг Монгол Улсад бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн нэгэн адил ААНОАТ-аас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх бодит шаардлага тулгарч байна.

Дээрх хэрэгцээ шаардлагын хүрээнд ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар Давст 31 талбайд хөрөнгө оруулагчтай хамтран хайгуулын ажлыг эрчимтэй явуулж, газрын тосны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хэсгийг өөрийн олборлосон газрын тосоор хангахад томоохон дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой юм.

Эрхэм гишүүд ээ, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганбаатар сайдад баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 3Г-аас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Давст 31 талбайд Монголын газрын тос боловсруулах үйлдвэр төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг хэвийн явагдах түүхий эдээр тасралтгүй хангах боломжийг бүрдүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулагч компанийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх нөхцөлийг бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгч талтай адил байхаар тогтоож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх замаар татварын таатай орчныг бий болгох нь зүйтэй гэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир газрын тосны үйлдвэр байгуулагдаад ашиглалтад орох хугацаа 2 дахь үед гол түүхий эд болох газрын тосны бүтээгдэхүүний олборлолт буурч байгаа шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал газрын тосны баталгаат нөөцийг нэмэгдүүлэх боломж, газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээний үндсэн зарчим, урьдчилсан нөхцөл, гэрээ хэлцлийн бэлтгэл ажлын түвшинд тохирсон санал

болон гэрээний нөхцөл нь улсын Монгол Улсын эрх ашгийн, ашгийг бүрэн хангаж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонход дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Сандагийн Магнайсүрэн, ашигт малтмалын газрын тос, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Лхамсүрэнгийн Баярмандал, Сангийн яамны татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, АМГТГ-ын Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга Бандийн Түвшинжаргал, Газрын тос боловсруулах үйлдвэрт ТӨК-ийн захиргааны газрын дарга Очирын Энхбаяр, Энхбаяр, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн Төлөвлөлтийн инженерийн албаны дарга Амаржаргалын Баяржаргал, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн Газрын тосны хайгуул, ашиглалтын газрын дарга Даваагийн Буян-Арвижсх, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨК-ийн Гэрээ, эрх зүйн газрын дарга

Уранбаатарын Чинзориг нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Ганболд гишүүнээр тасаллаа. Гочоогийн Ганболд гишүүн. Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Хуулийн төслийг бол дэмжиж байна. Тэгэхдээ энэ зөвхөн энэ Монгол газрын тос ТӨК-тай гэрээ байгуулсан гаднын хөрөнгө оруулагчид дээр л хамааралтай байна уу? Ерөөсөө Монгол Улсын хэмжээнд хайгуул хийж байгаа бүх гаднын хөрөнгө оруулалттай компани дээр энэ татварын хөнгөлөлт эдлэхээр байна уу? Энийг нэг тодорхой болгож асууя.

2 дугаарт нь энэ нь Петро Чайна Дачин Тамсагийн энэ олборлож байгаа түүхий нефть 1 сая 200 мянган тонн байснаа 600 мянга руу буугаад ирж байгаа яг үндсэн шалтгаан нь яг юу байна вэ? Энийг яг нарийн тодруулж, олборлолтоо яагаад бууруулаад байна уу, эсвэл яг нөөц нь багасаад байна уу? Энэний шалтгааныг нэг тодорхой сайд нэг хэлж өгөөч.

Нөгөө талаас энэ орон нутагт ч гэсэн их мэдээлэл их бүрхэг байх юм. Энэ Дорнодод олборлож байгаа газрын тостой холбоотой энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөл, тэгээд олж байгаа орлогын талаар нэг иргэдэд жоохон тодорхой мэдээллүүд өгч байхгүй бол тэрнээс нэг юу ч авахгүй тэгээд л ингээд л бүгдийг нь урагш нь зөөгөөд дуусаж байгаа юм шиг ойлголтууд энэ орон нутгийн иргэдэд асар их байх юм. Тийм ойлголтыг ч гэсэн ер нь сөрөг хүчний зүгээс энэ янз бүрийн энэ төрийн бус байгууллагууд энэ жагсаал цуглаан хийдэг нөхдүүд их өгөх юм нийгэмд. Тэгээд энэ дээр ер нь бол яамны зүгээс нэг нэлээн тодорхой ойлголтуудыг нийгэмд өгөх зайлшгүй

шаардлага байгаа юм байна лээ шүү гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад санал хэллээ. Асуулт байгаа юу? Ганболд гишүүний асуултад хариулъя. Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Яг эхлээд тэр асуусан асуулт нь манай хэн Төрийн нарийн бичгийн дарга эхний асуултад нь хариулчхаарай. Хоёрдугаарх асуултад нь хариулахад бол 1 сая 200 мянга байж байгаад яагаад 700 мянга руу буучлав. Энэ жил ер нь бараг 400 мянга, 500 мянга руу хүрч буух төлөвтэй байна. Энэ 5 сарынхаа байдлыг харж байхад. Тэгээд гол шалтгаан бол энэ CNPC гээд энэ Петро Чайна компанийн толгой Хятадын хамгийн том хөрөнгө юу улсын компани байгаа. Энэ компанийн хувьд бол Ганболд гишүүнээ хөрөнгө оруулалтаа эрс татаж байгаа. Энэ газрын тосыг чинь олборлохын тулд.../үг тасрав/

Л.Мөнхбаатар: Чинзориг сайд суугаарай.

Ж.Ганбаатар: Хажуу талд нь ахиад юу цооног өрөмдөж байж тэр лүүгээ тодорхой хэмжээгээр хөрөнгө оруулалт хийж байж тэр газрын тос маань дээшээ гардаг. Тэгээд яагаад хөрөнгөө татаж байна гэхээр энэ Монгол улсад энэ үйлдвэрийн талаар явуулж яаж байгаа дэмжлэг үнэхээр дутагдалтай байна. Та өөрөө мэдэж байгаа. Орон нутгийн асуудлууд байна, төрийн бус байгууллагуудын асуудлууд байна. Адаглаад энэ үйлдвэрийн даргын хилээр гаргахыг нь хорьчихож байна. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагаас дансыг нь хаачхаж байна. Энэ, ер нь бол Петрочайна компанийн толгой компани маань хөрөнгө оруулалтаа Орос руу шилжүүлж байгаа юм байна лээ. Ерөөсөө гол шалтгаан энэ.

Тэгээд бид нар ер нь яаж байгаа вэ гэхээр энэ 15 талбайг 2018 оноос хойш

хайгуулын чиглэлээр олон улсад тендер зарласан байгаа юм. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд хайгуул хийгээд өгөөч гээд. Үүгээр бол ер нь бол орж яг сонирхож байгаа компани бол одоогоор байхгүй байна. Тэгэхээр үнэхээр бид нарт бол хүндрэл үүсэж байгаа. Тэгээд энэ газрын тосны үйлдвэрийн хувьд бол Энэтхэгийн компани хайгуул хийе гэсэн ийм санал тавьсан юм байна лээ. Тэгээд газрын тосны үйлдвэрийн хувьд бол өөрөө бас нэг Энэтхэгийнхээ компанитай бас тодорхой хэмжээнд ийм бүтээгдэхүүн хуваах гэрээ хийгээд, ЗГ орж батлуулаад, тэгээд нэг үзье гэсэн ийм бодол бол байгаа юм байна.

Ер нь бол яг бодит байдал бол үнэхээр энэ газрын тосны үйлдвэрийн нөөцийн хувьд бол бид бас орон нутагтаа, иргэддээ ойлгуулах талаар бол ажиллаад л байна, ажиллаад л байна. Тэгээд асуудал бол байна л даа. Ерөөсөө яг бодит асуудал, бодит байдал бол энэ байна. ТНБД эхний асуултад хариулчихъя.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулъя. Магнайсүрэн дарга хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофоныг өгье.

С.Магнайсүрэн: Ганболд гишүүний асуултад хариулъя. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах үйлдвэрийг дэмжих талаар Их Хурлаас ЗГ-аас онцгойлон анхаарч, энэ газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих хууль батлагдсан. Энэ хуульд бол 2 үндсэн зарчим тусгагдсан. 1 дүгээрт бол ТӨК-д газрын тосны хайгуул ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбайг давуу эрхээр олгох, 2 дугаарт нь хайгуул ашиглалтын үйл ажиллагааг гадаад, дотоодын ААН-тэй хамтран явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн ийм 2 үндсэн зарчим бол суусан. Энэ хүрээнд Монгол Монголын газрын тос, Монгол газрын тос боловсруулах үйлдвэрт энэ яригдаад байгаа талбайг болбол давуу эрхээр олгосон. Ингээд давуу эрхээр олгосон талбайдаа ингээд

олон улсын томоохон 40 гаруй компанид урилга хүргүүлээд сонгон шалгаруулалт явуулахаар оролдсон боловч сонирхогч байгаагүй.

Ингээд тэд нарын яагаад сонирхогч байгаагүй талаар шалтгааныг нь судлахаар зэрэг Бүтээгдэхүүн хуваах гэрээтэйгээ адилхан тийм татварын хөнгөлөлт эдлүүлэх юм болбол зарим талаар хөрөнгө оруулж болох юм гэдэг ийм саналууд давамгайлсан юм билээ. Ингээд Сангийн яамтай бид нар энэ татварын хуулийн эрх зүйн орчныг яриад Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй гэрээ болон ТӨК-тай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээг Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй адилхан энэ татварын нэг ижил орчинд адилхан авч үзэх юм болбол илүү эрх зүйн тийм боломжтой орчин бүрдэх юм байна гэж үзээд өнөөдрийн энэ хуулийн нэмэлт орж ирж байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Төмөртөгоогийн Энхтүвшин асуултаа асууя. Үүний дараа санал хураалттай гишүүд байраа эзлээрэй.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Бид ингээд газрын тосны үйлдвэртэй болох гэж байна. 2026 онд гэхэд Монгол Улсад ямар ч байсан газрын тосны боловсруулах үйлдвэр ашиглалтад орно. Ажил нь нэлээн эрчимтэй явагдаж байна. Тэгээд харамсалтай нь юу гэдэг юм бид нар газар доорх баялгаа мэдэж чадахгүй байна, хайгуулаа хийж чадахгүй байна гээд. 2022, 2023 оны төсвийн төсөв хэлэлцэж байхад л энэ асуудлыг ярьсан. Бид ядаж боловсон хүчнээ бэлдэх хэрэгтэй байна. Ядаж бид нар 1 юм уу, 2 өрөмтэй болмоор байна, энэ төсөв хөрөнгийг нь суулгаж өгөөч гэдэг ийм асуудлыг тавьж байсан. Тэгээд харамсалтай нь энэ мөнгө төгрөг нь бол шийдэгдээгүй л дээ.

Монгол Улсад бол газрын тос зөндөө байгаа. Сулиа хээрийн сав газар, Тариачны сав газар, Давст гээд,

Хатанбулаг, Ханбогдын сав газар ч гэдэг юм уу ингээд зөндөө газрууд байж байгаа. Хамгийн гол нь л бид нар энэ хайгуулаа хийх ажлыг л эрчимжүүлэх зайлиггүй шаардлага байгаад байгаа юм. Тэгээд газрын тосны үйлдвэр ашиглалтад ордог, бид тосоор хангаж чадахгүй бол эдийн засгийн хувьд бол маш их хохирол дагуулна. Тийм учраас энэ хуулийг би орж ирж байгаад бас дэмжиж байна.

2 дахь асуудал юу гэдэг юм энэ газрын тосны хайгуул хийх гээд сонгон шалгаруулалт сонгон шалгаруулалтад юу гэдэг юм ялагчаар тодорсон энэ гадаад, дотоодын компаниудыг яаралтай хайгуулыг нь хийлгэх хэрэгтэй. Урьж, олон нийтэд танилцуулж, хайгуулыг нь хийх бүх бололцоо боломжоор нь бол Газрын тосны хэрэг эрхлэх газар бол энэ бололцоо боломжийг нь бий болгож өгөх хэрэгтэй. Ингэж байж бид нар юу гэдэг юм дотоодынхоо үйлдвэрийг л газрын тосны бүтээгдэхүүнээр хангах ийм бололцоо боломж бас бүрдэх юм.

Тэгээд энэ хууль бол юу гэдэг юм жоохон оройтож орж ирж байна оройтож. Мэдсэн бол юу гэдэг юм энийг 2 жилийн өмнө энийг гаргаад ингээд хайгуулаа эрчимжүүлсэн бол өдийд нэлээдгүй үр дүн гарчихсан байх ёстой болов уу л гэсэн бодолтой байж байна. Тэгээд энэ хуулийг дэмжиж байна. Энэ нэлээн цаг үеэ олсон ийм хууль орж ирж байна гэж үзэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Санал хураалт явагдъя, байраа эзлээрэй гишүүд. Байнгын хорооны саналаар Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураая. Санал хураалт. Байраа эзлээрэй. Санал хураалт. 59 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

17.49 цаг

Арав.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараа нь, дараагийн асуудал. Энэ юуг нь хэлэлцчихье дээ. Хөдөө аж ахуйн яамны ганц асуудал байгаад байгаа юм. Энийг нь явуулчихъя. Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцье. Хууль санаачлагчийн илтгэлийг ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун танилцуулна.

Х.Болорчулуун: Мал, амьтан, мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнийг зооноз гэх бөгөөд дэлхий дээр 1500 орчим хүний халдварт өвчин бүртгэсэн 60 хувь нь зооноз өвчин байна. Жил бүр хүний 4-өөс 5 халдварт өвчин шинээр бүртгэж байгаагаас 3-аас 4 буюу 75-аас 80 хувь нь амьтнаас хүнд халдварлаж байгааг судалгаагаар тогтоосон. Нийт зооноз өвчин 60 хувь нь сүүлийн 20 жилд шинээр бүртгэсэн зооноз өвчний 80 хувь нь вирус үүсгэдэг байна.

Монгол Улс хүний болон мал, амьтны зориулалттай эм, био бэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж байна.

Эмийн тухай хууль 1998 онд батлагдаж, 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч зарчмын хувьд мал амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн талаарх зарчмын суурь зохицуулалт хяналтын шалгалтын, хяналт шалгалтын талаар бүрэн тусгагдаагүй болно.

Түүнчлэн Монгол Улс 1989 онд ДМАЭМБ 1997 онд ДХБ-ын гишүүнээр элссэн бөгөөд гишүүн орны хувьд дээрх байгууллагуудын батлан гаргасан стандарт, удирдамж, заавар, зөвлөмжид нийцүүлэн үндэсний бодлого, хууль тогтоомжийг өөрчлөх, шинээр боловсруулах үүрэг хүлээсэн байдаг. Одоо мөрдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд хүний эмнэлгийн зориулалттай эм түүний дотор уламжлалт эм, био бэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулалтыг нарийн тусгагдсан бөгөөд мал амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйжлийн бэлдмэл тэжээлийн нэмэлтийн талаарх зохицуулалт бүрэн тусгагдаагүй байдаг.

Дэлхий дахинд мал, амьтны эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байгаа нь мал амьтны өвчний оношилгоо эмчилгээний шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн худалдаа, хангамж, эмийн бүртгэл, баталгаажуулалт, эмийн нэгдсэн цахим бүртгэлийг нэвтрүүлэх эмийн зохистой хэрэглээ, төрөөс баримтлах зарчим, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйжилтийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөлд олгох

хяналт шалгалт зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь тусгах хэрэгцээ шаардлага бий болоод байна. Иймд дээрх зориулалтыг тусгасан Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийг 7 бүлэг 24 зүйлтэйгээр Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомж батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан болно.

Хууль батлагдсанаар эмийн чанар, аюулгүй байдал, хангамж сайжирч, хүнсний аюулгүй байдал хангахад төр болон хувийн хэвшлийн үүрэг хариуцлага нэмэгдэнэ. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага болон бусад олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах бодлого, чиглэл, стратегийн үйл ажиллагааг тодорхойлох эрх зүйн орчин бүрдэнэ. Мал, амьтны гоц халдварт халдваргүй шимэгчлэх өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээний үр дүн сайжирч, мал амьтны өвчний гаралт, тархалт, өвчлөл буурч хүн ам, мал, амьтны эрүүл мэндэд учрах эрсдэл бууруулна. Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Болорчулуун сайдад баярлалаа. Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгт танилцуулна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 5 дугаар

сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч мал, амьтны эмийн зохицуулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын хяналтын болон үйл ажиллагааны чиг үүргийг тодорхой болгох, эмийн чанар, аюулгүй байдал, хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн хувийн хэвшлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх. Мал, амьтны гоц халдварт, халдварт, халдваргүй, шимэгчлэх өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулах мал, амьтны өвчний гаралт, тархалт, өвчлөлийг бууруулах, мал, амьтны эрүүл мэндэд учруулах эрсдэлийг бууруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын *d.parliament.mn* сайтад байршуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар хуулийн төсөл батлагдсанаар гарах үр дүнгийн талаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн мал, амьтны эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулах, чадавхжуулах зохицуулалтыг тусгасан эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Батжаргал малын эм бэлдмэлийн чанарын асуудлыг эргэн харах, мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын чиг баримжааг харгалзаж тухайн импортлогч оронд хүлээн зөвшөөрөгдсөн эм био бэлдмэлүүдээр малаа эрүүлжүүлэх тухай Монгол мал эрдэс, амь дэм, уургийн дутагдалд ороод давжаарч байгаатай холбогдуулан тэжээлийн нэмэлтэд онцгой анхаарах талаар санал хэллээ. Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн

хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, тухай хуульд, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Саранчимэг гишүүнд баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, ХХААХҮЯ-ны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Хөхөөгийн Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Бямбын Болдбаатар, Мал эмнэлгийн ерөнхий газрын статистик дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Сандагийн Батхуяг нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Саранчимэг гишүүн асуух юм уу? Саранчимэг гишүүн татаж авлаа. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны саналаар Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Санал хураалт гишүүдээ, байраа эзэлье. Учрал сайд суугаарай, Тэмүүлэн дарга сууя. Сарангэрэл гишүүн. Санал хураалт байраа эзлээрэй. 60,5 хувиар санал дэмжигдлээ. Санал дэмжигдлээ.

18 цаг болсон байна. Өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаагүй байгаа тул асуудлаа хэлэлцэж дуусах хүртэлх хугацаагаар сунгалаа.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ. Ургамлынх дараа нь болно, үгүй.

18.00 цаг

Арван нэг.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Одоо гаалийн асуудал байсан байх тийм ээ. Гишүүд суугаарай. Дараагийн асуудалдаа оръё. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ. Төсвийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар эрх зүйн дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4.23 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 6 дугаар тогтоолоор баталсан хууль зүйн дүгнэлт гаргах журамд заасныг баримтлан эрх зүйн дүгнэлт гарган ирүүлсэн.

Төсвийн байнгын хорооны 2024 оны 3 дугаар тогтоолоор хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Б.Пүрэвдорж нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэсгээс төслийн 1 дүгээр зүйлийг оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал гэж өөрчлөн найруулах, мөн хууль хоорондын нийцлийг хангах үүднээс ЗГ-т чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан батлуулах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны

хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 2 санал байна. Гишүүд байраа эзлээрэй. Гишүүд байраа эзлээрэй. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.23 дахь заалт нэмсүгэй:

38.1.23.оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материал.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Хүрэлбаатарын Булгантуяа, Бөхчулууны Пүрэвдорж цаашид Ажлын хэсэг гэнэ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.19-д” гэсний дараа “38.1.23-т” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 2 зүйл байгаа. Энэ эхнийхээ юуг хураачихъя. 25 оноос юм байна. 1 дүгээр санал хураалтыг танилцуулсан байгаа. Санал хураалтаа

явуулчихъя. Санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.19-д” гэсний дараа “38.1.23-т” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 56,4 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

18.05 цаг

Арван хоёр.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд оръё. Дараагийнхаа асуудалд оръё. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 5 дугаар сарын 3-ны

өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Хэдэн асуулт байна гэнэ вэ? Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

18.07 цаг

Дараагийнхаа асуудалд оръё. Ургамлын асуудал байгаа. Ургамлын асуудлаа явуулчихъя. Алийг нь оруулах юм

бэ. Яах вэ дарааллынхаа хувьд ургамал нь угаасаа өмнө байгаа юм.

Арван гурав. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийнхаа асуудалд орёё. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн.

БОХХАА-н байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 02 дугаар тогтоолоор дээрх хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Наранбаатараар ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Ганболд, Ганибал, Идэрбат, Саранчимэг, Туваан, Энхтүвшин нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа. Тус Байнгын хороо

2024 оны 5 сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, ургамал хамгааллын салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох гэж нэмэхээр, төслийн хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тавигдах шаардлага гэсэн 10 дугаар зүйлийг 11 дүгээр зүйлтэй нэгтгэн хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ болгон өөрчлөн найруулахаар, хорио цээртэй хөнөөлт организмын тандан судалгааг байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан холбогдох эзэн төрөл, зүйл байхгүй нь нотлогдсон байршилд тандан судалгааг хийх шаардлагагүй гэсэн зохицуулалтыг төслөөс хасах зэрэг төслийн талаар зарчмын зөрүүтэй 16, найруулгын шинжтэй 4 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар 11 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүд асуулт, санал гаргаагүй болно. Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн, санал хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, ХХААХҮЯ-ны Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Нофын Оюунсувд, ХХААХҮЯ-ны Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын хэлтсийн дарга Эмээлийн Уламбаатар, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дарга Мижидсүрэнгийн Бямбасүрэн, ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Газар тариалангийн бодлогын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Базаррагчаагийн Уранчимэг, ХХААХҮЯ-ны Бордоо, ургамал хамгаалал хөдөө аж ахуйн зохистой дадлын асуудал хариуцсан мэргэжилтэн Норовсүрэнгийн Отгонбаяр, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын Ургамал хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч Пүрэвсүрэнгийн Болд-Эрдэнэ нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураая. Нийтдээ 31 санал байна. Санал хураалтаа явуулъя гишүүдээ.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн

найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. БОХХАА-н байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх санал, 1. Чуулганы хуралдааныг бол сунгаж хуралдаж байгаа. Тийм учраас Чинзориг гишүүн маань бол чуулгандаа отгон чуулгандаа их идэвхтэй оролцох талаар Их Хурлын дарга өглөө үүрэг чиглэл өгсөн байгаа шүү Чинзориг сайдад.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “худалдааг дэмжих” гэснийг “худалдааны чөлөөт байдлыг дэмжих” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар, Ганболд, Ганибал, Идэрбат, Саранчимэг, Туваан, Энхтүвшин. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3.2 дахь хэсгийг хасах:

“3.1.Энэ хууль ургамлын эрүүл мэндийг хамгаалах, ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалтаас сэргийлэх, түүнтэй тэмцэх, устгахтай холбоотой үйл ажиллагаанд үйлчилнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.1.“ургамал” гэж байгалийн болон таримал бүх төрлийн ургамал, түүний үр, бусад ургал эрхтнийг;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Ургал эрхтэн гэдэг нь танай хуульд байдаг нэр томъёо юм уу? Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Энэ хуулийн 6.1-д заасан хөнөөлт организмтай тэмцэх, ариутгах, халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээний зааврыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлан энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санд байршуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал дэмжигдсэнгүй уналаа. 4 дүгээр зүйл уналаа, цаашаа явах уу? Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут горимын санал гаргая.

Д.Батлут: Дэмжиж санал өгсөн боловч санал дээр энэ тоног төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалтыг явуулъя. 5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн” гэснийг “шаардлагатай тохиолдолд лабораторид хүргүүлэх, шинжилгээний дүгнэлтэд үндэслэн” гэж өөрчлөн, 7.4 дэх хэсгийн “нийтэд” гэсний өмнө “энэ хуулийн 22.1-д заасан албан тушаалтан” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 10 дугаар зүйл болон 11 дүгээр зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Хорио цээрийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

10.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга ургамал хамгааллын асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран хөнөөлт организмын төрөл, зүйлээс хамааран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, орох, гарах хяналтын цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлийг тогтоож, анхааруулсан тэмдэг байршуулна.

10.2.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт тухайн шатны Засаг дарга дараах арга хэмжээг зохион байгуулна:

10.2.1.хорио цээртэй хөнөөлт организмын төрөл, зүйлийг тодорхойлох, голомт, тархалтыг тогтоох, хязгаарлах, устгах;

10.2.2.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, орох, гарах хяналтын цэг, хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн байгууламжид хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналтын доор мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт, устгалыг хийлгэх;

10.3, 10.2.3.хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах.

10.3.Хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах зардлыг энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан тухайн шатны Засаг дарга, 9.1.3-д зааснаар хорио цээр тогтоох тохиолдолд Засгийн газар тус тус шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Нэг агентлаг байгуулагдаж байгаа юм даа тийм ээ? Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэдэг маань одоо агентлаг байгуулагдах юм байна шүү дээ тийм үү энэ хуулиар, за. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэснийг “хийхэд холбогдох стандартыг баримтална” гэж

өөрчилж, 14.3 дахь хэсгийг хасаж, тайлбарыг 15.4 дэх хэсэгт шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “газар нутагт” гэсний өмнө “, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийн “төрийн бус байгууллага” гэсний дараа “, хуулийн этгээд” гэж нэмж, 19.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19.6, 19.7 дахь хэсэг болгох:

“19.6.Пестицидийг турших, бүртгэх, ашиглах, импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдахтай холбогдсон харилцааг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиар зохицуулна.

19.7.Пестицидийн хаягдал болон сав, баглаа боодлыг эгүүлэн татах, устгахтай холбогдсон харилцааг Хог хаягдлын тухай хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9.7 дахь заалт нэмж, 19.9.4, 19.9.5 дахь заалтын “байгаль орчны” гэсний дараа “нөлөөллийн” гэж тус тус нэмэх:

“19.9.7.ургамал хамгаалал, хорио цээрийн мэргэжилтэй, эсхүл энэ чиглэлээр мэргэшсэн агрономичтой болохыг нотлох дипломын хуулбар, нийгмийн даатгалын лавлагаа.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй уналаа. Та гаргах юм уу? Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ горимын санал гаргая.

Б.Бат-Эрдэнэ: Энэ саналыг хүчингүй болгох, санал хураах ийм санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийн гаргасан горимын саналаар 10 дахь санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргая.

Н.Энхболд: Би уг нь сая дэмжсэн юм даргаа. Тэгээд эсрэг гарчихсан байна. Дахиад санал хураалт явуулж өгөхийг хүсье. Хүчингүй болгоод дахиад санал хураалт.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд жаахан анхааралтай байгаарай. Хэлэлцэх асуудал олон байгаа шүү. 55,3 хувиар санал дэмжигдлээ. Үндсэн санал хураалтын томъёоллыг уншаад танилцуулчихсан байгаа. Үндсэн санал хураалтаа явуулъя. Санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

12.Төсөлд доор дурдсан агуулгатай 21.1.2 дахь заалт нэмж, төслийн 21.1.2 дахь заалтыг 22.2.11 дэх заалт болгон шилжүүлэх:

“21.1.2.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, ургамал хамгааллын салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох;” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмж, 22.3 дахь хэсгийн “бүртгэхтэй холбогдсон” гэсний өмнө “эрх олгох,” гэж нэмэх:

“22.2.7.хөнөөлт
организмын эрсдэлийн шинжилгээ хийх;”
Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 22 дугаар зүйлийн 22.2.9 дэх заалтын “бүтээгдэхүүн, зохицуулалттай бусад эд, материалд” гэснийг “бүтээгдэхүүнд” гэж, 22.2.10 дахь заалтын “мэргэжлийн багийн” гэснийг “эрх бүхий албан тушаалтны” гэж, “зохицуулалттай эд, материалыг” гэснийг “ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг” гэж өөрчилж, 22.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.8.хорио цээртэй хөнөөлт организмгүй, хөнөөлт организмын тархалт багатай болон аюулд өртсөн газар нутгийг энэ хуулийн 16.2-т заасан журмын дагуу тогтоох;”
Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 25 дугаар зүйлийн гарчгийн “Иргэн, хуулийн этгээдийн” гэснийг “Хүн, хуулийн этгээдийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

16.Төсөлд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйл нэмэх:

“25 дугаар зүйл.Эрдэм шинжилгээний байгууллагын бүрэн эрх

25.1.Эрдэм шинжилгээний байгууллага нь ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.ургамлын хөнөөлт организмын гаралт, тархалт, олиролт,

хөнөөлийн талаар тандан судалгаа, туршилт, зохион бүтээх ажил хийх, түүний үр дүнд үнэлэлт, дүгнэлт гаргах;

25.1.2.ургамал хамгааллын бүтээгдэхүүний хор аюулын шинж чанар, түүний ургамал, ус, хөрсөн дэх үлдэгдлийг тодорхойлох;

25.1.3.энэ хуулийн 18.1-д заасан ургамал хамгаалах цогц аргыг хэрэгжүүлэх болон ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг турших, ашиглах, импортлох, тээвэрлэх, хадгалах, худалдах талаар зөвлөмж боловсруулах;

25.1.4.ургамлын хөнөөлт организмаас хамгаалах стандарт, технологийн заавар боловсруулах, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хүн, хуулийн этгээдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх.

25.1.5.ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын сургалтыг ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулах.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “тархахаас сэргийлэх” гэсний өмнө “тохиолдолд” гэж, 8.1.1 дэх заалтын “зоорь, агуулахад” гэсний өмнө “үтрэм, ил талбай,” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хөдөө аж ахуйн” гэсний өмнө “хүнс,” гэж, 18 дугаар зүйлийн 18.3.2. дахь заалтын “бэлчээр,” гэсний дараа “хадлангийн болон ойн сан бүхий газар,” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “тооцоонд” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “ил ялгаварлах” гэснийг “үл ялгаварлах” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “тухайн нутаг дэвсгэрийн” гэснийг “тухайн шатны” гэж, 8.3 дахь

хэсгийн “холбогдох” гэснийг “шаардлагатай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “үед” гэснийг “тохиолдолд” гэж, “хорио цээрийн дэглэмийг” гэснийг “хорио цээрийг” гэж, 9.2 дахь хэсгийн “мөрдөнө” гэснийг “баримтлана” гэж, 9.4 дэх хэсгийн “Холбогдох шатны” гэснийг “Бүх шатны” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “хөнөөлт организмын голомтыг устгах үйл ажиллагааг” гэснийг “устгалыг хөнөөлт организмын” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хяналтын байгууллага” гэснийг “хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэж, 22 дугаар зүйлийн 22.2.6 дахь заалтын “мэдээллийн санд” гэснийг “мэдээллийн сангийн дэд сан болох” гэж, “дэд санг бий болгож” гэснийг “цахим санг бүрдүүлж” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бий болгож” гэснийг “бүрдүүлж” гэж, “хангаж ажиллана” гэснийг “хангана” гэж, 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх заалтын “байгуулах” гэснийг “бүрдүүлэх” гэж, 27.5 дахь хэсгийн “эрүүл мэндийг хамгаалах” гэснийг “эрүүл мэнд, ургамал хамгааллын” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “боловсруулсан” гэснийг, 4.1.9 дэх заалтын “бусад” гэснийг, 4.1.10 дахь заалтын “хүн,” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “химийн” гэснийг, 5.1.5 дахь заалтын “түүхий эд,” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “нутаг дэвсгэрийн дотор” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын “хөнөөлт организмын тархалт” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “шинжид зориулсан болон тухайн хөнөөлт организмын” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.9.5 дахь заалтын “тайлангийн” гэснийг тус тус хасах.

4.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар,

эшилэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье. Санал хураалтыг явуулна. 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмэн 2 дугаар зүйлийн дугаарыг “3” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Ургамал хамгааллын тухай,” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай,” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье. 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмэн 2 дугаар зүйлийн дугаарыг “3” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас” гэснийг “хөнөөлт организмаас” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ.

Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалт явуулъя. Төслийн 1 дүгээр зүйлийн “Тариалангийн тухай хуулийн” гэсний дараа “2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Ургамал хамгааллын тухай” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” гэж,” гэж, “хөнөөлт организм” гэсний өмнө “болон

25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтын “өвчин, хортон, хог ургамал” гэснийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг хэлэлцье.

Төслийн хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, 1 болон 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/20 дугаар зүйлийн 20.1.24 дэх заалт:

“20.1.24. ургамлын зохицуулалттай хорио цээргүй хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээ.”

2/27 дугаар зүйлийн 27.5.26 дахь заалт:

“27.5.26. ургамлын хорио цээртэй хөнөөлт организмтай тэмцэх арга хэмжээ;””

“2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.26 дахь заалтын дугаарыг “27.5.27” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 26-г нь 27 болгож л өөрчилж байгаа юм байна. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг хэлэлцье. Төслийн 2 дугаар зүйлийн “гарчгийн “Ургамал хамгааллын тухай” гэсний өмнө “Ургамлын эрүүл мэнд,”

гээж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 3 дугаар зүйлийн “7.8 дахь зүйлийн” гэсний дараа “гарчгийн “Ургамал хамгааллын тухай” гэснийг “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай” гэж,” гэж, “мөн зүйлийн 4 дэх хэсгийн” гэсний дараа “болон 13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.2 дахь заалтын” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Төслийн хуулийн нэрийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 1 болон 3 дугаар зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.65 дахь заалт нэмсүгэй:

“6.65. таримал ургамлын үр, сортын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 10.27, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.””

“3 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.48 дахь заалтын “13.2 дугаар зүйл,” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут горимын санал гаргая.

Д.Батлут: Тоног төхөөрөмж ажилласангүй, дэмжиж санал өгсөн. Энэ саналыг хүчингүй болгож, ахиж санал хураалгаж өгнө үү гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын гаргасан горимын саналаар уг саналыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай. 57,9 хувиар санал дэмжигдлээ. 2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6-гийн, хүчингүй сая хүчингүй болгосон. Үндсэн санал хураалтын юу үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “6.15 дугаар зүйлийн 1” гэснийг “6.15 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь заалт” гэж өөрчилж, “6.13 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэснийг, “6.14 дүгээр зүйлийн” гэсний дараах “2,” гэснийг, “6.15 дугаар зүйлийн” гэсний дараах “6” болон “9” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналыг санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал дэмжигдсэнгүй. Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр горимын санал гаргая.

Б.Баттөмөр: Би энэ санал хураалтыг дэмжсэн, саналыг дэмжсэн боловч энэ эсрэг гарчихлаа. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Д.Мөнхбаатар: Дэмжиж өгөхөөр л эсрэг гараад байгаа шүү энэ төхөөрөмж. Сайн ойлгохгүй л байх шиг байгаа юм тийм ээ, дэмжиж өгөхөөр эсрэг гараад байгаа шүү. Баттөмөр даргын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 55,3 хувиар санал дэмжигдлээ. Саналыг

хүчингүйд тооцчихсон. Одоо үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулъя. 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

“5.5.Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх эрсдэлийн түвшинг харгалзан импортын мэдэгдэл олгох амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3, 4, 5 дугаар зүйл нэмж, 2 дугаар зүйлийн дугаарыг “6” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Генетик нөөцийн тухай,” гэсний дараа “Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дараах

заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.8.мал, амьтны гоц халдварт өвчин /цаашид “амьтны гоц халдварт өвчин” гэх/, ургамлын хорио цээртэй хөнөөлт организм /цаашид “ургамлын хорио цээртэй зүйл” гэх/ илэрсэн тохиолдолд тухайн хилийн боомт, гүний гаальд хорио цээр тогтоох саналыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран Засгийн газарт оруулах, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилтийг хянах;”

4 дүгээр зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “гадаад хорио цээртэй өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг болон 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “гадаад хорио цээртэй өвчний халдвар, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хорио цээртэй хөнөөлт организм” гэж, мөн заалтын “эрүүл мэндийн” гэснийг “эрүүл мэнд, ургамал хамгааллын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, хог ургамал” гэснийг “хөнөөлт организм” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн

захиргааны” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтын “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эсхүл ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын “байгууллага” гэсний өмнөх “хорио цээрийн” гэснийг “эрх бүхий” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. Гишүүдээ саналаа өгөөрэй. 55,3 хувиар санал дэмжигдлээ. Наранбаатар гишүүний микрофоныг өгчихье.

Н.Наранбаатар: Даргаа түрүүний санал 4 дүгээр санал хураалт дээр уначихсан юм. Түүн дээр чиглэл өгөөч дахин боловсруулах. Зайлиггүй байх ёстой заалт байгаа юм. Тийм түрүүн дэмжигдээгүй, дахин боловсруулах чиглэл авъя.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүнээ юу юм байна тийм ээ? 4 дүгээр зүйл үү, 4 дэх санал хураалт юм байна тийм үү? Наранбаатар гишүүний хэлж байгаа зүйл бас үндэслэлтэй байх шиг байна. Ингээд 4 дүгээр зүйл дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Байнгын хороон дээрээ энэ асуудлаа сайтар ярилцаж оруулж ирээрэй. Дараагийнхаа асуудалд оръё. Энийгээ шилжүүлнэ тийм

ээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

18.50 цаг

Арван дөрөв.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 8 гишүүн 2024.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийнхаа асуудал орёё. Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна. Дараа нь Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн бэлдэж байгаарай. Санал дүгнэлттэй холбоотой ХЗБХ-ны санал, дүгнэлтийг танилцуулах ёстой. Хууль санаачлагчийнхаа илтгэлийг Одонтуяа дарга уншина. Дараа нь Мөнхөөгийн Оюунчимэг Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод 2002 он нэмэлт протоколд 2015 онд нэгдэн орж, соёрхон батлаад 9 жил өнгөрч байна. Монгол Улс соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцод нэгдэн орсон үүргийнхээ дагуу дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэгтэй. Хуулийн төслөө боловсруулахдаа НҮБ-ын Эрүүдэн

шүүхийн эсрэг дэд хорооны гишүүдээс санал авахаар хүргүүлсэн бөгөөд хуулийн төслийг НҮБ-ын Эрүүдэн шүүхийн дэд хорооны зөвлөлөөр хэлэлцээд 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн албан захидлын авсан болно. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын 18 дугаар зүйлд оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага чиг үүргийнхээ хувьд хүний нөөц, төсөв хөрөнгө, үйл ажиллагааны хараат бус байх баталгааг хангана.

Эрхэм Байнгын хорооны гишүүд ээ,

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай болон Эрүүгийн хуульд оруулж буй хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үзэл баримтлалын хүрээнд дэмжин шийдвэрлэж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 8 гишүүн 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас Монгол Улсын нэгдэн орсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх явдлаас урьдчилан

сэргийлэх зорилгоор бие даасан, хараат бус эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага байгуулах үүрэг хүлээсний дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны төсвийг бүрэн хараат бус байхаар нэг мөр зохицуулах, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэхэд бусад байгууллага, албан тушаалтан шууд нөлөөлөх эрсдэлтэй байдлыг хязгаарлах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн тангараг өргөх, шаардлага бичих зэрэг эрх зүйн зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар шинээр зардал гарахгүй, асуудал хариуцсан байгууллагын үндсэн төсвийн хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр ЗГ-ын хуралдаанаар уг хуулийн төслийг дэмжээгүй талаар мөн одоогийн тогтолцоогоор үргэлжлүүлэн ажиллах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа байгууллага, албан тушаалтнууд үйл ажиллагаагаа уялдуулж ажиллах шаардлагатай талаар тус тус санал хэлсэн болно.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-

ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдээ танилцуулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХЭҮК-ын дарга Дугарын Сүнжид, ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Ядамжавын Цэлмэн, ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Шагдарын Үнэнтөгс, ХЭҮК-ын гишүүн Батзэвэгийн Энхболд, ХЭҮК-ын гишүүн Ганбатын Нарантуяа нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Байнгын хороо, Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа орж ирье. Санал хураалт явагдана. Гишүүд орж ирээрэй. Гишүүд орж ирж байх хооронд эцсийн найруулгыг танилцуулна. Гишүүдийг орж ирэх хооронд хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсож, сонсьё.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Дагалдан гарсан Хүүхэд хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн, алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Тогтоолд тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна

уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Гишүүдээ оруулаарай.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын олон талт олон улсын гэрээний

хэрэгжилтийн талаар авах зарим хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хууль, тогтоолын эцсийн найруулгуудыг сонсож дууслаа.

19.03 цаг

Одоо санал хураалт явагдана. Гишүүдийг танхимд оруулъя. Гишүүд оруулъя, санал хураалт явуулъя. Гишүүдээ оруулаарай. Би саналын томъёоллыг уншъя. Тэгээд яах юм бэ, та хэд Одонтуяа дарга Хүний эрхийн Комиссынхонтойгоо бас ойлголцож байгаа юм байгаа биз дээ? Та хэд. Энхбаяр ахлах юм аа, сайд ч ахлахгүй байх. Зүгээр Их Хурлын өөр гишүүн л ахалж таарах байх л даа Байнгын хорооны. Ойлголцож байгаа юм байгаа биз дээ та хэд. Хэлэлцэх эсэх дээрээ ярья гээд байгаа юм уу? Хэлэлцэх эсэхийг нь гаргаж байгаад ярья гэж байгаа юм уу та нар. Томъёоллыг нь аваад ирээрэй. Санал хураалт явуулъя.

Байнгын хороо Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх шаардлагагүй гэснийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13,5 хувиар санал дэмжигдсэнгүй. Хууль зүйн байнгын хорооны санал дэмжигдсэнгүй боллоо. Ийм учраас уг төслийг Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна. Анхны хэлэлцүүлэгт шилжүүлж байна.

19.10 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна. Одоо Даргын зөвлөл Их Хурлын даргын өрөөнд хуралдана. Даргын зөвлөлийн гишүүд хуралдаа ороорой. Ажлын хэсэг, гишүүдэд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА